ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

2020 оны 11 дүгээр сарын 27 Улаанбаатар хот

| № | Агуулга | | Бүгд | Зорилго 1 **Иргэдийн оролцоотой Сүхбаатар дүүрэг** | Зрилго 2 **Боловсролд ээлтэй Сүхбаатар дүүрэг** | Зорилго 3 **Амьдрахад таатай Сүхбаатар дүүрэг** | Зорилго 4 **Иргэндээ үйлчлэх Сүхбаатар дүүрэг** | Зорилго 5 **Дэвжин дэшлэх Сүхбаатар дүүрэг** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Нийт заалтын тоо** | | **222** | **18** | **34** | **79** | **45** | **46** |
| 2 | Биелсэн /100%/ | | 178 | 16 | 25 | 60 | 41 | 36 |
| 3 | Хэрэгжилтийн явц | Хэрэгжих шатандаа | | | | | | |
| | | 70.0% | 10 | 1 | 1 | 4 | 1 | 3 |
| | | 40.0% | 5 | - | 1 | 3 | | 1 |
| 4 | | 0% | - | - | - | - | - | - |
| 5 | | Хугацаа болоогүй. | - | | | | | |
| 6 | | Үнэлэх боломжгүй. | 29 | 1 | 7 | 12 | 3 | 6 |
| НИЙТ ХУВЬ | | | **85,3%** | 92,7% | 76,7% | 81% | 92,6% | 83,6% |

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ

2020 оны 11 дүгээр сарын 27 Улаанбаатар хот

| Д/д | Дунд хугацааны бодлогын баримт бичгийн заалт | 2020 онд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2020 онд хүрэх түвшин, үр дүн | Шаард лагатай хөрөнгийн эх үүсвэр үүсвэр | Хариуцах хэлтэс | Явцын хувь | ХШҮ-ний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Иргэдийн оролцоотой Сүхбаатар дүүрэг | | | | | | | | |
| 1.1 Иргэдийн санаачилгыг дэмжин хамтран бүтээнэ. | | | | | | | | |
| 1 | ДЗДҮАХ-ийн 1.1.1. Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг тогтолцоог тогтмолжуулна. | Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахад барилга байгууламжийн инженер геологийн судалгаа, худгийн усны хайгуул, холбогдох техникийн нөхцөл, кадастрын зураг, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Судалгаанд үндэслэн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. | 50,000.0 | ТГХШХ | 100% | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хороонд хийгдэх явган замын гэрэлтүүлэг, 18, 20 дугаар хороонд хийгдэх явган хүний гүүрэнд хийгдэх гэрэлтүүлгийн 2кВа чадалтай техникийн нөхцөлийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-н 2020 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 15/01066/20 дугаартай техникийн нөхцөл гаргуулсан. Дүүргийн 1-11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийгдэх телехяналтын камерын цахилгааны тодруулга Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Зүүн түгээх төвөөр гаргуулж ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэр дээр 2 дугаар хорооны, 1А байрны зүүн талд байрлах 2306м2, 455м2 газар, 3 дугаар хорооны 13 дугаар байрны зүүн талд 1548м2 газар, 4 дүгээр хорооны хорооны 42 дугаар хорооны дунд 2158м2 газарт тус тус кадастрын зураг хийлгэсэн. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2015-2020 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын 118 байршилд кадастрын зураг хийлгэж дүүргийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. | | | | | | |
| 2 | | Дүүргийн хөгжлийн бодлоготой хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг уялдуулах чиглэлээр сургалт зохион байгуулна. | 30 албан хаагч хамруулах | Бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулалтын төлөвлөлт сайжирсан байна. | 9,000.0 | ТГХШХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Улсын хэмжээнд бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой сургалт хийгдээгүй. | | | | | | |
| 3 | | Орон нутгийн хөгжлийн сангийн журам шинэчлэгдсэнтэй | Хороодын ажлын алба, | Орон нутгийн хөгжлийн сангийн | 9,900.0 | ТГХШХ | 100% | 100% |

<table>
<tr><td rowspan="2"></td><td rowspan="6">Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйл;<br>ДЗДҮАХ-ийн 1.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын саналыг иргэдээс хууль тогтоомжийн дагуу авч, иргэдийн оролцооны түвшинг дүүргийн хэмжээнд нэмэгдүүлнэ.</td><td>холбоотой онол, практикийн сургалтыг үе шаттай зохион байгуулна.</td><td>Хэсгийн ахлагч нар</td><td>журам хэрэгжсэн байна.</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="7">Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 288 дугаар журам дагуу НЗДТГ-аас Нэг хот-Нэг стандарт зорилтын жил болгон зарласантай холбогдуулан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд иргэдээс авах санал асуулгыг нэг стандартын дагуу нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/11 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/31 дүгээр захирамжийн дагуу гар утасны аппликейшн ашиглан иргэдээс санал авах тухай онол, практикийн сургалтыг 2020 оны 02 дугаар сарын 03-14-ны хооронд дүүргийн 1-20 дугаар хорооны Зохион байгуулагч, 178 Хэсгийн ахлагч нарт цахимаар НЗДТГ, Азийн сантай хамтран сургалтыг зохион байгуулсан. Мөн хороодод эрх нээгдээгүй болон Ub smart аппликейшн ашиглалтын талаар 1-4, 12-19-р хороодод мэргэжилтэн Ж.Ууганцэцэг, Б.Батцэцэг нар мэдээлэл хийж зөвлөгөө өгч ажилласан. Хороодод 20000 ширхэг гарын авлага, 700 ширхэн плакат, хэсгийн ахлагч нарт 2,750,000 төгрөгний нэгж өгсөн. ОНХС-ийн санал асуулгыг идэвхжүүлэх зорилгоор НЗДТГ, Азийн сангаас зохион байгуулсан болзолт уралдаанд шилдэг хороогоор дүүргийн 7 дугаар хорооны ажлын алба, идэвхтэй оролцсон албан тушаалтнаар 20 дугаар хорооны зохион байгуулагч Б.Энхмаа 1 дүгээр байранд тус тус шалгарсан.</td></tr>
<tr><td rowspan="2">4</td><td>Сангийн сайдын 228 дугээр тушаалын дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг тухайн хорооны иргэдийн саналаар хэрхэн тохижуулах тухай ерөнхий зураглалыг авч, зөвшилцөн шийдвэрлэнэ.</td><td>Дүүргийн 1-20 хороодын өрх бүр хамрагдах</td><td>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын иргэдээс авах санал 95%-иас багагүй байна.</td><td>9,000.0</td><td>ТГХШХ</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/11 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/31 дүгээр захирамжийн дагуу гар утасны аппликейшн ашиглан иргэдээс санал авахаар болсон. Санал асуулгыг 2020 оны 03 дугаар сарын 01-ээс 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 20 хорооны 18-аас дээш насны 66849 иргэд санал өгөхөөс 46180 иргэн 15 ажлын төрлөөр давхардсан тоогоор 183,786 санал өгч дүүргийн хэмжээнд санал асуулга 69,8%-ийн хэрэгжилттэй зохион байгуулагдлаа. Иргэдээс бичгээр ирсэн 799 саналын байршлын судалгаа хийж холбогдох газруудад албан бичгээр уламжилсан. Иргэдээс ирүүлсэн санал асуулгыг нэгтгэн Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ, З.Энхболд, Э.Сүх-Эрдэнэ нар байршил дээр нь очиж судалгаа хийсэн. Нээлттэй санал асуулгаар иргэдээс ирүүлсэн боломжтой саналд үндэслэн байршил дээр судалгаа хийж хороо тус бүрээр нийт 71 ажил дээр даалгавар авахаар Хот байгуулалт хөгжлийн газарт хүргүүлсэн. Хороодын Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэх 259 урьдчилан жагсаалтыг хороодод хүргүүлсэн.</td></tr>
<tr><td rowspan="2">5</td><td>Олон нийтийн санал асуулгаар иргэдээс ирүүлсэн саналын хэрэгжилтийн мэдээг иргэдэд хүргэнэ.</td><td>Дүүргийн 1-20 хороодын 500-1000 өрх хамруулах</td><td>Иргэд мэдээлэлтэй болсон байна.</td><td>5,000.0</td><td>ТГХШХ</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">2021 оны ОНХС-ийн санал асуулгаар иргэдээс Гар утасны Smart Ub аппликейшнээр ирсэн санал:</td></tr>
</table>

| № | Төсөл, арга хэмжээ | Саналын тоо |
|---|---|---|
| 1 | Гудамж талбайн камержуулалт хийх | 30,541 |

| | | |
|---|---|---|
| 2 | Ахмад настан болон хүүхэд, залуучуудад зориулсан тоглоомын болон биеийн тамир чийрэгжүүлэлтийн талбай байгуулах | 19621 |
| 3 | Гудамж талбайн гэрэлтүүлэг хийх | 19,519 |
| 4 | Үерийн болон гадаргын ус зайлуулах хоолой хийх | 14,650 |
| 5 | Хатуу хучилттай болон шороон замын засвар шинэчлэлт | 14,265 |
| 6 | Явган хүний зам, гүүр, шат барих, засварлах | 12,780 |
| 7 | Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт / зам, талбай тэгшлэх, жишиг гудамж байгуулах, хаягжуулалт, ногоон байгууламж хийх г.м/ | 10,406 |
| 8 | Орон сууцны гадна фасад, дулаалга | 8940 |
| 9 | Ногоон байгууламж байгуулах, мод, бут, сөөг тарих, хамгаалах | 7760 |
| 10 | Орон сууцны дээврийн засвар | 7091 |
| 11 | Иргэний танхим шинээр байгуулах, тохижуулах, техник, тоног төхөөрөмж авах | 5949 |
| 12 | Хогийн төвлөрсөн цэг байгуулах, хогийн сав нэмэгдүүлэх | 5701 |
| 13 | Автомашины зогсоол байгуулах | 5575 |
| 14 | Авто замын шинэчлэлт засвар, үйлчилгээ | 5335 |
| 15 | Цахилгааны шугам, дэд өртөөний засвар, өргөтгөл | 3995 |
| 16 | Нийтийн бие засах газар барих, сэргээн засварлах, тохижуулах | 3292 |
| 17 | Цахилгааны шугам, дэд өртөөний засвар, өргөтгөл | 3173 |
| 18 | Худаг, усан сан байгуулах | 3160 |
| 19 | Ахуйн үйлчилгээний төв, нийтийн халуун усны газар барих, сэргээн засварлах, тохижуулах | 2033 |
| | **Нийт** | **183,786** |

**Иргэдээс бичгээр ирсэн саналын тайлан:**

| **№** | **Чиглэл** | **Саналын too** |
|---|---|---|
| | **Нийт** | **799** |
| **1.*Үүнээс: Хасагдах болон бусад эх үүсвэрээр хийгдэх санал*** | | **728** |
| 1.1 | Холбогдох дээд шатны байгууллагуудад уламжлах санал | 345 |
| 1.2 | Мэргэжлийн хяналтын дүгнэлт шаардах санал | 32 |
| 1.3 | Хасах санал | 126 |
| 1.4 | Байршилгүй санал | 225 |
| **2.*Хийгдэх боломжтой ажлын санал*** | | **195** |
| 2.1 | Даалгавар, зураг төсөвтэй | 188 |
| 2.2 | Даалгавар авах | 71 |

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан сургалт зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/616 дугаар захирамжийн дагуу сургалт зохиогдоогүй болно. Иймд иргэдээс ирсэн саналуудыг нэгтгэн хороодын ажлын албаар уламжлан мэдээллийн самбарт байршуулж иргэдэд мэдээлэл өгч ажилласан.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | | Иргэдийн бүлгийн жагсаалт үүсгэнэ. | Дүүргийн 1-20 хороодын иргэд | Иргэдийн оролцоо нэмэгдсэн байна. | | ТГХШХ | 100% | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай 2019 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр захирамжаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх, хувиарлах, зарцуулах үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсэг 2020 оны 01 дүгээр сарын 16-ний өдөр хуралдаж, 2020 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн бүлгээр хийгдэх ажил, бүлэгт тавих шаардлага, ажлын хэсгийн зөвлөмж шинэчилсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 3/1125 дугаартай албан бичгээр иргэдийн бүлгийн жагсаалт үүсгэн дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. | | | | | | |
| 1.2 Төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлнэ. | | | | | | | | |
| 7 | Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл; ДЗДҮАХ-ийн 1.2.1 Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан тайлагнаж ажиллах | Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар тайлангийн ном гаргах, уулзалт, өдөрлөг, арга хэмжээний талаар видео танилцуулга бэлтгэж иргэд, олон нийтэд танилцуулна. | Иргэдэд төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол мэдээлж ажиллах | Төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, хийж хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангагдах, дүүргийн Засаг даргын 2017-2020 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сурталчилсан байна. | 100,000.0 | ТЗУХ | 100% | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс албадаас зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг бэлтгэн телевиз, сонин, цахим хуудсуудаар олон нийтэд хүргэн ажиллаж байна. Ингэхдээ тайлант хугацаанд 450 мэдээ бэлтгэн дүүргийн албан ёсны вэб сайт, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2000 удаагийн давталттай дамжууллаа.<br>Иргэд олон нийт рүү чиглэсэн онцлох үйл ажиллагаанаас бэлтгэсэн мэдээллийг дурдвал:<br>Дүүргийн Засаг дарга мөрийн хөтөлбөрийн биелэлт, хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын тухай мэдээллийг телевизүүдийн зочны цаг болон ярилцлагын нэвтрүүлгүүдээр олон нийтэд хүргэлээ. Тухайлбал:UBS телевизийн “Нүүр тулсан ярилцлага” 30 минутын нэвтрүүлэг, Ийгл, С1 телевизүүдэд зочноор оролцон иргэд олон нийтэд хүргэсэн байна. Мөн Зууны мэдээ сонины Танил хүн булан, Өдрийн сонин, бие даасан 4 нүүр сонин гаргаж иргэдэд танилцуулав. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мөн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудаар зурган мэдээ бэлтгэн иргэддээ цувралаар танилцуулахын зэрэгцээ хороодод хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын зургуудыг 4 жилээр нь түүвэрлэн хороо тус бүрээр ангилан видео танилцуулга бэлтгэн иргэдэд сурталчиллаа.<br>Дэлхий нийтэд болон манай улсад тархаад буй коронавируст /ковид-19/ халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч буй урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээнүүдийн хүрээнд улс, нийслэл, дүүргээс зохион байгуулж буй үйл ажиллагаа, шийдвэрүүдийг цаг тухайд нь дүүргийн албан ёсны www.sbd.gov.mn вэб сайт болон “Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар” “Нээлттэй Сүхбаатар”, “Түмэнд түгээнэ”, 20 хороо тус бүрийн пейжүүдээр иргэд, олон нийтэд шуурхай мэдээлэн ажиллаж байна.<br>Тухайлбал: Аж ахуйн нэгж байгууллагуудад хандан гаргасан уриалга, нийслэл болон орон нутгаас орох гарах хөдөлгөөнийг хязгаарласан зохицуулалт, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглааныг түр хугацаагаар зогсоосон тухай, эргээд сэргээсэн шийдвэрүүд, сургууль цэцэрлэгүүдийг үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, түүний хүрээнд мэргэжлийн байгууллагуудаас явуулж буй арга хэмжээ, мэдээлэл, томуу, томуу төст өвчний өвчлөл, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, анхааруулга зөвлөмж, хатуу хөл хорионы үеийн дэглэм, зөвлөмжөөс гадна “Эргүүл” арга хэмжээний явц “Нэг хот-нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлууд, “Манай хороо-Миний гудамж” аянд оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагын сайн туршлагуудын мэдээг цувралаар олон нийтэд сурталчлан таниулж ажиллалаа. | | | | | | |
| 8 | | Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит 61-62 байгууллагуудын төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсаар дамжуулан хуулийн дагуу мэдээллээ мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж, тайлагнаж ажиллана. | 61-62 байгууллага хамрагдах | Төсвийн ил тод байдал сайжирч, иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох боломж бүрдсэн байна. | - | ДАА СТСХ | 100% | 100% |
| | | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсаар дамжуулан хуулийн дагуу мэдээллээ байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж 2020 оны Сүхбаатар дүүргийн ТЕЗ-ийн хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 23 байгууллагын нягтлан бодогч нарт утсаар болон “Сүхбаатар дүүрэг Аудит” гэсэн фэйсбүүк хаягаар зөвлөмж өгч гарсан зөрчлийг арилган ажилласан. Үүнд:<br>✓ Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 6 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан тухай тус хэлтсийн 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 42 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн байна<br>✓ 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 175-р цэцэрлэг, 234-р цэцэрлэг, 4-р сургууль, 71-р сургууль, Албан бус-Насан туршийн боловсролын төвийн шинээр ажилд орсон нягтлан бодогч нарт "Шилэн дансны тухай хууль” болон МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт хийлээ. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 05 дугаар сарын 19 ны өдрийн 198 дугаартай албан бичгээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа талаар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх сонсголыг ирүүлэх тухай заасны дагуу мэдээллийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлыг албанд цахимаар хүргүүлж, танилцуулга хийв. Нийслэл дэх төрийн аудитын газраас тус албанд ирүүлсэн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 916 дугаартай албан бичиг, 01/117 дугаартай албан шаардлагын дагуу:<br>- Төсвийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нийлсэн 22 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулаагүй зөрчлийг арилгуулах 19 дугаартай албан бичгийг 2020 оны 05 дугаар сарын 04-ны өдөр тус байгууллагуудад хүргүүлж биелэлтийг тус байгууллагуудаас бичгээр авсан болно. Мэдээгээ нөхөн байршуулаагүй байгаа байгууллагуудад утсаар ахин сануулсан.<br>- Тус 22 байгууллагын 914 мэдээлэл байршуулаагүй зөрчилтэй байсан бол одоогоор 99.7 хувийн гүйцэтгэлтэй болж сайжирсан байна.<br><br>Нийслэл дэх төрийн аудитын газраас тус албанд ирүүлсэн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 916 дугаартай албан бичиг, 01/117 дугаартай албан шаардлагын дагуу:<br>- Төсвийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нийлсэн 22 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулаагүй зөрчлийг арилгуулах 19 дугаартай албан бичгийг 2020 оны 05 дугаар сарын 04-ны өдөр тус байгууллагуудад хүргүүлж биелэлтийг тус байгууллагуудаас бичгээр авсан болно. Мэдээгээ нөхөн байршуулаагүй байгаа байгууллагуудад утсаар ахин сануулсан.<br>- Тус 22 байгууллагын 914 мэдээлэл байршуулаагүй зөрчилтэй байсан бол одоогоор 99.7 хувийн гүйцэтгэлтэй болж сайжирсан байна.<br>- Албаны 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 35-40 байгууллагад аудитын таөлөвлөгөө хөтөлбөрт Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тусган шалгаж зөвлөмж өгсөн. Албаны ажилтан албан хаагчиддаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 61 байгууллагаа хуваан хариуцуулж тухай бүр хяналт тавин, мэдээллэлээ хуулийн хугацаа хоцролгүй, үнэн зөв, ил тод байршуулахыг үүрэг болгон зөвлөн, тусалж ажиллаж байна. | | | | | | |
| 9 | ДЗДҮАХ-ийн 1.2.2 Алслагдсан хороодод төрийн үйлчилгээг Хөдөлгөөнт оффис-оор үзүүлнэ” | Хөдөлгөөнт оффис ажиллах журмын дагуу хэлтэс, нэгжүүд иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах, тайлагнах, боломжтой асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллана . | Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтүүдийг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлтэд хяналт тавин ажиллах | Дүүрэг, холбогдох хэлтсүүд дээр биеэр ирж үйлчилгээ авах боломжгүй ахмад, настан, ХБИ, цаг зав муутай иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, нэг дороос мэдээ, мэдээлэл авах боломж нөхцөл хангагдсан байна. | 6,000.0 | ТЗУХ | 100% | 100% |
| | | Шинэ төрлийн коронавирус гарч Онцгой комиссын тушаал шийдвэрийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдал зарлан хөл хорио тогтоож олон нийтийг хамарсан хурал уулзалт хийхгүй байх заалтын дагуу 2020 оны 1,2,3-р улиралд Хөдөлгөөнт оффисын баг ажиллаагүй боловч Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан дүүргүүдийн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Засаг дарга нарын гэр хорооллын хороодод ажиллах хуваарь удирдамжийн дагуу “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жил, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2009 оны 63 дугаар тогтоол, төр засгийн бодлого, шийдвэрийг сурталчлах, МУ-ын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан хатуу түлшийг хороодын борлуулалтын цэгээс айл өрхүүдэд нийлүүлэх, түгээх үйл ажиллагаанд хяналт тавих, сурталчлах, иргэдээс гаргасан өргөдөл гомдлыг газар дээр шийдвэрлэх хүрээнд дүүргийн Засаг дарга Х.Болормаа болон дүүргийн бусад удирдлагууд 2020 оны 02 сарын 12,13, 23-ны өдрүүдээс эхлэн 14 хоног тутам хороодод ажиллаж тухай бүр тулгамдсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэн холбогдох байгууллага, хэлтэс нэгж, албан хаагчдад үүрэг чиглэл өгч үр дүнг тооцон ажиллалаа.<br>Цаг үеийн нөхцөл байдлуудтай холбогдуулан дүүргийн ЗДТГ-ын албан хаагчид хороо тус бүрт хуваарилагдан тухай бүр хуваарийн дагуу ажиллалаа. Үүнд: Сайжруулсан түлшний хэрэглээний талаар зөвлөмж өгөх, зуухны судалгаа авах, Сайн картны болон угаарын хий мэдрэгч суурилуулах, Сар шинийн баярыг тохиолдуулан Ахмадуудад, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Одонтой эхчүүдэд хүндэтгэд үзүүлэх, Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбайд эргүүл жижүүр хийх зэрэг үйл ажиллагаануудыг хороодын Засаг даргын ажлын алба болон хэсгийн ахлагч нартай хамтран зохион байгууллаа.<br>2020 оны 3-р улиралд буюу 09 дүгээр сарын 2,3-ны 15,16-ны өдрүүдэд мөн хуваарийн дагуу хороодод ажиллан айл өрхүүдэд угаар мэдрэгч төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах болон зуухны бүрэн бүтэн байдлын талаар хэсгийн ахлагч нартай хамтран гэр хорооллын нийт айл өрхөөр орж зөвлөгөө зөвлөмж өгч санал хүсэлтийг хүлээн авч ажиллалаа.<br>Мөн Засаг дарга Х.Болормаа 2020 оны 3-р улирлаас дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа тохижилт, бүтээн байгуулалт, засвар шинэчлэлтийн ажлын явц, гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж, хороо тус бүрт очиж ажиллан тухайн ажлын гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай уулзан үүрэг чиглэл өгч ажиллаж байна. | | | | | | |
| 10 | Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйл; ДЗДҮАХ-ийн 1.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, иргэдэд нээлттэй ил тод болгоно. | Орон нутгийн хөгжил сангийн зарцуулалтыг иргэд олон нийтэд мэдээлнэ. | 100 | Төсөв санхүүгийн ил тод байдлыг мэдээлэн ажилласан байна. | - | СТСХ | 100% | 100% |
| | | 2020 онд Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжих 597,899.0 мянган төгрөгийн өртөг бүхий 14 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. Төсөлт арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг сар бүрийн 08-ны өдрийн дотор шилэн дансны сайтанд 100% байршуулан ажиллаж байна. Нийт 14 төсөлт арга хэмжээнээс 13 төсөлт арга хэмжээ хэрэгжиж 1 төсөлт арга хэмжээ хэрэгжих боломжгүй байна. 2020 оны 4 дугаар улирлын байдлаар 448,163.2 мянган төгрөгийн өртөг бүхий 13 төсөл арга хэмжээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсанаас 11 төсөл арга хэмжээний 379,261.6 мянган төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт гарсан. 1 төсөл арга хэмжээний 5,302.7 мянган төгрөгийн явцын санхүүжилт гарсан. | | | | | | |
| 11 | ДЗДҮАХ-ийн 1.2.4 Дүүрэг, хороодын иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэх, төр засгийн шийдвэрийг тогтмол мэдээлэлж, тулгамдсан асуудлыг | Хороодын Иргэний танхимд тогтмол зохион байгуулагддаг үйл ажиллагаануудад иргэд, хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | Хороо тус бүр 2-оос дээш Сайн туршлага хэрэгжүүлэн ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн байх | Иргэний танхимын үйл ажиллагаа тогтмолжиж, иргэд, залуучуудын идэвх оролцоо нэмэгдэн, Төр-Иргэний хамтын ажиллагаа сайжирсан байна. | 20,000.0 | ТЗУХ | 100% | 100% |

<table>
<tr>
<td></td>
<td>шийдвэрлэх үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.</td>
<td colspan="7">Тайлант хугацаанд хороо тус бүр ИНХ-ын тэргүүлэгчдийн хурал 5-аас дээш удаа, ӨЭМТ-тэй хамтран Шинэ төрлийн короновирусээс сэргийлэх сургалтыг 2-оос дээш удаа зохион байгуулан мөн "Хог хаягдал менежмент" зэрэг чиглэлүүдээр 1-р сард сургалт зохион байгуулан 2000 гаруй иргэн хамрагдсан байна.<br>НЗДТГ-ын Сургалт судалгааны төвтэй хамтран хороодын зохион байгуулагч нарт Харилцан суралцах арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх сургалтын 03 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд хороодод бүсчлэн зохион байгуулж 170 гаруй хүн хамрагдав.<br>ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хийгдэх ажлыг эрэмбэлүүлэх хурлыг 5 сард хороо тус бүр хэсэгчилэн зохион байгуулж, журамд заасан тоон үзүүлэлтийн дагуу ирцийг хангаж 1600 гаруй иргэдийг хамруулав.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хотын засаглалыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хороод өөрийн дотоод үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа шилдэг сайн туршлагыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, бусад хороодод нутагшуулах зорилгоор нийслэлийн нийт хороодын дунд “Сайн туршлага тодорхойлох, танилцуулах, түгээн дэлгэрүүлэх нь” болзолт уралдааныг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар 07 дугаар сарын 29-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж байгаатай холбогдуулан Болзолт уралдааны удирдамжийн дагуу дүүргийн хэмжээний хэлэлцүүлгийг 08 дугаар сарын 21-ний өдөр дүүргийн Иргэний танхимд зохион байгууллаа.<br>Хэлэлцүүлэгт 14-н хороо оролцож:<br>- 4 дүгээр хорооны жил бүр шинэчлэн гаргадаг “Манай хорооныхон” цуврал ном-13 санал<br>- 11 дүгээр хорооны “Гэрлэлтийн батлах гардуулах ёслол”-ыг зохион байгуулж хэвшсэн тухай туршлага – 12 санал<br>- 10 дугаар хорооны дахин төлөвлөлтийн бүс болох 100 айлын нийтийн байранд хэрэгжүүлсэн “Ирээдүйн 100 айл НүТББ” иргэдийн бүлэг ажиллуулсан тухай төсөл- 7 санал<br>- 12 дугаар хорооны “Ажлын байрны дасгал, хөдөлгөөн”-9 санал тус тус авч Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан 2 дугаар шатны хэлэлцүүлэг болон 09 дүгээр сарын 22-ны өдөр “Нийслэлийн харилцан суралцах арга зүйн форумд амжилттай оролцов.</td>
</tr>
<tr>
<td rowspan="2">12</td>
<td rowspan="2">Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйл; ДЗДҮАХ-ийн 1.2.7 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулал-тыг хуульд заасан</td>
<td>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим /www.tender.gov.mn/ системээр зохион байгуулна.</td>
<td>Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулах</td>
<td>100 хувь цахим системээр хэрэгжсэн байна.</td>
<td>-</td>
<td>ХААА ТГХШХ</td>
<td>100%</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">Захиалагчийн 2020 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оны эхэнд 36,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 128 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн болон төсвийн бусад эх үүсвэрээс хэрэгжих цаг үеийн шинж чанартай худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд нэмэлтээр тусгасны хүрээнд 38760.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 164 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллалаа.<br>2020 оны 3 дугаар улирлын өссөн дүнгийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 16947,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 122 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан, 16972,6 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарласан, зохион байгуулах шатанд байна.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслээр ил тод мэдээлнэ. | Төсвийн Ерөнхийлөн захирагчаас нэн шаардлагатай бус гэж үзсэн 2090,0 сая төгрөгийн өртөг бүхий 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг царцаасан бөгөөд төлөвлөгдсөн худалдан авалтын 83,7 хувийг хэрэгжүүлээд байна.<br>Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хүндрэлтэй буюу удаашралтай хэрэгжүүлэх боломжгүй төсөл арга хэмжээ байхгүй болно. Харин хэрэгжүүлэх хугацаа болоогүй бараа болон ажлын худалдан авалтыг тухайн цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Сонгон шалгаруулалтыг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, иргэд олон нийтэд худалдан авах ажиллагааны мэдээллийг шуурхай хүргэж ажилласнаар гомдол маргаангүй ажиллалаа. | | | | | | |
| 13 | | Худалдан авах үйл ажиллагааны мэдээллийг ил тод мэдээлж, иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Худалдан авах ажиллагаанд оролцох олон нийтийн оролцоо нэмэгдэж, хяналт сайжирсан байна. | 7,500.0 | ХААА ТГХШХ | 100% | 100% |
| | | - Худалдан авах үйл ажиллагааны мэдээллийг ил тод мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллах хүрээнд:<br>- 2019.12.16-ны өдрийн дүүргийн ИТХ-аар батлагдсан 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн Захиалагчийн 2020 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2020.01.07-ны өдрөөр дүүргийн Засаг даргаар батлуулан, Сангийн яамны Хууль эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэст хүргэн хянуулж tender.gov.mn систем болон sbd.gov.mn сайтад нээлттэй байршууллаа. Мөн тус өдрийн өдөр тутмын сонин “Өглөөний сонин”-д нээлттэй байршуулж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ил тод мэдээлэн сурталчилж ажиллалаа.<br>- Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан тендер шалгаруулалтыг 100 хувь цахим системээр зохион байгуулж ажилласнаар тендерийн урилга, баримт бичиг, үр дүн, тендерт шалгарсан ААНБ-ын гэрээний мэдээллийг бүрэн системд тухай бүрт бүрэн байршуулан ажиллалаа.<br>- Холбогдох мэдээллийг шилэн дансны сайтад сар бүр байршуулан ил тод мэдээлэн ажиллаж байна.<br>- Мөн албаны дэргэдэх мэдээллийн самбарт /Дүүргийн ЗДТГ-ын 2-р давхарт байрлах/ холбогдох мэдээллийг тогтмол байршуулж байна.<br>- Тус алба нь өдөр тутмын сонин “Өглөөний сонин”-той гэрээтэй ажиллаж, Захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга зарыг өдөр тутмын сонинд байршуулахад 7 700 000 төгрөгийг зарцуулаад байна. | | | | | | |
| | | 1.3 Эко дүүрэг бий болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 14 | ДЗДҮАХ-ийн 1.3.1 Иргэдийн оролцоотой “Ногоон хөгжил-Сүхбаатар” хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Эко орчин бүрдүүлэх чиглэлээр ухуулга, сургалт, сурталчилгаа явуулна. | 60 иргэнийг хамруулах | Ногоон байгууламжийн чиглэлээр сургалт зохион байгуулж, эко орчин бий болгосон байна. | 4,370.0 | ТНААХ | 50% | 70% |
| | | Мод тарих талаар хүсэлт ирүүлсэн 60 иргэнд тухайн хороодод нь Танайд мод тарья ТББ-тай хамтран 2020 оны 05 дугаар сарын 7 өдөр мод тарьж ,арчлах талаар анхан шатны заавар зөвлөгөөг өгөн ажилласан. | | | | | | |
| 15 | | Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулна. | Ажлын явц , хувиар | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд | 97,000.0 | ТНААХ | 95% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шилмүүст мод, навчит мод, бут, сөөгөөр ногоон байгууламж нэмэгдсэн байна. | | | | |
| | | Мод тарих үндэсний өдрийн хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг дарга захирамж гарган нутаг дэвсгэрийн хэмжээнд 05 дугаар сарын 09-ний өдөр бүх нийтийг хамруулан мод, бут зүлэг тарих ажлыг зохион байгуулахыг даалгасан.<br>Дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд гаднах орчиндоо мод тарих, өмнөх онуудад тарьсан мод, бутыг арчилж, хамгаалах, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, орчны зэрлэг ургамлыг устгах, мод бутны тогоог сэргээж услах зэрэг ажлуудыг хийж байна.<br>Дүүргийн хэмжээнд 169 аж ахуйн нэгж байгууллагын 778 гаран иргэн албан хаагчид 2322 ширхэг мод , 2810 м2 зүлэг, 451 м2 цэцгийн мандал шинээр тарьсан байна. Зарцуулсан хөрөнгө 39,050,000 төгрөг | | | | | | |
| 16 | ДЗДҮАХ-ийн 1.3.2 Ногоон байгууламж шинээр бий болгосон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжиж ажиллана. | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн мод бутыг хэлбэржүүлэх, шохойдож шуулт хийнэ. | 1-18 дугаар хорооны 160 байршлын 2818 ширхэг мод, бут сөөгөнд тайралт хийх | Ногоон байгууламжийн ургалт сайжирсан байна. | 68,001.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Иргэд, СӨХ-с хэлбэржүүлэх шаардлагатай мод бутны судалгааг хороодоор дамжуулан гаргаж нэгтгээд байна.<br>Нийтийн эзэмшлийн төв зам дагуух мод бутыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээ байгуулан Хот тохижилт ОНӨААТҮГ, Охь мандал ХХК хийж гүйцэтгэсэн болно. | | | | | | |
| 17 | ДЗДҮАХ-ийн 1.3.3 Ногоон байгууламж тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог хангаж ажиллана. | Рашаан булгийн эх хамгаалах гэрээт ажилтан ажиллуулна. | 15 дугаар хороо Зуун модны рашаан, 16-р хороо Дамбадаржаагийн рашаан, 20-р хороо Гүнжийн булгийн эхийг хамгаалах, орчны хог хаягдлыг цэвэрлэх | Сайн дурын идэвхтэй байгаль хамгаалагч ажиллуулж, тохижуулсан рашаан булгийн эхийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан орчны бохирдлыг арилгасан байна. | 3,600.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 15, 16, 20 дугаар хороонд байрлах Зуун модны эхэн дахь Энх мөнхийн рашаан, Гүнжийн булаг, зуун модны рашааны эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан, орчны бохирдлыг бууруулахаар 3 байгаль хамгаалагч ажиллуулан сар бүр 100,000 төгрөгийн урамшуулал олгосон. Зарцуулсан хөрөнгө 3,600,000 төгрөг | | | | | | |
| 18 | | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт хийнэ. | 1-14 дүгээр хороонд орон сууцны хороолол | Ногоон байгууламжийн | 82,500.0 | ТНААХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дундах, нийтийн эзэмшлийн орон сууцны гаднах 18500,15 м2 орон сууцны дундын ногоон байгууламжийн зүлэгт талбай болон 2783 ширхэг мод, бут сөөгний усалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, арчлалт хамгаалалтыг хийх | ургалт сайжирсан байна. | | | | |
| | | Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 1-14 дүгээр хорооны орц дундын ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд тарьсан мод, бут, сөөгний арчлалт, хамгаалалтыг иргэн, аж ахуй нэгжүүдэд хариуцуулан ажиллаж байна. Дээрх хороодыг гурван бүсэд хуваан гүйцэтгэгч байгууллага хариуцсан нутаг дэвсгэрийнхээ мод, бут, сөөгний ургалтыг сайжруулах, нөхөн тарилт хийх юм. Нийтдээ 18500м2 орц дундын ногоон байгууламж, 2483ш мод, бут, сөөгөнд 7 хоногт хоёроос гурван удаагийн давтамжтайгаар усалгаа хийж байна. Зарцуулсан хөрөнгө 49,741,925 төгрөг | | | | | | |
| ХОЁР. БОЛОВСРОЛД ЭЭЛТЭЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ | | | | | | | | |
| 2.1 Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын чанарыг сайжруулна. | | | | | | | | |
| 19 | ДЗДҮАХ-ийн 2.1.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх болон шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ. | Он дамжин хэрэгжиж буй 11,12,13,16 дугаар хороодод ерөнхий боловсролын сургууль, 12,16,18,19 дүгээр хороодод цэцэрлэгийн барилга шинээр барьж ашиглалтад оруулна. | Ажлын явц , хувиар | Ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоо 2180, цэцэрлэгийн хүүхдийн орны тоо 990 нэмэгдсэн байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд он дамжин хэрэгжиж буй ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн өргөтгөл 90%, 320 хүүхдийн суудалтай 71 дүгээр сургуулийн өргөтгөл 30%, 320 хүүхдийн суудалтай 11 дүгээр хорооны сургууль, цэцэрлэгийн цогцолбор 30%, 720 хүүхдийн суудалтай 12 дугаар хорооны барилга эхлээгүй, 960 хүүхдийн суудалтай 13 дугаар хорооны барилга 50%, 320 хүүхдийн суудалтай 16 дугаар хорооны барилга 30%-тай баригдаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд он дамжин хэрэгжиж буй тус бүр 280 хүүхдийн ортой 16 дугаар хорооны барилга 90%, 18 дугаар хорооны барилга 60%, 19 дүгээр хорооны барилга 100%, 150 хүүхдийн ортой 149 дүгээр цэцэрлэгийн барилга буулгаж барих ажил эхлээгүй, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн ортой 68 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 100%, Арабын нэгдсэн Эмират улсын хөрөнгө оруулалтаар 200 хүүхдийн ортой 25 дугаар цэцэрлэгийн барилга 90%, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 100 хүүхдийн ортой 143 дугаар цэцэрлэгийн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өргөтгөлийн барилга 100%, 150 хүүхдийн ортой 12 дугаар хорооны цэцэрлэгийн барилга 100%, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн ортой 54 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 100%-тай тус тус баригдаж, нийт 9 цэцэрлэг 1780 ороор нэмэгдүүлэхээр ажиллаж байна. | | | | | | |
| 20 | ДЗДҮАХ-ийн 2.1.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн, сургуулиудыг хоёр ээлжээр хичээллүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ. | Ерөнхий боловсролын 71, 58 дугаар сургуулийн барилгын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Ерөнхий боловсролын сургуулиудыг 2 ээлжинд бүрэн шилжүүлсэн байна. | - | НХХ БХ | 40% | 40% |
| | | 2018-2020 онд дамжин улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 71 дүгээр сургуульд 320 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “СТНАА” ХХК ажиллахаар гэрээ байгуулж, суурийн цутгалтын ажил хийж байна. Мөн 58 дугаар сургуулийн барилгын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 16 дугаар хороонд 320 хүүхдийн ортой бага сургуулийн барилгын гүйцэтгэгчээр “Агар дүнз” ХХК ажиллаж, гүйцэтгэл 30%-тай байна. | | | | | | |
| 21 | | Зарим төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд гарсан сул орон тоон дээр нэмэлтээр элсэлт зохион байгуулж, цэцэрлэгт хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд нэмэлтээр хүүхдүүдийг хамруулсан байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/14 дүгээр захирамжаар 2019-2020 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн 13 цэцэрлэгт нэмэлт элсэлтээр 279 хүүхэд хамруулсан. 2020-2021 оны хичээлийн жилд “ Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх, бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” БШУСайдын 2020 оны 08–р сарын 06-ны өдрийн А/17 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд бүлэг дүүргэлт өндөртэй 2, 54,75, 130, 216, 248-р цэцэрлэгийн 25-аас дээш давсан, 5 настай шинээр бүртгэсэн хүүхдүүдийг дуу хөгжим, биеийн тамирын зааланд шилжүүлэн байршуулах, 54 дүгээр цэцэрлэгийн 5 настай 25 хүүхдийг 68 дугаар цэцэрлэгт шилжүүлэх, төрийн бус өмчийн цэцэрлэгийн нэмэлт элсэлтэд 5 настай шинээр бүртгэгдсэн 99 хүүхдийг тухайн хорооны төрийн бус өмчийн цэцэрлэгийн нэмэлт элсэлтэд хамруулах зохицуулалт хийж, төрийн бус өмчийн 13 цэцэрлэгт нэмэлт элсэлтээр 5 настай 279 хүүхдийн хамруулаад байна. | | | | | | |
| 22 | ДЗДҮАХ-ийн 2.1.3 Хүүхэд бүрийг судлан оношлох, оношилгоонд тулгуурлан хөгжүүлэх арга зүйг багш бүрт эзэмшүүлэх, сургалтыг шат дараатай хэрэгжүүлэх, багш, удирдах ажилтны нэр хүнд, мэргэжлийн ёс зүй, мэргэжил, ур чадварыг сайжруулах зорилго бүхий сургалт- | Сургалт-судалгаа, хөгжлийн бодлогын зөвлөлийн сургалт, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, туршлага судлах, түгээн дэлгэрүүлэх дэмжих үйл ажиллагаа зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | СӨБ, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд судлагдахуун бүрээр багш багшаасаа суралцах тэргүүний аргазүй, туршлага судлах ажил зохион байгуулсан байна. | 120,000.0 | НХХ БХ | 90% | 100% |
| | | "Хотын соёл” мэдээллийн цаг аяны хүрээнд төрийн өмчийн 32 цэцэрлэгийн 236 багш 15 сэдвээр контент 54, цахим хичээл 170, 1 цахим үзүүлэн 1 хийсэн. Сэдэв тус бүрээр задалвал: Анхны уулзалт 6, Талархлын сар 12, Миний цэцэрлэг | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгаа, хөгжлийн бодлогын зөвлөл байгуулж, дэмжиж ажиллана. | миний гудамж 14, Ногоон өнгө цогцлооё 9, Амьтны ертөнцөөр аялцгаая 15, Миний цуглуулга 8, Хоггүй хот бидний бахархал 32, Би хийж чадлаа 6, Хотын хүүхдүүд дэлхийн хүүхдүүд 6, Хоолны амт 9, Баруун гарын дүрэм 14, Дугуй, ролик, тэшүүр унаж сурцгаая 7, Театрт зочилцгооё 9, Тэмдэг тэмдэглэгээг таньж мэдье 30, Номын өргөө 8, Эрүүл мэнд эрүүл ахуй осол аюулгүйн чиглэлээр 41 хичээл тус тус хийлээ. Сэдвээ зохион байгуулах хэлбэрээр нь нийтээр 217, эцэг эхтэй хамтрах 4, ганцаарчилсан 1, эцэг эхийн группээр 3 гэж ангилан бүлгийн багш нар цахим сүлжээнд байршуулж нийт хандалтын тоо 40714, бусад 26 байгууллагуудаас гаргасан 1154 /давхардсан тоогоор/ контентыг эцэг эх, хүүхдэд мэдээлэл хүргэснээр хандалтын тоо 114687 хүрсэн байна.<br>НҮБ, Дэлхийн банкны " Боловсролын чанарын шинэчлэл төсөл, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэвлэгдсэн 492 ш "Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж" гарын авлагыг 64 цэцэрлэгт тарааж, хэрэгжүүлэх арга зүйн сургалтын 64 цэцэрлэгийн 297 багшид явуулсан. Төрийн болон төрийн бус өмчийн нийт 36 сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхэлсэн. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагад эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу 2081 суралцагч давтлагад хамрагдан, нийт 177 анги танхимын бэлэн байдал, эрүүл ахуйн байдлыг хангах талаарх заавар зөвлөмж өгч, халдвараас урьдчилан сэргийлэх нөхцөл байдлыг бүрдүүлэн зохион байгуулж байна. 523 багш 10 судлагдахуунаар сургуулийн орчинд суралцагчдад давтлага өгч, давтлагын ирц 85 хувьтай хамрагдсан. | | | | | | |
| 23 | ДЗДҮАХ-ийн 2.1.5 СӨБ, Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын чанарт тавих хяналтыг сайжруулна. | Сургалтын сайжруулсан хөтөлбөрийн хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж буй сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | Сургалтын үйл ажиллагааг зогссонтой холбогдуулан төрийн бус өмчийн 21 сургуулиуд сургалтын хөтөлбөрийн онцлогтой уялдуулан цахим хичээлийг бэлтгэн сурагчдад түгээж, арга зүйгээ хөгжүүлж байна. Төрийн өмчийн 32 цэцэрлэгийн 240 багш, хөл хорио цээрийн үед хөтөлбөрийн хүрээнд 35 контент, 597 цахим хичээл хийж, бүлгийн групп байршуулахад контентын хандалтын тоо 11136, цахим хичээлийн хандалтын тоо 51318 байна. Эцэг эх, олон нийтийн оролцоонд тулгуурлан 229 ажил зохион байгуулахад 24176 эцэг эх, асран хамгаалагчид оролцсон байна. Цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан суралцахуйн 6 чиглэлээр явагдсан Теле хичээл, цахим сургалтыг 2020 оны 2 дугаар сарын 3-наас 4 дүгээр сарыг дуустал 12 долоо хоногийн хугацаанд төрийн болон төрийн бус өмчийн 63 цэцэрлэгийн хүүхдүүдэд хүрч буй байдалд хяналт тавьж, 7 хоног бүрийн мэдээг холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна. Хөл хорионы үед 2 дугаар сард 8675 хүүхэд, 3 дугаар сард 9800 хүүхэд, 4 дүгээр сард 11558 хүүхэд тус тус теле хичээлд хамрагдаж, төрийн болон төрийн бус өмчийн 325 багш зөвлөгөө өгч, хяналт тавьж, мэдээг 7 хоног бүр Боловсролын хэлтэст цахимаар ирүүлээд байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/194 дугаар тушаалын дагуу төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн суралцагчдад зориулсан теле хичээлд 3 дугаар сард бага анги 5226 багш, 154925 суралцагч, дунд анги 10416 багш, 210337 суралцагч, ахлах анги 7758 багш, 115394 суралцагч 4 сард бага анги 4029 багш, 124697 суралцагч, дунд анги 8265 багш, 170391 суралцагч, ахлах анги 6465 багш, 101742 суралцагчид хамрагдсан.<br>Төрийн болон төрийн бус өмчийн 64 цэцэрлэгийн эрхлэгч, 38 арга зүйч нарт БШУЯ-наас зохион байгуулсан "2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл, асуудал ба шийдэл" 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, 101 хүнийг хамруулсан. Нэгж дээр зохион байгуулах сургалтад 280 багш, 1201 ажилтныг хамруулан 8-р сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн бага боловсролын сургалтын менежерүүдийн 2020-2021 оны хичээлийн жилийн сургалт арга зүйн бэлтгэл хангах “СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ЗҮЙ “сургалтыг 26 сургалтын менежерт зохион байгуулсан. Бага ангийн багш нарын 2020-2021 оны хичээлийн жилийн сургалт арга зүйн бэлтгэл хангах “СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ЗҮЙ “ сургалт 2020 оны 8 сарын 27-нд 3 бүсэд хуваарилагдан 6, 16, Эрдмийн Хөтөч Цогцолбор сургууль дээр 342 багш нарт амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтад хуваарийн дагуу 37 сургуулийн 433 багш хамрагдахаас 342 багш хамрагдаж дүүргийн хэмжээнд 78,9 хувийн ирцтэй хамрагдсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” А/17 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд теле хичээлийн зөвлөмжийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Нийслэлийн Боловсролын газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хамтран дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 66 багш, 10 удирдах ажилтнуудад “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” танхимын сургалтыг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Өндөржүүлсэн бэлэн байдлын заавар, дүрэм журмын дагуу нэг ангид 20-25 багш, 1-1,5 метрийн зайтай сууж, бөөгнөрөл үүсгэхгүйгээр нийт 55 ангид танхимын сургалтыг халдвараас урьдчилан сэргийлэх нөхцөл байдлыг бүрдүүлэн биеийн халууныг хэмжин тэмдэглэл хөтлөн зохион байгуулсан. Дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн сургалтын менежерүүдийн сургалтыг 2020 оны 08 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Нийслэлийн ерөнхий боловсролын гуравдугаар сургууль дээр зохион байгуулж дунд ахлах ангийн 44, бага ангийн 29 нийт 73 сургалтын менежерүүд хамрагдсан. Судлагдахууны сургалтыг дүүргийн хэмжээнд 2020 оны 08 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд ерөнхий боловсролын 16 сургууль дээр зохион байгуулан дунд ахлах ангийн 1033 багш, бага ангийн 433 багш, нийт 1466 багш хамрагдсан. | | | | | | |
| 24 | | Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээ, сургалтын чанарт ахиц гаргах урьдчилсан сорил, хэлэлцүүлэг, уралдаан зохион байгуулж, үнэлж дүгнэж, урамшуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | ЭЕШ-ын дүүргийн хэмжээст онооны үзүүлэлт 3 баллаар ахиж 534-д хүрсэн байна. | - | НХХ БХ | 70% | 70% |
| | | Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд дэмжлэг үзүүлэхээр Монгол ТВ болон econtent.edu.mn, eec.mn хаягаар сурагчдад цахим хичээл түгээж байна. Төрийн өмчийн 22 сургуулийн 12-р анги төгсөж буй 1796 суралцагчид давтлага хичээл зохион байгуулж байна. Суралцагчдын Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор сорилыг хэрхэн цахимаар авч буй туршлагуудыг түгээсэн. Үүний үр дүнд сургуулиуд сорилыг 379 удаа онлайнаар судлагдахуун бүрээр авч анализ хийн, мэргэжлийн багш нар 566 удаа зөвлөгөө, зөвлөмжийг суралцагчдад цахимаар дамжуулсан.<br>Төрийн болон төрийн бус өмчийн нийт 36 сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхэлсэн. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагад эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу 2081 суралцагч давтлагад хамрагдан, нийт 177 анги танхимын бэлэн байдал, эрүүл ахуйн байдлыг хангах талаарх заавар зөвлөмж өгч, халдвараас урьдчилан сэргийлэх нөхцөл байдлыг бүрдүүлэн зохион байгуулж байна. 523 багш 10 судлагдахуунаар сургуулийн орчинд суралцагчдад давтлага өгч, давтлагын ирц 85 хувьтай хамрагдсан. | | | | | | |
| 25 | | Сургалтын байгууллагуудаар хяналт шалгалт хийнэ. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг дээшлүүлэх | Боловсролын чанар хүртээмж дээшилсэн байна. | 500.0 | МХХ БХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 19-ны хүртэл хугацаанд ажлын хэсэг гарган 23 сургууль, 32 цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн. | | | | | | |
| 26 | ДЗДҮАХ-ийн 2.1.6 сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтыг дэмжиж ажиллана. | Цэцэрлэгт хамрагдаж чадаагүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувилбарт сургалтад хамруулсан байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | -Дүүргийн цэцэрлэгийн насны 13887 хүүхдээс 11885 хүүхэд буюу 86% сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, 2000 гаруй хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй байна. Иймд цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор хувилбарт сургалтаар 216-р цэцэрлэгт 16, 14-р цэцэрлэгт 72 хүүхдийн тус тус хамруулан, нийт 360 цагийн сургалтын үйл ажиллагаа зохион байгууллаа.<br>-Тусгай хэрэгцээт боловсрол олгох 186-р цэцэрлэгт 7 төрлийн бэрхшээлтэй нийт 87 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 37 хүүхдээр нэмэгдсэн байна. | | | | | | |
| | | 2.2 Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжинэ. | | | | | | |
| 27 | Соёлын тухай хуулийн 19 дүгээр зүйл; ДЗДҮАХ-ийн 2.2.1 Залуучуудыг хотын соёлд суралцуулах сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | ЕБС, их, дээд сургуулийн 600 оюутан, сурагч оролцсон байна. | 9,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | Нийслэлийн хэмжээнд "Хотын соёл" аян эхлүүлсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Хотын соёл – Хувь хүний соёлоос эхэлнэ” уриан дор аяныг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, хотдоо соёлтой амьдрах зөв дадал, хэвшил, хандлагыг бий болгох, дүүрэг, хорооныхоо өнгө үзэмжийг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог хангах, хүүхэд, залуусыг соёлч, зөв иргэн болгон төлөвшүүлэх, төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зэрэг олон талт үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/25 дугаар тушаалаар 300,000 төгрөг шийдвэрлэн, төрийн албан хаагчдаар манлайлуулан аяныг сурталчилж байна. Үүнд:<br>“Бид хотын соёл аянд нэгдэж байна”, “Би хогоо хогийн саванд хийдэг”, “Би гудамжинд нус, цэр, шүлсээ хаядаггүй”, “Би гараа байнга халдваргүйжүүлэн савандаж угаадаг”, “Би замын хөдөлгөөнийг дүрмийг мөрдөж, хөдөлгөөнд оролцдог”, “Би цэвэр, цэмцгэр хувцаслан алхах дуртай”, “Би бусдад байнга хүндэтгэлтэй ханддаг”, “Би аав, ээж, ах эгчээсээ үлгэрлэн дууриадаг”, “Би хаана ч хэзээд дараалалд зогсож үйлчлүүлдэг”, “Бид инээмсэглэн угтаж, талархалаар үддэг” гэсэн уриалга бүхий давалгааг цахим орчинд түгээн ажиллалаа.<br>Сүхбаатар дүүрэг “Бид хотын соёл аянд нэгдэж байна” давалгааг эхлүүлсэн талаархи мэдээллийг sbd.gov.mn, ulaanbaatar.mn, nsug.ub.gov.mn, zasag.mn, gogo.mn, zindaa.mn, news.mn зэрэг цахим мэдээний сайтуудаар сурталчилсан.<br>Нийслэлийн Соёл урлагийн газраас ирүүлсэн 500 ширхэг зурагт хуудас, Олон нийтийн газар байршуулах 1500 ширхэг фото стикер, Үйлчилгээний газар байршуулах 1500 ширхэг фото стикерийг 1320 аж ахуйн нэгж байгууллагуудад байршуулан, “Хотын соёл” аяныг танилцуулан аянд идэвхтэй оролцохыг уриаллаа.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 3/961, 3/962 дугаартай албан тоотоор дэргэдэх хэлтэс, албад, хороодод аяныг сурталчилсан нөлөөллийн ажил зохион байгуулж, байгууллагынхаа цахим хуудсаар сурталчилан, олон нийтэд түгээж ажиллах чиглэлийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | | | | | | |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="7">-Томуу, томуу төст өвчний тархалт болон шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор залуучуудыг амны хаалт тогтмол зүүх, хэрэглэсэн амны хаалтаа ил задгай хаяхгүй байхыг уриалсан стикэр хэвлүүлэн 50 аж ахуйн нэгж, байгууллагад тарааж, олон нийтийн газраар явахдаа амны хаалт тогтмол зүүх, гар ариутгагч тогтмол хэрэглэхийг уриалан 1.04 минутын шторк хийж, фэйсбүүк хуудсаар дамжуулан 4869 хүнд хүргэлээ.<br>-"Нийтийн соёлыг эрхэмлэдэг, хоггүй хотын иргэд байцгаая" уриан дор Туул, Сэлбэ голын эрэг дагуу амарч, зугаалж байгаа иргэд, олон нийтэд “Хоггүй зугаалах гоё” наалт бүхий хогийн уут тараан, амарч байгаа орчиндоо хог тарихгүй байх, эргэн тойрны хогоо түүж, хогийн цэг дээр хаяхыг уриалсан наалт бүхий уутыг нийт 400 хүнд тараасан.<br>-Амьдрах ухааны 12 модуль сургалтын хүрээнд “Хорт зуршлаас сэргийлэх сэдэвт 3 удаагийн сургалтыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авч буй хорихоос өөр төрлийн ялтай 10 залууг хамруулан зохион байгууллаа.<br>-Y-PEER ТББ-тай хамтран өсвөр үе, залуучуудыг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх видео контент бэлтгэн цахим орчноор дамжуулан 2,072 хүнд хүргэн ажилласан.<br>-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран “Бүтээлч залуу” онлайн үзэсгэлэн зохион байгуулах ажлын хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж байгаа “207” брэндийн үйл ажиллагааг цахим орчноор дамжуулан олон нийтэд сурталчилан ажиллаж байна.<br>-2020 оны 09 дүгээр сараас эхлэн Ерөнхий боловсролын 16 дугаар сургуультай хамтран 3 төрлийн клубыг нээн ажиллуулж 44 хүүхдийг хөгжүүлж байна. 2020 оны 10 дугаар сарын 01-ээс эхлэн Монголын хүүхдийн ордонтой хамтран алслагдсан хороодын хүүхдийн хөгжлийг дэмжих 4 төрлийн дугуйлан хичээллүүлж байна.<br>-“Нийслэлийн залуучуудын дагаж мөрдөх 10 зөв дадал”-ыг сурталчилах сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлах өдөрлөгийн хүрээнд нийт 200 оюутан залуучуудад брошур тараасан. Ерөнхий боловсролын 1,2,3,6,29,31,45,35,58,71 дүгээр сургуулийн “Сургуулийн цагдаа”-аар дамжуулан 300 брошурыг олон нийтэд тараасан. 10 дугаар сарын 15, 21-ний өдрүүдэд “Эерэг тэмүүлэл” ТББ-тай хамтран зохион байгуулсан “Нийслэлийн залуучуудын баримтлах 10 зөв дадал” сургалтад Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 1, 2 дугаар курсын 268 оюутан залуусыг хамруулсан. “Нийслэлийн залуучуудын дагаж, мөрдөх 10 зөв дадал”-ыг сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг нийт 768 хүнд хүргэсэн.</td></tr>
<tr><td rowspan="2">28</td><td rowspan="2">ДЗДҮАХ-ийн 2.2.2 Дүүргийн залуучуудын хөгжлийг дэмжин ажиллана.</td><td>"Сүхбаатар залуус" хөтөлбөрийн хүрээнд Залуучуудын эрх, хөгжил, оролцоог хангахтай холбоотой хууль, тогтоомжийг сурталчлах сургалт, тэмцээн уралдаан зохион байгуулна.</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</td><td>Дүүргийн 14-35 насны залуусыг хамруулан идэвхжүүлсэн байна.</td><td>100,000.0</td><td>НХХ</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">-Дэлхий дахинд тархаж буй Ковид-19 вирусийн эсрэг ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа дүүргийн Онцгой комисст сайн дураараа ажиллах сонирхолтой 15-34 насны залуусыг цахимаар бүртгэх ажлыг 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл зохион байгуулж, зарыг дүүргийн ГБХЗХХ-ийн фэйсбүүк хуудаст байршуулан мэдээллийг залуучуудад хүргэв.<br>-Шинэ коронавирусийн халдвар манай улсад бүртгэгдэж, улс орон даяар хөл хорио тогтоогоод байгаа энэ үед ахуйн хүрээнд архидан согтуурах зөрчил ихсэж байгаатай холбогдуулан өсвөр үе, залуучуудыг архи, согтууруулах төрлийн ундааг хэтрүүлэн хэрэглэхээс татгалзаж, "Эрүүл амьдралын хэвшилтэй иргэд байцгаая" уриан дор архи, согтууруулах ундаа борлуулах зөвшөөрөлтэй 105 дэлгүүрт "Хэтрүүлэн хэрэглэхээсээ өмнө сайн бод!" анхааруулга санамж байршууллаа.</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран “Танд хэрэгтэй мэдээлэл” подкастраар залуучуудад чиглэсэн төрөөс хэрэгжүүлж буй хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг цахим орчноор дамжуулан 1,620 иргэнд хүргэн, мэдлэг мэдээллийг нь нэмэгдүүлсэн.<br>-Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журмыг сурталчлан таниулах, өсвөр үе, залуучуудыг сайн дурын ажил хийхийг уриалж, контент бэлтгэн, цахимд орчноор дамжуулан 785 иргэнд хүргэсэн.<br>-Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хүрээнд дүүргийн залуучуудыг цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, чөлөөт цагаа хамт олноороо зөв боловсон өнгөрүүлэх, залуусыг багаар ажиллах давуу талыг ойлгуулах зорилгоор мэдээлэл, технологийн сургалтыг 2020 оны 08 дугаар сарын 24-31-ний өдрүүдэд дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, “Сайн зөвлөгөө” ТББ хамтран 20 хорооны 15-34 насны 80 залуучуудад зохион байгууллаа. Мөн хуулийн хүрээнд дүүргийн Зорилтот бүлгийн бага орлоготой залуучуудыг гэрээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор гар урлал, технологийн анхан болон ахисан шатны сургалтыг 20 хорооны зорилтот бүлгийн 20 залуучуудад дүүргийн Жижиг Дунд Үйлдвэрлэлийг дэмжих төв, “Мөнх бийр” ТББ-тай хамтран 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгууллаа.<br>-Өсвөр үе, залуучуудад зориулсан “Сүхбаатарын ирээдүй“цуврал подкаст явуулж эхэлсэн бөгөөд тус покастаар дамжуулан сэтгэцийн эрүүл мэндийн талаарх мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөөг төвийн фэйсбүүк хуудаст байршуулан, 387 хүнд хүргэж, мэдлэг мэдээллийг нь нэмэгдүүлсэн.<br>-ГБХЗХГ, Монголын Анагаахын их, дээд сургуулиудын оюутнуудын нэгдэлтэй хамтран "Эерэг хандлага-Эрүүл оюутан" аяныг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Коронавируст халдвар дотооддоо алдаж хөл хорио тогтоосонтой холбоотойгоор цахим хэлбэрээр явуулж байна. Тус аянд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллеж, МУИС, ШУТИС, МУБИС дотуур байранд амьдардаг 500 оюутныг “Дотуур байранд хөл хорионд орсон оюутнуудын групп”-т оруулан цахимаар мэдээлэл хүргэлээ. | | | | | | |
| 29 | ДЗДҮАХ-ийн 2.2.3 Дүүргийн хэмжээнд Хүүхдэд ээлтэй Улаанбаатар хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан өдөрлөг зохион байгуулна. | 20 хорооны хүүхдүүдийг хамруулэх | Хүүхэд гэр бүлдээ амар тайван амьдарч, эрүүл аюулгүй орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх, авьяас чадвараа хөгжүүлэх боломж бүрдсэн байна. | 25,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | -Дүүргийн нутаг дэвсгэрт нийт 169 талбайгаас тоглоомын талбай 130, сагсны талбай /шийт/ 28, хөл бөмбөгийн талбай 3, хоккейн талбай 1, чийрэгжүүлэлтийн талбай 7, тохижилттой талбай 18 байна.<br>-Дүүргийн зорилтот бүлгийн хүүхдүүдийн судалгааг шинэчлэв. Нийт 1758 хүүхдээс бүтэн өнчин 124, хагас өнчин 1154, хөгжлийн бэрхшээлтэй 480 хүүхэд байна.<br>- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ГБХЗХХ-ээс зорилтот бүлгийн нийт 100 хүүхэд, ДЗОУБ-тай хамтран зорилтот бүлгийн /бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй/ 550 хүүхдэд гэрээр нь бэлэг хүргэж өгөв.<br>-Коронавирусийн халдвараас сэргийлэн, Улсын онцгой комиссын тогтоолын дагуу 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хорио цээрийн дэглэмийг сунгасан тул олон нийтийг хамарсан өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулаагүй болно. | | | | | | |
| 30 | | Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг | 20 хорооны Алдарт эхийн | Алдарт эхийн одонтой эхчүүдийг | 150,000.0 | НХХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тохиолдуулан өдөрлөг зохион байгуулна. | одонтой эхчүүдэд хүндэтгэл үзүүлэх | алдаршуулсан байна. | | | | |
| | | -Дүүргийн 20 хорооны 1-р зэргийн одонтой 1877, 2-р зэргийн одонтой 5531, нийт 7408 одонтой эхчүүдийн судалгааг шинэчлэн нэгтгэсэн. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр баталсан хуваарийн дагуу Тамгын газрын албан хаагчид хорооны Засаг даргын Ажлын албатай хамтран дүүргийн Засаг даргын гарын бэлэг /Монкрем ХХК-ний бүтээгдэхүүн халгай шампуний багц/-ийг 7650 одонтой эхчүүдэд гэрт нь хүргэлээ. Дүүргийн одонтой эхчүүддээ хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаанд Засаг даргын Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 117,045,000 төгрөг зарцуулсан. | | | | | | |
| 31 | | Хүүхэд, гэр бүлд ээлтэй аж ахуйн нэгж байгууллага, Оны шилдэг хүүхэд шалгаруулна. | Өрхийн хөгжлийг дэмжин хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн ажлыг дүгнэн урамшуулах | Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, үйлчилгээ, орчин болон сурлага, урлаг, спортын амжилт гаргасан сурагчдыг урамшуулсан байна. | 6,000.0 | НХХ ГБХЗХХ | 100% | 100% |
| | | -Хүүхэд, гэр бүлд ээлтэй аж ахуйн нэгж байгууллага шалгаруулах уралдааны удирдамж, постор, шторкийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, 20 хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн пейж, фэйсбүүк хуудас, sbd.gov.mn, sukhbaatar.child.gov.mn цахим хуудсанд байршуулан 14500 иргэнд хүргэсэн.<br>-Хүүхэд, гэр бүлд ээлтэй аж ахуйн нэгж байгууллага шалгаруулах уралдааны удирдамжийг дүүргийн 20 хорооны ЗДАА-д, 28 сургуульд, 40 цэцэрлэгт, 2 ОУ, ТББ-д, 3 банканд, 10 хоолны газар/ресторан/-д, 12 худалдааны газарт, 16 аж ахуйн нэгжид нийт 131 байгууллагад хүргэсэн.<br>-Дүүргийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/297 дугаар захирамжаар Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага шалгаруулах ажлын хэсгийг байгууллаа. Аж ахуй нэгж, байгууллагуудын материалыг 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хүлээн авч Ажлын хэсэг шалгаруулан, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт шалгарсан 7 байгууллагын материалыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн ажилласан.<br>-Архи, тамхины хор уршиг нь хүний бие махбодид хэрхэн нөлөөлдөг, түүнээс үүдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай видео хичээлийг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран бэлтгэн Гэр, бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн фэйсбүүк хуудсаар дамжуулан 1450 хүнд хүргэн ажилласан.<br>-Дүүргийн нутаг дэвсгэрт орцны жижүүрээр ажилладаг иргэдийн 130, Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж байгаа 200, Манай гэр асрамж, халамжийн төвд амьдарч байгаа 12, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авсан ГБХЗХХ-ийн хяналтанд байдаг 50, Амжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн 28 нийт 403 хүүхдэд коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гар ариутгагч, маск, амин дэм тус бүр 130 ширхэгийг тараасан.<br>- Дэлхий дахинд шинэ коронавирусын халдвар тархалт эрчимжиж байгаагаас урьдчилан сэргийлж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан сурагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор шүлэг болон гар зургийн уралдаан зохион байгуулсан. Уралдаан | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тус бүрдээ 3-5, 6-8, 9-11, 12-14 насны ангилалаар явагдаж нийт 350 хүүхэд оролцсоноос 27 хүүхэд шагналт байранд тодорхойлон өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан. | | | | | | |
| 32 | ДЗДҮАХ-ийн 2.2.4 Гэр бүлийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана. | Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг гэр бүлүүдэд зохион байгуулна. | Гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлага, зан үйлийн боловсролыг дээшлүүлэх | Нийт 800 гэр бүлийг хамруулж, гэр бүлийн боловсролыг дээшлүүлсэн байна. | 8,500.0 | НХХ | 100% | 100% |
| | | -Сарын сүүлийн Ням гаригийг Гэр бүлийн өдөр болгож, гэр бүлийн харилцаа, эцэг эх хүүхдийн үүрэг, хүүхдийн хүмүүжил, хариуцлагатай аав, ээж зэрэг 5 төрлийн мэдээллийг хорооны мэдээллийн самбараар дамжуулан иргэдэд түгээж байна.<br>-Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан пэйж хуудсаар дамжуулан "Үлгэрч аав, ээж" шүлгийн уралдаан зохион байгууллаа.<br>-Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй зорилтот бүлгийн 1 өрхөд 5 ханатай монгол гэр бэлэглэв.<br>-Коронавируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэн, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаан загалмайн хороотой хамтран зорилтот бүлгийн /орлого багатай, хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн, хууч өвчтэй, бага насны олон хүүхэдтэй, олон ам бүлтэй/ иргэдэд тусламж үзүүлж, тэдний дархлааг дэмжих зорилгоор 2020 оны 04 дүгээр сарын 28, 29, 30-ны өдрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй 318 хүүхдэд хүнсний болон дархлаа дэмжих бүтээгдэхүүний багц олголоо. Энэхүү үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын 2020 оны А/09 дүгээр захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын А/29 дүгээр тушаалаар 13,687,000 төгрөгийн төсөв зарцуулав.<br>- Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Дэлхийн Зөн Монголд Олон Улсын байгууллагатай хамтран 6 хорооны зорилтот бүлгийн /олон хүүхэдтэй, өрх толгойлсон, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой/ 250 өрхөд 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүнсний багц бүтээгдэхүүн гардуулан өглөө.<br>-Байгалийн давагдашгүй хүчин зүйл, хүчтэй аадар борооны улмаас үерт өртөж, орон гэр нь эргэн сэргээн засах боломжгүй, зайлшгүй дэмжлэг шаардлагатай 20 дугаар хорооны 5 өрхөд дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран дүүргийн Засаг даргын дүүргийн Засаг даргын 2020 оны А/246, А/247, А/248 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/58, А/59, А/60, А/61 дүгээр тушаалаар хөрөнгө шийдвэрлэж, 5 ханатай иж бүрэн гэр, зуух, гал тогооны тавилга, хүнсний багц тус тус олгов.<br>-Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийг үндэслэн КОЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр, Гүүд Нэйборс болон Ногоон Ази ОУБ-уудын Монгол дахь төлөөлөгчийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран хэрэгжүүлэх "Ковид-19 цар тахлыг даван туулах чадавхийг дэмжих" бодит тусламж үзүүлэх төсөлд хамрагдах гэр хорооллын 11 хорооны зорилтот бүлгийн 800 өрх /нэн ядуу/-ийн дэлгэрэнгүй мэдээллийг асуумжийн дагуу шалгуурт нийцүүлэн гаргаж, 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүллээ.<br>-Цагдаагийн байгууллагын хэмжээнд "Харилцаа-Хандлага" сэдэвт нэг сарын аяны хүрээнд дүүргийн Засаг дарга хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан дүүрэг дэх Замын Цагдаагийн хэлтсийн 10 зохицуулагчийн хүүхдэд хичээлийн хэрэгсэл хүлээлгэн өгөв. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | | - 1-20 дугаар хороодын байранд гэр бүлийн өдрийн самбар байршуулан ажиллаж, 50 мэдээ мэдээллийг байршуулан, цахим орчинд гэр бүлийн өдрийн 2 постор байршуулж 500 иргэнд мэдээ мэдээлэл хүргэсэн.<br>-Дэлхийн гэр бүлийн өдрөөр 2 өрхөд 5 ханатай монгол гэр авч өгсөн.<br>-Шинээр гэр бүл болж буй 17 хосод гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, гэрлэлтийн баталгааг гэрлэх ёслолын ордонтой хамтран гардууллаа. Мөн гэр бүлийн боловсрол олгох цуврал 5 цахим хичээлийг бэлтгэж 14560 хүнд хүргэж ажилласан.<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтран баталсан “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж”-ын хүрээнд “Хүүхэд, гэр бүлийн эрсдлийг тодорхойлж, зураглал гаргах түргэвчилсэн үнэлгээний 12130 ш судалгааг программд бүртгэлжүүлэн 12130 өрхөд анхааруулга зөвлөмж тараан ажилласан.<br>- Угийн бичиг хэрхэн хөтлөх талаар танхимын 2 удаагийн сургалтад 30 иргэн, цахим сургалтыг Шинэ үе оюуны тайлал ТББ-тай хамтран видео хичээлийг бэлтгэн, байгууллагын цахим хуудаст байршуулан “Байгууллагын эцэг эхийн зөвлөл”, иргэд, гэр бүлүүдэд цахим хэлбэрээр хүргэж, нийт 510 хүнд хүргэсэн. | | | | | | |
| 33 | ДЗДҮАХ-ийн 2.2.5 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг эрчимжүүлнэ. | Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлж, үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Эмэгтэйчүүд, хүүхдүүдийг аюулгүй орчинд хамгаалан ажиллах | Хүчирхийллийн хохирогчдын аюулгүй байдлыг хангаж, дахин эрсдэлд өртөх нөхцөлөөс хамгаалсан байна. | 5,000.0 | НХХ ГБХЗХХ | 100% | 100% |
| | | - Хүүхдийн тусламжийн утас-108-д ирсэн нийт 397 дуудлага мэдээлэлд хамтарсан багийн бүрэлдэхүүнээр аюулын зэргийг тодорхойлон, нөхцөл байдлын үнэлгээ хийж, гэр бүл, хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэн, аргазүйн зөвлөгөө өгч, холбон зуучилж ажилласан.<br>-НҮБ-аас хэрэгжүүлж буй төслийн санхүүжүүлтээр хүүхэд хамгаалах байранд засвар, тохижилтын ажил хийгдэж, 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр нээлтээ хийлээ. Хүүхэд хамгаалах байрны үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаан ажиллаж байна.<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж буй “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчид туслалцаа үзүүлэх” нь төслийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтад 2020 оны 08 дугаар сарын 27,28-ны өдрүүдэд сургуулийн нийгмийн ажилтан болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэнг хамруулаа.<br>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаарх шторк мэдээллийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн цахим хуудсанд байршуулан 12000 хүнд хүрч ажилласан.<br>-Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхэд 70, насанд хүрсэн 45, нийт 115 иргэнд сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн. | | | | | | |
| 34 | | Эрүүл мэндийн төвд байрлах нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчдэд сэтгэл заслын үйлчилгээ болон шаардлагатай үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлнэ. | Үйлчлүүлсэн иргэдийн тоо | Хүчирхийлэлд өртсөн иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлсэн байна. | 5,000.0 | НХХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн Нэг цэгийн үйлчилгээ” нэртэй цахим хуудсыг ажиллуулж, тогтмол зөвлөгөө, мэдээлэл өгч байна. Тус хуудсаар “Бэлгийн мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүдэд тусламж үзүүлэх нь, “Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлье” эцэг, эхчүүдэд өгөх зөвлөмж, “Өсвөр насны охидод өгөх зөвлөмж” сэдэвт зөвлөмжүүдийг байршуулж, нийт 540 хүн үзэж 53 удаа хуваалцсан байна.<br>-Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төвд 2020 оны 9 сарын байдлаар 46 иргэн /насанд хүрсэн 26 эмэгтэй, 2 эрэгтэй, хүүхэд-18\ үйлчлүүлсэнийг хорооны хамтарсан багаар шийдвэрлэж, 108-д шилжүүлсэн кейс 2, эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд 30, хамгаалах байранд 12 үйлчлүүлэгчийг 24-72 цаг байрлуулсан байна.<br>-Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэлтэс, хороодын хамтарсан багтай хамтран ажиллах гэрээний дагуу 7,11,12, 15,16,18 дугаар хорооны 6 үйлчлүүлэгчид аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ хийж, асуудлыг шийдвэрлэсэн.<br>-Хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд хүчирхийллийн улмаас үүсэн сэтгэлзүйн гэмтэл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, сэтгэлзүйн боловсрол олгох замаар амиа хорлох сэдлийг бууруулах, хүчирхийллийн харилцааг зөв аргаар таслан зогсоох, шийдвэр гаргах чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Сэтгэлд дотно үйлчилгээ” төсөл бичиж, дүүргийн Эрүүл мэндийн даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 225 дугаар албан бичгээр дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлсэн.<br>-Улсын онцгой комиссоос 8 сая төгрөгний мөнгөн тусламж үзүүлснийг Монгол улсын Шадар сайдын 2020 оны 52 дугаар тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/160 дугаар тушаал, дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны А/74 дүгээр тушаалын дагуу Ковид-19 халдвараас сэргийлэх ариутгал халдваргүйтлийн бодис, маск болон хамгаалах өрөөний урсгал засвар, тохижилт, хоол хүнс зэрэг шаардлагатай зүйлс авах бэлтгэл хангагдсан. | | | | | | |
| 35 | ДЗДҮАХ-ийн 2.2.6. Хорооны хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулж, хараа хяналтгүй болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг шуурхай хамгаалах үйлчилгээг сайжруулна. | Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна. | Хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх арга хэмжээг улирал бүр зохион байгуулж, хамтарсан багийн үйлчилгээ үзүүлэх | Хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоог бууруулсан байна. | 8,000.0 | НХХ ГБХЗХХ | 100% | 100% |
| | | -Дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Тээврийн цагдаагийн албатай хамтран дүүргийн нутаг дэвсгэр байрлах томоохон зах худалдааны төв, иргэд олноор цуглардаг газар 7 буудал, 32-ын тойрогт байрлах PC тоглоомын газар, авто угаалгын газар, Багшийн дээд, “Шангрила” зочид буудлын орчмоор хараа хяналтгүй хүүхэд илрүүлэх арга хэмжээг 2020 оны 3, 5, 8, 9 дугаар саруудад зохион байгуулж, 23 хүүхдийг илрүүлэн бүртгэлжүүлж, эцэг, эхэд нь сануулах арга хэмжээ авч хүлээлгэн өгсөн. Үүнээс дүүргийн харьяалалтай 5 хүүхэд, харьяаллын бус 18 хүүхэд байна.<br>-Орц, хонгилд амьдарч байгаа болон орцны жижүүрээр ажиллаж буй 0-17 насны хүүхэдтэй гэр бүл 107, хүүхэд 133, хүүхэдгүй гэр бүл 74, нийт 181 гэр бүлийн судалгаа гаргасан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Дэлхийн Зөн Монголд Олон Улсын байгууллагатай хамтран 6 хорооны зорилтот бүлгийн /олон хүүхэдтэй, өрх толгойлсон, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой/ 250 өрхийн хүүхдүүдэд 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдөр хичээлийн хэрэгсэл гардууллаа.<br>-Хүүхдийн түр хамгаалах байраар нийт 71 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажилласан. Үүнээс: 58 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэн, 7 хүүхдийг асрамж халамжийн төв, 6 хүүхэд хамгаалах байранд байрлав.<br>-Хүүхэд хамгааллын Able программд 473 хүүхдийг бүртгэлжүүлэн, 100 хүүхдийг эрсдэлийн даатгалын үйлчилгээнд хамруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан. | | | | | | |
| 36 | | Хорооны хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллана. | Кейс дээр ажиллах аргачлал, зааварчилгаа өгч, явцын үйл ажиллагааг дэмжих | Хамтарсан багийн үйл ажиллагаа тогтворжин нийгмийн ажил үйлчилгээ иргэндээ шууд хүрсэн байна. | 20,000.0 | НХХ ГБХЗХХ | 100% | 100% |
| | | -Хүүхдийн тусламжийн утас болон иргэнээс ирсэн нийт 397 кейс мэдээлэлд хороодын хамтарсан багтай хамтран үйлчилгээ үзүүллээ.<br>-Хүүхдийг ивээх сантай хамтран 16, 17 дугаар хорооны хамтарсан багийн 12 гишүүнийг хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ур чадварыг нэмэгдүүлэх 1 өдрийн сургалтад хамруулсан.<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан “Гамшгийн үед нийгмийн сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх нь” сургалтад 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдөр хорооны нийгмийн ажилтнуудыг хамрууллаа. Сургалтаар Нийгмийн сэтгэлзүйн дэмжлэг, Гамшгийн үеийн нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, Гамшгийн үед өөрийгөө халамжлахуй /Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь дүрийн тоглолт, сургалтын дараах тест болон сэтгэл ханамжийн судалгаа/ зэрэг мэдлэг, мэдээлэлтэй боллоо.<br>-Нийслэлийн Засаг даргын А/1051 дугаар захирамжид заасан “Ковид-19 цар тахлыг даван туулах чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах арга зүйн сургалтад 20 хорооны нийгмийн ажилтнуудыг 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр хамрууллаа .<br>- Японы хүүхдийг ивээр сан болон Нийслэлийн Цагдаагийн газартай хамтран 1-20 дугаар хорооны хамтарсан багийн гишүүдийг ажлын байран дээр нь чадавхижуулах сургалтад хамруулсан.<br>-Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Асуудал ба шийдэл хамтарсан багийн ур чадварын тэмцээнд дүүргийн 1 хорооны хамтарсан баг оролцож, илтгэлийн уралдаанд 1 дүгээр хорооны нийгмийн ажилтан амжилттай оролцож, нийслэлд 2 байр эзэлсэн. | | | | | | |
| | | 2.3 Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг сайжруулна. | | | | | | |
| 37 | ДЗДҮАХ-ийн 2.3.1 “Насан туршийн боловсролын төв”-өөр олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй | Насан туршийн боловсролын төвийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Засварын ажлын явц, үйл ажиллагааны хувиар | Сургалтын орчин нөхцөл сайжирсан байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | Насан туршийн боловсролын төвийн сургалтын орчинг 25.3 сая төгрөгийн хөрөнгөөр тохижуулсан. “Хотын соёл” мэдээллийн цагийн цахим хичээл, контент, зөвлөмж, уриалгыг багш суралцагчдад түгээж ажилласан.<br>Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх зорилгоор хөл хорио тогтоосонтой холбоотойгоор 2-5 дугаар сард дүйцсэн хөтөлбөрийн 3, иргэдийн сургалтад зориулсан 12 теле хичээлийг зохион байгуулж ажиллалаа. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхэд, иргэдэд сургалтыг онлайн хэлбэрээр явуулах үйл ажиллагааг дэмжин, шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | Насан туршийн боловсролын төвд 145 суралцагч суралцсанаас 29 суралцагч суурь боловсрол, 27 суралцагч бүрэн дунд боловсрол эзэмшсэн. Төгсөгчдөөс 3 суралцагч элсэлтийн ерөнхий шалгалтыг өгсөн байна. 2020-2021 оны хичээлийн жилд шинээр сургууль завсардсан болон суурь бүрэн дунд боловсрол эзэмших хүсэлтэй 30 суралцагчийг бүртгэн зохих түвшний шалгалтыг авч бага боловсролд 8, суурь боловсролд 10, бүрэн дунд боловсролд 12 суралцагч элсэн суралцсан. Энэ хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн Бага боловсролд 23 суралцагч, Суурь боловсролд 52 суралцагч, Бүрэн дунд боловсролд 42 суралцагч хамрагдан суралцаж байна. | | | | | | |
| 38 | ДЗДҮАХ-ийн 2.3.5 Сургалтын орчинг сайжруулах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Дүүргийн төсвийн байгууллагын санхүүгийн ажилтнуудад мэргэжлийн байгууллагаар сургалт, тэмцээн зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Туршлага судлах сургалтад хамрагдсанаар иргэдэд санхүүгийн чиглэлээр мэдээ, мэдээлэл өгөх нөхцөл бүрдсэн байна. | 9,000.0 | СТСХ | | Үнэлэх болом жгүй |
| | | Улсын хэмжээнд бэлэн байдал зарлаж, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хийгдээгүй. | | | | | | |
| 39 | | Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод мэдээлж, цахим хуудас болон байгууллагын самбарт байршуулна. | 100 | Төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг байгууллагын самбар болон цахим хуудсанд байршуулснаар дүүргийн иргэдэд төсвийн зарцуулалтын ил тод байдал хангагдсан байна. | - | СТСХ | 100% | 100% |
| | | Төрийн өмчид сургууль, цэцэрлэгийн 4 дугаар улиралын байдлаар төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлага, орлогын мэдээг сар бүр тулган баталгаажуулж иргэд олон нийтэд ил тод мэдээлэх буюу дүүргийн вэб сайт болон шилэн дансны сайтад байршуулан дараа жилийн төсвийн төслийг шилэн дансны хуулийн дагуу хугацаанд нь мэдээлэн ажиллаж байна. | | | | | | |
| 40 | ДЗДҮАХ-ийн 2.3.6 Хүүхэд тоглох явцдаа хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ. | Цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд "Хурд" спорт өрөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хүүхдийн хөгжлийг дэмжсэн байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | Монголын спорт өрөлтийн холбоотой хамтран 24, 51, 109, 225, 135, 216, 217, 160, 143-р цэцэрлэгийн нийт 18 багшийг 9,603,000 төгрөгийн зардлаар сургагч багшаар бэлтгэж, хамтран ажиллах гэрээ байгуулан, 3500 гаруй хүүхдийн оюуны хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 41 | | Өсвөрийн шигшээ багийн багш, дасгалжуулагч, тамирчдыг хот, улс, олон улс, тив, дэлхий, олимпын аварга шалгаруулах тэмцээнүүдэд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Өсвөрийн шигшээ багийг дэмжсэн байна. | 30,000.0 | НХХ БТСХ | 100% | 100% |
| | | Үндэсний бөхийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 10 дугаар сарын 24-ний өдөр 58 дугаар сургуулийн зааланд 16,17,18 гэсэн 3 насны ангилалаар зохион байгуулж, нийт 11 сургуулийн 47 тамирчин оролцож, багийн дүнгээр Спортын Төв Сургууль, 71, 58-р сургуулиуд шалгарсан.<br>Улсын аварга шалгаруулах тэмцээн Булган аймагт 2020 оны 10 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохиогдож, 16,17,18-насны ангилалд Сүхбаатар дүүргээс 3 тамирчин 1 дасгалжуулагч оролцсоноос 16 насанд IX байр, 17 насанд XIII байр, 18-н насанд III байр эзэлж, багийн нэгдсэн дүнгээр 30 байгууллагаас VI байр эзэлсэн байна.<br>Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 онд баг, тамирчид олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээн уралдаанд оролцоогүй болно. | | | | | | |
| 42 | НЗДҮАХ-ийн 4.4.6 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 2.4.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжинэ. | Оюутны спортын V дугаар их наадмыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан оролцоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хүүхэд, залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | 30,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх боломжгүй |
| | | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Сайдын 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн Оюутны спортын V дугаар их наадам зохион байгуулах тухай А/493 дугаар тушаал гарсан боловч, коронавирус (COVID-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамж, нийслэлийн Онцгой комисс, дүүргийн Онцгой комиссын тогтоол, шийдвэрүүдийн дагуу нийтийг хамарсан тэмцээн, уралдаан зохион байгуулахыг хориглосон. | | | | | | |
| 43 | | Өсвөрийн шигшээ баг тамирчдыг спортын, хэрэглэл материалаар хангах, бэлтгэлийн орчинг сайжруулах арга хэмжээ авна. | Өсвөрийн шигшээ багийг уулын дугуй, явган аялалын үүргэвч, теннисний шал болон бусад эд материалаар хангах | Өсвөрийн шигшээ багийг дэмжсэн байна. | 30,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх боломжгүй |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан зохион байгуулагдаагүй. | | | | | | |
| 44 | | Хүүхэд, залуучуудын үүсгэл санаачилгын клуб, дугуйлангийн | Үйл ажиллагааны | Хүүхэд, залуучуудад чиглэсэн үйл | 20,000.0 | НХХ БТСХ | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | хэрэгжилт хувиар | ажиллагааг зохион байгуулсан байна. | | | | Үнэлэх болом жгүй |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй нийт 15 фитнес клуб, ерөнхий боловсролын сургуулийн 19, их дээд сургуулийн 7 спорт заал, 12 усан бассейн үйл ажиллагаа явуулдаг. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг тамирчдыг бэлтгэх зорилготой бокс, ширээний теннис, чөлөөт бөх, хөл бөмбөгийн тус бүр 1, нийт 4 клуб, дугуйлан байна.<br>Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан тус клуб, дугуйлангуудад сургалт, тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй болно. | | | | | | |
| 45 | ДЗДҮАХ-ийн 2.4.3 Эко сургууль, Ногоон цэцэрлэг байгуулах аяныг хэрэгжүүлж, бодлогыг дэмжинэ. | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхэд, сурагчид, эцэг эхчүүдийн сайн дурын клуб, бүлгүүдийг байгуулж, дэмжиж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Сайн дурын үйл ажиллагааг дэмжсэн байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | Мод тарих бүх нийтийн өдрийг тохиолдуулан “Усан бөлбөө” ХХК-тай хамтран 45, 58-р сургууль, 16, 69,160-р цэцэрлэгийн хашаанд 35 шилмүүст, 1000 гаруй бутлаг ургамал, хөрс олгож, тариалах аргачлал, арчилгаа тордлогыг зааж сургаж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. | | | | | | |
| 46 | | Сургууль, цэцэрлэгүүдийн эко орчин бүрдүүлэх гадна орчны тохижилтын ажлыг хийнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Орчны тохижилт сайжирсан байна. | - | НХХ БХ | 100% | 100% |
| | | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сурах орчин нөхцөл сайжруулах, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2, 130 дугаар цэцэрлэгийн сантехник, цахилгаан, агааржуулалт, барилгын их засвар хийж, 4, 31 дүгээр сургуулийн цонх, сантехник, урлаг заалны засвар хийсэн. Мөн 6, 31, 35, 58, 71 дүгээр сургуулийн сургалтын самбар, 51 дүгээр цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилсэн. Ерөнхий боловсролын 35, Эрдмийн хөтөч цогцолбор сургуульд хүүхдийн автобус шинээр олгож, 31, 58 дугаар сургуулийн гадна спортын талбайг тохижуулсан. | | | | | | |
| 47 | ДЗДҮАХ-н 2.4.4 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг бүрэн хангахад чиглэгдсэн арга хэмжээ, туршлагыг нэвтрүүлж, аюулгүй орчин бий болгоно. | Сургууль цэцэрлэгийн бүсийн хүүхдийн аюулгүй байдлыг хангаж урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж ажиллана. | Хүүхдийн тоглоом, тоног төхөөрөмжүүдийн эвдрэл гэмтэл аюулгүй байдлыг стандартын дагуу болгох | Эрсдэлт орчин буурсан байна. | 500.0 | МХХ ТНААХ | 100% | 100% |
| | | Монгол улсын Ерөнхийлөгчийн 10 дугаар зарлиг, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 30, 62 дугаар тогтоол, Улс, Нийслэл, Дүүргийн онцгой комиссын хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын А/108, 166, 168, 223 дугаар захирамж, Засгийн газрын үндэслэн томуу, томуу төст өвчлөл, тархалт болон коронавирусын халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ЕБС, цэцэрлэгүүд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд, дээд боловсролын байгууллагууд, бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газрууд, өдөр өнжүүлэх төвүүд, хүүхэд харах үйлчилгээний газруудад хяналт тавин ажиллаж байна. НМХГ-н дарга, дэд даргын мэдэгдэлийг ЕБС 47, СӨБ 66, их дээд сургууль 18, МСҮТ 5 нийт 136 газарт тарааж ажиллалаа. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | | НМХГ-ын дэд даргын баталсан 02-02/12 дугаар удирдамжийн хүрээнд МУБИС-ын харъяа Ерөнхий боловсролын сургууль, Биеийн тамир спортын дунд сургууль, 131, 71, 58, 31, 35 дугаар дунд сургуулийн ойролцоо үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ нийт 26 аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар бүтээгдэхүүний хэрэглэж дуусах хугацаа нь хэтэрсэн 12 нэр төрлийн 25 ширхэг 65.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг устгалд оруулж, шинжилгээ сорилтын бичиг баримтгүй, шошгын зөрчилтэй “Даниста бэйкери” ХХК-ийн Горзок нэрийн 56 ширхэг, “Гайхамшигт 4 улирал” ХХК-ийн 17 ширхэг наполеон торт, “Русская зима” ХХК-ний 10 ширхэг печень, 27 ширхэг медовик нэрийн тортыг татан авалт хийлгүүллээ. Хяналт шалгалтын явцад 81 зөрчил илрүүлж, 68 зөрчил буюу 84 хувийг арилгуулж, илэрсэн зөрчилд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 2 аж ахуйн нэгж, 7 иргэнд нийт 2200.0 мянган төгрөгний шийтгэл ногдуулж, бүрэн барагдуулан ажиллалаа.<br>МХЕГ-ын даргын 01/197 дугаар “Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын орчинд худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” тухай удирдамжийн хүрээнд Сүхбаатар дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй ЕБС, их дээд сургуулиас 150 метрийн радиуст байрлах 4 хүнсний худалдааны газар, 41 ТҮЦ-дэд худалдаалж буй хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийлээ. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 207 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хоол үйлчилгээнд хэрэглэхийг хориглох хүнсний түүхий эд бүтээгдэхүүн” болох энгийн нүүрс ус ихтэй бүтээгдэхүүн 10-25, кремтэй бүтээгдэхүүн 3-6, лаазалсан бүтээгдэхүүн 5-8, майонез 2-3, өтгөрүүлсэн сироп, жүүс 5-7, хийжүүлсэн ундаа 5-15, кофе 5-6, хоол амтлагч 3-11, хайрсан боорцог 2, шар цавуу 1-2, гутлын тос 1-2, согтууруулах ундаа 8-16 нэр төрөл худалдаалагдаж байна. Хяналт шалгалтаар нийт 149 зөрчил, дутагдал илрүүлэн 88 буюу 59 хувийг арилгуулан ажиллалаа. Иргэн Б.Одгэрэлийн ТҮЦ-т худалдаалж байсан 6 нэрийн 63700 төгрөгийн БНХАУ-д үйлдвэрлэсэн хүчиллэг чихэр, пирошки зэргийг буцаан татан авалт хийлгэсэн. НМХГ-ын даргын 02-01/2776 тоот “Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэх тухай” мэдэгдлийн хүрээнд 36 ЕБС-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийж, 1 байгууллагад Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 1000.0 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч эрх бүхий албан тушаалтаны албан даалгавар хүргүүллээ. Шалгалтанд хамрагдсан газруудад “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5021:2019 стандарт, “Ковид-19”-ийн үеийн халдвар, хамгааллын дэглэм”, “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн”, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөгөө өгч, “Хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч танд” сэдэвт ном, гарын авлага, сургалтын материалыг тараан ажиллалаа. | | | | | | |
| 2.5 Хүүхэд, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | | |
| 48 | ДЗДҮАХ-ийн 2.5.4 Өсвөр насны хүүхдүүдийн эрүүл мэндийн боловсролд анхаарч халдварт өвчин, хорт зуршлаас урьдчилан сэргийлж ажиллана. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдаас "Үе тэнгийн сургагч багш" бэлтгэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна. | Сургагч багшийн тоог 2 дахин нэмэгдүүлэх | Үе тэнгийн сургагч багш үеийн хүүхдүүдэд нөлөөлөл ихэссэн байна. | 2,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | -Улсын Онцгой Комиссын шийдвэрээр 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан төлөвлөгдсөн сургалт хойшлогдсон тул Өсвөр үеийн кабинетаар үйлчлүүлсэн 579 өсвөр насны хүүхэд, эцэг эхчүүдэд ганцаарчилсан сургалт зөвлөгөө өгч, гарын авлага тараасан. Үүнээс: Өсвөр насны 36 хүүхдэд томуу, томуу төст өвчин, 472 хүүхдэд коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, 23 хүүхдэд эрүүл зөв хооллолт, 19 хөвгүүдэд архи тамхины хор нөлөө, дэлгэцийн донтолт, 29 охидод хөхөө зөв шалгах, эрүүл нөхөн үржихүйн эрүүл мэнд ганцаарчилсан сургалтыг, ханын самбар, биет ашиглаж зохион явуулсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төвтэй хамтран Ражив Гандийн нэрэмжит ҮУПТК-ийн 60 эмэгтэй, 60 эрэгтэй нийт 120 оюутан залууст “Охидын нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Өсвөр насны жирэмслэлт”, “Хөвгүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвүүдээр 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж бэлгэвч 90 ширхэг, жирэмслэлтээс сэргийлэх эм 20 тр, гарын авлага 180 ширхэгийг тараасан.<br>-Ерөнхий боловсролын сургуулийн ангийн сурагчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох зорилгоор харьяа Монгол-Хятад найрамдал сургууль болон 29-р сургуулийн ахлах ангийн 75 хүүхдээс сэтгэл гутрал, сэтгэл түгшилт илрүүлэг судалгаа авсан. Судалгааны үр дүнд 88% нь сэтгэл гутралгүй гарсан. Сэтгэл түгшилтийг сургуулиар нь харьцуулж үзэхэд Хятад-Монгол найрхи боловсролын сургуулийн хүүхдүүдийн 66,8% нь сэтгэл түгшилтийн 1-р зэрэгтэй, 29-р сургуулийн сурагчдын 61,5% нь сэтгэл түгшилтийн 2-р зэрэгтэй гарсан. Судалгааны үр дүнг үндэслэл сурагчдад стресс бухимдлаа тайлах энгийн аргууд сурталчилгааны материал тарааж, сэтгэл зүйчийн зөвлөгөө шаардлагатай 21 хүүхдийг ЭМТ-д сэтгэлзүйн тусламж үйлчилгээнд хамруулсан. | | | | | | |
| 49 | НЗДҮАХ-ийн 4.3.1 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.5.6 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд, залуучууд, иргэдийн авьяасыг нээн хөгжүүлж, урлаг соёлын үйл ажиллагааг дэмжинэ. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Хүрэл тулга 2020” уралдаан зохион байгуулна. | Хүүхэд, багачуудын авьяасыг нээж хөгжүүлэх | Улс, нийслэлийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан байна. | 4,000.0 | НХХ | | Үнэлэх боломжгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан зохион байгуулагдаагүй. | | | | | | |
| 50 | | ЕБС-ийн сурагчдын дунд хүүхдийн найрал дуу зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Тэмцээн зохион байгуулсан байна. | 6,000.0 | НХХ | | Үнэлэх боломжгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагаа зогсож, олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан 10 дугаар сард зохион байгуулагдах байсан хүүхдийн найрал дууны наадмыг нийслэлийн Соёл урлагийн газраас хойшлуулж, 2021 оны хавар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | | | | | |
| 51 | | Дээлтэй Монгол наадам зохион байгуулж, оролцоно. | Соёлын аялал жуулчлалыг сурталчлах | Үндэсний өв соёлыг хадгалж, түгээн дэлгэрүүлсэн байна. | 8,000.0 | НХХ | | Үнэлэх боломжгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан зохион байгуулагдаагүй. | | | | | | |
| 52 | НЗДҮАХ-ийн 1.4.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.5.7 Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө, дурсгалт газруудын соёлын | Нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгалт газруудын хадгалалт хамгаалалтыг сайжруулах төлөвлөгөөт хяналт, шалгалт зохион байгуулж, угаалга, цэвэрлэгээний ажлыг тогтмол хийнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалын арчлалт, хамгаалалтыг сайжруулж, угааж, арчин нөхөн сэргээсэн байна. | 10,000.0 | НХХ | 100% | 100% |

| | | |
|---|---|---|
| | аялал жуулчлалын ажлыг дэмжинэ. | -Дүүргийн хэмжээнд байгаа 42 хөшөө, дурсгалт газарт кадастрын зураглал хийлгэж, Засаг даргын 2020 оны 01 сарын 06-ны өдрийн 1/20 дугаартай албан тоотоор дүүргийн Газрын албанд газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлжүүлэх тухай хүсэлт хүргүүлсэн.<br>-Нийслэлийн Соёл урлагийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/42 тоот албан бичгийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Ханддоржийн өргөө, Дамбадаржаалан хийд, Нэгдүгээр сургууль, Чойжин ламын сүм музей, Үндэсний номын сан, Хүүхдийн урлан бүтээх төв, Дашчойлон хийд, Улсын драммын эрдмийн театр зэрэг түүх соёлын дурсгалт барилга, байгууламж, сүм хийдийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалтай танилцаж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон ажиллалаа.<br>-Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах нийт 52 түүх соёлын дурсгалт газрын судалгаа, бүртгэлийг шинэчлэн, нийслэлийн Захирагчийн албаны Хот тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэст хүргүүлсэн.<br>-Сүхбаатарын талбайн өмнөх цэцэрлэгт хүрээлэнд хийгдсэн тохижилтын ажлын явцад эрсдэл учирч болзошгүй байсан Авто замын сүлжээний эхлэл цэг, Төрийн дуулалт хөшөө, Энхтайвны хонх зэрэг хөшөө, дурсгалын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллах тухай дүүргийн Засаг даргын 2020 оны 04 сарын 08-ны өдрийн 1/719 дугаартай албан тоотыг Хот байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлэн, хяналт тавин ажиллаж, хөшөө дурсгалуудын аюулгүй байдлыг хангаж ажилласан.<br>-Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02-03/1380 удирдамжийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын хөшөө, дурсгалт 52 газрын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавин ажиллалаа. Хяналт, шалгалтаар хөшөө дурсгалуудын хадгалалт хамгаалалтын байдалд нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас үнэлгээ хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн.<br>-Дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах түүх, соёлын дурсгалт зүйлийн хамгаалалтын бүс болох Дамбадаржаалан хийдийн ойролцоо “Аргал ойл” ХХК-ны шатахуун түгээх станц ажиллаж байгаа нь соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх заалтыг зөрчиж байгаа тул дүүргийн Засаг даргын 08 дугаар сарын 10-ны өдрийн 1/1646, 1/1647 тоот албан бичгээр тус шатахуун түгээх станцын удирдлагад болон хорооны Засаг даргад гал гарах эрсдлээс сэргийлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэл хүргүүллээ. Мөн дүүргийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 1/1649 тоот албан бичгээр 20 дугаар хорооны Засаг даргад тус хорооны нутаг дэсвсгэрт байрлах Долоон хонхорын зарим хонхор хэсгүүдэд үүссэн хог хаягдлыг иргэд, цэвэрлүүлэн, хяналт тавин ажиллах чиглэл хүргүүлсэн.<br>-Дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дашчойлон хийдийн баруун талд байрлалтай түүх соёлын дурсгалт Эх дагины аймгийн дуганы барилга 2012, 2016 оны мэргэжлийн хяналтын дүгнэлтээр ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон боловч, тус барилгад Монголын ахмад циркчдийн холбоо үйл ажиллагаа явуулж, циркийн жүжигчид бэлтгэл, сургуулилт нууцаар хийж, хууль зөрчиж байсан тул дүүргийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 1/1645 тоот албан бичгээр үйл ажиллагаагаа нэн даруй зогсоохыг анхааруулав. Мөн нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт тус байгууллагын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч өгөх тухай дүүргийн Засаг даргын 1/1650 тоот албан бичиг хүргүүлэн ажилласан.<br>-Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас 9 дүгээр сарын 27-ний өдөр зохион байгуулсан уулзалтад дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын дургалт газруудын хадгалалт, хамгаалалтын байдалд хэрхэн хяналт тавьж ажиллаж байгаа талаар илтгэл танилцуулсан. |
| ГУРАВ. АМЬДРАХАД ТААТАЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ | | |
| 3.1 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | НЗДҮАХ-ийн 5.4.4 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.1.3 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, хяналтын камерыг нэмэгдүүлнэ. | Камерын арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | 124 байршлын 276 камерын арчлалт хамгаалалтыг хэрэгжүүлэх | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 309,622.3 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орчны хяналтыг сайжруулах зорилгоор ашиглаж байгаа 354 ширхэг хяналтын камерын арчлалт хамгаалалтыг сайжруулж, ашиглагчаар Би энд Эн ХХК-тай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Зарцуулсан хөрөнгө 177 000 000 төгрөг | | | | | | |
| 54 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | 6310 гэрлийн арчлалт хамгаалалтыг сайжруулах | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 944,971.0 | ТНААХ | 90% | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 6130 ширхэг гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалтыг Гэрэлтүүлэг чимэглэл ХХК, Би Эм Жи Эл ХХК, ДМТМ трейд ХХК-иуд хариуцан ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт, арчлалт хамгаалалтын ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу сард 3 аас доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу засвар үйлчилгээг тогтмол хийж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн асалт 99,1%-тай байна. Зарцуулсан хөрөнгө 791.199.085 төгрөг | | | | | | |
| 55 | | Гэрэлтүүлгийн шонг кодолж мэдээллийн санд бүртгэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Дүүргийн нутаг дэвсгэр дээрх 6310 гэрлийн мэдээллээр мэдээллийн бааз үүсгэсэн байна. | 31,550.0 | ТНААХ | | 70% |
| | | Нийслэлийн хэмжээнд гэрэлтүүлэг, хяналтын камерыг нэгдсэн стандарын дагуу ижил тэмдэглэгээ хийж, мэдээллийн сан үүсгэхээр судалгааг Нийслэлийн мэдээлэл технологийн газар хийж байна. Тус ажлыг 2021 оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөж байна. | | | | | | |
| 56 | НЗДҮАХ-ийн 3.3.3 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.1.5 Иргэдийн саналын дагуу нийтийн эзэмшлийн талбай дахь авто зогсоол, ногоон байгууламж, сул шороон хучилт, явган хүний зам, гүүр,шат, хударг усан сангийн хэмжээг нэмэгдүүлнэ. | Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон замын засварын арчлалтыг хийнэ. | Дүүргийн 12-18 дугаар хороонд 1525м2 сайжруулсан шороон замыг засварлах | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 314,296.8 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 12 дугаар хорооны Хангайн 17, 15, 14, 9, 8, 7 гудамжнуудын уулзвар, Хангайн 8 дугаар гудамж, Хангайн 8 дугаар гудамжнаас дунд далангийн гүүр хүртэлх авто зам, 558 дугаар худгийн орчим гэх байршлуудад 730 метр замыг авто гридер ашиглан хусаж тэгшлэх, индүүдэх ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэхээр дүүргийн Засаг даргын Тамгын газартай 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 194 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тус ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр дуусч хүлээлгэн өгөөд байна. | | | | | | |
| 57 | | Нийтийн эзэмшлийн явган хүний замыг засах, арчлалт хамгаалалт хийнэ. | 1500м2 явган хүний зам засварлах | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд | 67,500.0 | ТНААХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | | | | |
| | | Бэринг ХХК засварлах шаардлагатай 738,3м2 явган замын ажлыг засварлахаар Нийслэлийн авто замын хөгжлийн газартай гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд иргэдээс ирүүлсэн засварлах шаардлагатай 258 м2 явган замын засвар үйлчилгээг хүүхдийн тоглоомын талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажилладаг аж ахуй нэгж байгууллагуудар засварларлуулсан болно. | | | | | | |
| 58 | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлаар мэдээллийн сан үүсгэж баяжуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Мэдээллийн бааз үүсгэсэн байна. | 40,000.0 | ТНААХ | | 100% |
| | | ArcGIS программ болон Google earth программд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийг тогтмол оруулсан болно. | | | | | | |
| 59 | ДЗДҮАХ-ийн 3.1.6 Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллана. | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | 1-20 дугаар хорооны 143 байршлын 120554.34м2 талбайн сүүдрэвч, 4405м2 хүүхдийн тоглоом, 380 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786м2 спорт талбайн тохижилт бүтээн байгуулалтын ажлын засвар, цэвэрлэгээ үйлчилгээг хийлгэх | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 1,029,989.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 143 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбай, засвар үйлчилгээг хийлгэхээр 10 бүс болгон Сайн сод сервис ХХК, Эй ти энд ти ХХК, Жито ХХК, Сарнайн мөнхжин групп ХХК, Мон Арден ХХК, Бэмс ХХК, Тайсун гүрэн ХХК, Эрхэт гүн Бюлдинг ХХК, Билэг фүүдс ХХК, БЧХЦ ХХК | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зэрэг Аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Зарцуулсан хөрөнгө 822,231,900 төгрөг | | | | | | |
| 60 | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн усан оргилуурын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | 12 усан оргилуурын засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг хариуцан байнгын ажиллагаатай болгох | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 73,700.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт 20 усан оргилуур байдгаас 17 усан оргилуур цагийн хуваарийн дагуу хэвийн ажиллаж эхэлсэн. Үүнд:<br>1-р хороо Шангри-Лагийн урд усан оргилуур, 7-р хороо 4, 6 дугаар байрны дунд усан оргилуур, 1-р хороо Гранд хаан айриш паб усан оргилуур, 1-р хороо Гэрлэх ёслолын ордон усан оргилуур, 1-р хороо Үндэсний соёл амралтын хүрээлэн усан оргилуур, 6-р хороо Хүүхдийн урлан бүтээх төв усан оргилуур, 8-р хороо Улаанбаатар зочид буудалын урд усан оргилуур, 1-р хороо Контининталь зочид буудал усан оргилуур, 1-р хороо Драмын театрын усан толио, 10-р хороо Хилчин СӨХ усан оргилуур, 8-р хороо Монгол туркын цэцэрлэг усан оргилуур, 2-р хороо 31, 32 дугаар байрны хойд талын усан оргилуур, 5-р хороо 39 дүгээр байрны хойд талын усан оргилуур, 4-р хороо Цэрэндоржийн гудамжны усан оргилуур, 6-р хороо 6/2 байрны усан оргилуур, 7-р хороо Сити их сургуулийн усан толио, Усан оргилуурын арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байгаа СӨХ-н зүгээр усан оргилуурын ашиглалтын зардлал олгож өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу ашиглалтын зардлыг тооцон олгохоор болсон<br>Дүүргийн Засаг даргын тамгын газар Саут воли ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан засварлах шаардлагатай 1-р хороо 24-р байрны урд усан оргилуур,2-р хороо 27-р байрны урд усан оргилуур, 5-р хороо 39 байрны урд усан оргилуур, 7-р хороо 6 байрны дундах усан оргилуур, 10-р хороо 37 байрны урд усан оргилуур, 24 байрны усан оргилуурын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн болно . Зарцуулсан хөрөнгө 8,452,250 төгрөг | | | | | | |
| 61 | | Багшийн дээдийн нүхэн гарцны урсгал засварын ажлыг хийнэ. | Нүхэн гарцны гэрэл засвар, цахилгааны шидны засвар, дотор засварын ажлыг хийх | Иргэдийн аюулгүй, тав тухтай зорчих нөхцөл бүрдсэн байна. | 20,000.0 | ТЗУХ ААТ | 35% | 40% |
| | | Нүхэн гарцны шатсан гэрэл сольж, цахилгааны засвар хийгдсэн. 4 дүгээр улиралд урсгал засварын ажил хийдэхээр төлөвлөж байна. | | | | | | |
| 62 | ДЗДҮАХ-ийн 3.1.8 Сууц өмчлөгчдийн холбоодын хариуцлагыг өндөржүүлж, үйл | Сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалт хийх болон шилдэг тохижилттой иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулж урамшуулна. | 188 сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалтын | Шилдэг тохижилттой СӨХ шалгаруулан иргэдийн эрүүл аюулгүй орчинд | 11,000.0 | ТНААХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг дэмжиж ажиллана. | | ажлыг зохион байгуулах | амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | | | | |
| | | Нийслэлийн засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээ”-ний тухай А/1358 дугаар захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах А/10 дугаар захирамж гарч Ажлын хэсэг байгуулагдан Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2020 оны 02 дугаар 12-ны өдрийн Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэг зохион байгуулах удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн 1-11 дүгээр хорооны орон сууцны хороолуудад үйл ажиллагаа явуулж байгаа Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, түвшин тогтоох ажлыг зохион байгуулж ажиллалаа. Хяналт шалгалтын ажлын хүрээнд 16836 өрхийн эрх ашгийг хариуцан ажиллаж байгаа 147 Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг шалгаж түвшин тогтоох ажлыг зохион байгуулсан бөгөөд 51 СӨХ бүрэн хангалттай /86-100 оноо/, 56 СӨХ хангалттай /71-85 оноо/, 40 СӨХ хангалтгүй /71-ээс доош оноо/ үнэлгээ авсан байна. | | | | | | |
| 63 | | Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, хууль сурталчлах сургалт зохион байгуулна. | 188 сууц өмчлөгчдийн холбооны удирдах ажилтанд хууль сурталчлах сургалт зохион байгуулах | Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаа сайжирсан байна. | 6,350.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирлуудад хяналт шалгалтын ажилтай холбоотой мэдээлэл өгөх хурлыг зохион байгууллаа. Хуралдаанд 112 СӨХ-ны дарга оролцож, Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамж, хяналт шалгалтын ажлын удирдамжийг танилцуулж, Улаанбаатар лифт НӨҮГ, Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл, Хувийн орон сууц нийтийн аж ахуйн хөгжлийн төв зэрэг орон сууц нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас мэдээлэл хийлээ. | | | | | | |
| 3.2 Иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулна. | | | | | | | | |
| 64 | НЗДҮАХ-ийн 5.4.7, 5.4.10 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.1 Гэнэтийн аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлнэ. | Нийтийн эзэмшлийн авто замын хальтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлнэ. | Нийтийн эзэмшлийн 4449777 м2 зам талбай хальтиргаа гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлэх | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 160,000.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Зам талбайн хальтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэхээр 2019-2020 онд нөөцөлсөн давс, тусгай бодисийн үлдэгдэл давс 27,96 тонн, тусгай бодис 4,9 тонн байгаа бөгөөд дүүргийн Хот тохижуулалтын зардлаар 75 тонн давс, 65 тонн тусгай бодис авч дүүргийн хэмжээнд энэ онд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, замын хальтиргаа гулгааг арилгах ажлын хүрээнд давс -129 тонн, тусгай бодис 95 тонн-г нөөцлөөд байна.<br>Ажилчдын ажлын багаж хэрэгсэл 100 хувь хангагдсан болно. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | | Шар ус болон үерийн ус зайлуулах шугам сүлжээний урсгал засварын ажлыг хэрэгжүүлнэ. | Ажлын явц , хувиар | 12-18 дугаар хороодод ус зайлуулах хоолой тавих, суваг шуудуу сэргээж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 127,000.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 15 дугаар хорооны булгийн ус айл өрхийн хашаа, гудамжаар урсаж байсан баршилд 140 метр шуудуу, 18 метр ус зайлуулах ган хоолой суулгах, 18-р хорооны бэлхийн 49-р гудамж, 20 дугаар хорооны цолмонгын хэсэгт үерийн ус их хэмжээгээр урссаны улмаас эвдэрсэн 410 метр хайрган замыг сэргээн засварлах 3 байршилд голын гарамд лотки байршуулах ажлыг хийж гүйцэтгээд байна.<br>Мөн 17, 20 дугаар хороодод хийгдэх ус зайлуулах хоолой хийх далан суваг сэргээх ажилд дайрга, шороо нийлүүлэх ажлын 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 80 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээг Эмралд ланд ХХК-тай байгуулан 2020 оны 04 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд 120 м3 /11 HOWO маркын машин/ дайрга, шороог шаардлагатай байршлуудад буулган далан суваг, зам талбайг сэргээн засварлаж 2 байршилд 500мм-н ус зайлуулах ган хоолойг суулгаж, суваг шуудууг сэргээн засварлаад байна. | | | | | | |
| 66 | | Иргэд, ААН албан байгууллагад ой хээр, обектын гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээлэл өгөх, чиглэлээр ФМ, ТВ, радиогоор богино хэмээний кино, шторкийг явуулна. | ФМ, ТВ, радиогоор богино хэмжээний кино, шторк 3, явуулах давтамж 200 | Иргэд ААН албан байгууллага мэдээллээр бүрэн хангагдсан байна. | 7,000.0 | ОБХ ЗДТГ | 100% | 100% |
| | | Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх өдөрлөг, нэгдсэн арга хэмжээ, хяналт шалгалт, Пиротехникийн хэрэгслийн талаар, хүүхдийн өвлийн амралттай холбогдуулан сэрэмжлүүлэг, Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг халдвар авахаас хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээллийг SBN телевизэд 4 удаа, Парламент телевизэд 1 удаа, Монголын Үндэсний телевизэд 1 удаа, “VTV” телевизэд 2 удаа нийт 8 удаа ярилцлага өгч, Зууны мэдээ сонин, өдрийн тойм, zogii.mn сайтад тус тус 1 удаа нийт 3 удаагийн ярилцлага, Онцгой мэдээ сонинд 2 удаа мэдээ байршуулан, тус телевизүүдээр 8 удаа шторк явуулж, Sbd.nema.gov.mn сайт, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс пэйж хуудсаар 110 удаагийн мэдээллийг байршуулан, Засаг даргын Тамгын газрын гаднах урсдаг самбараар 2 удаагийн давтамжтайгаар мэдээллийг ард иргэдэд хүргэн ажиллалаа. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн телевизээр 3 удаа, Өнөөдөр сонинд 1 удаа ярилцлага өгч сэрэмжлүүлэг, шторк 3-ыг өгч нэвтрүүлэн, ОБЕГ-ын ontsgoisur.gov.mn цахим сайтад “Бэлэн бай” сургалтын багцаар зохион байгуулсан 28 удаагийн сургалтын мэдээ, Онцгой байдлын хэлтсийн sbd.nema.gov.mn веб сайтад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлгийг 135 удаа байршуулж, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн пейж хуудас, ОБЕГ-ГУСГ, НОБГ-урьдчилан сэргийлэх, Нээлттэй Сүхбаатар дүүрэг, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-20-р хорооны Пейж хуудсуудаар түгээн, мөн дүүргийн гадаах Лед дэлгэцээр 2-3 удаагийн, хэлтсийн гадаах дэлгэцээр 3-5 удаагийн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | давтамжтайгаар иргэдэд хүргэн ажиллалаа. Энэ хугацаанд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ард иргэдийн сургалтыг 4 удаа, 194 хүнийг хамруулан, 11.30 цагийн сургалт, Гамшгаас хамгаалах сайн дурын бүлгийн сургалтыг нийт 3 бүлгийн 35 гишүүнийг хамруулан 3 удаа 13 цаг нийт 7 удаа 229 хүнийг хамруулан, 24.30 цаг зохион байгуулсан. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар SBN TV-д 1 удаа ярилцлага өгч, Онцгой байдлын хэлтсийн sbd.nema.gov.mn веб сайтад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлгийг 139 удаа байршуулж, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн пейж хуудас, ОБЕГ-ГУСГ, НОБГ-урьдчилан сэргийлэх, Нээлттэй Сүхбаатар дүүрэг, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-20-р хорооны Пейж хуудсуудаар түгээн, мөн урьдчилан сэргийлэх 3 төрлийн шторкийг Тэнгис кинотеатрын дэлгэцээр 3-4 удаа олон нийтэд хүргэж ажилласан. Мөн 13 дугаар хорооны ЖДҮДТөвийн гадаах Лед дэлгэцээр 4-5 удаагийн, хэлтсийн гадаах дэлгэцээр 2-3 удаагийн давтамжтайгаар иргэдэд хүргэн ажиллалаа | | | | | | |
| 67 | | Ой хээрийн гал түймрээс гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд сургалт сурталчилгаа зохион байгуулна. | Сургалт зохион байгуулах, тоо 18 удаа | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг дээшилсэн байна. | 5,000.0 | ОБХ ЗДТГ | 100% | 100% |
| | | 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр нийслэлийн Байгаль орчны газрын Зуслангийн товчоотой хамтран дүүргийн 19 дүгээр хорооны ногоон бүс дэх “Хараацай” зуслангийн амрагч ахлах, дунд насны 40 хүүхдэд ой хээрийн түймэр, үер, усны болон болзошгүй аюулын эрсдлээс урьдчилан сэргийлэх сэдвээр 1.30 цагийн сургалтыг зохион байгуулсан. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг 18,19 дүгээр хорооны 50 иргэний хамруулан 2 удаа 2 цагийн сургалтыг зохион байгуулсан. | | | | | | |
| 68 | | Өсвөр насны болон оюутан сурагчдад чиглэсэн гамшгийг сургалтыг эрчимжүүлэх, оюутан цэрэг хөтөлбөрт гамшгийн сургалтын төлөвлөгөөг тусган сургалтыг зохион байгуулна. | Сургалт зохион байгуулах, тоо 4 хамрагдах оюутан 500 | Өсвөр насны хүүхдүүдийн гамшгаас хамгаалах мэдлэг дээшилсэн байна. | 7,000.0 | ОБХ ЗДТГ | 100% | 100% |
| | | 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр нийслэлийн Байгаль орчны газрын Зуслангийн товчоотой хамтран дүүргийн 19 дүгээр хорооны ногоон бүс дэх “Хараацай” зуслангийн амрагч ахлах, дунд насны 40 хүүхдэд ой хээрийн түймэр, үер, усны болон болзошгүй аюулын эрсдлээс урьдчилан сэргийлэх сэдвээр 1.30 цагийн сургалтыг зохион байгуулсан.<br>Тайлант хугацаанд оюутан сурагчдад 1 удаа, 40 хүүхдийг хамруулан 1 удаа 1.30 цаг зохион байгуулсан. 135, 69, 234 дүгээр цэцэрлэгийн 80 хүүхэд, багачууд, 16 дугаар сургуулийн 246, “Буратиногийн найзууд” Хүүхэд хөгжлийн төвийн 24, Этүгэн их сургууль, Сити их сургууль, Монгол улсын их сургууль, Монгол улсын Боловсролын их сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Шихихутаг хууль зүйн их сургууль, Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын дээд сургуулийн 259 нийт 609 оюутан, сурагч, хүүхэд багачуудад Улаан Загалмайн хороотой хамтран гамшгаас хамгаалах “Бэлэн бай” сургалтын багцын хичээлүүдийг ашиглан Гамшиг, “Гал түймэр”, “Газар хөдлөлт”, “Үер усны осол”, гэмтэл, бэртлийн үеийн анхны тусламжийн мэдлэг олгож, мөн гамшгийн үед амь насаа аврах талаар мэдлэг олгож, баталгааны хуудсаар сургалтыг баталгаажуулж ажиллалаа. | | | | | | |
| 69 | | Гамшгаас хамгаалах команд штабын сургалтыг хороодуудад зохион байгуулж, иргэд олон | Сургалтад хамрагдах иргэд 1000 | Иргэдийн түр хоргодох байр, нүүлгэн шилжүүлэх | 9,500.0 | ОБХ МУЗН | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нийтэд түр хоргодох байр, нүүлгэн шилжүүлэх байршил, түр цугларах цэгийн талаар мэдээлж, сургалт зохион байгуулна. | | байршил, түр цугларах цэгийн талаар мэдээлэлтэй болсон байна. | | | | |
| | | Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр баталсан “Нийслэлийн эрсдэл өндөр алслагдсан гэр хорооллын хороодын иргэдэд гамшгаас хамгаалах “Бэлэн бай” сургалт зохион байгуулах ажлын удирдамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн эрсдэл өндөр алслагдсан гэр хорооллын 18,20 дугаар хороодын иргэдэд удирдамж, хөтөлбөрийн дагуу 08 дугаар сарын 11-ний өдрөөс 08 дугаар сарын 12-ны өдрүүдэд танхимын сургалтыг 71 иргэнд зохион байгуулан ажилласан. | | | | | | |
| 70 | | Хорооны Засаг дарга, Сууц өмчлөгчдийн холбооны удирдлага, ажилчдад хог, хогийн цэгийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, гал унтраах дадлага сургууль, мөн тусгай дунд сургуулийн сурагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн,өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг эхчүүдэд гамшгаас хамгаалах сургалт, мэдлэг олгоно. | Сургалтад хамрагдах иргэд 500 | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг дээшилсэн байна. | 7,500.0 | ОБХ МУЗН | 100% | 100% |
| | | 1.2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 10.00 цагт 10 хорооны Засаг даргын ажлын алба, хороонд үйл ажиллагаа явуулж байгаа Сууц өмчлөгчдийн холбооны удирдлага, иргэд нийт 42 хүнд гамшгаас урьдчилан сэргийлэх “BE READY” сургалтын багцаас “Гал түймэр” сэдвээр танхимын сургалт орж, сургалтаар гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хуульд иргэн, аж ахуйн нэгжийн үүргийг сургалтаар танилцуулж, галын унтраагуур хэрхэн ажиллуулах талаар мэдээлэл өгч ажиллалаа. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн 9,13,15 дугаар хорооны хэсгийн ахлагч, иргэн нийт 64 хүнийг хамруулан 2 танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглах талаар мэдлэг олгосон.<br>Мөн 25 дугаар тусгай сургуулийн 32 сурагч, 186 дугаар тусгай цэцэрлэгийн 10 хүүхэд тэдний асран хамгаалагч 10 хүнд нийт 52 хүнд болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх 2 цагийн танхимын сургалтыг зохион байгуулсан. | | | | | | |
| 71 | | Байгалийн голомтот тарваган тахал болон хүн, малын гоц халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулна. | Зохион байгуулах сургалт 2 удаа, сэрэмжлүүлгийн тараах материал, зурагт самбар байрлуулах | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг дээшилсэн байна. | 8,000.0 | ОБХ МУЗН | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дүүргийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн Байгалийн голомтот тарваган тахал болон хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай А/255 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Тарваган тахал” өвчний талаар иргэдэд тодорхой мэдээллийг өгөх үүднээс тахалын тархах зам, илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдээ мэдээлэл өгөх зайлшгүй шаардлагатай байгаа үүднээс дүүргийн Онцгой байдлын хэлтэсийн алба хаагчид болон дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс хамтран тус дүүргийн 14-р хороо болох 7 буудал орчмын аж ахуй нэгж, албан байгууллага, худалдаа үйлчилгээний газруудад тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, тараах материал, хуудасыг тарааж ажиллалаа. Тус ажиллагаанд батлагдсан хуваарийн дагуу 14 хоногт нэг удаа Гал түймэр унтраах, аврах 34, 74 дүгээр ангиудын бэлтгэл ээлжийн алба хаагчид дүүргийн Цагдаагийн 2 хэлтсээс, Эрүүл мэндийн төв, Мал эмнэлэг, замын цагдаагийн алба хаагчидтай хамтарч давхардсан тоогоор 52 алба хаагч 4 удаа ард иргэдийг сэрэмжлүүлэн ажиллалаа.<br>Тус ажлын хүрээнд Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага 1400 орчимыг тарааж иргэдэд танилцуулга мэдээлэл өгсөн. Мөн 25 Аж ахуй нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний салбар, төв дээр сануулга сэрэмжлүүлэг өгч ажилласан. Тэдгээрээс мах, түүхий эдийн 12 худалдааны цэгээр орж маханд нь хяналт шалгалт хийн тарваган тахалын сэрэмжлүүлэг өгч халдварт өвчний талаар мэдээлэл өглөө.<br>Үүнд: тарваган тахалын халдвар авах боломжтой нөхцөл нь<br>o Мэрэгч амьтаны арьсанд байдаг бүүрэгэнд хазуулах<br>o Тарвага зурамны махыг дутуу боловсруулан хэрэглэх<br>o Мөн өвчтэй хүнтэй харилцах явцад халдвар авах хандлагатай бөгөөд амьсгалаар, хоол боловсруулах замаар, цусаар авч болно.<br>Халдвар авсан тохиолдолд өндөр халуурах, толгой өвдөх, дотор муухайрах, толгой эргэх, хий юм сонсох, харагдах нүүр ам улайран хавдах зэрэг байдлаар тарваган тахалын анхны шинж тэмдэг илэрдэг. Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авч ажиллах талаарх наад захын мэдээллийг өгч танилцуулсан. | | | | | | |
| 72 | | Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулах, гамшиг үүссэн үед даван туулах арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулах сургалт 2 удаа, сэрэмжлүүлгийн тараах материал, зурагт самбар байрлуулах | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг дээшилсэн байна. | 9,000.0 | ОБХ ТНААХ | 90% | 100% |
| | | Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 дугаар албан даалгавар гарсантай холбогдуулан дүүргийн Онцгой комиссын 2020 оны 03 сарын 06-ны өдрийн “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгавар гаргуулж холбогдох хэлтэс, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Удирдамж, төлөвлөгөөний хүрээнд үерийн аюултай газар буусан айл өрхүүдийн судалгааг дүүргийн Газрын албанаас гаргуулж, 13,14,15,16,17,18,19,20 дугаар хороод дээр шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2020 оны 03 дүгээр сарын 19-ний өдрөөс 03 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулан ажиллалаа. Дээрх хороодын Засаг даргын ажлын албыг цуглуулан шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар үүрэг чиглэл өгч, үерийн аюултай газар буусан дээрх хороодын нийт 264 өрхийн 498 иргэнд үерийн зам дээрээс нэн даруй нүүх “ШААРДАХ | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ХУУДАС"-ыг тарааж, мэдээлэл, санамж өгч ажиллахад Онцгой байдлын хэлтсээс давхардсан тоогоор 34 алба хаагч, хэсгийн ахлагч 18 нийт 52 албан хаагч ажиллалаа. 1. Энэ хугацаанд хуваарийн дагуу Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 11-26 УНҮ улсын дугаартай фургон загварын автомашинтайгаар давхардсан тоогоор Гал түймэр унтраах 34 дүгээр ангийн бэлтгэл ээлжийн 237 алба хаагч, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 35 дугаар ангийн 76 алба хаагч, тус дүүргүүдийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн 57 албан хаагч, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсийн 55 албан хаагч нийт 423 алба хаагч Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо Гачууртын могойтын дэнжээс Баянзүрхийн гүүр, Баянзүрхийн гүүрнээс Маршалын гүүр хүртэл Туул голын хойд, урд эргийн дагуу 2 чиглэлээр хөдөлгөөнт эргүүлийн үүргийг гүйцэтгэн ажилласан.<br>Туул голын эрэг дагуу амарч зугаалж байгаа 2208 автомашинтай 2901 хүүхдэд, 4084 том хүнийг хараа хяналтгүй голын эрэг дагуу тоглуулахгүй байх, архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх хэрэглсэн тохиолдолд усанд орохгүй байх, олон хүн цугларч бөөгнөрөл үүсгэхгүй байх, зөв боловсон соёлтой амарч гарсан хог хаягдлаа авч явах талаар машины чанга яригчийг ашиглан хөдөлгөөнт сэрэмжлүүлгийг хүргэж, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас гаргасан "Би хариу цлагатай аав, ээж" санамж, үер усны аюулаас урьдчилан сэрэмжлүүлэг заавар зөвлөмж бүхий 4420 тараах материал боршурыг тарааж, 38 тээврийн хэрэгслийг уснаас татаж гаргасан.<br>2. Дүүргийн Засаг даргын 2020 оны "Үер усны ослын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" А/233 дугаар захирамжийн хүрээнд 14,16 дугаар хороод дээр үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2020 оны 07 дугаар сарын 30-ны зохион байгуулж үерийн аюултай газар буусан дээрх хороодын нийт 51 өрхийн 82 иргэнд үерийн зам дээрээс нэн даруй нүүх "ШААРДАХ ХУУДАС"-ыг тарааж, мөн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх 150 ширхэг сэрэмжлүүлэг тарааж ажиллахад Онцгой байдлын хэлтсээс давхардсан тоогоор 18 алба хаагч, хэсгийн ахлагч 3 нийт 21 албан хаагч ажиллалаа.<br>3.Нийслэлийн Онцгой байдлын газраас өгсөн үүргийн дагуу гол усны ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хүүхдийг хараа хяналтгүй эрсдэлтэй газар гол, нуур, цөөрөм, тогтоол усны орчимд явуулахгүй, тоглуулахгүй байх, хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах талаар Гал түймэр унтраах, аврах 34,35 дугаар ангийн автомашины чанга яригчаар нийт 12-14 удаа Туул голын эрэг орчмоор зугаалж байгаа иргэдэд хүргэж ажилласан. | | | | | | |
| 73 | Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоол; Гамшгийн Эрсдлийг олон нийтийн оролцоотой үндэсний хөтөлбөр; ДЗДҮАХ-ийн 3.2.1 Гэнэтийн гамшиг осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлнэ. | Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Хэн хэзээ ч хаана ч бэлэн бай" сургалт дадлагыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэнэ. | Сургалт зохион байгуулах 24 удаа 2000 иргэдийг хамруулах | Иргэдийн өөрийгөө болон бусдыг хамгаалах ур чадвар нэмэгдсэн байна. | 9,000.0 | ОБХ МУЗН | 100% | 100% |
| | | Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын Онцгой комиссын шийдвэрээр нэгдсэн арга хэмжээ цуцлагдсантай холбогдуулан сургалт дадлагыг 4 дүгээр улиралд зохион байгуулахаар ажиллаж байна. 2020 оны 09 дүгээр сарын 03,07-ны өдрүүдэд дүүргийн Улаан Загалмайн хороотой хамтран 13,15 дугаар хорооны гамшгаас хамгаалах сайн дурын бүлгийн гишүүн 25 иргэнийг хамруулан гамшгаас хамгаалах "Бэлэн бай" сургалтын багцын хичээлүүдийг ашиглан Гамшгаас хамгаалах тухай хууль эрх зүйн орчин, Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоо, Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам, Гамшгийн тухай ерөнхий ойлголт, "Гал түймэр", "Газар хөдлөлт", "Үер усны осол", Аянга цахилгаанаас урьдчилан сэргийлэх, Ахуйн хэрэглээний химийн бодис материалын зохистой хэрэглээ, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулахад хувь нэмрээ оруулах, Ой, хээрийн түймэр, "Анхны тусламж"-ийн видео хичээл, Гэмтэл, бэртэл, живэх, түлэгдэх үеийн анхны тусламж, зүрх уушигны сэхээн амьдруулалтыг онол болон дадлагыг | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 74 | | хослуулан 11 цагийн сургалтыг дүүргийн Улаан Загалмайн хороотой хамтран зохион байгуулсан. Сургалтын төгсгөлд “Бэлэн бай” сургалтын Сургагч багшаар сургагдсан “Гэрчилгээ” олгосон. Гамшгаас хамгаалах менежмент, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэг олгох сургалтыг Удирдах ажилтны сургалтыг 1 удаа 17 хүнд, байгууллага аж ахуйн нэгжийн ажилтан албан хаагчдад 24 удаа, 1163 хүн, иргэдэд 2 удаа 50 хүнд, оюутан сурагчдад 14 удаа 662 хүнд нийт 41 удаа зохион байгуулж эдгээр сургалтанд нийт 1892 хүн хамрагдсан. | | | | | | |
| 74 | | Зуслангийн газруудын орц гарцыг гал унтраах автомашин саадгүй нэвтрүүлэх боломжтой болгоно. | Зуслангийн 50-аад хэсгүүдэд | Гамшиг осол болон, гал түймэр гарсан үед шуурхай ажиллагаа хангагдсан байна. | 8,000.0 | ОБХ | 100% | 100% |
| | | Ногоон бүсийн зусланд газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай НЗД-ын 2020.04.06-ны өдрийн А/454 дүгээр захирамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо, Гоодойн амны зусланд 2020 оны 6 дугаар сарын 16, 18-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн онцгой байдлын хэлтэс, Газар зохион байгуулалтын албатай хамтран зохион байгуулан ажиллалаа.<br>Тус зуслангийн бүсэд 11 байршилд орц, гарц гаргахаар суурин судалгаа хийн газар дээр нь ажиллаж, 8 дугаар байршилд буюу 2019 онд өнжмөл шар өвснөөс үүсэлтэй гал түймэр гарсан газарт 4 хаалга гаргаж, Гойдоон зуслангийн байршил буюу ойн сан бүхий газарлуу гарах хэсгийн орц, гарцыг гаргах 1 нэгж талбарт шаардах хуудас өгч ажиллалаа. | | | | | | |
| 75 | | Гэр хорооллын мухар гудамж бүхий хэсгүүдийг эмх цэгцтэй болгоно. | Судалгаагаар 42 мухар гудамж | Иргэдийн галын аюулгүй байдал хангагдсан байна. | 10,000.0 | ОБХ | 40% | 40% |
| | | Дүүргийн хэмжээнд гэр хорооллын 8-н хороонд 152 мухар гудамжны судалгааг гарган, газрын албатай хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | | | | | |
| 76 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл 32.1.1, 32.1.9 дэх заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.1 Гэнэтийн гамшиг осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлнэ. | Хавар, намрын хуурайшилттай үед, ой хээрийн түймрийн эрсдэл бүхий хэсгүүдэд урамшуулалтай морин эргүүл болон байнгын харуул пост ажиллуулна. | Хуурайшил бүхий үед 5-н сар ажиллуулах | Ой хээрийн түймрийн байгаль экологид учрах тоо хохирол буурсан байна. | 8,000.0 | ОБХ | 100% | 100% |
| | | Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01, Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны 1/01, нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар, Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Өнжмөл шар өвсний түймэр гарахаас урьдчилан сэргийлэх тухай” А/487 тоот захирамж, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн “Нийслэлийн ногоон бүсийг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавих тухай” А/25 дугаар тушаал, дүүргийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 03 дугаар албан даалгавар, Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/124, “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулах шалгалт зохион байгуулах тухай” А/133 дугаар захирамжийн хэрэгжилтүүдийг хангаж ажилласан. Нийслэлийн Онцгой байдлын газрын удирдах ажилтны шуурхайгаас өгсөн үүрэг, “Эелдэг харьцааг хэвшүүлье” аяны хүрээнд Угаарын хийн хордлого, ой хээр болон шар өвсний гал түймэр, коронавирусийн халдвараас урьдчилан | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх, хүүхдийг ахуйн гал түймэр, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 7 хоногт 2-3 удаа дүүргийн нутаг дэвсгэрийн гудамж талбай, нийтийн эзэмшлийн талбай, зам гарцаар явж байгаа иргэдэд сэрэмжлүүлэг, зөвлөмжийг автомашины болон зөөврийн чанга яригчийг ашиглан олон нийтэд хүргэн ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/321 дүгээр захирамжийн хүрээнд Гал түймэр унтраах 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хөдөлгөөнт эргүүлийн үүргийг хэлтсийн офицер бүрэлдэхүүн, Гал түймэр унтраах, аврах 34,74 дүгээр ангийн бэлтгэл ээлжийн бүрэлдэхүүн 11.00- 20.00 цагийн хооронд үүрэг гүйцэтгэн ажиллалаа. Энэ хугацаанд 18,19,20 дугаар хорооны нутагт орших Бэлх, Сэлх, Хадат цуурай, Майхан толгой, Баянбулаг, Хандгайт, Яргайтын богино, Янзага зуслан зэрэг газруудын амуудаар Гал түймэр унтраах, аврах 34, 74 дүгээр ангийн давхардсан тоогоор 114 алба хаагч 54-34 УБУ улсын дугаартай Портер, 11-26 УНҮ улсын дугаартай Фургон, 10-04 Хино маркийн автомашинтайгаар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийн үүргийг гүйцэтгэн 17 зөрчлийг илрүүлэн газар дээр нь арилгуулж, энэ хугацаанд дээрх амуудад зугаалга хийж байсан 164 иргэн, 61 автомашиныг буцааж, иргэдэд ой хээр, шар өвсний түймрээс урьдчилан сэргийлэх, хүн олноор цугларсан газруудад аялал зугаалга хийхгүй, зорчихгүй байх, мөн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэхийг давхар сануулж, сэрэмжлүүлэг 480 ширхэгийг тараан ажилласан. | | | | | | |
| 77 | | Шар өвсний галын аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хавар, намрын хуурайшилтын үед хадах, түүнийг мал бүхий иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна. | Хуурайшил бүхий үед 5,9,10 дугаар саруудад ажиллуулах хүн хүч, техник, багаж худалдаж авах | Ой хээрийн түймрийн байгаль экологид учрах тоо хохирол буурсан байна. | 20,000.0 | ОБХ | 100% | 100% |
| | | Албан даалгавар, удирдамжийн хүрээнд 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хөдөлгөөнт эргүүлийн үүргийг хэлтсийн офицер бүрэлдэхүүн, Гал түймэр унтраах, аврах 34, 74 дүгээр ангийн бэлтгэл ээлжийн бүрэлдэхүүн 11.00-20.00 цагийн хооронд үүрэг гүйцэтгэн ажилласан. Энэ хугацаанд 18, 19, 20 дугаар хорооны нутагт орших Бэлх, Сэлх, Хадат цуурай, Майхан толгой, Баянбулаг, Хандгайт, Яргайтын богино, Янзага зуслан зэрэг газруудын амуудаар Гал түймэр унтраах, аврах 34, 74 дүгээр ангийн давхардсан тоогоор 442 алба хаагч, Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 130 алба хаагч нийт 755 алба хаагч 54-34 УБУ улсын дугаартай Портер, 11-26 УНҮ улсын дугаартай Фургон, 10-04 Хино, 08-03 УНҮ Ланд-80 маркийн автомашинтайгаар ой хээр, шар өвсний түймрээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийн үүргийг гүйцэтгэн шар өвсөө шатааж байсан 81 зөрчлийг илрүүлэн газар дээр нь арилгуулж иргэдэд ой, хээр, шар өвсний түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг хүргүүлэн ажилласан.<br>Дүүргийн Засаг даргын А/133 тоот “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулах тухай” захирамжийн дагуу ногоон бүсэд эргүүлийн үүрэг гүйцэтгэх 10 ААНБ-ыг томилгоожуулан амралтын өдрүүдэд ногоон бүсийн нутаг дэвсгэрт 150 км газар эргүүл шалгалтыг явуулах талаар заавар зөвлөгөө өгч ажиллуулсан.<br>Ой, хээрийн түймэр, шар өвсний түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 04 дүгээр сарын 27-ны өдөр дүүргийн 19 дүгээр хороо “Шарга морьт”-ын гүүрний дэргэд 7х3 хэмжээтэй сэрэмжлүүлэг самбарыг байршууллаа.<br>Хил залгаа Төв аймгийн Онцгой байдлын газар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүдтэй ой, хээрийн түймрийн үед хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан. Дүүргийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/124 захирамжийн хүрээнд 6.662.660 мянган төгрөгийг гаргуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үеийн ой, хээрийн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 78 | | түймрээс урьдчилан сэргийлэх самбар, сэрэмжлүүлэг тараах материал, алба хаагчдын хоол хүнс, шатахуун тос, тослох материал, дүүргийн урамшуулалт морин эргүүлүүдийг ажлуулахтай холбогдуулан морин эргүүлүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан хаврын улирлын үед ажиллах цалин хөлс, хантааз зэрэг зүйлийг шийдвэрлэж ажилласан.<br>Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын А/25 тоот “Нийслэлийн ногоон бүсийг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавих тухай” тушаалын дагуу Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажил зохион байгуулах удирдамжийн дагуу гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа Ж.Хүдэрчулуун, гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч Н.Наранзул нар дүүргийн байгаль хамгаалагч, морин эргүүлийн ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр шалгаж үүрэг чиглэл өгч ажилласан. | | | | | | |
| 78 | ДЗДҮАХ-ийн 3.2.2 Хороодод үүсэн байгуулагдсан Хөршийн холбоог нэмэгдүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана. | Байгуулагдсан хөршийн холбоог чадваржуулах, шаардлагатай хороодын холбоог шинээр нэмэгдүүлэхийн тулд цагдаагийн байгууллагатай хамтарч сурталчилгааны аян зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, нэмэгдсэн тоогоор | Гэмт хэргийн тоо буурч иргэд аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна. Хөршийн холбоог 10-аар нэмэгдүүлсэн байна. | 9,000.0 | Цагдаагийн газар ТЗУХ | 100% | 100% |
| | | Дүүргийн хариуцсан 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 27 бүлгийн 68 гишүүд хөршийн хяналтын үйл ажиллагааг хороо хариуцсан хэсгийн байцаагч, хороон цагдаа нартай хамтран зохион явуулж байгаа бөгөөд цагдаагийн байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч удирдлагаар ханган ажиллаж байна. Удирдах байгууллагаас ирүүлсэн тушаал шийдвэр, үүрэг даалгавар, Монгол Улсын хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, сурталчлах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцсан хороодын нутаг дэвсгэрт “Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх” “Хулгайчид боломж бүү олго” “Архигүй орчин”, “Анхаарал халамж-Эрсдэлгүй орчин”, “Албадан эмчилгээ”, “Сүүдэр бүү тусга”, “Камержуулалт”, “Хичээл эхэллээ” зэрэг 8 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд оролцож, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 156 цагийн эргүүлд ажиллаж, сэжигтэй хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйлийн талаарх 13 мэдээллийг өгч, хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулсан 25 ажил арга хэмжээнд оролцож, бүлгийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 8 удаагийн сурталчилгааг зохион байгуулж, согтууруулах ундааны зүйлийг хэтрүүлэн хэрэглэсэн, биеэ авч явах чадваргүй болсон, бие нь муудаж ухаангүй болсон нийт 5 хүнийг ар гэрт нь болон Яаралтай түргэн тусламж, цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, хүүхдийн тоглоомын талбай, байрны гадна, ногоон байгууламж, орц хонгил зэрэг олон нийтийн эзэмшлийн газарт бүлэг бөөгнөрөл үүсгэсэн нийт 62 тохиолдлыг хууль сануулан тарааж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 958 ширхэг зөвлөмж, санамж сэрэмжлүүлэг болон зурагт хуудсыг хариуцсан байр орчимд тарааж ажилласан байна. 3-р улиралд хөршийн хяналтын бүлгийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсны үр дүнд 1 хөршийн хяналтын бүлэг шинээр байгуулагдсан. Хөршийн хяналтын бүлэг үйл ажиллагаа явуулснаар гэмт хэргийн гаралт 2020 оны эхний 08 сарын байдлаар 1215 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 268 хэргээр буюу 18.1 хувиар буурсан байна.<br>Дүүргийн хариуцсан 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 9 бүлгийн 36 гишүүд хөршийн хяналтын үйл ажиллагааг хороо хариуцсан хэсгийн байцаагч, хороон цагдаа нартай хамтран зохион явуулж байгаа бөгөөд цагдаагийн байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч удирдлагаар ханган ажиллаж байна. Удирдах байгууллагаас ирүүлсэн тушаал шийдвэр, үүрэг даалгавар, Монгол Улсын хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, сурталчлах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцсан хороодын нутаг дэвсгэрт “Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх” “Хулгайчид боломж бүү олго” “Архигүй орчин”, “Анхаарал халамж-Эрсдэлгүй орчин”, “Албадан эмчилгээ”, “Сүүдэр бүү тусга” зэрэг 22 | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 79 | | нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд оролцож, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 242 цагийн эргүүлд ажиллаж, сэжигтэй хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйлийн талаарх 18 мэдээллийг өгч, хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулсан 25 ажил арга хэмжээнд оролцож, бүлгийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 8 удаагийн сурталчилгааг зохион байгуулж, согтууруулах ундааны зүйлийг хэтрүүлэн хэрэглэсэн, биеэ авч явах чадваргүй болсон, бие нь муудаж ухаангүй болсон нийт 18 хүнийг ар гэрт нь болон Яаралтай түргэн тусламж, цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, хүүхдийн тоглоомын талбай, байрны гадна, ногоон байгууламж, орц хонгил зэрэг олон нийтийн эзэмшлийн газарт бүлэг бөөгнөрөл үүсгэсэн нийт 31 тохиолдлыг хууль сануулан тарааж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 738 ширхэг зөвлөмж, санамж сэрэмжлүүлэг болон зурагт хуудсыг хариуцсан байр орчимд тарааж ажилласан байна. Хөршийн хяналтын бүлгийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсны үр дүнд 1 хөршийн хяналтын бүлэг шинээр байгуулагдсан. | | | | | | |
| 79 | НЗДҮАХ-ийн 5.4.3 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.3. “Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлнэ. | "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг эрчимжүүлэхийн тулд шилдэг олон нийтийн цагдаа, оюутан цагдааг шалгаруулж урамшуулж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Гэмт хэргийн тоо буурч иргэд аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна. | 8,300.0 | Цагдаагийн газар ТЗУХ | 100% | 100% |
| | | Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын хэмжээд 2020 онд нийт 15 олон нийтийн цагдаа ажилласан. Гэмт хэрэг зөрчил гарсан газар, ул мөрийг хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаагийн хамт 2051 удаа хамгаалж, архидан согтуурч биеэ авч явах чадваргүй 529 иргэнийг ар гэр, асран хамгаалагчид нь болон хэлтэс, тасагт хүлээлгэн өгч, удаа дараа архидан согтуурч, ар гэртээ агсам согтуу тавьж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж 964 иргэнийг шүүхээр оруулан 7-30 хоногийн хугацаатай баривчлуулах ажилд ахлах байцаагч, хэсгийн байцаагч нарын хамтаар ажилласан байна.<br>Дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 57 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн ажиллах түр журам”-ын хүрээнд 109 олон нийтийн цагдаа /хэсгийн ахлагч/ нарыг олон нийтийн цагдаагаар ажиллуулж, өдөр бүр үр дүнг тооцон хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцсан хороодын нутаг дэвсгэрт зохион давхардсан тоогоор нийт 79 төрлийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, 122 төрлийн нэг бүрчилсэн арга хэмжээг хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, хэв журмын урамшилт эргүүл нартай хамтран зохион байгуулж, иргэд олон нийтэд хууль эрх зүйн мэдлэг олгох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, сургалт, зөвлөгөөн зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт давхардсан тоогоор хэлтсийн 28 шаардлагыг нийт 6676 аж ахуйн нэгж байгууллага хүргүүлж, 4756 хариу авч үр дүнг тооцон ажилласан<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлснээр 2020 оны эхний 10 сард 1259 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 543 хэргээр буюу 30.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2016-2020 оны хооронд идэвхтэй оролцсон 53 иргэнийг хэлтсийн баярын бичиг болон мөнгөн урамшууллаар шагнаж урамшуулсан. 10-20 хорооны нутаг дэвсгэрийн 98 аж ахуйн нэгж байгууллагыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүлд татан оролцуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулж ажиллуулснаар гомдол мэдээлэл буюу 8.4 хувиар буурсан. | | | | | | |
| 80 | НЗДҮАХ-ийн 5.4.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.4 | Хэв журмын урамшилтай эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, эргүүлүүдийн | Урамшилтай эргүүлүүдийн цалинг олгох, | Тогтоосон квотын дагуу бүрэн Хэв журмын | 416,120.0 | ТЗУХ ХЗТ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Дүүрэгт хэрэгжүүлж байгаа хэв журмын урамшуулалтай эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | чадваржуулах зорилгоор сертификаттай сургалтад хамруулна. | сургалтад хамруулах, үнэмлэх олгох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хантааз, бусад хэрэглэлээр хангах | урамшилтай эргүүл ажиллаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирсан байна. | | | | |
| | | Хэв журмын урамшилтай эргүүлийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар 77 эргүүлийг томилсон.<br>Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолоор 2020 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 420000 мянган төгрөг байхаар шинэчилсний дагуу Хэв журмын урамшилтай эргүүлийн сарын урамшууллыг 420000 төгрөг болгож тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллав.<br>Хэв журмын урамшилтай эргүүлүүдийг ажил үүргээ биелүүлэхэд шаардагдах ажлын хантааз, үнэмлэх өгөх ажилд А/14 дүгээр тушаалаар 3496000 төгрөг зарцуулав.<br>Нийт Хэв журмын урамшилтай 9 эргүүлийг ажлаас чөлөөлж, 13 эргүүлийг шинээр ажилд томилж Хөлсөөр ажиллах гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.<br>Хороодын Хэв журмын урамшуулалт эргүүлийн эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Хууль зүйн үндэсний хүрээлэн, дүүргийн Цагдаагийн газартай хамтран 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр дүүргийн хурлын танхимд хороодын Хэв журмын урамшилтай 79 эргүүлд “Хууль бидний амьдралд” сэдэвт 2 цагийн сургалт зохион байгуулав. Сургалтаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Арга зүйч багш Б.Оюун-Эрдэнэ Зөрчлийн тухай хууль, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, дүүргийн Цагдаагийн газрын Цагдаагийн 2 дугаар хэлтсийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах Н.Энхбат гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хэв журмын урамшилтай эргүүлийн үүрэг, оролцоо, дүүргийн Хууль зүйн тасгийн дарга П.Булганмаа Жендэрийн хэвшмэл ойлголт сэдвээр тус тус мэдээлэл өглөө. Сургалтад хамрагдсан Хэв журмын урамшилтай эргүүлд 400 гаруй шинэ хууль тогтоомжийн эмхтгэл тараалаа. | | | | | | |
| 81 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйл; ДЗДҮАХ-ийн 3.2.5 Гэмт хэрэг, зөрчлийг бууруулж, иргэдийн аюулгүй байдлыг хангана. | Шүүхийн шийдвэрийг биелүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангасан байна. | 863,739.8 | ТЗУХ ХЗТ | 100% | 100% |
| | | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж 12.145.745 төгрөгийг иргэн Ц.Алтансувдад олгосон. | | | | | | |
| 82 | | Шүүхтэй холбоотой асуудлаар холбогдох зардлыг шийдвэрлэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангасан байна. | 702.0 | ТЗУХ ХЗТ | 100% | 100% |
| | | Шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамж Т.Майхүү 70200 төгрөг Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсээс олгосон. | | | | | | |
| 83 | | Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ТББ- | Эрсдэлт бүлгийн сууриь мэдээллийн | Хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдож | 5,000.0 | ТЗУХ ХЗТ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уудтай хамтарч сургалт, судалгааны ажил зохион байгуулна. | сантай болж зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн ажил үйлчилгээ үзүүлэх | болзошгүй эрсдэлт бүлгийн суурь мэдээллийн сантай болсон байна. | | | | |
| | | Дүүргийн Цагдаагийн газрын алба хаагчдад Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр тус газрын I хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батдэлгэр 1 удаа, эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа Д.Гантөмөр 1 удаа, II хэлтсийн дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Байдраг 1 удаа нийт бие бүрэлдэхүүнд сургалт орж, алба хаагчдад энэ чиглэлээр тогтмол үүрэг чиглэл өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар гаргасан гарын авлага болон холбогдох материалыг дүүргийн 1-20-р хорооны хэсгийн байцаагч нарын өрөөнд байрлуулж иргэд олон нийтэд энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл хүргэн ажиллаж байна. Уг гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа болон холбогдох бусан мэдээллийг Facbook page хуудас болон мэдээллийн сайтуудаар дамжуулан иргэд олон нийтэд тогтмол хүргэн ажиллаж байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр саун массажны газар, зочид буудал, зарын сайтуудад тогтмол хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Бүх нийтийн эрх зүйн боловсролын дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн, СБДЦГ хамтран дараах 2 сургалтын зохион байгуулав. Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар сургалтад зориулж 240000 төгрөг зарцуулав. “Сурагчдын эрх зүйн боловсролыг сайжруулах нь” сэдэвт сургалтаар Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 10 дугаар сарын 05-ны өдрөөс 12-ны өдрүүдийн хооронд дүүргийн ерөнхий боловсролын 58, Насан туршийн боловсролын төв, 35, 3, 131 дүгээр сургуулийн дунд, ахлах ангийн 420 гаруй сурагчидад “Сурагчдын эрх зүйн боловсролыг сайжруулах нь” сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтаар хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хандлага, хүүхдийн эрх, гэмт хэрэгт холбогдохоос хэрхэн өөрийгөө сэргийлэх, сэтгэцэд нөлөөт мансууруулах төрлийн хорт бодисны хор хөнөөлийн талаар 1 цагийн мэдээлэл өглөө. | | | | | | |
| 84 | | Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ТББ-уудтай хамтарч сургалт, судалгааны ажил зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан байна. | 10,000.0 | Цагдаагийн газар ТЗУХ | | Үнэлэх болом жгүй |
| | | Хүн худалдаалах гэмт хэрэг энэ онд бүртгэгдээгүй байна. Эрүүгийн цагдаагийн албанаас 2020 оны 09 дүгээр сарын 15-наас 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Улсын хэмжээнд зохион байгуулсан “Нуугдмал” арга хэмжээний салбар төлөвлөгөөг боловсруулж, хэлтсийн даргаар батлуулж дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах Төрийн болон хувийн хэвшлийн “Нийслэлийн хүрээ амаржих”, “Нийслэлийн өргөө амаржих”, “Хатагтай”, “Таны төлөө бид”, “Эвт хүч”, эмнэлэгүүд рүү албан бичиг хүргүүлж “Нийслэлийн өргөө амаржих”, “Таны төлөө бид”, “Эвт хүч”, өрхийн эмнэлэгүүдээс насанд хүрээгүй буюу 14-16, 16-18 насны жирэмсэн болсон, үр хүндүүлсэн, хүүхэд төрүүлсэн 57 охидуудын судалгааг дэлгэрэнгүйгээр гаргуулан авч ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Их дээд сургууль, Ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилчид, эмч, эмнэлэгийн ажилтнууд, баг хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтнуудтай | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уулзаж насанд хүрээгүй үедээ жирэмсэлсэн, төрсөн, үр хөндүүлсэн охид эмэгтэйчүүдийн талаар мэдээ, мэдээлэл авах зорилгоор хамтран ажиллах талаар урьдчилсан байдлаар санал солилцож сургалт семинар явуулах талаар зохион байгуулах арга хэмжээ авч байсан боловч нийслэлийн Засаг дарга А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, аялал зугаалга, урлаг, соёл, кинотеатр, жолооны курс, цахим тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоохтой холбогдуулан уулзалт зохион байгуулах арга хэмжээ түр хойшлогдсон болно. | | | | | | |
| 85 | | Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Гэр бүлийн хүчирхийлэл буурсан байна. | 10,000.0 | Цагдаагийн газар ТЗУХ | 100% | 100% |
| | | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хайр өвтгөдөггүй”, “Гэр дүүрэн инээмсэглэл” “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье”, “Дэлхийн гэр бүлийн өдөр”, “Хүүхэд илрүүлэлт”, “Сүүдэр бүү тусга” зэрэг арга хэмжээг дүүргийн харъяа хэлтэс, прокурор, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Олон нийт, хүүхэд, залуус руу чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор Засаг даргын тамгын газраас 3.000.000 төгрөгийг шийдвэрлүүлэн “Про стар” ХХК-тай гэрээ байгуулан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 төрлийн шторкийг “Про стар sound” студээр бүтээлгэж олон нийтэд хүргэх, Энх-Арслан сайттай хамтран гэр бүлийн хүчирхийллээс татгалзах хандлагыг бий болгох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоо зорилтод болон шууд, зохиомжид 14 контент мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэх нөлөөллийн ажлыг тус тус зохион байгуулсан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 130 иргэний судалгаа мэдээллийг гаргаж дүүргийн прокурор, гэр бүл хөгжлийн хэлтэстэй хамтран ар гэрээр орж асуумж санал хүсэлтийг авч дахин зөрчил гаргасан 4 этгээдийг бүртгэл судалгаанд авч хороодын хамтарсан багаар зан үйл нөлөөлөх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Мөн гэр бүлийн хүчирхийллийн онцлог болон олон давтамжтай дуудлага мэдээлэл ирүүлсэн 48 иргэний ар гэрээр тасгийн дарга, ахлах мэргэжилтэн, байцаагч нараас орж хууль, эрх зүйн талаар яриа таниулга хийсэн.<br>Гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцаа, зан үйл, харилцаа хандлагын зөөлрүүлэх, гэр бүлийн гишүүдийн хэн нэгэндээ хэлж ойлгуулж чадахгүй, хэн нэгнээсээ тогтож сонсоогүй чин сэтгэлийн үг, утга агуулга бүхий захидлыг зорилтод бүлгийн иргэдэд хүргэж эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор “Захидал” арга хэмжээг зохион байгуулж зорилтод бүлгийн 83 хүнд гэр бүлийн гишүүд, ар гэр, ойр дотнын хүнээс тухайн хүн очих чин сэтгэлийн үгтэй захидлыг авч хүргэх ажлыг зохион байгуулсан.<br>Мөн дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран 5 өрхийг сонгон гэр бүлийн таарамжгүй харилцааг үгүй болгох нөлөөллийн үйл ажиллагааг гэр бүлийг бүх гишүүдийг оролцуулан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Дээрх ажил арга хэмжээг оновчтой зохион байгуулж ажилласнаар гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэл 2019 оны 09 дүгээр сарын байдлаар 410 бүртгэгдсэн бол 2020 оны 09 дүгээр сарын байдлаар 199 бүртгэгдэж 51,4 хувиар буурсан. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчилд холбогдогчид хууль заасан шийтгэлийг 2019 онд 55 хүнд, 2020 онд 78 хүнд оногдуулсан нь 41,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | | | | | | |
| 86 | | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд сар бүр иргэдэд үнэгүй | Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний зөвлөлийн 2019 оны 04 дүгээр | Эрх зүйн хөтөчийн ажиллах үйл ажиллагааны зардлыг шийдсэн байна. | 10,000.0 | ТЗУХ ХЗТ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрх зүйн зөвлөгөө өгч, хууль сурталчлах хүрээнд боршур, гарын авлага хийлгэж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан орон нутагт сургалт сурталчилгаа хийнэ. | тогтоолын хүрээнд Эрх зүйн хөтчийн ажиллах журмын хэрэгжилт хангагдах | | | | | |
| | | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд Эрх зүйн хөтчөөр бэлтгэгдсэн 13 нийгмийн ажилтны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эрх зүйн хөтчөөр ажиллах тухай арга хэмжээг тусгаж иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөөг хүргэх ажлыг эрчимжүүлсэн.<br>Эрх зүйн хөтөчийн ажиллах үйл ажиллагааны зардал 10 сая төгрөгийг дүүргийн 2020 оны Үндсэн чиглэлд тусгаж батлуулсан.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран 2020 оны 02 дугаар сарын 21-ний, 10 дугаар сарын 22-ны өдөр тус тус дүүргийн Нэг цэгийн төв дээр “Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө” өгөх өдөрлөг зохион байгуулав. Нийт 90 гаруй иргэдэд үнэгүй хууль зүйн зөвлөгөө өглөө. Мөн 05 дугаар сарын 20-ны өдөр 19-17 цагийн хооронд “Иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд Шинэ төрлийн коронавирусын халдвартай холбоотойгоор иргэдэд 75050801, 75050802, 75050803, 75050804 дугаарын утаснаар анхан шатны хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг үнэ төлбөргүй өглөө. Төрийн мэдээлэл сэтгүүлийн 43 дугаарыг 20 хороонд тарааж шинээр батлагдсан хууль, тогтоомжуудыг сурталчиллаа.<br>Шинэ Covid-19 өвчний улмаас Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 62 дугаар тогтоол, 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 64 дүгээр тогтоол, 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны Иргэдийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/108, Иргэдийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай А/223, Коронавируст /КОВИД-19/ халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай А/436, Захирамжид өөрчлөлт оруулах тухай А/590, А/752, А/930 дугаар захирамжийн дагуу олон хүн цуглуулах, танхимын сургалт зохион байгуулах үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон тул иргэдэд зориулсан сургалт хийгдээгүй. | | | | | | |
| 87 | | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд сар бүр иргэдэд үнэгүй эрх зүйн зөвлөгөө өгч, хууль сурталчлах хүрээнд боршур, гарын авлага хийлгэж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан орон нутагт сургалт сурталчилгаа хийнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Эрх зүйн хөтөчийн ажиллах үйл ажиллагааны зардлыг шийдсэн байна. | 12,000.0 | Цагдаагийн газар ТЗУХ | 100% | 100% |

<table>
<tr><td></td><td rowspan="3"></td><td colspan="7">Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор ерөнхий боловсролын 26 сургуулийн 12560 сурагч, 21 их, дээд сургуулийн 9870 оюутан, 87 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 750 ажилтан, алба хаагчдад нийт 75 удаагийн сургалтыг зохион явуулсан.<br>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол гэмтэл, хорт зуршил, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн хэлтэс, сургуулийн захиргаа, нийгмийн ажилтан, эцэг эхийн зөвлөлөөс ахлах ангийн сурагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэн ахлах ангийн сурагчдаас анги хамт олноороо бага, дунд ангийн сурагчдад зөв үлгэр дуурайл үзүүлэх, зөвлөн чиглүүлэх, буруу, зөв үйлдлийг дүү нартаа ойлгуулах, олон нийтийн газар биеэ зөв боловсон авч явах дадал хэвшилд суралцахад чиглэгдсэн “Бид дүү нартаа зөв үлгэр дууриал үзүүлнэ” нөлөөллийн аяныг ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн сурагч, анги удирдсан багш, нийгмийн ажлтныг хамруулан зохион байгуулсан. Үр дүн, үр нөлөө: Ахлах ангийн буюу 12 дугаар ангийн 18 бүлгийн 630 сурагчаас ангийн багш, нийгмийн ажилтантай хамтран бага, дунд ангийн 7860 сурагчид “Хорт зуршлаас-Хол явцгаая”, “Харилцааны эерэг хандлага”, “Ахмад хүн, найз нөхдөө хүндлэх”, “Биеэ хэрхэн зөв авч явах” зэрэг сургалт, харилцан ярилцлагыг зохион байгуулж сурагчдаас санал асуулга авч хорт зуршлаас өөрийгөө хэрхэн хамгаалах мэдлэгийн төвшинг тогтоох, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт”, “Тусламж үйлчилгээг хаанаас авч болох” талаар жүжигчилсэн тоглолт, зурган хэлбэр, эрх зүй, эрх үүргийг сонирхолтой хэлбэрээр тайлбарлан үзүүлэх, Замын хөдөлгөөний дүрэм, өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах талаар “АХА” тэмцээнийг хүүхэд багачууд, дүү нарынхаа дунд зохион байгуулж өргөмжлөл гардуулж, амттанаар урамшуулсан.<br>Түүнчлэн “Болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга замууд” сэдвээр ханын самбарыг сонирхолтой баримт, зурагт хуудас, хөгжилтэй байдлаар дүү нартаа ойлгомжтой хэлбэрээр, бүтээлч санаачлагаар гаргаж сургуулийн мэдээллийн самбарын дэргэд байршуулсан нь сургуулийн орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, үе тэнгийн гадуурхалыг үгүй болгоход үр дүнгээ өгсөн.</td></tr>
<tr><td rowspan="2">88</td><td>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран уралдаан, тэмцээн, хэлэлцүүлэг зохион байгуулна.</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</td><td>Иргэдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажил эрчимжиж, гэмт хэргийн гаралт буурсан байна.</td><td>10,000.0</td><td>Цагдаагийн газар ТЗУХ</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих прокуроруудтай хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүндэрч буй бэрхшээл, зөрчлийг шийдвэрлэлтийг ахиулах, сайжруулах чиглэлээр санал хүсэлтийг солилцон, цаашид хийх ажлыг тодорхойлсон. Зөвлөгөөнд тус хэлтээс 6 алба хаагч оролцсон ба гарсан шийдвэр нь хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан үндэслэлээр зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгохгүй байх, зөрчлийн бүртгэл судалгааг хөтлөх 1 алба хаагчийг томилж, бүртгэлийг сайжруулах, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны гаргаж байгаа шийдвэрийг дугаарлаж ирүүлэх, үүнийг архивын нэгж болгох гэсэн 3 төрлийн шийдвэр гарсан. Мөн дүүргийн прокурорын газраас зохион байгуулсан сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд 1 эмэгтэй, 1 эрэгтэй баг 14 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр амжилттай оролцсон.<br>Тус дүүргийн 10-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчилд холбогдон саатуулагдсан 1652 иргэнд урьдчилан сэргийлэх зорилгоор 87 төрлийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан ажилласан. Тухайлбал: Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэнд архи согтууруулах ундааны хор уршиг, зөрчлийн тухай хуулийн</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдох заалтуудаар 83 удаагийн сургалт орсон. Дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Мүгэн фүүдс ХХК-ны 22 ажилтан, ЗСНБ ХХК-ны 83 ажилтанд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт орсон. 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран 2020 оны эхний хагас жилд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаарх зөвлөгөөнийг зохион байгуулан ажилласан.<br>2020 оны 09 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн Прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих прокуроруудтай хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүндэрч буй бэрхшээл, зөрчлийг шийдвэрлэлтийг ахиулах, сайжруулах чиглэлээр санал хүсэлтийг солилцон, цаашид хийх ажлыг тодорхойлсон. Зөвлөгөөнд тус хэлтсээс 75 алба хаагч оролцсон ба гарсан шийдвэр нь хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан үндэслэлээр зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгохгүй байх, зөрчлийн бүртгэл судалгааг хөтлөх 1 алба хаагчийг томилж, бүртгэлийг сайжруулах гэсэн 2 төрлийн шийдвэр гарсан. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдад зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийг алба хаагчдад танилцуулж, нэгдсэн бүртгэл судалгааг бичээчээр хөтлүүлж 7 хоног бүрийн баасан гарагт дүүргийн прокурорын газарт хүргүүлж байна. | | | | | | |
| 89 | | Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ТББ-уудтай хамтарч сургалт, сурталчилгаа зохион байгуулах, тараах материал бэлтгэж зах худалдааны төвүүдэд байршуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан байна. | 9,000.0 | Цагдаагийн газар ТЗУХ | 100% | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулж буй 34 иргэн, аж ахуй нэгж байгууллагууд Монгол Улсын Засгийн Газрын тохируулагч агентлаг Стандарт хэмжил зүйн газраас 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 35 дугаар тогтоолоор батлан гаргасан “Барьцаалан зээлдүүлэх нийтлэг шаардлага MNS:5274-2017 заавал дагаж мөрдөх стандарт-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.<br>Цагдаагийн ерөнхий газрын харъяа Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын даргын баталсан “Мөнгө Угаалт, Хяналт”, “Хуурамч мөнгө” зэрэг нэгдсэн арга хэмжээ зохион явуулах удирдамж, төлөвлөгөөний дагуу хариуцсан нутаг дэвсгэртээ зохион байгуулсан.<br>Тус газрын I, II хэлтсээс хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг давхардсан тоогоор 23 арилжааны банк, 9 банк бус санхүүгийн байгууллага, 25 барьцаалан зээлдүүлэх газар, 17 гадаадын хөрөнгө оруулалттай газруудын дэлгэрэнгүй судалгаа, байршлыг гарган ажилласан. Дүүргийн 1-ээс 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкууд, Банк бус санхүүгийн байгууллагууд, Барьцаалан зээлдүүлэх газрууд, гадаадын хөрөнгө оруулалттай газруудад Мөнгө угаах, Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбогдох өндөр эрсдэлтэй төр, олон нийт, хувийн өмч хөрөнгийг завших, үрэгдүүлэх, залилах, нийгмийн халамж, даатгалын хөрөнгийг завших, байгаль хамгаалах журмын эсрэг, татвар төлөхөөс зайлсхийх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүдэд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйчилсэн шалгаж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө орлогыг нуусан, шилжүүлсэн, хувиргасан үйлдлийг тогтоох чиглэлээр санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг явуулан биелэлтийг хангасан эсэх, програм сүлжээний нууц аюулгүй байдал, харуул хамгаалалт, теле хяналтын камер, дохиолол, гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйлс, сэжигтэй этгээдүүдээс эд зүйл тавигдсан эсэх, эд зүйлсийг шалгаж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, төр, олон нийт, хувийн өмч хөрөнгийг завших, үрэгдүүлэх, залилах, нийгмийн халамж, даатгалын хөрөнгийг завших, байгаль | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамгаалах журмын эсрэг, татвар төлөхөөс зайлсхийх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүдэд мөнгө угаах гэмт хэргээр холбон шалгаж ажилласан.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг арилжааны банк, хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газар, гадаадын хөрөнгө оруулалттай 62 аж ахуй нэгж байгууллагын 105 албан тушаалтан ажилтан, мэргэжилтэнд төр, олон нийт, хувийн өмч хөрөнгийг завших, үрэгдүүлэх, залилах, нийгмийн халамж, даатгалын хөрөнгийг завших, байгаль хамгаалах журмын эсрэг, татвар төлөхөөс зайлсхийх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн хор уршигийн талаар яриа сургалт хийсэн. | | | | | | |
| 90 | | Зам тээврийн осол үйлдсэн иргэдэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ. | Сургалтад хамрагдсан иргэдийн хувь, сургалтын тоо | Зам тээврийн осол буурсан байна. | 7,000.0 | ЗЦХ ГБХЗХХ | 100% | 100% |
| | | 03 дугаар улиралд /2020.07.01-09.15/ дүүргийн нутаг дэвсгэрт 558 зам тээврийн осол бүртгэгдсэнээс уг осол хэрэгт буруутай 558 жолоочоос 261 жолоочид “Зам тээврийн гэмт хэрэг, осол хэргийн шалтгаан нөхцөл байдал, хор уршиг” сэдэвт 15 минутын сургалтыг хэлтсийн байрны 101 тоот өрөөнд 4-6 жолоочтойгоор ажлын өдрүүдэд зохион байгуулсан.<br>Сүхбаатар дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран төрийн хэвшлийн ЕБС-ийн захирал нарт болон хороодын засаг дарга нарт, Дүүргийн аврах, гал унтраах 34-р анги, “Өгөөж чихэр боов” ХХК-ын түгээлтийн жолооч нарт дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй зам тээврийн гэмт хэрэг, ослын талаар болон хүүхэд өртсөн байдал, 2020.01.01-ний өдрөөс шинээр хэрэгжиж эхэлсэн Монгол Улсад Гэмт хэрэг, Зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэлэг зохицуулалт зэрэг сэдвээр 5 удаа 350 хүнд сургалт зохион байгуулан ажилласан байна. | | | | | | |
| 91 | | Бага насны хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс сэргийлэх зорилгоор зурагт хуудас тараана. | Бага насны хүүхдийн осолд өртөх тоо буурсан үзүүлэлт, хувь | Хүүхдийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцуулахдаа зориулалтын суудлыг хэрэглэж хэвшсэн байна. | 8,000.0 | ЗЦХ ГБХЗХХ | 100% | 100% |
| | | Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан бага насны хүүхдийг зам тээврийн осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх” агуулга бүхий 2 төрлийн зурагт хуудсыг осол хэрэг ихээр бүртгэгдсэн 3 хар цэгтэй ойр байрлах 3 сургуулийн 1-2 дугаар ангийн 890 сурагчдад тараах ажлыг тус сургуулийн багш, нийгмийн ажилтан нартай хамтран зохион байгуулсан.<br>Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотойгоор бага насны хүүхдүүд харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцох үедээ зам тээврийн осолд өртөж бэртэх, гэмтэх асуудал тасралтгүй гарч байгаатай холбогдуулан мөн Гарц нэгдсэн арга хэмжээний хүрээнд Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 6, 11, 16, 25, 29, 31, 35, 45, 58, 71 зэрэг нийт 19 сургуульд гараас гарт хөтөлбөрийг хэрэгжилтийг сайжруулах, сургууль орчмын бүсэд тавих хараа хяналтыг сайжруулах, 10 хүртэлх насны хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч нь ирээгүй тохиолдолд явуулахгүй байх талаар албан мэдэгдэл хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилалж байна.<br>10, 11 сард хугацаанд зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, 10 нас хүрээгүй хүүхдийг замын хөдөлгөөнд ганцааранг нь оролцуулахгүй байх, бага насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний дүрэм болон хэрхэн аюулгүй замын | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлгөөнд оролцох талаар 6 төрлийн ЕБС-д 11 өдөр 48 удаагийн сургалтад 1650 орчимд багш, сурган хүмүүжүүлэгч, сурагч, эцэг, эхчүүдэд сургалтыг зохион байгуулан ажилласан байна. | | | | | | |
| 92 | | Зам тээврийн осол ихээр гарч буй цэгүүдийн судалгааг гарган, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Зам тээврийн осол буурсан байна. | 7,000.0 | ЗЦХ | 100% | 100% |
| | | Тус хэлтсээс сар бүрийн зам тээврийн осол хэрэгт криминологи судалгааг гаргаж хэвшсэн. 2020 оны 08 дугаар сарын 07, 14, 21, 28-ны баасан гарагийн өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт 4 удаагийн “Согтуу” хэсэгчилсэн хяналт, шалгалтыг зохион байгуулж, уг хяналт шалгалтад үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоот хуваарийн боловсруулахдаа 2019, 2020 онд бүртгэгдсэн хар цэгийн судалгааг үндэслэн 12 цэгт 42 алба хаагчдыг томилгоожуулан, хяналт, шалгалтыг зохион байгуулсан.<br>Гарц нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 тв-д 3 удаа Явган зорчигчийн зохицуулдаггүй гарцтай хэсгээр гарах үед давуу эрх эрх олгоогүй жолоочид хариуцлага тооцох МУ-ын ЗХД-ийн 16.1 дэх заалтын хэрэгжилтийг хөдөлгөөнд оролцогч жолооч нарт хэвшил болгох зорилгоор мэдээ, мэдээлэл хүргэн ажилласан байна. Сүхбаатар дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсээс 2020 оны эхний 10 сарын байдлаар Зөрчлийн тухай хуулийн 14.7.38 дах хэсгээр 4929 жолоочийг 98.580.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулан ажилласан байна.<br>Мөн явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах оройн цагаар үйлдэгддэг явган зорчигч өртсөн зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарц орчимд гэрэлтүүлгийг сайжруулах чиглэлээр Дүүргийн ГХУСАЗСС-д саналыг гарган хүргүүлсэний дагуу дүүргээс нийт 90 сая төгрөгийг шийдвэрлэн өгч тендер зарлан Тендерийн тухай хуулийн дагуу шалгарсан аж ахуйн, нэгж байгууллагатай гэрээг байгуулан нийт 10 байршилд гэрэлтүүлэг сайжруулах бусад тэмдэг, тэмдэглэгээний ажлыг зохион байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд 11-р сард багтаан хийж дуусгана.<br>Чингэлтэйн өргөн чөлөөнд 2 байршилд П хэлбэр бүхий зарын самбар болон Лед дэлгэц бүхий рам 2 ширхэгийг байршуулах ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх шторк явуулах, гүйдэг хэвтээ лед дэлгэцээр зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх утга бүхий мэдээ, мэдээлэл ач холбогдолтой болно.<br>Сургууль орчимд зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд төв зам дагуу байршилтай сургуулийн судалгааны дагуу ЕБС-ийн явган хүний гарцанд хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх хүүхдийн дүрс бүхий анхааруулах 46 тэмдэг байршуулахаар саналыг дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ-д хүргүүлсэний хандсаны дагуу 9 сая төгрөг шийдвэрлүүлж “Мэжиккроун” ХХК-тай гэрээ байгуулан төв зам дагуу байршилтай 23 байршилд бүрэн байршуулсан. | | | | | | |
| 93 | | Олон нийтийн цагдаагийн тоог нэмэгдүүлнэ. | Олон нийтийн цагдааг 4 хүнээр нэмэгдүүлэх | Зам тээврийн осол буурсан байна. | 39,760.0 | ЗЦХ | 35% | 40% |
| | | Олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулах зарыг 2 удаа тавьж, ажиллах хүсэлт гаргасан 3 иргэнийг судлахад тавьсан шаардлага хангаагүй болно. | | | | | | |
| 94 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйл; | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ТББ-тай хамтарч | Архинд донтох өвчтэй хүмүүсийн зан үйлд нөлөөлсөн байх | Архинд донтогчид, түүнд өртөж болзошгүй эрсдэлт бүлгийн суурь | 5,000.0 | ТЗУХ ХЗТ | 70% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ-ийн 3.2.5 Гэмт хэрэг, зөрчлийг бууруулж, иргэдийн аюулгүй байдлыг хангана. | сургалт, судалгааны ажил зохион байгуулна. | | мэдээллийн сантай болно. | | | | |
| | | Шинэ Covid-19 өвчний улмаас Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 62 дугаар тогтоол, 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 64 дүгээр тогтоол, 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны Иргэдийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/108, Иргэдийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай А/223, Коронавируст /КОВИД-19/ халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай А/436, Захирамжид өөрчлөлт оруулах тухай А/590, А752 дугаар захирамжийн дагуу олон хүн цуглуулах, танхимын сургалт зохион байгуулах үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон тул иргэдэд зориулсан сургалт хийгдээгүй.<br>Дүүргийн Цагдаагийн газрын мэдээллийн санд согтууруулах, мансууруулах төрлийн эмгэгтэй 208 хүний бүртгэл судалгаа байгаагаас тайлант хугцаанд 72 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулсан.<br>Дүүргийн ЕБСургуулийн сурагч нарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн тухай сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажил хангаж ажиллаж байна. | | | | | | |
| 95 | | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ТББ-тай хамтарч сургалт, судалгааны ажил зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан байна. | 15,000.0 | Цагдаагийн газар ТЗУХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Эмийн сан” болон эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хяналт тавих чиглэлээр судалгааг нэгтгэж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 64 эмийн сан болон томоохон эм ханган нийлүүлэх байгууллагууд болох Ази-Фарм, Евро-Фарм зэрэг байгууллагуудад хяналт тавихад ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй, Хариуцсан нутаг дэвсгэрт 18-22 насны иргэд ихэнх тохиолдолд үйлчлүүлдэг баар, ресторан, цахим тоглоомын газруудын судалгааг 1-8 дугаар хороодын хэсгийн байцаагч, хороон цагдаа нараар гаргуулж, энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг Биир Хаус, Их Монгол, Салм, Лакс, Мийтинг, Холливууд, Смайл, Санни, Чоко, Зу гэх нэр бүхий 15 баар, ресторанууд, Зен, Гем Арена, Баттел Арена, Портал, Элит, Лоф гэх нэр бүхий 9 цахим тоглоомын газруудын үйл ажиллагаанд шалгалт явуулж, хар тамхи мансууруулах бодис хэрэглэдэг байж болзошгүй этгээдүүдийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах, сэжигтэй байр байгууламжийг судалж, хяналтад авах зорилгоор эрүүгийн мөрдөгч нарыг хуваарь гарган дээрх объектуудад чиглүүлэн мэдээ, мэдээлэл цуглуулах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2020 он гарснаар хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй сэжигтэй этгээд 28, сэжигтэй байр байгууламж 4-ийг бүртгэж, судалгаанд авч ажилласан. Хар тамхи мансууруулах бодис хэрэглэж байгаа этгээдүүдийн талаар болон нийгэмд тархаад буй эрэлт ихтэй мансууруулах бодисын талаар мэдээ, мэдээлэл цуглуулах зорилгоор энэ чиглэлд туслах хүч судлан ажиллаж байгаа бөгөөд авагдаж буй мэдээллийг тухай бүрд нь ЭЦА-ны мэдээллийн нэгдсэн санд оруулж, шалгалтын ажиллагааг явуулж газар хэлтсийн даргыг мэдээллээр ханган ажиллаж байна. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой авагдсан мэдээлэлд сэжигтэй этгээдүүдийг баримтжуулж эрүүгийн хариуцлагад татах | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зорилгоор тус газрын нэгдүгээр хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгаас нээж баримтжуулалтын ажиллагаа явуулж байсан мөрдөн тагнах хэргийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж шийдвэрлэсэн байна. | | | | | | |
| 96 | | Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулна. | Их цэвэрлэгээний тоо, чанар | 8 удаагийн их цэвэрлэгээ зохион байгуулж ил задгай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 254,200.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 8-ны өдөр, 4 дүгээр сарын 25, 5 дугаар сарын 23, 6 дугаар сарын 13, 10 дугаар сарын 10 ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулж нийт 735тн хог хаягдлыг тээвэрлэж, 100,000м2 талбайд ариутгал халдваргүйтлийн ажлыг хийж гүйцэтгэсэн болно. 111,604,400 төгрөгийг цэвэрлэгээний ажилд зарцуулсан. | | | | | | |
| 97 | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйл; НЗДҮАХ-ийн 3.2.2 дэх заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.6 Агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулна. | Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ хийнэ. | 132 байршлын 434116.7м2 талбайг сард 4 удаагийн давтамжтайгаар цэвэрлэгээ хийх | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 1,079,464.6 | ТНААХ | 100% | 100% |
| | | Нийтийн эзэмшлийн 132 байршлын 434116,7м2 зам талбайн цэвэрлэгээг хариуцан 4-20 дугаар хороог Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т сар бүр 66,259,401,1-3 дугаар хороог Сүхбаатар тохижилт ХХК сар бүр 12,022,674 төгрөгийн санхүүжилт авч байна. Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ 795,112,812 төгрөг, Сүхбаатар тохижилт 144,272,088 төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Зарцуулсан хөрөнгө 939,384,900 төгрөг | | | | | | |
| 98 | | Зориулалтын бус газар хог хаядаг иргэн, аж ахуйн нэгжийг илрүүлж, хуулийн дагуу хариуцлага ногдуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Орчны бохирдол буурсан байна. | - | ТНААХ | 100% | 100% |
| | | 2020 оны байдлаар зориулалтын бус газар хог хаясан 45 зөрчлийг хороодод хүргүүлэн хог хаясан иргэдэд сануулах арга хэмжээ авсан болно. | | | | | | |
| 99 | | Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хог хаягдлыг бууруулах, үерийн далан сувагт хяналт шалгалт хийнэ. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллана. | Агаарын бохирдол буурсан байна. | 2,000.0 | МХХ ТНААХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Монгол улсын Засгийн газрын 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016, Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай А/1377 дугаар захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан А/433-А/820 дүгээр тушаал, захирамж, МХЕГ-ын даргын “Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамж, НМХГ-ын даргын А/52 дугаар тушаалаар баталсан “Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд хяналт шалгалт хийх хуваарь”-ийн дагуу 7 хоног бүрийн 5 дахь өдөр бүр хариуцсан хороон дээр хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нартай хамтран 1-20 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ЗГ-ын 62-р тогтоол, НЗД-ын А/1377 дугаар захирамжийг танилцуулан хяналт шалгалт хийн ажиллаж байна.<br>Нийслэлийн Засаг даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 захирамжийн дагуу шуурхай штабт 24 цагаар хуваарийн дагуу ажиллалаа. Дээрх хугацаанд угаарын 26 дуудлагаар тандалт хийн ажиллалаа.<br>Хяналт шалгалтаар ДСП хавтан, хог хаягдал шатаасан, хог хаягдлыг ил задгай зориулалтын бус газар хаясан зөрчилд 5 аж ахуйн нэгж, 3 иргэнд 1950.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч бүрэн барагдуулсан байна.<br>1-20 дугаар хорооны Засаг дарга нар болон Хог тээвэрлэгч 3 аж ахуй нэгжид коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авах талаар нийт 23 мэдэгдлийг хүргүүлж нийтийн их цэвэрлэгээний байдалд хяналт тавьж ажиллаж байна. Хяналт шалгалтаар зөрчил гаргасан 3 аж ахуй нэгж 1 иргэнд 3650.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч албан даалгавраар үүрэг өгсөн. Мөн НЗД-ын А/166 дугаартай захирамжийн хүрээнд Ариутгал халдваргүйтгэл хийж байгаа компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 5 газрын 4 төрлийн хуурай бодис, найруулсан 4 төрлийн уусмалаас дээж авч шинжилгээнд хамруулахад хлоридын идэвхи тухайн бодисын шаардлагын хэмжээнд байв. Байгууллага аж ахуй нэгж иргэдийн ажлын байр болон эрсдэлтэй цэгүүдэд халдваргүйтгэл хийж байгаа байдалд түүврийн аргаар нийт 289 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж дүн мэдээг өдөр бүр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн ажиллаж байна.<br>Дүүргийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу улсын /ахлах/ байцаагчид 17 дугаар хорооны 7,8 хэсгийн 165 айл өрхийн иргэдэд өвөлжилтийн бэлтгэлийг хангуулж, янданг хөөлөх, зуухны битүүмжлэл, ашиглалтыг сайжруулан, угаарын хордлогоос сэргийлж, угаар мэдрэгчийг тогтмол хэрэглэх талаар зөвлөмж, сэрэмжлүүлэг өгч ажиллалаа. | | | | | | |
| 100 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд хог хаягдлыг бууруулах чиглэлээр ажил зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Орчны бохирдол буурсан байна. | | ТНААХ СБДэвшил | 100% | 100% |
| | | Дүүргийн 6 хорооны 22 байрны урд тал, 11 хорооны Нэгдсэн эмнэлэгийн урд тал, 19 дүгээр хорооны зуслангийн бүсийн 4 байршил, 20 дугаар хорооны Гүнжийн булаг зэрэг нийтийн эзэмшлийн гудамж талбайд үүссэн үүсмэл хогийн цэгийг устгаж, “Хог хаяхыг хориглоно” гэсэн хуулийн хариуцлагыг сануулсан агуулга бүхий самбаруудыг байршуулсан.<br>Мөн 10 дугаар хороонд цаасыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг хийж байршуулснаар гудамж талбайд хаягдах цаасан хайрцагны хог хаягдал багассан. Дүүргийн 19, 20 дугаар хороодын зам дагуу үүсмэл хогийн цэгийг бууруулах чиглэлээр “ Хоггүй наадамлацгаая” аяны зохион байгуулж, зам дагуу уриалга бүхий 16 ширхэг самбарыг байршуулсан. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын хог хаягдлыг бууруулах, иргэдийг соёлтой байхад уриалах зорилгоор 2020 оны 10-р сарын 06-ны өдөр зам талбайн үйлчлэгч нарын ажлын хэрэгсэл болох 20 ширхэг хогны тэргэн дээрээ “Хогоо ил задгай хаяхыг хориглоно, тамхины иш цонхоороо бүү хая” уриалга бүхий наалтыг наасан. Мөн 2020 оны 10-р сарын 15-ны өдрөөс эхлэн хариуцсан бүсийн хороодын хогийн бункерт том оврын, барилгын болон бусад төрлийн хог хаягдлыг багасгах зорилгоор дүүргийн 4,10,12,19 дүгээр хороодын 6 бункерийн гадна талд “Тухайн бункерт зөвхөн ахуйн зориулалттай хог | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хаягдлыг хаях тухай сануулга, хог тээврийн хуваарь болон байгууллагын холбоо барих утас”-ыг бичсэн мэдээллийн самбарыг байршуулсан. 2020 онд нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдлыг бууруулах чиглэлээр нийт 5 удаагийн томоохон ажлыг хийж гүйцэтгэж, зуслангийн бүсийн үүсмэл хог хаягдлыг эрс багасгаж, орчныг бохирдлыг 2 дахин бууруулан ажилласан. | | | | | | |
| 101 | | Хог хаягдлын хуваарийг хороо тус бүр дээр шинэчлэн батлан мөрдүүлж, хог тээврийн зөрүү, нэмэлт санхүүжилт олгоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Хог хаягдлыг хуваарийн дагуу тээвэрлүүлж, хог тээврийн алдагдал багасна. | | ТНААХ СБДэвшил | 100% | 100% |
| | | Дүүргийн Засаг Даргын Тамгын газартай “Хог тээврийн түр гэрээ”-г сар бүр байгуулан 4,5,6,8,9,10,11,12,13,16,18,19,20 дугаар хороодын газар зүйн болон хүн амын онцлогт нийцсэн хог тээврийн хуваарийг боловсруулсан. Уг хуваарийн төслийг хороо тус бүрийн Засаг дарга руу 2020 оны 03 дугаар сарын 20 өдрийн 11 тоот албан бичгээр хүргүүлсэн. Дээрх гэрээний дагуу хог тээврийн рейсийн тайланг сар бүр Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэст хүргүүлэн ажилласан. 2020 оны 07 дугаар сард Хороодын Засаг Даргын саналыг үндэслэн хог тээврийн хуваарийг өөрчлөн дүүргийн Засаг даргын орлогчоор батлуулж, хуваарийн хэрэгжилтийг хангах үүднээс хороо тус бүрт 100 ширхэг нийт 1400 ширхэг хог тээврийн хуваарь, ажилчдын мэдээлэл бүхий тараах материал бэлтгэж тараасан, нийт 13 хорооны цахим хуудас, нүүр номонд хог тээврийн хуваарийг байршуулах ажлыг тус тус зохион байгуулсан. Хог тээврийн зөрүүний нэмэлт санхүүжилт 558.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Мөн 2020 оны 4 дүгээр улиралд хорио цээрийн үед гэртээ байгаа хүүхэд багачуудад зориулан хог хаягдлыг ангилан, ялгах, ууталж савлах зөв дадал хэвшлийг бий болшох зорилгоор “Цэвэр орчин таны баталгаа” сэдэвт комекс номыг бүтээн, тараах ажлыг хийж гүйцэтгэсэн. | | | | | | |
| 102 | | Хог хаягдлын хураамж төлөхөөс зайлсхийсэн болон удаан хугацааны өр үүсгэсэн аж ахуйн нэгжийн татварыг барагдуулах ажлыг хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Татварын тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | | ТНААХ СБДэвшил | 100% | 100% |
| | | Хог хаягдлын хураамжийг гэрээгээр тохирцсон хугацаанд төлөөгүй 64 аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 158 тоот албан бичгээр Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст мэдэгдсэн. Цаашид дээрх аж ахуйн нэгжээр хамтарсан ажлын хэсэг байгуулж, төлбөр барагдуулах чиглэлээр үзлэг, шалгалт хийх ажлын хуваарийг гарган ажиллаж байна. 2020 оны 8 дугаар сард Сүхбаатар дүүргийн татварын хэлтстийн мэргэжилтэн нартай хамтран удаан хугацаагаар хог тээврийн төлбөрийг төлөөгүй 14 аж ахуйн нэгж, хураамжаас чөлөөлөх хүсэлт ирүүлсэн 36 аж ахуйн нэгжээр гэнэтийн үзлэг шалтгалтыг зохион байгуулж, 16 орчим сая төгрөгийн төлбөрийг барагдуулж дууссан. Мөн энэ онд хог тээврийн төлбөр бууруулах 46, төлбөрөөс чөлөөлөх 39 аж ахуйн нэгжийн хүсэлтийг татварын хэлтэст уламжлан шийдвэрлүүлсэн. | | | | | | |
| 103 | | Аж ахуйн нэгж болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршсан пункер, хогийн савны судалгааг гаргаж, ариутгах ажлыг зохион байгуулах, | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хог хаягдлын үйлчилгээ сайжирч иргэдийн эрүүл аюулгүй орчинд | - | ТНААХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ариутгалын тоног төхөөрөмжөөр хангаж, ажлын хөлсийг гүйцэтгэлээр олгоно. | | амьдрах нөхцөл бүрдсэн байна. | | | | |
| | | Нийтийн эзэмшлийн талбайд тавигдсан 48ш хог ангилан ялгах хогийн савны ариутгал халдваргүйтгэлийг хог тээвэрлэгч байгууллага нарт хог ачсаны дараа тогтмол ариутгал халдваргүйтгэл хийж байх талаар мэдэгдэн ариутгал халдваргүйтгэлийн тогтмол хийж байгаа болно. | | | | | | |
| 104 | НЗДҮАХ-ийн 3.2.8 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.7 Агаарын бохирдлыг бууруулах талаар хувийн хэвшлийн байгууллагуудын шинэ санаачлага дэвшилтэт технологи дэмжиж ажиллана. | Агаарын бохирдлыг бууруулах талаар хувийн хэвшлийн байгууллагуудын шинэ санаачилга дэвшилтэт технологийг дэмжиж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын уялдаа холбоо сайжирч түүхий нүүрсний хэрэглээ багассан байна. | - | ТНААХ | 100% | 100% |
| | | 2020 оны 09 сарын 01-ны өдрийн Нийслэлийн агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагчийн Цэвэр агаар-Цэлмэг тэнгэр өдөрлөг зохион байгуулах тухай албан бичгийн хүрээнд дүүргийн 14 дүгээр хороо Оргил худалдааны төвд НҮБ-аас санаачилсан Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг өдрийг “Цэвэр агаар-Цэлмэг тэнгэр” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх, өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд зохион байгуулсан. Өдөрлөгөөр дулаалгын материал, шалны халаалт, дулаан баригч, цахилгаан, хийн халаагуур гэх мэт эрчим хүчний хэмнэлттэй, өртөг багатай, байгал орчинд ээлтэй бүтээгдэхүүнийг танилцуулах, ногоон зээлийн үйлчилгээний талаарх мэдээллийг банк, санхүүгийн байгууллагууд өгч, зээлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж ажиллав.<br>Өдөрлөгт Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, Мэргэжлийн хяналтын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтэс хамтран оролцож дулаалга хийх, сайжруулсан түлшээ нөөцлөх талаар иргэдэд сурталчилж, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зуух, яндан, ханан пийшингийн битүүмжлэл шалгах, заавар зөвлөмж мэдээлэл өгч ажиллалаа. | | | | | | |
| 105 | | Гэр хорооллын, айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгэнэ. | 19957 айл өрхийн жорлон, бохирын цооногт ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хэрэгжүүлэх | Хөрсний бохирдол багасч халдварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн байна. | 171,093.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 9-20 дугаар хорооны гэр хорооллын 19668 өрхийн жорлон, бохирын цооног, 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн 150,573,78м2 талбай, үерийн далан гуу жалга 99,651,22м2 талбайд ариутгал, халдваргүйтгэлийн ажил Санхими ХХК хариуцан ажилласан болно. Зарцуулсан хөрөнгө 303,030,300<br>Шинэ төрлийн коронавирус Улаанбаатар хотод бүртгэдсэнтэй холбоотойгоор бүх нийтийн бэлэн байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, дүүрэг болон хороодын ажлын байр, Цагдаагийн газар, Цагдаагийн 2 дугаар хэлтсийн байр, Гал түймэр унтраах, аврах ангиуд, голомт бүхий газруудад ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг яаралтай зохион байгуулсан болно. | | | | | | |
| 106 | НЗДҮАХ-ийн 3.3.7 дахь заалт; | Хог хаягдлын үйлчилгээг сайжруулж, хог тээврийн | Үйл ажиллагааны | Хог хаягдлыг хуваарийн дагуу | 997,000.0 | ТНААХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ-ийн 3.2.8 Хог хаягдлын менежментийг одоогийн түвшингээс сайжруулна. | нарийвчилсан хуваарь гаргаж мөрдүүлэх, хог хаягдлын үйлчилгээний орлогыг нэмэгдүүлж алдагдлыг багасгана. | хэрэгжилт, хувиар | тээвэрлүүлж, ил задгай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлсэн байна. | | | | |
| | | Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ 48,500,000 төгрөг, Сүхбаатар тохижилт ХХК 19,000,000 төгрөгийн нэмэлт санхүүжилт сар бүр авч байна. 2020 он гарснаар Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Улаанбаатар шинэчлэлт ХХК нийт 800,000,000 төгрөгийн нэмэлт санхүүжилт аваад байна. | | | | | | |
| 107 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сандал, хогийн сав байршуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Нийтийн эзэмшлийн талбайд эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн сав, сандал байршуулж ил задгай хог хаягдал багасч, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлсэн байна. | 175,000.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 1-10 дугаар хорооны 64 СӨХ-с ирүүлсэн саналаар 393ш хогийн сав, 336ш сандал байршуулах хүсэлт ирүүлсэнийг судалж судалгаа гаргаад байна.<br>Орон сууцны хороолол дундах нийтийн эзэмшлийн хогийн бункергүй хог хаягдал үүсдэг 28 байршилд хогийн сав байршуулсан. | | | | | | |
| 108 | | 1-20 дугаар хороонд Тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хог хаягдлын үйлчилгээ сайжирсан байна. | 153,600.0 | ТНААХ | 100% | 100% |
| | | Орчны бохирдол хог хаягдлын хяналтыг сайжруулар зорилгоор дүүргийн 20 хороонд Тохижилт хог хаягдлын олон нийтийн байцаагчид сар бүр 420,000 төгрөгийг цалин өгч ажиллуулж байна. 2020 онд 99,960,00 төгрөг | | | | | | |
| 109 | | Олон нийтийн байцаагч нарын чадавхижуулах сургалт зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч чадавхижсан байна. | 6,970.0 | ТНААХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Шинэ төрлийн корановирус илэрсэнтэй холбоотойгоор сургалтыг 2021 онд хийхээр төлөвлөсөн болно. | | | | | | |
| 110 | | Хог хаягдал дахин ангилах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гадаад улс орнуудад туршлага судлах боломжийг бүрдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хог хаягдлын дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна. | 5,000.0 | ТНААХ СБДэвши л | | Үнэлэх болом жгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тус газар нь 2020 оны сургалтын төлөвлөгөөг ажилчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан боловсруулж, гүйцэтгэх захирлаар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу хог хаягдал дахин ангилах чиглэлээр 2 ажилтанг гадаад улсад сургалтад хамруулахаар төлөвлөсөн боловч халдварт өвчинтэй холбоотойгоор дээрх ажлыг хийж гүйцэтгэх боломжгүй болсон. | | | | | | |
| 111 | | Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг чанартай сайн хийж гүйцэтгэх, санхүүжилтийг гэрээний дагуу олгоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Нийтийн эзэмшлийн цэвэрлэгээ үйлчилгээ хуваарийн дагуу хийгдэж, орчны бохирдол буурсан байна. | - | ТНААХ СБДэвшил | 100% | 100% |
| | | Дүүргийн Засаг Даргын Тамгын газартай 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн сар бүр " Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулан 4-20 дугаар хороодын нийтийн эзэмшлийн 112 гудамж, зам бүхий 312468,8 м.кв талбайг сард 4-5 удаагийн давтамжтайгаар цэвэрлэж, тайланг сар бүр Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэст хүргүүлэн 4 дүгээр улирлын байдлаар нийт 791.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Уг гэрээний дагуу нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний өвлийн болон зуны цагийн хуваарь, гудамж талбайд байрлах байгууламжийн угаалга, цэвэрлэгээний хуваарийг гүйцэтгэх захирлаар тухай бүр батлуулан ажилласан. Мөн 2020 оны 7,8 саруудад хариуцсан бүсийн шарилж, лууль цэвэрлэх ажлыг зохион байгуулж нийт 26 байршлын 89700м2 бүхий 56,1тонн шарилж цэвэрлэж, тээвэрлэсэн. Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2020 оны 09-р сарын 11-ны өдрийн А/31 тоот тушаалаар "Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээний дүрэм"-ийг батлуулан мөрдүүлж, ажлын байрны үзлэг шалгалтыг 7 хоногт 2 удаа хийж гүйцэтгэснээр зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний чанар сайжирсан. | | | | | | |
| | | 3.3 Иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | |
| 112 | НЗДҮАХ-ийн 4.4.8 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.3.3 Иргэд болон зорилтод бүлгүүдийн дунд /Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ нийтийн биеийн тамирын үйлчтилгээг өргөжүүлж, Бүх Ард түмний, Хүүхдийн, Үндэсний, Оюутны спортын наадмуудыг зохион байгуулж, Их наадмуудад Дүүргийн баг тамирчдыг оролцуулна. | Дүүргийн ахмадын хороо, хороодын иргэний танхимыг түшиглэн ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл бололцоогоор ханган ажиллана. | Ахмадуудын санал санаачилгыг дэмжин ажиллах | Ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай боломжийг бүрдүүлсэн байна. | 5,000.0 | НХХ | 90% | 100% |
| | | Дүүргийн ахмадын хорооны байранд ахмадын чөлөөт цагаа өнгөрүүлэх нийтийн бүжиг, хийн дасгал, хурал зөвөлгөөн зэрэг урлаг, спортын олон төрлөөр ашиглаж болох 45м2 заал тохижуулахад дүүргийн төсвөөс 2,9 сая төгрөгийн өртгөөр засвар үйлчилгээ хийж, тоног төхөөрөмжөөр хангасан. | | | | | | |
| 113 | | Иргэдийн спортын IX наадмыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж оролцоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Спортын наадам зохион багйуулагдсан байна. | 30,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Дүүргийн иргэдийн спортын наадмыг нийслэлийн нэгдсэн зааврын дагуу спортын 7 төрлөөр 11 дүгээр сарын 14-30-ны өдрүүдэд зохион байгуулахаар дүүргийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/373 захирамжаар 20,606,000 төгрөг шийдвэрлэсэн боловч, УОК-ийн шийдвэрээр Коронавирусийн халдвараас сэргийлэх, хөл хорио тогтоож, бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбогдуулан тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна. | | | | | | |
| 114 | | Ахмадын хавар , намрын өдөрлөг зохион байгуулна. | Үйл ажиллагааны | Ахмадын идэвх оролцоо сайжирсан байна. | 6,000.0 | НХХ БТСХ | 70% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилт, хувиар | | | | | |
| | | Нийслэлийн Засаг даргын үүргэг гүйцэтгэгч Ж.Батбаясгалангийн уриалгаар 2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Монголын Хийн дасгалын холбооны дэргэдэх Сүхбаатар дүүргийн Ахмадын “Хийн дасгалын Тэнгэрийн увидас” ТББ-тай хамтран ахмадуудынхаа дунд хийн дасгалаар 50 цагийн, Поротийм фитнесс клубтай хамтран ард иргэдийн дунд хөгжимт чийрэгжүүлэх дасгалаар 78 цаг, дүүргийн Ахмадуудынхаа дунд Граунд гольфын талаар 64 цагийн сургалтууд зохион байгууллаа.<br>Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосон. | | | | | | |
| 115 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт өдөрлөг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд үзүүлэх оролцоог нэмэгдүүлсэн байна. | 3,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан хойшлогдсон. | | | | | | |
| 116 | | Бүх нийтийн спорт өдөрлөг, спорт явган аялал зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Иргэдийн идэвх оролцоо нэмэгдсэн байна. | 2,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Дэлхийн алхалтын өдөр”-ийн аяныг улс орон даяар 2020 оны 10 сарын 21-ний өдрөөс 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсантай холбогдуулан дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос 10 дугаар сарын 31-ний өдөр Циркийн хойд талын талбайгаас Зайсан чиглэлд бүх нийтийн явган алхалт зохион байгуулж, нийт 1000 гаруй хүн оролцлоо.<br>Тус аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагч, аж ахуйн нэгж байгууллагууд, ЕБС, СӨББ, Хороодын иргэдийн дунд зохион байгуулсан “Алхалт - Амьдралын хэв маяг” онлайн уралдаанд хамрагдсан нийт 30 байгууллагын тайлан мэдээ, видео бичлэгийг 7 шалгуур үзүүлэлтээр дүгнэн эхний 3 байрыг шалгаруулаа. Үүнд:<br>I байр 283-р цэцэрлэг, II байр 18-р хорооны ЗДАА, III байр 29-р сургуулийн хамт олон тус тус шалгарсан. | | | | | | |
| 117 | | Дүүргийн хэлтэс, албад, хороодын дунд спорт наадам, өдөрлөгүүд зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Албан хаагчдын спортоор хичээллэх боломж бүрдсэн байна. | 20,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын “Спорт наадам-2020” тэмцээнийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас спортын 5 төрлөөр зохион байгуул, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын давхардсан тоогоор 43 тамирчин оролцож, сагсан бөмбөгийн төрөлд оролцсон эрэгтэй баг тамирчид Нэгдүгээр байрт шалгарч Алтан медаль, дартсын баг тамирчид Мөнгөн медаль, шатрын төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр Хүрэл медаль хүртсэн амжилттай. Мөн дүүргийн тамирчин тус тэмцээний шилдгийн шилдэг эрэгтэй тамирчнаар тодорлоо. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дүүргийн дэргэдэх хэлтэс албадын ажилтан, албан хаагчдын тэмцээнийг 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн боловч, коронавирусийн халдвараас сэргийлэх, хөл хорио тогтоосонтой холбогдуулан зохион байгуулагдаагүй болно. | | | | | | |
| 118 | | Дүүргийн хэмжээнд "Олимпизм ба бие бялдрын хүмүүжил" сэдэвт болзолт уралдаан зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Болзолт уралдаан зохион байгуулагдсан байна. | 2,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан хойшлогдсон. | | | | | | |
| 119 | | "Улаанбаатар-Лиг" сагсан бөмбөг, волейбол, шатрын "Их нүүдэл", "Дуулиан 2020" футзалын тэмцээнүүд зохион байгуулж, "UB-марафон" олон улсын гүйлтэд иргэдийг өргөнөөр хамруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тэмцээн уралдаануудад иргэдийг идэвхитэй оролцуулсан байна. | 2,000.0 | НХХ БТСХ | 100% | 100% |
| | | ЕБС-иудын сурагчдын “Улаанбаатар-Лиг” сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 10 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд Буянт ухаа Спортын ордонд зохион байгуулагдаж, нийслэлийн 9 дүүргийн 96 багийн 1152 тамирчин оролцсон. Сүхбаатар дүүргээс бага, дунд, ахлах насны охид, хөвгүүд ангилалд 1,2,3,31,131, ӨЗБЛАСургуулиуд, Логографим дунд сургуулиудын баг тамирчид оролцсоноос дунд насны охидын 1 дүгээр сургуулийн баг тамирчид өргөмжлөл, Алтан медаль, цом, мөнгөн шагналаар, хөвгүүдийн 3 дугаар сургуулийн баг тамирчид өргөмжлөл, Алтан медаль, цом, мөнгөн шагналаар, ахлах насны хөвгүүдийн 3 дугаар сургуулийн баг тамирчид, өргөмжлөл, цом, Хүрэл медаль, мөнгөн шагналаар тус тус шагнуулллаа. Тус тэмцээний дунд насны охидын “ШИЛДЭГ ТАМИРЧИН”-аар 1 дүгээр сургуулийн Н.Нандинхүсэл, хөвгүүдийн дунд насны ангилалын “ШИЛДЭГ ТАМИРЧИН”-аар Т.Тэмүүлэн, “ШИЛДЭГ ДАСГАЛЖУУЛАГЧ”-аар Д.Отгонбаатар нар шалгарч, өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар тус тус шагнуулллаа. | | | | | | |
| 120 | | Хийн дасгалын хамтлагтай болно. | Ахмадуудын санал санаачилгыг дэмжин ажиллах | Бие бялдарын түвшин сайжирч чийрэгжсэн байна. | 4,000.0 | НХХ | 70% | 70% |
| | | Иргэдийг хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, эрүүл зөв амьдрах дадал хэвшүүлэх зорилгоор дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос 9 дүгээр сард дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 6-р сургуулийн гаднах талбай, Циркийн хойд талын талбай, Алтай хотхоны гадна талбай зэрэг газруудад өглөө бүр 07.00 цагт өглөөний дасгал, хийх дасгал хөдөлгөөнийг зохион байгуулж, иргэдэд COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхийг уриалж ажилласан. | | | | | | |
| 121 | НЗДҮАХ-ийн 4.4.2 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.3.4. дахь заалт: Иргэдийн амьдралын зөв дадал хэвшил олгох, хөдөлгөөний | Эрүүл мэндээ дээдлэгч өрх, иргэн байгууллага шалгаруулна. | Эрүүл мэндийн сайдын 2009 оны 184 дүгээр тушаал, өрх, иргэдийн дунд нийслэлийн Засаг даргын | Эрүүл мэндээ дээдлэгч өрх, иргэн байгууллагын тоог 2019 оны хүрсэн түвшингээс бууруулахгүй байна. | 3,500.0 | НХХ ЭМТ | | Үнэлэх болом жгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хомсдолоос урьдчилан сэргийлэх, зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн аян, Бие бялдрын чийрэгжилтийн түвшиг тогтоох сорил хөтөлбөрийг жил бүр өрнүүлж, хүн амын бие бялдрын боловсролын түвшинг дээшлүүлнэ. | | 2003 оны 504 дүгээр захирамж, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2015 оны А/55 тушаалын болзолт журмын дагуу | | | | | |
| | | -Дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаал, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан эрүүл мэндээ дэмжигч байгууллага, өрх, иргэн шалгаруулах удирдамжийн дагуу анхан шатны шалгаруулалтад “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”-ээр 2 дугаар хорооны иргэн Д.Энхтуяа, 9 дүгээр хороо Д.Алтанцэцэг, 11 дүгээр хороо Х.Эрдэнэчимэг, 8-р хороо Ч.Аюушжав нарыг, Эрүүл мэндээ дээдлэгч өрх”-өөр 12 дугаар хороо О.Саруулган, 13 дугаар хороо Б.Энх-Амгалан, 2 дугаар хороо Д.Төмөрбаатар, 15 дугаар хороо О.Билгүүнсайхан, 20 дугаар хороо Н.Даваажав нарын гэр бүлийг, Эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар 2, 51 дүгээр цэцэрлэгийг шалгаруулж, материалыг нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.<br>Дэлхий дахинд шинэ коронавирусийн халдварт өвчин дэгдсэнтэй холбогдуулан УОК-оос олон нийтийг хамаргсан үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосон тул шалгаруулалт хойшлогдсон. | | | | | | |
| 122 | | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд иргэдийг өргөнөөр хамруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна. | 3,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан зохион байгуулагдаагүй. | | | | | | |
| 123 | | Биеийн тамир, спортын "Шилдэг хамтлаг" шалгаруулах болзолт уралдааныг зарлан явуулж дүгнэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Биеийн тамир, спортын хамтлагуудын тоо нэмэгдэж, үйл ажиллагаа сайжирсан байна. | 3,000.0 | НХХ БТСХ | 100% | 100% |
| | | Дэлхийн алхалтын өдөр”-ийн аяныг улс орон даяар 2020 оны 10 сарын 21-ний өдрөөс 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсантай холбогдуулан дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос 10 дугаар сарын 31-ний өдөр Циркийн хойд талын талбайгаас Зайсан чиглэлд бүх нийтийн явган алхалт зохион байгуулж, нийт 1000 гаруй хүн оролцлоо. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 124 | | Тус аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагч, аж ахуйн нэгж байгууллагууд, ЕБС, СӨББ, Хороодын иргэдийн дунд зохион байгуулсан “Алхалт - Амьдралын хэв маяг” онлайн уралдаанд хамрагдсан нийт 30 байгууллагын тайлан мэдээ, видео бичлэгийг 7 шалгуур үзүүлэлтээр дүгнэн эхний 3 байрыг шалгаруулланаа. Үүнд:<br>I байр 283-р цэцэрлэг, II байр 18-р хорооны ЗДАА, III байр 29-р сургуулийн хамт олон тус тус шалгарсан. | | | | | | |
| 124 | | СӨББ, ЕБС-иудын хүүхдүүдийн "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн тэмцээн ахмадуудын дунд гимнастрадын тэмцээн зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Нийслэлийн шигшээ тэмцээнд оролцогч баг тамирчдын нэмэгдэж, тамирчин сурагчдын үзүүлэх амжилт нэмэгдэнэ. | 3,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан зохион байгуулагдаагүй. | | | | | | |
| 125 | | "Хүүхдийн спорт-өнөө ба ирээдүй" сэдэвт олон улсын форм зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хүүхдийн спортын өнөөгийн байдлыг судалж, тодорхойлсон байна. | 1,000.0 | НХХ БТСХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан зохион байгуулагдаагүй. | | | | | | |
| 3.4 Газар өмчлөх ажлыг үргэлжлүүлнэ. | | | | | | | | |
| 126 | ДЗДҮАХ-ийн 3.4.1 "Зуслан" Ерөнхий төлөвлөгөөний дагуу дүүргийн 15,19,20 дугаар хороодын зуслангийн газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан үргэлжлүүлнэ. | Зуслангийн бүсийн иргэдийн Гэнэтийн гамшиг осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, Түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх, нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Зуслангийн бүсийн орц гарц нэмэгдэнэ. Гэнэтийн гамшиг ,ослын үед түргэн тусламж богино хугацаанд хүрсэн байна. | 5,000.0 | ГЗБА ТГХШХ | 95% | 100% |
| | | Хот суурийн газрын гэр хороолол, орон сууцны хороололд гал унтраах, түргэн тусламжийн авто машин хүрэлцэн очих орц гарцыг гаргах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын 2020 оны 04 сарын 14- ний А/513 тоот Газрын зөрчил арилгах , орчны аюулгүй байдлыг хангах захирамжийн хүрээнд 18 байршилд 32 обьект чөлөөлхөөс 18 байршлын 32 обьектийг чөлөөлж нийтийн эзэмшлийн зам талбайд орц гарцыг нээж тохижилт хийх боломжийг бүрдүүлэн ажилласан. | | | | | | |
| 127 | | "Зуслангийн" ерөнхий төлөвлөгөөний<br>дагуу дүүргийн ,15, 19, 20. хороодын зуслангийн газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан, үргэлжлүүлэн явуулах газар | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Иргэдийн хувийн өмч нэмэгдсэн байна. | - | ГЗБА ТГХШХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өмчлөлийн ажлыг эрчимжүүлэн ажиллана. | | | | | | |
| | | 2020 оны байдлаар Нийслэлийн Засаг даргын 8 удаагийн захирамжаар зуслангийн бүсэд нийт 273 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 13.6 га газрыг өмчилж аваад байна. | | | | | | |
| 128 | | Зуслангийн бүсийн орц гарцыг чөлөөлөх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Дүүргийн хэмжээнд газар чөлөөлөх судалгааг гаргаж, Зуслангийн бүсийн газар чөлөөлөлтийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Зуслангийн ногоон бүс дэх иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, газрын зөрчил маргаан арилсан байна. | - | ГЗБА ТГХШХ | 100% | 100% |
| | | Зуслангийн ногоон бүс дэх газрын зөрчил арилгах зуслангийн газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Дүүргийн Засаг даргын 2020 оны 05 сарын 22-ны өдрийн А/194 тоот захирамжийн хүрээнд Зуслангийн 19 амны 67 байршилд орц гарц гаргах ажлыг зохион байгуулан ажилласнаас 58 байршилд орц гарц хашаа хаалт, зөөврийн байгууламж байршуулсныг чөлөөлөөд байна | | | | | | |
| 129 | Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын тухай хуулийн 3.3, 3.4 дэх заалт; Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 2 дугаар зүйл; НЗДҮАХ-ийн 4.7.8 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.4.2 Иргэд зуслангийн газартаа өрхийн аж ахуй эрхлэх санал санаачилгыг идэвхижүүлж ажиллана. | Өрхийн тариалан эрхлэгчдэд зориулж онолын болон практик сургалт зохион байгуулна. | 2 удаагийн сургалтад 200 иргэнийг хамруулах | Тариалан эрхлэгчдийн мэдлэг, ур чадвар дээшилж, иргэдийн орлого нэмэгдсэн байна. | 2,000.0 | ХХҮХ | 100% | 100% |
| | | Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, ХААИС-тай хамтран газар тариалан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан “Хүнсний ургамал хамгаалах цогц технологи, аргууд”, “Ил талбайд зарим хүнсний ногоо тариалах зохистой дадал”, “Хүлэмжинд улаан лооль, цэс, чинжүүний үрслэг ургуулах зохистой дадал”, “Жимс, жимсгэнэ тариалах агротехнологийн зохистой дадал”, “Хүлэмжинд өргөст хэмх, байцаа зарим навчит ногооны үрслэг ургуулах зохистой дадал” зэрэг цахим хичээлийг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын www.hhaag.ub.gov.mn цахим хуудас болон Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар дүүрэг, Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн пейж, хороодын пэйж хуудаст тус тус байршуулан олон нийтэд түгээж, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас zoom.app програм ашиглан зохион байгуулсан сургалтад өрхийн аж ахуй эрхлэгч 34 иргэдийг хамруулсан.<br>“Хүлэмжийн зарим ногооны үрслэг ургуулах технологи”, “Ил талбайн зарим ногоо тариалах технологи”, “Жимс, жимсгэнэ тариалах технологи”, “Ургамал хамгаалах цогц технологи” сэдвийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудаас бэлтгэсэн 5 хичээлийг дүүргийн 1200 гаруй, аж ахуйн нэгж, иргэн, өрхийн тариаланчдад нийслэл, дүүрэг, хорооны цахим хуудсуудаар дамжуулан сурталчилсан.<br>Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 16 дахь заалт, дүүргийн Засаг даргын баталсан 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Анхан шатны нэгж хороодын анхдагч мэдээний чанарыг сайжруулах тухай” ажлын удирдамжийн дагуу дүүргийн Статистикийн хэлтэстэй хамтран 2020 оны 07 дугаар сарын 21-23-ны өдрийн хооронд дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийн албан ёсны статистикийн мэдээний үнэн зөвийг шалгах, илэрсэн дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах замаар статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах зорилгоор дүүргийн 213 өрх, 3 ААН-ийн үйл ажиллагаанд түүврийн аргаар 9 хорооны 25 өрх, 5 ААН тариалалтын байдалтай | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 130 | | танилцаж, А-ХАА-7 маягтын дагуу тариалалт хийсэн талбайд хэмжилт хийж, мэдээний үзүүлэлт бүрээр тулган нягталж, статистик мэдээний ач холбогдлыг таниулан ойлгуулах, мэдээг чирэгдэлгүй хугацаандаа үнэн зөв өгч хэвших талаар заавар, зөвлөгөө өгч, газар тариалангийн мэдээг өрх, ААНБ-аас үндсэн 5 маягтаар мэдээний графикт хугацаанд анхан шатнаас цуглуулахад шаардагдах суурь ойлголтыг нийт 9 хорооны Засаг дарга, зохион байгуулагч, 87 хэсгийн ахлагч нарт өгч, хороо тус бүр дээр гарсан алдаа, дутагдлыг ажлын хэсгийн дүгнэлтээр танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хороодод зөвлөмж хүргүүлсэн. | | | | | | |
| 130 | | Эрүүл баталгаатай төмс, хүнсний ногооны борлуулалтын сүлжээ цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлж, өрхийн тариалан эрхлэгчдийн болон хөдөө орон нутгийн ногоог хямд үнээр дүүргийн иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна. | Хөдөө орон нутгийн болон өрхийн тариалан эрхлэгч 24 иргэнийг дэмжих | Ажлын байраар хангаж, хүнсний ногооны борлуулалт нэмэгдсэн байна. | 1,000.0 | ХХҮХ | 100% | 100% |
| | | Дүүргийн өрхийн тариалан эрхлэгч 3 иргэн, Грийн элдорадо ХХК, Хурын үнэр ТББ-дад мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/105 дугаар тушаалаар батлагдсан Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмын дагуу гарал үүслийн гэрчилгээ олгож, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн мэдээллийн санд бүртгүүлэн, тариалан эрхлэгчдийг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл дүүргийн 12 дугаар хороо, 32-ын тойруу, 16 дугаар хоро, Бэлхийн 31-662 тоот, Дээж хүнсний дэлгүүрийн гадна талбайд мод бут, цэцгийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэдийг дэмжин ажилласан.<br>Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан ерөнхий боловсролын 45 дугаар сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэстэй хамтран мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага Усан бөлбөө ХХК-иар сургуулийн гадна орчны тохижилт ногоон байгууламжийг сайжруулах зорилтын хүрээнд 0,02 га талбайд ногоон байгууламж хийж, 7ш гацуур, 5ш нарс, 50ш агч, 50ш голт бор, 20ш үхрийн нүд, нийт 142 ш мод тарьж, сургуулийн захиргаанд хүлээлгэн өгсөн.<br>Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хүүхдийн урлан бүтээх төв, Эвт үйлчилгээний төв, Дарь эхийн 33-ын автобусны буудлын талбай, Хүүхэд элгэмсэг төвийн дэргэдэх талбай дахь 4 борлуулалтын цэгт эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ худалдаалах чиглэлээр хамтран ажиллах гэрээг 10 иргэнтэй гэрээ байгуулж, хөдөө орон нутгийн ногоочдын болон дүүргийн өрхийн тариаланчдын тарьж ургуулсан ногоог иргэдэд шууд хүргэх ажлыг зохион байгуулж байна.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол Улсын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулах, хэрэгцээт хүнсээ дотоодын үйлдвэрлэлээр хангах, импортыг орлох, экспортыг дэмжих зорилтын хүрээнд Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Монголын хүнсчдийн холбоо хамтран Мишээл экспо төвд “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан доор 15 дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Намрын ногоон өдрүүд-2020” өргөтгөсөн худалдаанд дүүргийн 2 өрхийн тариалан эрхлэгчийг дэмжин оролцуулж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Шинэ ургацын төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа” зохион байгуулах удирдамжийн дагуу дүүргийн 9 дүгээр хорооны Их тойруу, 11 дүгээр хорооны Хангай хотхон, 12 дугаар хорооны 32-ын тойрууд Төв, Сэлэнгэ, Ховд аймгийн 15 хүнсний ногоочдын төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн өргөтгөсөн худалдаа гаргаж, хүн амын хүнсний | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгцээнд эдгээр төвлөрсөн худалдааны цэгүүдээр 68,45 тн төмс, 171,2 тн хүнсний ногоо, 726 шил даршилсан ногоо, 0,2 тн зөгийн бал борлуулж, дүүргийн хүн амын хэрэгцээд нийлүүлсэн. | | | | | | |
| 131 | ДЗДҮАХ-ийн 3.4.3 Газар зохион байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, судалгаагаар хангаж ажиллана. | Дүүргийн газар зохион байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай, материал, судалгаагаар хангана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Иргэдийг мэдээллээр хангаснаар газар чөлөөлөлтийн ажил эрчимжсэн байна. | - | ГЗБА ТГХШХ | 100% | 100% |
| | | Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, судалгаагаар хангах ажлын хүрээнд Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтэстэй 3 талт гэрээ байгуулж ажилладаг бөгөөд газраа чөлөөлж буй иргэдэд зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна. | | | | | | |
| ДӨРӨВ. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧЛЭХ СҮХБААТАР ДҮҮРЭГ | | | | | | | | |
| 4.1 Төрийн үйлчилгээг иргэдэд цогц, хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | |
| 132 | Иргэний бүртгэлийн тухай хуулийн 18, 22 дугаар зүйл; ДЗДҮАХ-ийн 4.1.1 Төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулан нэгдсэн удирдлагын программ хангамжийг хөгжүүлнэ. | Мал, тэжээвэр амьтдын тооллогыг дүүргийн нутаг дэвсгэрт чанартай зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тооллогыг чанартай зохион байгуулсан байна. | 5,000.0 | СХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Мал, тэжээвэр амьдтын тооллого 12 дугаар сарын 07-ноос 17-ны хооронд явагддаг тул хугацаа болоогүй байна. | | | | | | |
| 133 | | Улсын бүртгэгч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулна. | 2 удаа сургалт хийх | Албан хаагчдын мэдлэг чадвар дээшилсэн байна. | 10,000.0 | БүХ ТЗУХ | 100% | 100% |
| | | Монгол Улсад өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 18 удаагийн хуралд давхардсан тоогоор 52 албан хаагч оролцсон. | | | | | | |
| 134 | | Зорилтот бүлгийн иргэдийг бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулна. | 200 иргэдийг хамруулах | Иргэний бичиг баримтын зөрчил арилсан байна. | 5,000.0 | БүХ ТЗУХ | 100% | 100% |
| | | Тайлант хугацаанд тус хэлтсээс иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах үйлчилгээг үзүүлээд байна. Үүнд:<br>Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:<br>Гадаадад зорчих эрхийн бүртгэл-5186<br>Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /шинээр иргэний цахим үнэмлэх авах/ - 5100<br>Иргэний үнэмлэх дахин олголт – 1354<br>Иргэний үнэмлэхний хугацаа дуусч, дахин авсан-3400<br>Төрөлт – 2797<br>Гэрлэлт – 729<br>Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл–213 | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нас баралтын бүртгэл – 970<br>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:<br>Хүлээн авсан мэдүүлэг – 20661<br>Анхны бүртгэл – 2169<br>Өмчлөх эрх шилжих гэрээ – 3586<br>Барьцааны гэрээ – 9935<br>Бусад гэрээ – 376<br>Дүүргийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтран зорилтот бүлгийн нийт 30 иргэнд иргэний үнэмлэх, 4 хүүхдэд төрсний гэрчилгээ олгосон байна. | | | | | | |
| 135 | | 20 хороонд гэр бүлийн хүндэтгэлийн булан байгуулна. | 20 хороонд байгуулах | Гэр бүл батлахад таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 15,000.0 | БүХ ТЗУХ | | Үнэлэх болом жгүй |
| | | Улсын хэмжээнд бэлэн байдал зарласантай холбоотой хийгдэх боломжгүй болсон. | | | | | | |
| 136 | ЗГҮАХ-ийн 5.1.17 дахь заалт, НЗДҮАХ-ийн 5.2.7 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.1.2 Дүүрэг, хороодын иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулан төрийн үйлчилгээний нэр төрөл, тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Биеэр ирж үйлчилгээ авах боломжгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, цаг зав муутай иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, нэг дороос мэдээ, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн хоёроос доошгүй төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | Нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан ямар төрлийн үйлчилгээг хүлээн авах хүсэлтэй байгаа талаар иргэдээс судалгаа авч, судалгаанд тулгуурлан хоёроос доошгүй үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллана. | Төрийн үйлчилгээний чанар нэр төрөл, хүртээмж нэмэгдсэнээр, иргэдийн сэтгэл ханамж сайжирч түргэн шуурхай үйлчилгээ авах боломж хангагдсан байна. | 500.0 | ТЗУХ | 100% | 100% |
| | | Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, зохион байгуулалтын сайжруулах дөрвөн асуулгатай, санал асуулгын хуудсыг иргэдээр бөглүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Иргэдийн эрэлт хэрэгцээ, санал хүсэлтийг хүлээн авч, дүүргийн Татварын хэлтэстэй хамтран нэг цэгийн үйлчилгээнд улсын тэмдэгтийн хураамжийн код олгох, үл хөдлөх хөрөнгийн хоёр хувийн код олгох, татвар төлөгчөөр бүртгэх, ebarimt системд хэрэглэгчийг шинээр үүсгэх нууц үгийг сэргээх, орон сууцны болон сургалтын төлбөрийн хөнгөлөлтийн материалд зөвлөгөө өгөх, тайлан хүлээн авах зэрэг үйлчилгээг 2 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл 3800 гаруй иргэдэд үйлчилсэн байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай иргэдэд цахим мейл хаяг шинээр үүсгэж, татварын EBARIMT.MN цахим системд эрдэнэс таван толгойн 1072 хувьцааг тухайн иргэний арилжааны банкны данстай холболт хийж үйлчиллээ.<br>Дүүргийн нэг цэгийн үйлчилгээний нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлэхэд нийгмийн даатгалын сүлжээгүй улмаас иргэдийн мэдээлэл мэдэгдэхгүйгээс заавал тухайн хэлтэст нь очих хүндрэл үүсдэг байсныг “Сайн дурын даатгал”, “Лавын | | | | | | |

<table>
<tr><td></td><td rowspan="3"></td><td colspan="6">программ”, “Төр хариуцах, эрүүл мэндийн даатгал”-ын сүлжээг нэвтрүүлснээр нийгмийн даатгал, эрүүл мэндийн 7 төрлийн үйлчилгээг шууд хүргэж байна.</td></tr>
<tr><td rowspan="2">137</td><td>Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлнэ.</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</td><td>Иргэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй авах боломж нөхцөл хангагдсан байна.</td><td>7,000.0</td><td>ТЗУХ АТ</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлын бэлтгэлийг хангаж Засаг дарга, орлогч, Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нар, хороодын засаг дарга нарын нийт 32 /е Token/ төхөөрөмжийг ашиглан тоон гарын үсгээр албан бичиг солилцон ажиллаж байна.</td></tr>
<tr><td rowspan="2">138</td><td rowspan="2">НЗДҮАХ-ийн 4.1.4 дэх заалт;<br>ДЗДҮАХ-ийн 4.1.3 Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана.</td><td>Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хуулийн дагуу хяналт шалгалт хийж, үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлнэ.</td><td>Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</td><td>Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйлчилгээний стандарт хангагдсан байна.</td><td>3,500.0</td><td>ХХҮХ<br>МХХ<br>Цагдаагийн газар</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/166, А/333, А/436, А/438, А/521, А/616 дугаар Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай захирамжуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Онцгой комиссоос батлагдсан хуваарийн дагуу 1, 7, 8 дугаар хорооны худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийж, эргүүлээр ажилласан мөн Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс ирүүлсэн, халдваргүйжүүлэлт хийх зөвлөмжийг 1600 ширхэгийг хэвлүүлэн 20 хорооны иргэн, аж ахуйн нэгжид тарааж, тусгай зөвшөөрөл бүхий халдваргүйтгэл хийх 15 аж ахуйн нэгж байгууллагын 2 дахь удаагийн халдваргүйтгэлээр 4 сард 952 аж ахуйн нэгжийн 17,825,146 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан. Аж ахуйн нэгж байгууллагуудад Тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудаар ариутгал халдваргүйтгэлийг 14 хоног тутамд хийлгүүлж, хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын үед эдийн засгийг дэмжих зарим арга хэмжээний тухай” А/930, А/997, А/1073, А/1114 дүгээр захирамжуудын дагуу коронавирусийн халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх, чиглэлээр баар, биллъярд, хүүхдийн тоглоомын газар, үйлчилгээний газрууд, амралтын газар, PC тоглоомын газар, диско болон бүжгийн баарны газруудад халдварын эрсдэлийн үнэлгээ хийж, мэргэжлийн байгууллагатай хамтран стандартын шаардлагыг хангуулан үе шаттайгаар нээж хяналт тавин ажилласан.<br>2. Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолоор Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242, А/1248 дугаар захирамжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй тус дүүргийн нутаг дэвсгэр дэх хүнсний дэлгүүр, зах худалдааны төв, хүнсний үйлдвэр болон бүтээгдэхүүн түгээлт хийж буй аж ахуйн нэгжүүдийн бараа татан авах болон хүргэлт хийхээр замын хөдөлгөөнд оролцох QR кодтой зөвшөөрөл авах хүсэлтэй 340 ААНБ-ын 694 тээврийн хэрэгслийн судалгааг УБЗАА болон НХХААГ-т хүргүүлж шийдвэрлүүлээд байна.<br>Мөн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэр дэх 7 зах</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | худалдааны төв, 9 сүлжээ дэлгүүр, 100 гаруй хүнсний дэлгүүрийн ариутгал, халдваргүйжүүлэлт, иргэд үйлчлүүлэгчдэд хандсан анхааруулга, сэрэмжлүүлэг тавьсан эсэх, зай барьж үйлчлүүлж буй эсэхэд хяналт шалгалт хийлээ.<br>Шалгалтаар томоохон сүлжээ дэлгүүр болон хүнсний дэлгүүрүүд анхааруулга, санамж, сэрэмжлүүлгийг гадна болон дотор талд байрлуулсан, ариутгал халдваргүйтгэлийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудаар хийлгэсэн бөгөөд өдөр тутмын цэвэрлэгээг ариутгалыг тогтмол хийж байлаа. Хүнсний дэлгүүр, супермаркет, минимаркетуудад харьцангуй хүний нягтралшил бага, иргэд хүн хоорондын зайгаа барин үйлчлүүлж байна.<br>3. Дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс Цагдаагийн газраас албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураагдсан согтууруулах ундаа, утаат тамхи зэргийг Улсын орлого болгох шийдвэрүүдийн дагуу хамтран ажиллах гэрээ байгуулсан Мастер фудс ХХК-ийн Хүнсний 50-р дэлгүүрт 4839200 төгрөгийн согтууруулах ундаа, Үндэссайхан ХХК-ийн Нөмрөг хүнсний дэлгүүрт 900480 төгрөгийн согтууруулах, ундаа утаат тамхи, ОЧУХ ХХК-ийн Наран хүнсний дэлгүүрт 2615050 төгрөгийн согтууруулах ундаа, утаат тамхи, Эхлэл дуулал ХХК-ийн Ангария хүнсний дэлгүүрт 709110 төгрөгний согтууруулах ундааг хүлээлгэн өгч, худалдан борлуулсан нийт 8225460 төгрөгийг дүүргийн Орон нутгийн 100200600210 тоот дансанд төвлөрүүллээ. Гэрээний хугацаанд ажил гүйцэтгэсний хөлс 10 хувийг аж ахуйн нэгж, байгууллагуудад олгож, хамтран ажиллаж байна.<br>4. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглоно гэж заасны дагуу дүүргийн Засаг даргын 2020 оны А/25, А/71, А/139, А/196, А/234, А/270, А/299 дугаар захирамжуудаар тамхи худалдах тусгай зөвшөөрлийн эрхийг 8 цэгт шинээр олгож, 22 цэгийн эрхийг сунгахаар шийдвэрлэлээ. Одоогийн байдлаар 148 цэг тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийн эрхтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.<br>5. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 212 дугаар тогтоол, 2019 оны 23 дугаар хурлын тэмдэглэлийн 2.6 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай “ А/889 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны “Нийслэлийн хүн амын махны тогтвортой хангамжийг бүрдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” А/309 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулан нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, махны үнийг тогтворжуулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт худалдааны газрын стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан 28 хүнсний дэлгүүрт Цан Сан Тан Ий ХХК, Мах импекс ХХК, Хиам консервины үйлдвэр ХХК, Монгол Мах Эко ХХК зэрэг мах бэлтгэн нийлүүлэгч үйлдвэрүүд 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 127.595 тн хонь, ямаа, үхрийн махыг хүн амын хүнсний хангамжид нийлүүлсэн.<br>Мөн 2020 оны 05 дугаар сарын 02-25-ны өдрүүдэд 11 дүгээр хорооны Хангай хотхоны гадна талбай, 12 дугаар хорооны Бүрд захын гадна талбай , 18 дугаар хорооны Бэлх захын гадна талбай болон 13 хорооны Арви худалдааны гадна талбайд нөөцийн махны өргөтгөсөн худалдааг (гулуузаар) тус тус зохион байгууллаа. Үүссэн цаг үеийн нөхцөл байдал, коронавирусийн халдвараас урьдлчилан сэргийлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс өргөтгөсөн худалдааны зохион байгуулалт, хөл хорионы дэглэм, ариутгал халдваргүйжилт, иргэдийн бөөгнөрөл үүсэхээс урьдчилан сэргийлэх зэрэгт холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллалаа.<br>Өргөтгөсөн худалдаагаар нийт гарал үүслийн гэрчилгээтэй 3751 ширхэг гулууз буюу 79,144 тонн хонь, ямааны мах, борлуулагдсан ба борлуулалтын мэдээг өдөр тутам авч Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хүнс, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллалаа.<br>6. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх,ажлын хүрээнд бэлтгэн нийлүүлэгч Ихэр шарангад ХХК, Цан Сан Тан Ий ХХК, Цалуут импекс ХХК, Траст трейд ХХК, Баатрууд тэнгэр ХХК зэрэг үйлдвэрүүдэд бэлтгэсэн нөөцийн махны худалдааг 2020 оны 11 дүгээр сарын 15-22-ны өдрүүдэд Саруул зах, 11 дүгээр хороолол, Хангай хотхон, Арви худалдааны төв, Долоон буудал, Хан-Эрдэнэ дэлгүүр, Бэлх |

| | | |
|---|---|---|
| | | зах, Шарга морьт цэгүүдэд зохион байгуулж ажиллалаа. Нийт 8 өдрийн өргөтгөсөн худалдаагаар нийт 58.55 тн үхэр, хонь, ямааны махыг худалдан борлуулсан байна.<br>Өргөтгөсөн худалдаанд хороодын Ажлын алба, дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсүүд хамтран хяналт тавьж, хүн хоорондын зай бариулах, ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хангуулан хамтран ажиллалаа.<br>7. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар баталсан “Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдааны газруудыг аттестатчилах” удирдамжийн дагуу хяналт, шалгалтыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.<br>Шалгалтын удирдамжинд заагдсаны дагуу худалдааны 52, хоол үйлдвэрлэлийн 96, нийт 148 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажилт, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангаж буй эсэх, түүхий эд, материал, хүнсний нэмэлтийн гарал үүсэл, баталгаажилт, хадгалалтын горимын мөрдөлт, шошгын стандарт, бэлэн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, худалдаалалтын нөхцөл, зохистой дадал, байгууллагын дотоод хяналтын журмын хэрэгжилтэнд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Шалгалтын удирдамжинд заасан худалдааны нийт 52 аж ахуйн нэгжээс 49 нь хамрагдсан. Үүнээс:<br>- сунгах -35,<br>- түр түдгэлзүүлэх-3,<br>- цуцлах-11,<br>- үйл ажиллагаа зогссон- 3, нийт 52 аж ахуйн нэгжийн нэрсийг хүргүүллээ.<br>Хоол үйлдвэрлэлийн нийт 98 аж ахуйн нэгж хамрагдсан. Үүнээс:<br>- сунгах -69,<br>- хүчингүй -7,<br>үйлчилгээний ангиллын зэрэглэл буурах-1 нийт 77 аж ахуйн нэгжийн нэрсийг, шалгалт зохион байгуулсан тухай илтгэх хуудас, танилцуулгын хамт 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 8/1208 дугаар албан бичгээр УБЗАА-нд хүргүүлсэн.<br>8. Дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран тайлант хугацаанд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 16 үйлдвэрт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.<br>9. ХХААХҮЯ-аас Засгийн газрын 2019 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын үйл ажиллагааны тогтвортой байдлыг тогтоох, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ, хүчин чадлын талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулах, хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор хоршоодын хөгжлийн үнэлгээг Монголын хоршоодын мэдээлэл сургалтын төвтэй хамтран 9 хоршооны үйл ажиллагаанд хийсэн ба хоршоодын 37,5 хувь нь мал аж ахуй, газар тариалан, 12,5 хувь нь эсгий, гар урлалын үйлдвэрлэл, 50 орчим хувь нь мод, модон эдлэл, авто засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Хоршоодын үнэлгээний дүн мэдээг нэгтгэн Монголын хоршоодын мэдээлэл сургалтын төвд хүргүүлэн ажиллалаа.<br>10. Дүүргийн 1 дүгээр хорооны 22 дугаар байрны оршин суугчдаас иргэн А.Ганчимэгийн эрхэлж буй “Гранд спа” саун, массажны үйлчилгээний талаар гаргасан гомдлын дагуу дүүргийн МХХ-ээс 2020 оны 08 дугаар сард хийсэн хяналт шалгалтын явцад хүний эрүүл мэндэд ноцтой хохирол үүсч болзошгүй нөхцөл байдал үүсгэж буй тул Нийслэлийн Сүхбаатар дүүргийн прокурорын газрын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор үйл ажиллагааг түр зогсоож, зөрчлийн хэрэг нээж, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, зөрчлөө арилгах үүрэг чиглэл өгөгдсөн. Гэвч иргэн А.Ганчимэг төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг үл биелүүлэн, лацыг хөдөлгөж, үйл ажиллагаагаа дур мэдэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нээсэн зөрчил гаргасан тул дүүргийн Засаг даргын Тамгын газар, МХХ хамтран гүйцэтгэлийн хяналт шалгалт явуулж, дахин зөрчил арилгах үүрэг чиглэл өгч, зөрчлийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, Цагдаагийн хяналтад оруулсан.<br>11. Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн баталсан “Дэн буудал” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газрын Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсийн холбогдох улсын байцаагчид хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дэн буудлуудад “Дэн буудлын үйлчилгээний ерөнхий шаардлага” MNS5738:2007 стандарт”-ын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй нийт 35 дэн буудал хамрагдсан.<br>Шалгалтаар зочин хүлээн авах өрөөний цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хангалтгүй, агаарын солилцоо муу, их цэвэрлэгээг тогтмол хийдэггүйгээс архи, тамхины эвгүй үнэр нэвчсэн, зөөлөн эдлэл, цагаан хэрэглэлийг угааж цэвэрлэхийн өмнө халдваргүйжүүлэлт хийдэггүй, тохижилт болон урсгал засварыг тухай бүр хийдэггүйгээс зочин хүлээн авах өрөөнүүдийн обой урагдсан, хана, таазны шохой хуурсан, зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл, ор, ширээ сандал зэрэг тавилга, хэрэгслүүд хуучирч өнгө үзэмжээ алдсан, ажилчид нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдаагүй, мэргэжлийн сургалтанд хамрагдаж мэргэшээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн 5 дэн буудалд арга хэмжээ авч ажиллалаа.<br>12. Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлт өгсөн худалдаа, хоол үйлдвэрлэлийн 29 аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байрандаа стандарт, эрүүл ахуйн зохистой дадал, норм дүрмийг мөрдөж ажиллаж буй зэрэгт хяналт тавьж, ажлын дүн мэдээг нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүллээ. | | | | | | |
| 139 | | Байгууллагын хүсэлт, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийн дагуу санхүүгийн хяналт шалгалт хийж хариуг өгч ажиллана. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тоо, чанар | Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | - | ДАА | 100% | 100% |
| | | -Сүхбаатар дүүргийн Ахмадын хорооноос 2020 оны цалингийн тооцоолол, тогтоолтыг шалгуулах тухай 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн №8 дугаартай албан бичгийн дагуу уг асуудлыг шалгаж хариуг албаны 2020 оны 02 дугаар сарын 07 –ны өдрийн №4 дугаартай албан бичгээр,.<br>-Нийслэлийн Дотоод аудитын газраас харьяаллын дагуу шилжүүлсэн иргэний өргөдлийг шалгаж, хариуг албаны даргын 2020 оны 04 дүгээр сарын 15 тоот албан бичгээр,<br>-36-р цэцэрлэгээс “Хариу ирүүлэх тухай” 2020 оны 6 дугаар сарын 23 нд ирүүлсэн 21 дугаартай албан бичгийг судалж хариуг Албаны даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 33 дугаартай албан бичгээр,<br>-“Нийслэлийн Дотоод аудитын газраас 2020 оны 07 дугаар сарын 10 нд харьяаллын дагуу шилжүүлсэн 02/084 дугаартай албан бичгийн дагуу өргөдлийг шалгаж хариуг албаны даргын 07 дугаар сарын 31 -ний өдрийн 38 дугаартай албан бичгээр,<br>-“Багахандгайт”ОНӨААТҮГ-с Дүгнэлт гаргуулах тухай 2020 оны 08-р сарын 18-ны 13 дугаартай албан бичгийг судалж, хариуг албаны даргын 2020 оны 08 –р сарын 25 ны өдрийн 39 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлж, нийт иргэд аж ахуйн нэгжээс ирүүлсэн 5 өргөдөл хүсэлтийг шалгаж холбогдох байгууллага, иргэдэд хариуг хүргүүлж ажилласан байна. | | | | | | |
| 140 | Хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйл; | Хүнсний зориулалтын сав баглаа боодлын эрүүл ахуй, | Хүнсний тухай хууль бусад журмын | Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, эрсдэлээс | 500.0 | МХХ ХХҮХ | 100% | 100% |

<table>
<tr>
<td></td>
<td rowspan="4">ДЗДҮАХ-н 4.1.4 Хяналт шалгалтыг сайжруулж,төрийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлнэ.</td>
<td>чанар аюулгүй байдалд хяналт шалгалт хийнэ.</td>
<td>хэрэгжилтийг хангуулах</td>
<td>урьдчилан сэргийлсэн байна.</td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td></td>
<td colspan="7">Монгол улсын засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хүнсний сав, баглаа, боодлын үйлдвэрүүд, хүнсний худалдааны газрууд, хоол үйлдвэрлэлийн газруудад сав, баглаа, боодлын зориулалтаар ашиглаж байгаа нэг удаагийн нийлэг хальсан уутны хэрэглээ, худалдаалах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Саруул групп ХХК-ийн “Саруул” худалдааны төв, Гурван эвтэн ХХК-ийн “Меркури” худалдааны төв, Меркури худалдааны төвийн дэргэдэх иргэн Г.Болоржаргал “Хэрэглээ” шоп дэлгүүрийг хамруулан хийлээ. Шалгалтаар дээрх газруудад нэг удаагийн нийлэг хальсан уутны хэрэглээг хязгаарлах тухай Засгийн газрын 189 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй байлаа. Хяналт шалгалтын явцад 3 төрлийн 2853 ширхэг, 501,350 төгрөгийн үнэ бүхий нэг удаагийн нийлэг хальсан уутыг улсын /ахлах/ байцаагчийн 3 актаар хураан авч устгуулахаар “Албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгө орлого, эд зүйл хэрэгслээс хохиролд нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах, асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж шийдвэр гарган биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий Нийслэлийн Зөвлөл”-д шилжүүлж шийдвэрлэсэн. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 3 албан шаардлагыг хүргүүлэн биелэлтийг нь хангуулахаар ажиллаж байна.<br>Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжид хуванцар сав, баглаа боодлын аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхэд МХЕГ-ын хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, НМХГ-ын төв лаборатори, магадлан итгэмжлэгдсэн Номин Холдинг ХХК-ын лабораторит хамруулсан нэг удаагийн хуванцар хоолны сав, баглаа боодол ашиглаж байна. Хуванцар савны хэрэглээний талаар 3 аж ахуйн нэгжид сургалтыг зохион байгуулж ажиллалаа.</td>
</tr>
<tr>
<td rowspan="2">141</td>
<td>Ундны ахуйн усыг нийтэд түгээж буй гүний худгуудад хяналт шалгалт хийнэ.</td>
<td>Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах</td>
<td>Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна.</td>
<td>500.0</td>
<td>МХХ ТНААХ</td>
<td>100%</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшилд байгаа 25 гүний худаг, гэр хорооллын ус түгээх цэг, шугамын худаг 12, хүүхэд өсвөр үеийн 13 байгууллага аж ахуйн нэгж иргэдийн 9 гүний худаг, төвлөрсөн усан хангамжийн 10 хэрэглэгчийн цэг, 3 гол булаг шандын усны чанар найрлагын байдалд хяналт шинжилгээ хийлээ. Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 11 буюу 72 хувь нь “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 12.4.1-д заасны дагуу эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, ялангуяа шинээр гаргасан худгууд цаашид эрүүл ахуйн бүс тогтоох боломжгүй, бохирдуулах боломжтой эх үүсвэрийн дунд байрласан; гүний худагт ажиллагсадын 72 хувь нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаагүй; ус түгээх байр гүний худгуудад эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоох боломжгүй байна. Шинжилгээ, сорилын дүнгээр нян судлал, хими, хүнд металлын шинжилгээ хийлгэхэд 5 буюу 14.8 хувь нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй, үзүүлэлтээр нь ангилвал: нян судлалын шинжилгээг 3 үзүүлэлтээр хийлгэхэд 7 нь эерэг гарч “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” MNS 900:2005 стандартаас 1.2-2.9 дахин их гарсан байна. Санзайн хойд булгийн ус, 19 дүгээр хорооны булгийн ус, Сэлбэ голын уснаас /3 гол, булаг, шанд/ 6 сорьц дээж авч шинжилгээнд хамруулахад итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгээс үзэхэд “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормоор үнэлгээ дүгнэлт өгөхөд II буюу цэврийн зэргийн ангилалд байна. Шалгалтын явцад 8 зөрчил, дутагдал илрүүлэн, 85 хувийг нь арилгуулж, унд ахуйн усны чанар найрлагад хийсэн шинжилгээний дүнг үндэслэн,</td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 10 дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийн дагуу 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 6.17 дугаар зүйлийн 1 дэх заалтаар 2000.0 мянган төгрөг, 3 иргэнд 600,0 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж, эрх бүхий албан тушаалтны албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, гүний худгийн уснаас давтан дээж авч, шинжлүүлэхэд 100% стандартын шаардлага хангасан байна. 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02-01/738, 2020 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн 02-01/1574 дугаартай 2 төрлийн мэдэгдэлийг 38 ус хангамжийн үйлчилгээ эрхлэгчид хүргүүллээ.<br>Цаашид төвлөрсөн бус усан хангамжийн хамгаалалтын бүсэд авах арга хэмжээг сайжруулах, эх булгийг паспортжуулахад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, дүүргийн засаг захиргааны байгууллагаас нутаг дэвсгэртээ байгаа уст цэгийн ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавьж, нэгдсэн судалгаа, бүртгэл, мэдээллийн сантай болох, хүн амын дунд ундны усыг зөв зохистой хэрэглэх, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх мэдлэг хандлагыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын оновчтой хэлбэрийг ашиглан олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр богино хэмжээний сурталчилгаа явуулах шаардлагатай байна. | | | | | | |
| 142 | | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 35-40 байгууллагын санхүү аж ахуйн болон үйл ажиллагаанд санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны засгийн газар, байгууллага иргэдээс олгосон зээл, өгсөн хандив тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт зарцуулалтад хяналт тавьж, зөвлөн тусалж ажиллана. | 2020 онд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудын хуваарь гарган төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан ажиллах | Төрийн үйлчилгээ хүнд сурталгүй, шуурхай болно. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж заавар журам, стандартын хэрэгжилт хангагдаж, байгууллагын үйл ажиллагаа сайжирч, үнэ цэнэ нэмэгдсэн байна. | | ДАА СТСХ | 100% | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирамжийн хамрах хүрээний Төрийн өмчийн ерөнхий боловсролын 19-20 сургуульд "Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив"-ын санхүүжилтийн гүйцэтгэлд "Гүйцэтгэлийн аудит", төрийн өмчийн 20 цэцэрлэгийн 2018,2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж дүгнэлт гаргаж зөвлөмж өгсөн ба төрийн өмчийн 2 сургууль, Биеийн тамир спортын хороо, 234,248,225,109-р цэцэрлэгийн 2018,2019 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хийх аудит үргэлжилж байна. Аудитаар: анхан шатны баримтын бүрдэл дутуу, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, акталсан хөрөнгийг шийдвэрлээгүй, холбогдох дүрэм журам хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой нийт 796572,8 мянган төгрөгийн зөрчил илэрч 144 заалт бүхий 21 зөвлөмж өгсөн байна.<br>Үүнээс 186 дугаар цэцэрлэгт 146,794.2 мянган төгрөгийн зөрчилд 5 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 143 | | Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон дээд байгууллагын шийдвэрээр тусгайлсан аудит, Санхүүгийн хяналт шалгалт хийнэ. | Өгөгдсөн үүрэг даалгавар, гаргасан хүсэлтийг хуулийн хүрээнд шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргах | Зөрчил дутагдал арилж, хууль тогтоомжийн биелэлт хангагдан, төсвийн үр ашиг дээшилсэн байна. | | ДАА СТСХ | 100% | 100% |
| | | Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу Улсын төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний барилга, байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын үйл ажиллагаа, түүний үр дүнд эрсдэлд суурилсан дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх хэрэгжилтийг хангахаар Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж буй 44 барилга байгууламжийн захиалагчийн техник хяналтын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийхээр Сүхбаатар дүүргийн Худалдан авах ажиллагаанаас тодруулахад тус дүүрэгт улсын төсвөөр худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирээгүй бөгөөд захиалагчийн техник хяналт хийгдээгүй тул судалгаа гаргах боломжгүй байна. Энэ тухай Сангийн Яамны Санхүүгийн хяналт эрсдлийн удирдлагын газарт 2020 оны 04-р сарын 17-ны өдрийн 12 тоот албан бичгээр хүргүүллээ. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр 1 болон 68 дугаар цэцэрлэгийг шалгах ажлын хэсэгт орж, 5 асуудлаар шалгаж дүгнэлт гарган, ажлын хэсэгт нэгтгүүлсэн. | | | | | | |
| 144 | | Авто засварын газруудад хяналт, шалгалт явуулах, хууль бус мод бэлтгэх ажлыг таслан зогсоох чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. | Дүүргийн нутаг дэвсгэр дэх 80 Авто засварын газруудад хяналт, шалгалт явуулах, хууль бус мод бэлтгэх ажлыг таслан зогсоох | Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгасан байна. | 1,000.0 | ХХҮХ | 100% | 100% |
| | | “Автотээврийн тухай” хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Авто үйлчилгээ-Ангилал, Ерөнхий шаардлага MNS5025:2010, “Автомашины угаалгын үйлчилгээ.Ангилал, Ерөнхий шаардлага” MNS5347:2003 стандартуудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Нийтийн тээврийн үйлчилгээний газрын даргын баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид хийх шалгалтын удирдамж”-ийн хүрээнд 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд Нийтийн тээврийн үйлчилгээний газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч, Авто үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн алба хаагч нартай хамтарсан шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>Шалгалтад Сүхбаатар дүүрэгт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 59 аж ахуйн нэгж, иргэн хамрагдаж холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангасан 28 иргэн аж ахуй нэгж Нийтийн тээврийн үйлчилгээний газарт хүсэлт гарган Ангиллын гэрчилгээ 24, саналын хуудас 19 олгож дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүсэлт гаргасан 43 иргэн, аж ахуйн нэгжтэй Худалдаа, үйлчилгээ эрхлэх гурвалсан гэрээ байгуулж “Батламж” олгоод байна.<br>Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах зорилгоор 14 аж ахуйн нэгж, иргэнд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар 13 дах заалт, 15 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг үндэслэн 2 500 000 төгрөгийн шийтгэл ногдуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 145 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл ; ЗГҮАХ-ийн 5.7 Жендерийн тэгш байдлыг хангах, Дүүргийн ИТХТ-ийн 2018.06.07-ны өдрийн Жендерийн дэд хөтөлбөр батлах тухай 21 дүгээр тогтоол; ДЗДҮАХ-ийн 4.1.4 Хяналт шалгалтыг сайжруулж, төрийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлнэ. | Жендерийн тэгш байдлыг хангах хөтөлбөрийн биелэлт хангах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хөтөлбөрийн биелэлт хангагдсан байна. | 10,000.0 | ТЗУХ ХЗТ | 100% | 100% |
| | | Шинэ Covid-19 өвчний улмаас Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 62 дугаар тогтоол, 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 64 дүгээр тогтоол, 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны Иргэдийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/108, Иргэдийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай А/223, Коронавируст /КОВИД-19/ халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай А/436, Захирамжид өөрчлөлт оруулах тухай А/590, А752 дугаар захирамжийн дагуу олон хүн цуглуулах, танхимын сургалт зохион байгуулах үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон тул иргэдэд зориулсан сургалт хийгдээгүй.<br>Хороодын Хэв журмын урамшуулалт эргүүлийн эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Хууль зүйн үндэсний хүрээлэн, дүүргийн Цагдаагийн газартай хамтран 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр дүүргийн хурлын танхимд хороодын Хэв журмын урамшилтай 79 эргүүлд “Хууль бидний амьдралд” сэдэвт 2 цагийн сургалт зохион байгуулав. Сургалтаар Хэв журмын урамшилтай эргүүлүүдэд Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн тасгийн дарга П.Булганмаа Жендэрийн хэвшмэл ойлголтын тухай 30 миунтны мэдээлэл өглөө. | | | | | | |
| 146 | НЗДҮАХ-ийн 5.1.6 "Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр" хэрэгжүүлж, авлигаас ангид төрийн албыг бэхжүүлсэн тунгалаг хот болно.ДЗДҮАХ-ийн 4.1.4 Хяналт шалгалтыг сайжруулж, төрийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлнэ. | Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан заалтын хэрэгжилтийг хангаж ажиллана. | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан заалтын хэрэгжилтийг 95 хувьд хүрсэн байна. | 10,000.0 | ТЗУХ | 100% | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/435 дугаар захирамжаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж ирүүлсэн. Уг төлөвлөгөөний дүүрэгт хамаарах 15 заалтын хэрэгжилтийг хангуулахаар холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. | | | | | | |
| 4.2 Татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар хураалтыг эрчимжүүлнэ. | | | | | | | | |
| 147 | ДЗДҮАХ-ийн 4.2.1 Улс олон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангаан татвар | Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ. | Хяналт шинжилгээ үнэлгээний ТУ-2.4 стандартын дагуу 100 хувийн | Улс, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах | - | ТХ СТСХ | 100% | 100% |

<table>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2">хураалтыг эрчимжүүлэн төлөвлөгөөг биелүүлж ажиллана.</td>
<td></td>
<td>гүйцэтгэлд хүргэж ажиллах</td>
<td>ажлыг зохион байгуулан гүйцэтгэлд хяналт тавих замаар өссөн дүнгээр 100% биелүүлсэн байна.</td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td colspan="7">2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөр өссөн дүнгээр улсын төсөвт 119,283,600 мянган төгрөг төвлөрүүлэхээс 107,018,886 мянган төгрөг төвлөрүүлж 89,72 хувийн, нийслэлийн төсөвт 109,642,041 мянган төгрөг төвлөрүүлэхээс 68,295,271 мянган төгрөг төвлөрүүлж 62,2 хувийн, орон нутгийн төсөвт 94,500,340 мянган төгрөг төвлөрүүлэхээс 52,969,031 мянган төгрөг төвлөрүүлж 56,5 хувийн, нийт 3 төсвийн нийлбэр дүнгээр 323,425,982 мянган төгрөг төвлөрүүлэхээс 228,283,188 мянган төгрөг төвлөрүүлж 70,5 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.<br>Орон нутгийн төсөв тасарсан шалтгаан:<br>1. Монгол Улсын Их хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоол, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай, Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай зэрэг хуулиуд гарсанаар татварын төрлүүд дээр орлого төвлөрүүлэхэд хүндрэл үүссэн.<br>Цар тахлын улмаас аялал жуулчлалын тоо эрс буурах, улсын онцгой комиссоос гаргасан олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх талаар гаргасан тогтоол хэрэгжиж байсантай холбоотой хоол үйлдвэрлэл, баар, рестораны үйл ажиллагаа, дотоодын аялал жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээнд сөргөөр нөлөөлж түүнийг түшиглэсэн бичил бизнес эрхлэгчдийн орлого буурч татварын өр, дутууг төлөхөд хүндрэл гарч байна. 2020 оны 10 дугаар сараас үйл ажиллагаа нь хэвийн явагдаж эхэлсэн боловч жигдрээгүй байгаа бөгөөд урд саруудын алдагдалаа нөхөж чадаагүй байгаа талаар тайлбар өгч байна.<br>Цар тахлын улмаас улсын онцгой комиссоос хил хаасантай холбоотойгоор бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, эргэлтэнд сөргөөр нөлөөлж үйл ажиллагаа нь доголдсон.<br>2. Улсын тэмдэгтийн хураамж нь төрийн эрх бүхий байгууллагуудаас үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгөөс бүрддэг бөгөөд тухайн иргэн, хуулийн этгээд хэзээ үйлчилгээ авахаас хамаарч энэ төрлийн хураамжийг холбогдох төсөвт төвлөрүүлдэг.<br>2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 5.6 Үрчилсний, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний, хүйс өөрчлөгдсөний, шилжилт хөдөлгөөний, Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоосны бүртгэлээс бусад иргэний улсын бүртгэлийг засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй бүртгэнэ гэж заасан байна Мөн 2018.11.01-ний өдөр батлагдсан А/207 актын дугаартай Иргэний улсын бүртгэл хөтлөх журамын 1.2 Иргэний улсын бүртгэлийн дараах төрлийг засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй бүртгэнэ: гэж заасны дагуу 2018 онд Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст төвлөрч байсан Улсын тэмдэгтийн хураамж нь 2019 оноос эхлэн нийслэлийн 9 дүүрэгт хуваагдаж ордог болсон.<br>Мөн Covid-19 цар тахлын улмаас гадаад улсад зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотойгоор гадаад паспортын улсын тэмдэгтийн хураамжид нөлөөлөл үзүүлж байна.<br>3. Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайлангийн төрлөөр 2019 онд улсын хэмжээнд 76,010,138.6 мянган төгрөгийн татварын орлого орсон үүнээс Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст 28,243,724.0 мянган төгрөгийн татварыг дүүргийн төсөвт төвлөрүүлсэн. Энэ нь нийт орлогын 37,1% нь байна.</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td colspan="7">Хувь хүний орлогын албан татварын шинэчилсэн найруулгатай холбоотой өөрчлөлтөөс тогтмол бус үйл ажиллагааны орлогод ногдуулсан татвар (10 хувь), газар эзэмших, ашиглах эрх борлуулсны орлогод ноогдуулсан татвар, хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлого, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүн болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн урлагийн тоглолтод оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлогод ногдуулсан татвар (5 хувь) гэсэн заалтууд нь шинэ Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайлангийн маягтанд ороогүй байна. Мөн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогооос бусад хүүгийн орлого (зээлийн хүү, харилцах дансны үлдэгдэл, батлан даалт гаргасны төлбөр, өрийн бичиг/бонд/, хууль болон гэрээний дагуу авч байгаа хүү, анзын орлого) нь 2020 оны 04 сарын 29 ны өдөр батлагдсан<br>“КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ” хуулийн 10 дугаар зүйл.Төв банк болон арилжааны банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ 10.4.Цар тахлын үед банкны харилцах дансанд хүү тооцохгүй, гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй бөгөөд иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ гэж заасны дагуу 2020 оны 12 сарын 31 ний өдрийг хүртэл уг орлого төвлөрөхгүй байх шалтгаан болж байна.<br>2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулинд 16.1.10.хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого чөлөөлж байсан бол 2019 оны 03 сарын 22 өдөр шинэчлэн найруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулинд 22.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого; гэж өөрчлөлт орсон нь нөлөө үзүүлж байна.</td></tr>
<tr><td rowspan="2">148</td><td rowspan="2">ДЗДҮАХ-ийн 4.2.2 Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хууль, Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль болон бусад татварын хууль тогтоомжийг сурталчилан ажиллана.</td><td>Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Авто зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийг холбогдох газруудтай хамтран төвлөрүүлэн ажиллана.</td><td>Ногдуулсан татварыг стандарт түвшинд хүргэн хураах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах</td><td>Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Авто зам ашигласны төлбөр холбогдох дансанд төлөвлөгөөний дагуу төвлөрсөн байна.</td><td>-</td><td>ТХ<br>СТСХ</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">2020 оны АТБӨЯХАТ-ын төлөвлөгөө 5,050,842.8 мянган төгрөг батлагдан өгөгдсөнөөс 4,544,317.5 мянган төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлж 90.8 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна./ 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар/<br>АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ төвлөрүүлэх зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/15 захирамжийн дагуу СБД-ийн Засаг даргын 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/22 тоот захирамж гарч, ажлын хэсэг байгуулагдсан. АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ хураах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн хэлтэс албад, өөрийн хэлтсийн нийт ажилтнуудын тээврийн хэрэгслийн судалгааг номерын дугаараар гаргуулж, өөрсдийн машины татвараа хугацаанд нь төлөх, нэмж доод тал нь 10 хүнд зөвлөгөөг өгч татварыг төлүүлэх ажлын зааварчилгаа сурталчилгаа хийж ажилласан. Дүүргийн замын цагдаагийн хэлтэстэй хамтран төлөгдөөгүй тээврийн хэрэгслийг зогсоож татвараа төлөхийг сануулах арга хэмжээ аван ажилласан. Татварын хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний авто хариуцсан 2 татварын улсын байцаагч иргэний тээврийн хэрэгслийн татварыг хүлээн авч, татварын хувь хүний татварын тасгийн 1 байцаагч аж ахуй</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td colspan="7">нэгжийн тээврийн хэрэгслийн татварыг хүлээн авч ажиллаж байна. Татварын алба шинэлэг хэлбэрээр цахим татварын системийг нэвтрүүлэн ажиллаж иргэд татвар төлөгч нар хаана ч цахимаар татвар төлөх бүрэн боломжтой болсон. Татварын алба ТУНС буюу Татварын удирдлагын нэгдсэн систем нэвтрүүлж татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд нэхэмжлэхэд суурилсан төлбөр төлөх боломжоор хангасан нь энэ системийн давуу тал болж байна. Мөн төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах замаар И-баримт сайтад нэхэмжлэх үүсгэн татвараа төлдөг болсон. Шинэ системийн талаар олон удаагийн сургалт, мэдээ мэдээлэл тараах материал тараагдсан бүрэн хөгжүүлэлт хийгдсэн байна. Төлөгдөөгүй тээврийн хэрэгслийн судалгааг гарган файлаар болон тус бүрээр хэвлэн бичиг хэргийн зардал, шуудан холбооны зардалтай нь 1-20 дугаар хороодод албан бичгээр хүргүүлэн АТБӨЯХАТ-ыг төлүүлэх арга хэмжээ аван хамтран ажилласан.<br>АТБӨЯХАТ , агаарын бохирдлын төлбөр ,авто зам ашигласны төлбөр хураалтын хяналтын үзлэг шалгалт,Улаанбаатар хотын ерөнхий менежер захирагчийн ажлын албаны даргын удирдамжийн дагуу тус дүүргийн замын цагдаагийн хэлтэстэй хамтран төлөгдөөгүй тээврийн хэрэгслийн үзлэг шалгалтын хүрээнд:<br>1-р ээлж:<br>2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 10-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаанд нийслэлд бүртгэлтэй албан татвар, төлбөрөө тогтоосон хугацаанд төлөөгүй авто тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулж, хуулиар ногдуулсан албан татвар ногдуулах тус ажлыг Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1-р хэлтсийн албан хаагчидтай хамтран ажиллаж нийт 544 гэрчилгээ хураагдаж ирсэнээс өнөөдрийн байдлаар 464 тээврийн хэрэгсэлийн татвар төлөгдөж Авто тээвэр -215,411,883.70 Зам ашигласаны төлбөр 102,967,531.01 Агаарын бохирдолын төлбөрт- 380,630.00 төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллаж байна.<br>Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар , агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласаны төлбөр хураалтын 2 дугаар үе шатын хяналтын үзлэг, шалгалтыг Нийслэлийн татварын газар, Тээврийн цагдаагийн алба, Дүүргийн татварын хэлтэс хамтран зохион байгуулах ажлын хүрээнд:<br>2-р ээлж:<br>2020 оны 10 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1-р хэлтсийн албан хаагчидтай хамтран ажиллаж нийт 88 гэрчилгээ хураагдаж ирсэнээс өнөөдрийн байдлаар 67 тээврийн хэрэгсэлийн татвар төлөгдөж Авто тээвэр-4,404,996.0 Зам ашигласаны төлбөр 1,629,300.0 Агаарын бохирдолын төлбөрт- 131,886.0 төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллаж байна.<br>Мөн өртэй Аж ахуй нэгж дээр графикаар төлүүлэх арга хэмжээ авч цаашлаад авто тээврийн татвараа төлөх боломжгүй газруудад албан бичгээр битүүмжлэх болон мэдэгдэх хуудсыг арилжааны 5 банканд хүргүүлэн ажиллаж байна.</td>
</tr>
<tr>
<td rowspan="2">149</td>
<td rowspan="2"></td>
<td>Татварын баазад бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг бүртгэх, хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэх асуудлыг шийдвэрлэх, бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг татварт бүрэн хамруулах, өрийг барагдуулах ажлыг зохион байгуулна.</td>
<td>Татварт хамрагдсан татвар төлөгчийн тоо нэмэгдэж, батлагдсан төлөвлөгөөний дагуу төсвийн орлогыг төвлөрүүлэх</td>
<td>Үл хөдлөх эд хөрөнгийг бааз суурийг нэмэгдүүлж, татварт бүрэн хамруулсан байна.</td>
<td>-</td>
<td>ТХ<br>СТСХ</td>
<td>100%</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">2020 онд Үл хєдлєх эд хєрєнгийн албан татвар тєлєгчийн бүртгэлийг сайжруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажил зохион байгуулан ажилласнаар бүртгэлгүй байсан хөрөнгүүдийг бүртгэлжүүлэн татвар ногдуулан ажиллаж байна.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2020 онд шинээр 75 хуулийн этгээд, иргэний нийт 163 үл хөдлөх эд хөрөнгийг шинээр бүртгэн 1,731,559.6 мянган төгрөгийн татварийг ногдуулан ажилласан.<br>УБЕГ-аас шинээр гэрчилгээ гаргуулан авсан хөрөнгүүдийн судалгаан дээр ажилбар хийн 93 татвар төлөгчийн 210 хөрөнгийг шинээр бүртгэн 2,264,081 мянган төгрөгийн ногдол оруулан ажиллаж байна.<br>Хот байгуулалт, хөгжлийн газраас ирүүлсэн судалгааны дагуу 2 татвар төлөгчийн 2 хөрөнгийг бүртгэн 49,138.5 мянган төгрөгийн ногдол оруулан ажиллаж байна.<br>ERP болон EDOC системд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт бүртгүүлэх, хасуулах, өөрчлөлт хийлгэх тухай ирсэн нийт 254 албан хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. | | | | | | |
| 150 | | Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд хог хаягдлын хураамжийг барагдуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хууль тогтоомжийн дагуу хог хаягдлын хураамжийг хураасан байна. | - | ТХ СТСХ | 100% | 100% |
| | | 2020 онд дүүргийн нутаг дэвсгэрт Хог хаягдлын Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Улаанбаатар дэвшил ХХК гэсэн 3 компани ажилласан.<br>Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоор орон нутгийн төсөвт 2019 онд 2,100,322.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,000,678.6 мянган төгрөг төвлөрүүлж 95.5% ийн гүйцэтгэлтэй ажилласан. 2020 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө 5,400,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,697,747.9 мянган төгрөг төвлөрүүлж 31.4% ийн гүйцэтгэлтэй байна.<br>2020 оны төлөвлөгөө нь 2019 оны төлөвлөгөөнөөс 2.6 дахин өндөр тавигдсан нь үндэслэлгүй өндөр тавигдсан гэж үзэж байна. Мөн Монгол Улсын Их хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолын дагуу ААНБ, сургууль, цэцэрлэгүүд, үйлчилгээний газрууд ажиллахгүй болсон нь орлого тасрахад нөлөөлсөн. | | | | | | |
| 151 | | “Татвар төлөгчийн өдрүүд” арга хэмжээний хүрээнд татварын хууль, тогтоомжийг сурталчлах, татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Татвар төлөгч болон шинэ татвар төлөгч нарт сегментээр, татвар төлөгчийн салбарын ангиллаар нь системтэй сургалтыг явуулсан байна. | 20,000.0 | ТХ СТСХ | 100% | 100% |
| | | Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу жил бүрийн тавдугаар сарын хоёр дахь долоо хоногт “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг зохион байгуулдаг. 2020 оныг “Цахим татварын жил” болгон дэвшүүлсэн зорилтот ажлын хүрээнд энэ удаагийн татвар төлөгчдийн өдрүүдийг “Эрсдэлийн эсрэг хамтдаа” уриан дор 2020 оны 5 сарын 04-нөөс 08-ны өдрүүдэд коронавирусын цар тахлын улмаас цахимаар амжилттай зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>- “Миний мэдэх татвар” гар зураг, эссэ бичлэг уралдаан<br>-“Стейниц” МШАкадемитай хамтран “Ирээдүйн татвар төлөгч”-дийн дунд Онлайн шатрын тэмцээн<br>- Авто родио 96.3 FM-тэй хамтран зохион байгуулсан асуулт, хариултын тэмцээн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - Зах худалдааны төвийн төлөгчидтэй биечлэн уулзаж шинэчлэгдэн батладсан хууль тогтоомжийг танилцуулж, гарын авлага тараасан<br>- И-баримт олгоход хүндрэлгүй, худалдан авалт хийж буй иргэдэд хохиролгүй гарцыг шийдвэрлэх, И-баримтад холбогдоогүй бол хэрхэн холбогдох талаар зөвлөгөө заавар өгч ажилласан<br>- Сүхбаатар дүүргийн 20 хорооны мэдээллийн самбаруудыг шинэчилж, тараах материалуудаар дүүргэсэн<br>- Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг цахимаар хэрхэн төлөх заавар зөвлөгөөтэй 2000 ширхэг тараах материалыг тараасан<br>- Монголын үндэсний телевизийн цагийн хүрд мэдээллийн хөтөлбөр, Like телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр татварын талаар мэдээлэл хүргэж ярилцлага өгсөн<br>- Өдрийн сонин, www.in-mongolia.mn , www.times.mn цахим мэдээллийн сайтуудаар COVID -19 ЦАР ТАХАЛЫН ҮЕД ТАТВАР ТӨЛӨГЧ ТАНЫ ЭДЛЭХ ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЧӨЛӨӨЛӨЛТ гарчигтай нийтлэл гаргасан<br>- Нийгмийн хариуцлагаа хүлээж татвараа хугацаандаа төлсөн 12 татвар төлөгчдийг цахим хуудсанд алдаршуулан байршуулсан<br>- Мөн албан хаагчдыг “Facebook”-ийн профайл зургандаа “Татвар төлөгчдийн өдрүүд 2020” хүрээг нэмж нэгдэхийг уриалж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. | | | | | | |
| 152 | | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Татварт хамрагдсан татвар төлөгчийн тоо | Татвар төлөгчдийн хуулийн мэдлэг дээшилж, татварт хамрагдсан татвар төлөгчийн тоо нэмэгдсэн байна. | 10,000.0 | ТХ<br>СТСХ | 100% | 100% |
| | | Борлуулатын орлого 50 сая төгрөгөөс давсан НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдвэл зохих 540 хуулийн этгээдийн судалгааг жижиг болон бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн байцаагчдад хуваан өгч утсаар дуудан ирүүлэх, бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 12 сарын 01-ны өдрийн байдлаар чөлөөлөгдөх орлоготой -41, валютын ханшийн орлоготой-28, өөр дүүрэгт бүртгэлтэй-8, НӨАТ суутган төлөгчөөр 399 татвар төлөгчийг бүртгэж 83.3 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна<br>‘’Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8, Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журмын, 6.2.2-т заалтыг үндэслэн Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газраас ирүүлсэн 830 хуулийн этгээд болон иргэдийг албан татвар суутган төлөгчийн бүртгэлээс хасах бааз цэгцлэх ажилбар хийгдэж байна.<br>Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа зах худалдааны төвүүдэд 2020 оны 08-р сарын 17-ны өдрийн 04/1414 дугаар албан бичиг хүргүүлж лангуугаар худалдаа эрхлэгчдийн судалгаа гарган 41 худалдааны төвөөр худалдаа, үйлчилгээ эрхлэгч 1265 иргэн, 346 хуулийн этгээдийн лангуу, павилон тус бүрт QR код бүхий наалтыг наан байршуулах ажлыг зохион байгуулан хүргэн ажиллаж байна. Мөн ТЕГ, НТГ-ын даргаас өгсөн чиглэлийн дагуу 2020 оны 09 сарын 28-ны өдөр Сүхбаатарын талбай дээр зохион байгуулагдсан “Номын баяр 2020” үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэн, ААН-ыг бүртгэлжүүлэн 77 ширхэг QR код бүхий наалтыг хэвлэн нааж зөвлөгөө өгч, арга зүйгээр хангаж ажилласан. Тус дүүргийн нутаг дэвсгэрт бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн 2-р ээлжийн судалгааг гарган 764 татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийн судалгааг Нийслэлийн татварын газарт хүргүүлэн ажиллаж байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТЕГ-ын 2020 оны 09 сарын 30-ын өдрийн 03 тоот даргын албан даалгаврын дагуу тус дүүрэгт байрлах зах, худалдааны төвүүдийн QR коджуулалт, ашиглалтад хяналт тавих ажлын хүрээнд ТУБ болон хураагч нар зах худалдааны төвүүдээр хяналт тавьж QR код ашиглах заавар зөвлөгөө өгч хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.<br><br>Нийслэл хотын албан татвараар 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөр өссөн дүнгээр 952,878 мянган төгрөгийн төлөвлөгөө өгөгдсөнөөс 542,623 мянган төгрөг төвлөрүүлж 56.9 хувийн гүйцэтгэлийн явцтай ажиллаж байна.<br>Нийслэл хотын албан татвар суутган төлөгч нь баар, ресторан, амралтын газар, зочид буудалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүд байдаг. Гэтэл Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас Улсын болон нийслэлийн онцгой комиссын шийдвэрийн дагуу 2020 оны 2 дугаар сарын 01-нээс баар, зочид буудал, амралтын газрын үйл ажиллагаа бүрэн зогссон, 2020 оны 04 дүгээр сарын16-ны өдрөөс нийслэлийн онцгой комиссын шийдвэрээр амралтын газар, зочид буудлын үйл ажиллагааг нээсэн боловч хил хаалттай нөхцлөөс үүдэн гадаад улсаас ирэх жуулчид байхгүйтээ холбогдон үйл ажиллагаа сэргэж чадахгүй байгаа, мөн рестораны үйл ажиллагаанд цагийн хязгаарлалт тавигдсантай холбоотой борлуулалтын орлого эрс буурсан зэрэг шалтгаан нөхцлөөс үүдэн нийслэл хотын албан татварын төлөвлөгөө биелүүлэхэд хүндрэл үүсч байна.<br>Нийт 66 аж ахуйн нэгж, 102 иргэнтэй холбогдож ажилбар хийлээ. Үүнээс 31 газарт шаардлага хүргүүлж , 33 газраас тайлбар авч , 51 газрыг нийслэл хотын албан татвар төлөгчөөр бүртгэж , 53 газарт ажилбар хийгдэж байна. | | | | | | |
| 153 | | Татварын удирдлагын нэгдсэн систем /TAIS/, шинээр батлагдсан хууль тогтоомжийг татвар төлөгчдөд сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулна. | Хууль тогтоомж, холбогдох журам, зааварчилгаанд нийцүүлэх | Татвар төлөгчдийн хуулийн мэдлэг дээшилж, татварт хамрагдсан татвар төлөгчийн тоо нэмэгдсэн байна. | 20,000.0 | ТХ<br>СТСХ | 100% | 100% |
| | | TAIS-ийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор Татварын албанаас нэхэмжлэхэд суурилсан цахим төлбөрийн системийн талаарх сургалтыг 3 удаа, шинэ татварын багц хуулиар “Хїннї Молл” ХХК-ийн нягтлан бодогч, санхүүгийн 11 ажилчдад, Нийслэлийн ерөнхий боловсролын 25-р сургуулийн 52 багш ажилчдад, “Єсвєрийн зохион бүтээгчдийн ахлах сургууль”-ийн 36 багш ажилчдад Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хуулиар сургалт зохион байгуулсан. Мөн татвар төлөгчдийн өдрөөр 43 зах худалдааны төвийн 1388 татвар төлөгчидтэй биечлэн уулзаж шинэчлэгдэн батладсан хууль тогтоомжийг танилцуулж, 5262 татвар төлөгчдийг гарын авлага тараах материалаар ханган ажилласан.<br>Иргэний боловсролд” шууд нэвтрүүлэгт 2 удаа оролцож Нэмэгдсэн єртгийн албан татварын хууль, И-баримтын талаар мэдээлэл зєвлєгєє єгч ажилласан. Монголын үндэсний телевизийн цагийн хүрд мэдээллийн хөтөлбөр, Like телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр татварын хуулийн талаар мэдээлэл хүргэж ярилцлага өгсөн. Мөн өдрийн сонин, www.in-mongolia.mn , www.times.mn цахим мэдээллийн сайтуудаар COVID -19 ЦАР ТАХАЛЫН ҮЕД ТАТВАР ТӨЛӨГЧ ТАНЫ ЭДЛЭХ ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЧӨЛӨӨЛӨЛТ гарчигтай нийтлэл гаргаж ажиллалаа.<br>2020 ны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар Сїхбаатар дүүргийн Татварын хэлтсийн Фэйсбүүк хуудсаар 302 удаагийн цаг үеийн мэдээ мэдээллийг татвар төлөгчдөд түгээн ажиллаж байна. | | | | | | |
| | | 4.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ. | | | | | | |
| 154 | Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйл; НЗДҮАХ-ийн 4.2.15, | Нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох судалгааны ажлыг | Хамтран ажиллах байгууллага, | Судалгааны үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, | 1,500.0 | НХХ<br>ЭМТ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.2.16 дахь заалт, ДЗДҮАХ-ийн 4.3.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ. | эрчимжүүлж, Онол практикийн хурал зохион байгуулна. | судалгааны ажлын тоо, чанар | эмчилгээ оношлогооны шинэ арга техник тодорхойлогдсон байна. | | | | |
| | | -Дүүргийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/169 дугаар захирамжийн хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн техник, технологи, эмчилгээний шинэ арга, аргачлалын үр дүнг хэлэлцүүлэх, дүүргийн хүн амын дундах өвчлөлийн бүтэц, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор эмч, мэргэжилтнүүдийн дунд "Эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл 2020" Онол практикийн хурал зохион байгуулж, нийт 31 илтгэл хэлэлцүүлсэний 42,5% нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, 57,5% нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлийн байна. "Эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл 2020" онол практикийн хурлаас 3 эмч, 3 сувилагчийн шилдэг илтгэлийг шалгаруулан, дүүргийн Засаг даргын Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнан урамшууллаа.Судалгааны илтгэлүүдээр илтгэлийн хураангуй эмхтгэл хэвлүүлж, судалгааны гарын авлага болгон ашиглаж байна. | | | | | | |
| 155 | | Дүүргийн хүн амын эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх тандалт судалгаа хийнэ. | Судалгааны тоо | Судалгаа хийгдсэн байна. | 10,000.0 | НХХ ЭМТ | 100% | 100% |
| | | -Дүүргийн хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн тоо мэдээ, статистик тайланд дүн шинжилгээ хийж, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх тандалт судалгаа хийх удирдамж болон судалгаа хийхэд шаардагдах төсөв боловсруулсан. Коронавирусийн халдвараас шалтгаалан орон нутгийн төсвийн судалгааны ажил түр хойшлогдоод байна.<br>-АШУҮИС-тай хамтран "Судалгаа хийх арга, аргачлал" сэдвээр дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний 42,2%-ийг сургалтад хамруулсаны үр дүнд 2020 онд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээр чиглэлээр 31 судалгааны ажил хийгдэж, эмхэтгэл хэвлүүлсэн. | | | | | | |
| 156 | НЗДҮАХ-ийн 4.2.13 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.3.3 Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцон ажиллана. | Өрхийн эрүүл мэндийн төвийн 3 талт гэрээг шинэчлэн байгуулж, хагас, бүтэн жилээр үр дүнг тооцно. | 3 талт гэрээний шалгуур үзүүлэлтээр | Гэрээний хэрэгжилт сайжирсан байна. | 20,000.0 | НХХ ЭМТ | 100% | 100% |
| | | -Дүүргийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гурван талт гэрээний гүйцэтгэлээр шагнаж урамшуулах тухай А/72 дугаар захирамжаар 2019 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр "Бүрэн хангалттай" дүгнэгдсэн 7, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 17 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг тус бүр 500,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа.<br>-Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Гүйцэтгэлийн гэрээ байгуулах тухай" А/193 дугаар захирамж, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах тухай" А/13 дугаар тушаалын дагуу дүүргийн 16 Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/68 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гурван талт гэрээний 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг гэрээг үнэлэхэд 89.8% буюу Хангалттай дүгнэгдсэн.<br>Жилийн эцсээр дүгнэнэ. | | | | | | |
| 4.4 Иргэн бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | |

<table>
<tr>
<td rowspan="2">157</td>
<td rowspan="2">НЗДҮАХ-ийн 4.2.1 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 4.4.1 Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж, Иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа хамруулж эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллана.</td>
<td>Халдварт бус өвчнийг эрт илрүүлгийн хувийг нэмэгдүүлэх "Эрүүл иргэн" аян хэрэгжүүлнэ.</td>
<td>Эрт илрүүлгийн дундаж хувийг 60%-д хүргэх</td>
<td>Дүүргийн нийт хүн амын 5-аас дээш хувийг "Эрүүл иргэн аян"-ны үйл ажиллагаанд хамруулсан байна.</td>
<td>20,000.0</td>
<td>НХХ ЭМТ</td>
<td>100%</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">-“Эрүүл иргэн” аяны нээлтийн өдөрлөгийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Эрүүл мэндийн төвийн зөвлөх поликлиник, Салбар амбулатори 1, Гал унтраах 34-р анги дээр 3 хэсэгт зохион байгуулсан. Өдөрлөгт давхардсан тоогоор 978 иргэнийг 12 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулж, цөсний чулуутай 2, даралт ихсэлттэй 26, B вирустай 2, C вирустай 2, чихрийн шижингийн 1 тохиолдол шинээр оношлон эмчийн хяналтанд эмчилж байна. Коронавирусийн халдварын улмаас Улсын онцгой комиссын шийдвэрээр олон нийтийг хамарсан ажил, сургалт, хурал цуглаан, спортын тэмцээн уралдаан зохион байгуулахыг хориглосон тул дүүргийн 1-20 дугаар хороонд хуваарийн дагуу зохион байгуулах эрүүл мэндийн өдөрлөг түр хойшлогдсон.<br>-2020 оны эхний 10 сарын байдлаар артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 95823 иргэнээс 57973 буюу 60,5%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 95823 иргэнээс 58244 буюу 60,8% хамрагдаж, артерийн гипертензийн эрт илрүүлэг нийслэлийн дунджаас 11,8%, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг 16,8%-иар тус тус өндөр байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензийн 738, чихрийн шижин 2-р хэв шинжийн 132 тохиолдол илрүүлэн хяналтанд авсан. Чихрийн шижингийн-глюкозын ачааллалтай сорил 78 хүнд хийсэн.<br>-2020 оны эхний 10 сараар халдвар бус өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд /10,0 хүн аманд/ амьсгалын замын өвчлөлийн тогтолцооны эмгэг 958,7, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 1195,9, шээс бэлгийн замын тогтолцооны эмгэг 552,6, зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг 620,8, нүд түүний дайврын эмгэг 322,6, арьсны өвчин 331,8, мэдрэлийн тогтолцооны өвчин 527,4, чих хамар хоолойн өвчин 235,7, осол гэмтлийн шалтгаант өвчлөл 275,3 , яс булчингийн тогтолцоо холбох эдийн өвчин 547,5 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад амьсгалын замын өвчлөлийн тогтолцооны эмгэг 909,1, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 289,9, шээс бэлгийн замын тогтолцооны эмгэг 238,7, зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг 247,7, нүд түүний дайврын эмгэг 80,9, арьсны өвчин 110,2, мэдрэлийн тогтолцооны өвчин 178,1, чих хамар хоолойн өвчин 51,7, осол гэмтлийн шалтгаант өвчлөл 169,1, яс булчингийн тогтолцоо холбох эдийн өвчин 166,2 тохиолдлоор тус тус /10,0 хүн амд/ буурсан байна.</td>
</tr>
<tr>
<td rowspan="2">158</td>
<td rowspan="2">НЗДҮАХ-ийн 4.2.2 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 4.4.2 дахь заалт: Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.</td>
<td>"Эрүүл хүүхэд-эрүүл шүд" аян хэрэгжүүлнэ.</td>
<td>Сургалтад хамруулсан хүүхдийн тоо</td>
<td>7-12 насны хүүхдийн 50%-ийг, 0-6 насны хүүхдийн эцэг эхийн 30%-ийг сургалтад хамруулсан байна.</td>
<td>8,000.0</td>
<td>НХХ ЭМТ</td>
<td>95%</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">-Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх 4 зорилт, 10 заалттай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.<br>-Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2020 оны эхний 10 сарын байдлаар Эрүүл мэндийн төвийн Зөвлөх поликлиник, салбар амбулатори 1, 2-ийн шүдний кабинетаар 2-12 насны 4837 хүүхэд үйлчлүүлсэн нь үзлэгт хамрагдах дүүргийн 2-12 насны хүүхдийн 10%-ийг эзэлж байна. Үзлэгээр өвчлөл илэрсэн 3491 хүүхдээс 2075 буюу 59,4%-ийг эрүүлжүүлсэн.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрүүл шүд - Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хүрээнд ӨЭМТ-үүд 2-12 насны нийт 6329 буюу зорилтот насы хүүхдийн 15,6%-ийг урьдчилан сэргийлэх сэргийлэх үзлэгт хамруулж өвчлөл илэрсэн хүүхдийн эцэг эхэд хүүхдийн шүдний үзлэг дүгнэлт, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх талаар мэдээлэл хүргэх, хамтран ажиллаж байна.<br>- ӨЭМТ болон сургууль цэцэрлэгүүд “Шүд угаах арга”, “ Шүдэнд ээлтэй хоол хүнс”, “Сүүн байнгын шүдний онцлог”, “Шүд солигдлын үе” зэрэг сэдвүүдээр нийт 11 төрлийн суртчилгааны материал хэвлүүлж, цахим хуудсанд 7 төрлийн сурталчилгаа байршуулан нийт 5397 хандалт авсан байна.<br>- Хүүхдийн үзлэгийн кабинетыг шүдний эмч сувилагч нар хамтран 600,000 төгрөгийн санхүүжилтээр шинээр тохижуулан хүүхдэд ээлтэй, тав тухтай орчин, шүд угаах булан бий болгож, эмч,сувилагч нарын хуваарь гарган хүүхэд, эцэг эхчүүдэд шүд угаах аргыг эзэмшүүлж байна. 195 эцэг эх, 303 хүүхдэд “Хүүхдийн шүдний арчилгаа”, “Шүдэнд ээлтэй хоол хүнс” сэдвээр зөвлөгөө өгсөн.<br>-Дүүргийн төсвийн 12 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвд иж бүрэн хүүхдийн шүдний ор олгосон. | | | | | | |
| 159 | НЗДҮАХ-ийн 4.2.3, 4.2.4 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.3 дахь заалт: Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ. | Сүрьеэгийн идэвхитэй эрт илрүүлгийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна. | Илрүүлгийн хувиар | Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг 25%-д хүрсэн байна. | 15,000.0 | НХХ ЭМТ | 100% | 100% |
| | | 2020 эхний 10 сарын байдлаар сүрьеэгийн нийт үзлэг 22681 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,8%-иар өссөн. Урьдчилан сэргийлэх үзлэг 21356 буюу өмнөх оны мөн үеэс 3,5%-иар өссөн. 10 сарын байдлаар 136 сүрьеэгийн тохиолдол шинээр бүртгэгдсэнээс 44 сүрьеэгийн тохиолдол буюу 32,2%-ийг онлайнаар эмчилгээг зайнаас хянасан.<br>- ХӨСҮТ, БНСУ-ын сүрьеэгийн нийгэмлэг, Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран архины хамааралтай, орон гэргүй, түрхэц эерэг уушгины сүрьеэ, хүүхдийн сүрьеэ, эмэнд тэсвэртэй сүрьеэгийн хавьтал зэрэг зорилтот бүлгийн 483 иргэнийг сүрьеэгийн идэвхитэй эрт илрүүлэг үзлэгт хамруулж, сүрьеэгийн түрхэц эерэг 6, түрхэц сөрөг 19, урьдчилан сэргийлэх эмчилгээ 7, нийт 25 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан. Зорилтот бүлгийн хүн амын 17,5%-ийг хамруулсан байна.<br>- Эрүүл мэндийн сайдын А/145 дугаар тушаал, Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 8 сарын 14-ний өдрийн А/69 дүгээр тушаалын дагуу дүүргийн харъяа ерөнхий боловсролын 46 сургууль /Төрийн 25, хувийн 21/ 62 цэцэрлэг /төрийн 32, хувийн 30/ цэцэрлэгийн багш, ажилчдыг 2020 оны 8 дугаар сарын 1-31 хооронд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Нийт 3885 хүн хамрагдсан. Рентген харалтанд өөрчлөлттэй 89 хүнийг илрүүлсэн. 53 сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг цэрний шинжилгээнд хамруулж уушгины түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдол 2, уушгины түрхэц сөрөг сүрьеэгийн тохиолдол 6 буюу нийт сүрьеэгийн 8 тохиолдлыг оношилж харьяа дүүрэгт нь эмчилгээнд хамруулсан.<br>-Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийн дунд идэвхитэй эрт илрүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Сүрьеэгүй дүүрэг аян зохион байгуулах тухай А\340 дүгээр захирамжаар “Сүрьеэгүй хороо”, “Сүрьеэгүй ААНБ”, “Сүрьеэгүй сургууль, цэцэрлэг” шалгаруулах болзолт уралдаан зарласан. Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт зохион байгуулах, иргэдийг эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах, Эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн диспансерын агааржуулалтын фильтер солих, аяны үйл ажиллагааг дүгнэхэд уг захирамжаар 2,663,000 төгрөг шийдвэрлэв. | | | | | | |
| 160 | НЗДҮАХ-ийн 4.2.4 дэх заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.4 ХДХВ, БЗДХ-ыг бууруулах, эрт | ХДХВ, БЗДХ-ыг бууруулах, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр "Тэмбүүг устгая" аян зохион байгуулна. | Хамруулсан хүн амын тоо | 15-65 насны хүн амын 30% хамрагдсан байна. | 20,000.0 | НХХ ЭМТ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | илрүүлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, ажиллана. /Хорооны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Сүрьеэ, ХДХВ/БЗДХ-ыг бууруулах, Халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, Жирэмсний хяналтыг сайжруулах, Хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, Дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, ӨЭМТ-ийг дэмжиж ажиллах арга хэмжээг тусгайлан тусгаж, үр дүнг тооцох/ | -Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/327 дугаар тушаалын дагуу ЭМТ-ийн даргын А/68 дугаар тушаалаар “Тэмбүүг устгая” арга хэмжээг хэрэгжүүлж, дүүргийн 15-54 насны 61732 хүнээс 50% буюу 30866 хүнийг тэмбүү, ХДХВ-ийн халдвар илрүүлэх үзлэгт, шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөнөөс 2020 оны эхний 10 сарын байдлаар 32731 хүн хамруулж, 226 тэмбүүгийн тохиолдол илрүүлж, 99,1%-ийг эмчилгээнд хамруулсан. ХДХВ-ын халдвартай 2 тохиолдол илрүүлэн ХӨСҮТ-д шилжүүлж, онош баталгаажсан. Бүртгэгдсэн шинэ халдварын хавьтал илрүүлэлт 60%-тай, хавьтлын эмчилгээнд хамралт 98%-тай байна.<br>- Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын онцгой комиссын шийдвэр, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/59 дүгээр тушаалын дагуу Цагдаагийн 1,2 дугаар хэлтэстэй хамтран гэр оронгүй тэнэмэл, архины хамааралтай **271** иргэнийг бэлгийн замын халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн хуучин **15,** шинээр **7** тохиолдол илрүүлэн албадан эмчилгээнд шилжүүлсэн.<br>-Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны А/480, А/739 дүгээр тушаалын дагуу “Оюутны эрүүл мэндийг дэмжих” сарын аяны хүрээнд Үйлдвэр урлалын политехник коллеж, Монгол улсын их сургуулийн дотуур байрны 1519 оюутныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, тэмбүүгийн 4 тохиолдол, сүрьеэгийн 5 тохиолдол, артерийн даралт ихсэлттэй 2, таргалалттай 21, харааны өөрчлөлттэй 61 тохиолдлыг тус тус илрүүлэн тохирох зөвлөгөө өгч, хяналтанд авсан.<br>-Жирэмсэн эмэгтэйчүүдийг 100% тэмбүүгийн шинжилгээнд хамруулж, 56 жирэмсэн эх эерэг гарч, /өмнөх оны мөн үеэс 21,4%-иар өссөн/ 50 жирэмсэн эмэгтэй эмчилгээнд бүрэн хамрагдсан, одоо эмчилгээ үргэлжилж байгаа 6 жирэмсэн эмэгтэй байна. Хавьтал 31 эрэгтэйд сорил тавин онош батлагдаж, эмчлэн эрүүлжүүлсэн. Төрөлхийн тэмбүүгийн 1 тохиолдол гарч өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. | | | | | | |
| 161 | | Эх хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтийг сайжруулах болзолт аян зохион байгуулна. | Аяны шалгуур үзүүлэлтээр | Эх, хүүхдийн эндэгдэл, хяналтгүй төрөлтийн тоо буурсан байна. | 3,000.0 | НХХ ЭМТ | 100% | 100% |
| | | - 2020 оны 1 дүгээр улирлын эх, хүүхдийн үндсэн үзүүлэлтийн байдалд дүгнэлт хийж, Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 9/874, дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 195 дугаар албан бичгээр 1-20 дугаар хорооны Засаг дарга, ӨЭМТ-ийн дарга нарт “Эх хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтийг сайжруулан, хамтран ажиллах тухай чиглэл” хүргүүлэн 2020 оны 07 дугаар сард дүгнэхэд үүрэг даалгаврын биелэлт 85%-тай байна.<br>-Сүхбаатар дүүрэгт төрөх насны эмэгтэйчүүд/15-49 нас/ 38208, зорилтот бүлгийн 12844, эмзэг бүлгийн 1212 эрсдэлт бүлгийн 2145 эмэгтэйчүүдийн бүртгэлтйг тус тус шинэчилсэн.<br>-2020 оны 8 дугаар сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 2206 эх орсон. Нийт хяналтад байгаа жирэмсэн эмэгтэй 2990, үүнээс эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад 1961 буюу 65,6 %, ӨЭМТ-ийн эмчийн хяналтад 1029 буюу 34,4 % байна.<br>-Жирэмсний эрт үеийн хяналт 90,4% буюу өмнөх оны мөн үеэс 0,1%-иар буурсан, нийслэлийн дундажаас 1,2%-иар өндөр үзүүлэлттэй байна. 19 өөс доош насны охидын төрөлт 58 буюу өмнөх оны мөн үеэс 41,4%-иар /41/ буурсан.<br>-Жирэмсний хяналтанд шинээр орсон 2797 эмэгтэйчүүдийг цусны бүлэг, резус факторыг тодорхойлох, элэгний В, С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд 100% хамруулсан. Шинээр хяналтанд орсон эмэгтэйчүүд өмнөх оны мөн үеэс 9,7%-иар буурсан байна.<br>- Нийт хяналтанд байгаа 2854 жирэмсэн эмэгтэйгээс эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд 1952 буюу 68,4%, ӨЭМТ-ийн эмчийн хяналтанд 902 буюу 31,6% байна. ӨЭМТ-д хянагдаж буй жирэмсэн эмэгтэй өмнө оны мөн үеэс 1,5%-иар өссөн. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Эмэгтэйчүүдийн эмчийн нийт үзлэг 5424, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 1479 эмэгтэйг хамруулж, 66,1%-ийг /976/ эмчлэн эрүүлжүүлж, 4,9%-ийг /73/ диспансерийн хяналтанд авсан.<br>-Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын хэрэглээний хувь 48,1% буюу өмнө оны мөн үеэс 26%-иар өссөн.<br>-2020 оны 10 сарыг дуустал давхардсан тоогоор 5 хүртлэх насны 57451 хүүхдийн өсөлт, хөгжлийг хэмжиж, өсөлт, хөгжил, жингийн алдагдалтай, суурь өвчтэй 84 хүүхэд илрүүлэн хяналтанд авч, 70 хүүхэд буюу 83,3%-ийг эрүүлжүүлж, эмчилж байна. ХӨЦМ-ийн нийт үзлэгээр 6250 хүүхэд үзүүлсэнээс суурь өвчтэй 236 хүүхдийг диспансерын хяналтанд авч 145 хүүхэд буюу 61,4%-ийг эрүүлжүүлсэн. Суурь өвчний эрүүлжүүлэлт 61,4%-тай байна.<br>-Сүхбаатар Нэгдсэн эмнэлэгт эхний 10 сарын байдлаар 5385 хүүхэд хэвтэн эмчлүүлж, хүлээн авах яаралтай тусламжийн тасагт 4532 хүүхэд үзүүлээд буцсаныг ӨЭМТ-үүдэд эргэн мэдээлж, гэрийн идэвхитэй эргэлт, утсаар хяналт зөвлөгөөг өгч ажилласан. Гэрийн эргэлт 87%.<br>-Нийслэлийн түргэн тусламжийн төвд эхний 10 сарын байдлаар 1038 дуудлага ирсэн нь өмнөх оны мөн үеэс 58 дуудлагаар багасч, ӨЭМТ-үүдэд эргэн мэдээлж, гэрийн идэвхитэй эргэлт, утсаар хяналт, зөвлөгөө өгч ажилласан. Эргэлт 89%. | | | | | | |
| 162 | НЗДҮАХ-ийн 4.2.5 дахь заалт, ДЗДҮАХ-ийн 4.4.5 Амьсгалын замаар дамжих халдварт өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулна. | Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулна. | Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтээр | Амьсгалын замын цочмог халдварын хүндрэл, эндэгдэл буурсан байна. | 10,000.0 | НХХ ЭМТ | 100% | 100% |
| | | -2020-2021 онд “Томуу, томуу төст өвчний идэвхижил, дэгдэлтийн үед ажиллах төлөвлөгөө” –г шинэчлэн баталж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.<br>- ТТТӨ-ний тандалтын мэдээг өдөр бүр авч дүгнэн, 7 хоног бүр холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд танилцуулан хариу арга хэмжээ авч ажиллаж байна. 2020 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар амбулаторийн үзлэгийн 3,2%- ийг ТТТӨ эзэлж, өмнөх оны мөн үеэс 0,9%-иар буурсан.<br>- Дүүргийн хэмжээнд ТТТӨ “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдварын үед өртөх эрсдэлт бүлгийн 33226 иргэдийн судалгаа 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр шинэчлэн тодотгосон. Үүнд: 0-5 насны хүүхэд 16307, жирэмсэн эмэгтэйчүүд 1917, 65-аас дээш насны иргэд 9247, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2790, хорт хавдартай иргэн 367, сүрьеэгээр өвдсөн 301, архаг хууч өвчтэй иргэдийн тоо /эрхтэн шилжүүлэн суулгуулсан, дархлаа дарангуйлах эм хэрэглэдэг гэх мэт 2297 иргэн байна. Дээрхи иргэдэд утсаар зөвлөгөө өгөх, гэрийн тусламж үйлчилгээг сайжруулан ажиллахыг ӨЭМТ-үүдэд үүрэгжүүлэн, хяналт тавьж ажиллаж байна.<br>- 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/449, НЭМГ-ын А/116, ЭМТ-ын даргын А/85 тушаалын дагуу Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10-ны хороонд “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулж 6 сартайгаас 9 насны 26491 хүүхэд хамруулахаас 18733 буюу 66%-ийг, Эрүүл мэндийн ажилтан, онцгой байдал, цагдаагийн байгуулагын алба хаагчид 1533 хамруулахаас 100%-ийг, жирэмсэн, архаг хууч өвчтэй иргэд, 65-аас дээш насныхан нийт зорилтот бүлгийн 3940 хамруулахаас 3500 буюу 88,8%-ийг, 2020 оны 10 дугаар сарын 22-ноос эхлэн дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 10,11,12 настай хүүхдүүдэд томуугийн эсрэг дархлаажуулалтад 6101 хүүхэд хамруулахаас 5245 хүүхэд буюу 85,9% -ийг буюу нийт 31960 хамруулахаас 29009 буюу 90.7% хамруулсан.<br>- Томуу, томуу төст өвчний үед дайчлан ажиллуулах Эрүүл мэндийн төвийн 12 нарийн мэргэжлийн эмч, Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй 81 эмчийн судалгааг гаргасан. ЭХЭМҮТ-өөс гаргасан 2020-2021 оны томуугийн улиралд баримтлах эмнэлзүйн удирдамжийг гарын авлага хүүхдийн тусламж үйлчилгээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>- 2020 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр ЭМЯ, ХӨСҮТ-ээс хамтран зохион байгуулсан "Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн бэлэн байдал, хурдавчилсан оношлогоо сэдэвт сургалтанд 16 өрхийн эрүүл мэндийн төв тус бүрээс 1 их эмч хамрагдсан | | | | | | |

| | | |
|---|---|---|
| | | -Олон нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 41 төрлийн зөвлөгөө зөвлөмж, мэдээллийг http://sbemt.ub.gov.mn/ “Сүхбаатар Эрүүл мэндийн төв” цахим хуудсанд байршуулсан. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр:<br>• FM-104.5-д “Томуу, томуу төст өвчнөөс урьчдилан сэргийлэх, хүүхдийн асаргаа сувилгаа”<br>• МҮОНТ-ийн олон нийтийн цаг шууд нэвтрүүлэгт “ТТТӨ, коронавирусийн өнөөгийн байдал”<br>• ETV телевиз-д “Томуу, томуу төст өвчний өнөөгийн байдал, дэлгэцийн донтолт” зэрэг сэдвээр дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч нар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч, сурталчилсан.<br>- Сүхбаатар Эрүүл мэндийн төвд ТТТӨ болон Коронавируст /Ковид-19/ халдварын талаарх зөвлөгөө өгөх 350793 тусгай дугаарын утсыг 24 цагаар, ӨЭМТ-үүд ажлын өдөр 8 цагаар тусгай дугаарын утсаар ажиллуулж байна.<br>-Дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах Ажлын хэсгийн уулзалтыг 3 удаа зохион байгуулж, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах дүүргийн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, амбулаторийн үзлэг, эмнэлэгт хэвтэлт, өвчлөлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид зохион байгуулах ажлын талаар харилцан мэдээлэл солилцов. Мөн томуугаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020-2021 онд хамтран ажиллах 3 талт гэрээ байгуулж, Эрүүл мэндийн төв, 20 хорооны ӨЭМТ тус бүрд дүүргийн төсвөөс нийлүүлж буй маск, гар ариутгагч, бээлий, лент зэргийг олгосон.<br>- Иргэдийг томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр шуурхай арга хэмжээ авч ажиллах зорилгоор дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар 33 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгууллаа. Уг ажлын хүрээнд 17 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа.<br>- Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын 2020 оны 9/78, 9/246, 9/247 дугаар албан бичгээр 1-20 дугаар хорооны Засаг дарга, дэргэдэх 24 хэлтэст Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвөөс гаргасан 11 төрлийн сэрэмжлүүлэг зөвлөгөө зөвлөмж, цаг үеийн мэдээлэл хүргэн, ажилтан, албан хаагчид, иргэдийг шинэ коронавирусийн халдвар, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэл өгч, хяналт тавин ажиллалаа.<br>- Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр шуурхай арга хэмжээ авч, дүүргийн Засаг даргатай Ажлын хэсгийн хамт 2020 оны 02 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд 11,12,13,14,15 дугаар хорооны Засаг даргын ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төвүүд бэлэн байдлыг хэрхэн ханган ажиллаж буй болон томуу, томуу төст өвчний үзлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үүрэг чиглэл өгч, тулгамдаж буй асуудлыг сонсч, боломжтой асуудлыг шийдвэрлэв.<br>-Дүүргийн Засаг даргын 2020 оны А/33, А/48, А/73, А/80, А/134, А/142 дугаар захирамж, дүүргийн ЗДТГ-ын дарган А/17, А/49, А/50 дугаар тушаалаар нийт 111,301,800 төгрөгийн санхүүжилт шийдвэрлэж, дүүргийн ЗДТГ, хороо, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэст маск 42,566 ш, зайнаас халуун хэмжигч 45 ш, бактерын эсрэг саван 1035, шингэн савангийн хайрцаг 35, зөөврийн кварц 1, запас гэрэл 4 ш, зөвлөмж хэвлүүлэх 10000 ширхэг, ариутгалын бодис жавильсин 2 хайрцаг, гар халдваргүйжүүлэгч гель 220 литр, спирт 5л, ариутгалын бодис 150 литр, халдвар хамгааллын комбинзон, нүдний шил, хаалт бүрдэл 42, нэг удаагийн бээлий 400 хос, даралтын аппарат 1, пульсоксимитр 1, аюулгүйн хайрцаг 10 ширхэг, 3 өнгийн эмнэлгийн зориулалтын хогны уут 300 ширхэг, сахарын тест 200 ширхэг, дархлаажуулах бэлдмэл 150 хайрцаг, Тамифлю 75гр эм 500 хайрцаг, ариутгалын сальфетка 250 хайрцаг, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 2, отсос 2, дуслын памп 2, тарианы памп 2, дуслын хөл 5, яаралтай тусламжийн тэргэнцэр 3, зөөврийн кварц 3 ширхэг яаралтай тусламжийн эм, тариа, хэрэгсэл олгосон. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Дүүргийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн дүүргийн хэмжээнд “Маскаа зүүцгээе, гараа угаая” аяны үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах тухай А/370 дугаар захирамжаар 10,260,000 төгрөг шийдвэрлэн, нийт 25000 ширхэг маск, 10 хайрцаг буюу 500 хос бээлий авч, дүүргийн ЗДТГ, хороодын ЗДАА, Хэсгийн ахлагч, Нэг цонхны үйлчилгээний ажилтан, албан хаагчдын 2 сарын хэрэгцээний хангалтыг нөөцлөөд байна.<br>-Томуугийн эсрэг нэмэлт дархлаажуулалт” аяны хүрээнд Эрүүл мэндийн төв, Боловсролын хэлтэстэй хамтран төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, эмч нар нийт 200-аад хүнд томуу болон амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, томуугийн эсрэг нэмэлт дархлаажуулалт, анхаарах асуудлын талаар 2 удаа сургалт зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020.09.29-ний өдрийн 3/1987, 3/1988 тоот албан бичгээр 20 хороо, дэргэдэх 22 хэлтэст Томуу томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварын үгдрэл, хүндрэлээс сэргийлэх, хариу арга хэмжээ авч ажиллах, дархлаажуулалтад ажиллах гишүүдийн үүрэг, анхаарах асуудал чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. Дархлаажуулалтын аяны хүрээнд томуугийн эсрэг дархлаажуулалтад 6 сартайгаас 9 насны 26491 хүүхэд хамруулахаас 18733 буюу 66%, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 10,11,12 настай хүүхдүүдэд 6101 хүүхэд хамруулахаас 5245 хүүхэд буюу 85,9% хамруулсан. | | | | | | |
| 163 | | Дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, аюулгүй дархлаажуулалтын чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна. | Дархлаажуулалтын хувиар | Дархлаажуулалтын хамралт нэмэгдэж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдол буурсан байна. | 2,000.0 | НХХ ЭМТ | 97% | 100% |
| | | -Дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/337 дугаар захирамжаар 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд дүүргийн хэмжээнд “Томуугаас сэргийлье” уриан дор томуугийн эсрэг нэмэлт дархлаажуулалтын аяны ажлыг зохион байгууллаа. Уг захирамжаар дүүргийн төсвөөс 4,217,200 төгрөг шийдвэрлэж, дүүргийн Эрүүл мэндийн төв болон 20 хорооны Өрхийн эрүүл мэндий төвд нийт 1500 ширхэг амны хаалт, 22 ширхэг гар ариутгагч гель, 552 ширхэг цаасан лент, 138 хайрцаг нэг удаагийн бээлий олгосон.<br>-Дархлаажуулалтын аяны хүрээнд 6 сартайгаас 9 насны 26491 хүүхэд хамруулахаас 18733 буюу 66%-ийг, Эрүүл мэндийн ажилтан, онцгой байдал, цагдаагийн байгууллагын алба хаагчид 1533 хамруулахаас 100%-, жирэмсэн, архаг хууч өвчтэй иргэд, 65-аас дээш насныхан нийт зорилтот бүлгийн 3940 хамруулахаас 3500 буюу 88,8%, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 10,11,12 настай хүүхдүүдэд томуугийн эсрэг дархлаажуулалтад 6101 хүүхэд хамруулахаас 5245 хүүхэд буюу 85,9% -ийг, нийт 31960 хамруулахаас 29009 буюу 90.7% хамруулсан.<br>-Товлолын дархлаажуулалтад 2020 оны 10 сарын байдлаар 39040 хүүхэд хамруулахаас 37415 хүүхэд буюу 95,8% хамруулж, өмнө оны мөн үеэс 0,2%-иар буурсан байна | | | | | | |
| 164 | НЗДҮАХ-ийн 4.2.6 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 4.4.6 Дүүргийн залуучуудын дунд “Эрүүл залуус” аян өрнүүлнэ. | Цэргийн насны залуусын эрүүлжилтийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна. | Цэргийн насны залуусын эрүүлжилтийг сайжруулах арга хэмжээний тоо | Цэргийн насны залуусын эрүүлжилтийг 2019 оноос сайжруулсан байна. | 5,000.0 | НХХ ЭМТ | 100% | 100% |
| | | -2019 оны II ээлж, 2020 оны цэрэг татлагаар эрүүл мэндийн үзлэгт нийт 2236 залуус хамрагдсанаас өвчний учир чөлөөлөгдсөн 776 буюу 34,7% байна. Өвчний учир чөлөөлөгдсөн залуусаас богино хугацаанд эмчлэгдэх боломжтой тохиолдлыг 14 нарийн мэргэжлийн эмч нарын диспансерийн хяналтад шилжүүлж, эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ЭМТ, | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ӨЭМТ-тэй хамтран ажилласнаар 2020 оны байдлаар 117 буюу 69,6%-ийг эрүүлжүүлж, эрүүлжүүлэлт өмнө оноос 4,2%-иар ахиулсан. 2020 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар илрүүлэг шинжилгээнд 101 хүн хамруулснаас В, С вирус илрээгүй | | | | | | |
| 4.5 Зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | | | | | | | | |
| 165 | НЗДҮАХ-ийн 4.7.5 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 4.5.1 Ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийн суурь судалгааг нарийвчлан гаргаж, өрхийн хөгжлийг дэмжин, хөтөлбөр, арга хэмжээнд хамруулна. | Зорилтот бүлгийн иргэдэд амьжиргааны бодит туслалцаа үзүүлнэ. | Хамрагдсан иргэдийн тоо | Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргаа дээшилсэн байна. | 30,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | Тус дүүрэг нь 16497 ахмад настантай. Халамжийн сангаас 199 ахмад настан өндөр насны тэтгэвэр авч, бусад ахмад настнууд нийгмийн даатгалын сангаас тэтгэврээ авч байна. Дүүргийн хэмжээгээр 3100 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг. Үүнээс нийгмийн халамжийн сангаас-1131, нийгмийн даатгалын сангаас-1969 иргэн тэтгэвэр авч байна.<br>-"Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2020 онд "Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-т сонгогдсон 448 өрхтэй ажиллах төлөвлөгөө боловсруулан, хөтөлбөр"-т хамрагдаж буй өрхийн гишүүдийн хэрэгцээ, чадавх, боломжийг нь харгалзан суурь судалгаа гаргаж, мэдээллийн сан үүсгэсэн.<br>Хөдөлмөрийн насны 10 иргэнийг нийтийг хамарсан ажилд 10 хоног ажиллуулж, түр ажлын байраар хангаж, 2.520.000 төгрөгийн цалин урамшуулал, хорих ангиас суллагдсан 4 иргэн, хөдөлмөрийн насны 27 иргэн, нийт 31 иргэнийг байнгын ажлын байранд, ахмад настан-8, хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлага өрхийн 16 иргэн, хөдөлмөрийн насны 23 иргэн, нийт 52 иргэнийг түр ажлын байраар хангаж, нийт давхардсан тоогоор 219 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл өгч, ажлын санал хүргүүлэн, ажилд зуучилж, түр болон байнгын ажлын байраар хангасан.<br>Өрхийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх сонирхолтой 16 өрхийн 18 иргэнийг санхүүгийн хөнгөлөлттэй зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамруулан 25.280.000 төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Үүнээс нийгмийн халамжийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 14 иргэн хамруулан 13.280.000 төгрөгний санхүүжилт олгосон.<br>Зорилтот өрхтэй ажиллах ажлын төлөвлөгөөнд 3 зорилт,17 ажил төлөвлөн, ЗӨХХСҮХ-т хамрагдсан өрхийн гишүүдийг нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулах ажлын хүрээнд 320 өрхийн 2768 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, хуулийн дагуу төрийн үйлчилгээнд хамруууллаа. Үүнээс: тэтгэвэр, тэтгэмжид 385 иргэн, хөнгөлөлт тусламжид 413 иргэн, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 1966 иргэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 185 иргэн байна. Нийгмийн халамжийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан 185 иргэнийг үйлчилгээ тус бүрээр ангилан үзвэл: Эрүүл мэндийн сэргээн засах үйлчилгээнд 127 иргэнд 22,225,000 төгрөгний зардлыг, өдрийн үйлчилгээнд 33 иргэнд 2,970,000 төгрөгний зардлыг, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд 6 иргэнд 1,680,000 төгрөгний зардлыг, түр байрлуулан асрамжлах үйлчилгээнд 5 иргэнд 10,620,000 төгрөгний зардлыг, бүлгийн зохион байгуулалттайгаар төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд 14 иргэнд 13,280,000 төгрөгний зардлыг гэрээт 5 байгууллагад үйлчилгээний зардал нийт 50,775,000 төгрөгийг нийгмийн халамжийн сангаас олгосон.<br>-Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Нийгмийн халамжийн газраас ирүүлсэн иж бүрдэл багц /маск-5ш, саван 2ш, витамин-10ш, зөвлөмж-1ш зэрэг/-ийг "Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-т хамрагдсан 9-20 дугаар хорооны нийт 200 өрхөд тараасан.<br>-"Цагаан хуар" ТББ-тай хамтран зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдсан 448 өрхөөс хүнсний хэрэглээгээ бүрэн хангаж чадахгүй 12 өрхөд нэн тэргүүнд хүнс, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн олгосон.<br>"Корона вирус"-ийн цар тахлын үед авах хариу арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн амьжиргааны түвшин доогуур өрхөд хүнс болон ариун цэврийн багцын тусламж хүргэх ажлыг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | “Монголын Улаан загалмайн нийгэмлэг” хамтран 2020 оны 11 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд 20 хорооны 448 өрхөд хүнс болон ариун цэврийн багц хүргэлээ.<br>Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Зорилтот өрхийг сайжруулсан түлшээр хангах тухай” А/30 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн Нийгмийн халамжийн газар, “Таван толгой түлш” ХХК-ний хамтарсан шийдвэрээр өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдан 0-240 оноотой, “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т хамрагдсан 395 өрхөд сайжруулсан түлш олгох ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулав. Тус дүүргийн 9, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хорооны зорилтот өрхүүдэд сайжруулсан шахмал түлш олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 18 дугаар хороонд байрлах “Бэлх” цэг, 20 дугаар хороонд байрлах “Сэлх” түлш таталтын цэгүүдэд зорилтот өрхөд тараах сайжруулсан шахмал түлшний таталт хийв. Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдэд сайжруулсан түлш үнэгүй тарааснаар дулаан өвөлжих боломж бүрдүүлж байна. | | | | | | |
| 166 | | Хүмүүнлэгийн чиглэлээрх Засгийн газрын зарим чиг үүргийг гүйцэтгэнэ. | Хамрагдсан иргэдийн тоо | Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргаа дээшилсэн байна. | 100,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | -Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/04, А/55, А/79, А/99 дүгээр тушаалаар нийт 2,500,000 төгрөг шийдвэрлэж, иргэдийн дунд Донорын өдөрлөг 4 удаа зохион байгуулж, нийт 213 хүн хамруулав.<br>-Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/05, А/07 дугаар тушаалын дагуу дүүргийн Цагдаагийн I, II хэлтэс, Замын цагдаагийн хэлтсийн албан хаагчдын ажлын хэрэгцээнд зориулан эмнэлгийн анхны тусламжийн 30 багц, 300 ширхэг санитол, 36 ширхэг Зөв аарц, дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажлын хэрэгцээнд анхны тусламжийн 5 багц олгов. Иргэдэд халдвараас сэргийлэн 1000 ширхэг гар ариутгагч олгосон. Уг ажилд нийт 9,850,000 төгрөг зарцуулсан.<br>-Шинэ коронавирус (covid-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/08, А/09 дүгээр тушаалаар 9,225,000 шидвэрлэж, тус дүүргийн эмзэг бүлгийн 350 өрхөд хүнсний тусламж, 1000 өрхөд витаминжуулалтын багц /витамин С 50мг дөрвөн төрөл, аарц 1л/ олгов.<br>-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/44, А/57 тоот тушаалыг үндэслэн зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах сайн дурын идэвхтэнүүдэд хэрэглэгдэх ажлын хувцас худалдан авахад нийт 7,000,000 төгрөг зарцуулсан.<br>-Дүүргийн Засаг даргын 2020 оны А/247, А/248 дугаар захирамж, Тамгын газрын даргын 2020 оны А/59, А,60, А/61, А/62, А\97, А\98 дугаар тушаалын дагуу аадар борооны улмаас үерт автаж, гэр оронгүй болсон 20-р хорооны Ч.Хишигсүрэн, Д.Батзориг, С.Сэлэнгэ, Б.Цэрэнбямба, Н.Эрдэнэдалай болон өөрийн гэсэн орон гэргүй иргэн Т.Уламбаяр, гэр нь гал түймэрт өртсөн иргэн Б.Амгаланболд зэрэг 7 өрхөд тус тус 5 ханатай иж бүрэн гэр олгож, хүнс, ахуйн хэрэглээний шаардлагатай тусламж үзүүлэхэд 27,1000,000 төгрөг зарцуулав.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/80 тоот тушаалаар “Ахмадууд хүмүүнлэгийн үйлсийг манлайлагчид” уулзалт, өдөрлөг зохион байгуулж, 1-20 дугаар хорооны 140 ахмад оролцлоо. Уг ажилд 7,525,000 төгрөг зарцуулав.<br>-Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу “COVID-19” цар тахал хүн амын дунд илэрсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/105 тушаалаар гар ариутгагч, амны хаалт худалдан авахад 4,000,**000** төгрөг зарцуулав.<br>Дээрхи ажилд дүүргийн төсвөөс нийт 71.500.000 төгрөг зарцуулсан байна. | | | | | | |
| 167 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хийсэн бараа бүтээгдэхүүнийг | 5 аас доошгүй үзэсгэлэн | Хөгжлийн бэрхшээлтэй | - | НХХ<br>ХөХҮХ | 70% | 70% |

<table>
<tr><td></td><td></td><td>худалдан борлуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.</td><td>худалдаанд оролцуулах</td><td>иргэний амьжиргаанд дэмжлэг болсон байна.</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="7">-Дүүргийн хэмжээнд 16497 ахмад настан, 3100 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас нийгмийн халамжийн сангаас 1131, нийгмийн даатгалын сангаас 1969 иргэн тэтгэвэр авч байна.<br>-Тус дүүргийн 11 дүгээр хорооллын “Дөрвөн-Уул” захын худалдааны төвийн 1 давхарт 2019 онд ажиллуулсан борлуулалтын цэгийг үргэлжлүүлэн ажиллуулж, хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэний нийт 850,000 төгрөгийн бараа бүтээгдэхүүн борлуулж, өрхийн орлогыг нэмэгдүүллээ.<br>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг 2020 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч цар тахлын улмаас зохион байгуулагдаагүй байна.</td></tr>
<tr><td rowspan="2">168</td><td rowspan="2">НЗДҮАХ-ийн 4.7.1 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 4.5.2 Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг санаачлан ажиллана.</td><td>Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг илрүүлэх, бүртгэх, нийгэмшүүлэх ажилд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.</td><td>Зорилтот бүлгийг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах</td><td>Бичиг баримтжуулах, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээнд Зорилтот бүлгийг 75 хувиас дээш хамруулсан байна.</td><td>15,000.0</td><td>НХХ<br>ХөХҮХ</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="7">-Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран архины хамааралтай, орон гэргүй, сүрьеэгийн хавьталтай зорилтот бүлгийн 210 иргэнийг сүрьеэгийн идэвхитэй эрт илрүүлэг үзлэгт хамруулж, сүрьеэгийн 2 тохиолдол шинээр илрүүлж, эмчилгээнд хамруулсан. Зорилтот бүлгийн хүн амын 1%-ийг хамруулсан.<br>- Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэн, Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэр, нийслэлийн Засаг даргын 2020 оны А/223 дугаар захирамжийн дагуу олон нийтийг хамарсан уулзалт, сургалт, семинар, урлаг спортын арга хэмжээг зогсоосонтой холбоотой идэвхитэй эрт илрүүлэг зохион байгуулах боломжгүй байна.<br>-Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу Сүхбаатар Эрүүл мэндийн төвийн даргын А/33 тоот тушаалын дагуу дүүргийн Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран тус дүүргийн нутаг дэвсгэрт тэнэн амьдарч байгаа иргэдийг бүртгэлжүүлэх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, нийгмийн үйлчилгээнд хамруулах ажлыг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, нийт 52 иргэн /эрэгтэй 45, эмэгтэй 7 иргэн/ хамрагдсан. Тус арга хэмжээний хүрээнд 5 чиглэлийн буюу дотор, сүрьеэ, сэтгэц, бэлгийн замын халдвар, гэмтлийн эмчийн үзлэг, эхо, рентген, хепатитийн В, С вирус илрүүлэх шинжилгээ, ХДХВ/ДОХ, тэмбүүгийн шинжилгээ, цусны ерөнхий шинжилгээ зэрэг 6 төрлийн шинжилгээ хийж, иргэн тус бүрт дүгнэлт гаргасан. Бүртгэлийн хэлтэстэй хамтран 31 иргэний бичиг баримтжуулахад 573.500 төгрөг зарцуулсан.</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тус дүүргийн хэмжээнд 2019, 2020 онуудад “Гэртээ харих зам” нийслэлийн дэд хөтөлбөрийн хүрээнд бүртгэсэн гэр оронгүй, тэнэмэл амьдралтай 155 иргэний дэлгэрэнгүй судалгааг гарган, нийслэлийн Нийгмийн халамжийн газарт 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 1/285 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Дүүргийн хэмжээнд илрүүлэн, бүртгэсэн гэр оронгүй, тэнэмэл амьдралтай 52 иргэнээс 9 иргэн дүүргийн Эрүүл мэндийн төвд, 3 иргэн хорооны өрхийн Эрүүл төвөөс эрүүл мэндийн үйлчилгээ авч байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанаас зорилтот бүлгийн иргэдийг түр ажлын байраар хангах ажлын хүрээнд орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдээс гадна тус эрсдэлд өртөж болзошгүй 2 иргэнийг нийтийг хамарсан ажилд зуучилсан. 13 дугаар хорооны зорилтот иргэн “Б”-г Баянзүрх дүүрэгт байрлалтай гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх, түр хоноглохоор байраар үйлчилдэг “Дөлгөөн минж” ТББ-д хүлээлгэн өгсөн. 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Нийслэлийн ЗДТГ, Нийслэлийн Нийгмийн халамжийн газар болон Цагдаагийн байгууллагууд хамтран орон гэргүй тэнэмэл амьдралтай 248 иргэдийг коронавирусийн шинжилгээнд хамруулж, “Нийгмийн хамгааллын тусгай төв” болон түр хоноглох үйлчилгээ үзүүлж байгаа 6 байгууллагуудад байршуулав. | | | | | | |
| 169 | | Ажил, мэргэжилгүй иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн 500-аас доошгүй иргэнийг мэргэжлийн болон давтан сургалтад хамруулж, 60-аас доошгүй хувийг нь ажлын байраар хангана. | Сургалтад хамруулах иргэдийн тоо 200, ажилд зуучлах иргэд 60 хувь | 60% нь Ажил мэргэжилтэй болж иргэдийн амьжиргаа дээшилсэн байна. | - | НХХ ХөХҮХ | 100% | 100% |
| | | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн хүрээнд 300 иргэнд мэдээлэл хүргэж, Сүхбаатар дүүргийн ажил, мэргэжилгүй 230 залуучуудын судалгааг гарган Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газарт хүргүүлсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын жагсаалтаар баталсан сургалтын байгууллагаар мэргэжлийн ур чадвар олгох сургалтад ажилгүй иргэнийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас тус сургалтын зардлыг танагдсан учир Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаагүй.<br>“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т хамрагдаж буй өрхийн гишүүдийн хэрэгцээ, чадавх, боломжийг нь харгалзан суурь судалгаа гаргаж, мэдээллийн сан үүсгэсэн.<br>Хөдөлмөрийн насны 10 иргэнийг нийтийг хамарсан ажилд 10 хоног ажиллуулж, түр ажлын байраар хангаж, 2.520.000 төгрөгний цалин урамшуулал, хорих ангиас суллагдсан 4 иргэн, хөдөлмөрийн насны 27 иргэн, нийт 31 иргэнийг байнгын ажлын байранд, ахмад настан-8, хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлага өрхийн 16 иргэн, хөдөлмөрийн насны 23 иргэн, нийт 52 иргэнийг түр ажлын байраар хангаж, нийт давхардсан тоогоор 219 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл өгч, ажлын санал хүргүүлэн, ажилд зуучилж, түр болон байнгын ажлын байраар хангаж ажилласан. | | | | | | |
| 170 | НЗДҮАХ-ийн 4.2.14 дэх заалт;<br>ДЗДҮАХ-ийн 4.5.3 Сүхбаатар сувиллын цогцолборын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч сувилах | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллана. | Хамрагдсан хүүхдийн тоо, хувиар | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал дээшилсэн байна. | 5,000.0 | НХХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тасаг нээж ажиллуулна. | -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 2020 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 15 удаа байгуулж, нийт 317 хүүхдийн асуудал хэлэлцэн, шинээр байнгын асаргаа тогтоосон 82, сунгалт 202, цуцалсан 8, онош тодруулахаар, материал дутуу буцаасан 9, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолт, дүгнэлт бичсэн 15, шилжиж ирсэн 1 хүүхэд байна. | | | | | | |
| 171 | ДЗДҮАХ-ийн 4.5.4 Ахмад настныг эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, тэдний насны онцлогт тохирсон нийгмийн идэвхтэй амьдралд татан оролцуулах Ахмад настны зөвлөх үйлчилгээг өргөжүүлэн ажиллана. | Олон улсын ахмадын өдрийг угтсан ажлуудыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | Төлөвлөгөө хэрэгжсэн байна. | 10,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | Олон улсын ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай дүүргийн Засаг даргын 2020 оны А/317 дугаар захирамжийн хүрээнд Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх өдөрлөг, уулзалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хороо бүр зохион байгуулж, нийт 2000 гаруй ахмад настанг хамруулсан. | | | | | | |
| 172 | | Сар шинийн баяраар албан байгууллагуудад харьяалалгүй дүүргийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Хамрагдсан ахмадын тоогоор | Ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн байна. | 210,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | Сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн зарим иргэдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хөрөнгийг дүүргийн төсвөөс шийдвэрлэж, дүүргийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/01 дүгээр захирамжийн хүрээнд зохион байгуулалтын үйл ажиллагааны хуваарийг 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдөр батлуулав. Хуваарийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд 1-20 дугаар хороодод нийт 14000 ширхэг бэлгийг хүргэх ажлыг “Өгөөж чихэр, боов” ХХК зохион байгуулж, хороодын Засаг даргын ажлын албатай холбогдох хэлтсүүд хамтран ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллав. Мөн Хороодын ахмадын төлөөлөл болох 84 тэргүүлэгч гишүүдэд хүндэтгэл үзүүлсэн. | | | | | | |
| 173 | | 2-3 ахмадын хоршоо нөхөрлөлийг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Зорилтот бүлгийн ахмадуудын амьжиргаа дээшилсэн байна. | 20,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | Ахмад настны боломж чадамжинд тохирсон ажлын байр бий болгосон ажил олгогчийг урамшуулал дэмжлэгт хамруулах ажлын хүрээнд “Ахмадад ээлтэй байгууллага” тодруулах журмын дагуу 50 аж ахуй нэгжид лого олгосон. Олон нийтэд ахмад настны талаарх эерэг ойлголт хандлагыг төлөвшүүлж, тэднийг гэр бүл, нийгэм, хамт олны дунд ажиллаж амьдрах харилцан бие биедээ туслах, эерэг орчин бүрдүүлэх зорилгоор “Юмхнаар юм хийцгээе” бүтээлийн уралдаан зарлаж дүгнэж ажилласан. | | | | | | |
| 174 | | Хороодын ахмадын зөвлөлийн дарга нарын ажлын ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Ахмадын зөвлөлийн дарга нарын ажлын ур чадвар дээшилсэн байна. | 3,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | Албан бус Насан туршийн боловсролын төвтэй хамтран Ахмадын хорооны Зөвлөлийн дарга, тэргүүлэгч 110 ахмадуудад “Мэдээлэл технологи, түүний хэрэглээ” сэдэвт 14 хоногийн сургалтыг 2020 оны 09 сарын 14-25-ны өдрийн хооронд зохион байгуулсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 175 | | “Ажилч зөгий” хөтөлбөрийн хүрээнд зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн жишиг ахмадын хөдөлмөрийн бирж байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Зорилтот бүлгийн ахмадын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 20,000.0 | НХХ | | Үнэлэх болом жгүй |
| | | Монгол улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолоор “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” шилжсэнтэй холбогдуулан ААН, байгууллагууд “Ажилч зөгий” хөтөлбөрийг дэмжин ажиллах нөөц бололцоогүй байна. Иймд бэлтгэд ажлын хүрээнд дүүргийн хэмжээний нийт ахмадын судалгаа, ААНБ-ын судалгааг шинэчлэн, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлсэн. Нэгдсэн судалгаатай болсноор цаашид авах арга хэмжээ тодорхойлогдож гүйцэтгэл сайжирна. | | | | | | |
| 176 | ДЗДҮАХ-ийн 4.5.5 Ахмад настанд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх иргэд, залуучуудын сайн дурын үүсгэл санаачилга, хөдөлгөөнийг дэмжин “Хариу нэхээгүй тус” аян зохион байгуулна. | Зорилтот бүлгийн ахмадуудад зориулсан "Хариу нэхээгүй тус" аян зохион байгуулна. | Үйл ажиллагаанд хамрагдсан ахмадын хувь | Иргэдийн амьдрах нөхцөл сайжирсан байна. | 2,000.0 | НХХ | 100% | 100% |
| | | Шинэ коронавирусийн халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, халдварт өвчний тархалтыг зогсоож, хяналтад авахад хүн бүр хариуцлагатай байхыг уриалж, Ахмадын хорооны хамт олон нэг өдрийн цалингаа дүүргийн Онцгой комисст хандивлав. Нэгдсэн хөл хорионы үед харж, хандах үр хүүхэдгүй, ганц бие ахмад настангуудад дүүргийн улаанзагалмай, Засаг даргын нөөц сангаас хүнсний тусламж нийт 59 ахмад настанд хүргэсэн. | | | | | | |
| ТАВ. ДЭВЖИН ДЭЭШЛЭХ СҮХБААТАР ДҮҮРЭГ | | | | | | | | |
| 5.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана. | | | | | | | | |
| 177 | ДЗДҮАХ-ийн 5.1.1 Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр явуулна. | Ажил олгогчдын өдөрлөгийг зохион байгуулна. | Өдөрлөгт 80-100 ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагыг хамруулах | Ажил олгогчдын чуулган зохион байгуулж, зөвлөмж гаргасан байна. | 15,000.0 | НХХ ХөХҮХ | | Үнэлэх болом жгүй |
| | | - Ажил олгогчдын чуулган зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах журам”, “Ажил олгогчийн урамшуулал”-ыг аж ахуй нэгж байгуулагуудад танилцуулж, цахимаар 800 ААНБ-т сурталчилсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/64 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах” журмын дагуу дүүргийн Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлд 10 байгууллага материалаа ирүүлсэнээс шаардлага хангасан 3 байгууллагыг 2-р шатны шалгаруулалтад оролцуулахаар дүүргийн ХХҮХ-ийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/43 албан бичгээр ХАБЭА-н төвд дэмжин уламжлав. ХАБЭА-н үндэсний хорооноос “Мон хорус” ХХК эрүүл аюулгүй ажлын байрны үзүүлэлтээрээ тэргүүн байранд шалгарууллаа.<br>-“Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай” танилцуулга сурталчилгааг 1-20 дугаар хорооны аж ахуй нэгж, байгуулагад цахимаар сурталчилж, тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагуудаас -- “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 111 дүгээр заалтын хэрэгжилтийг аж ахуй нэгжид танилцуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг давхардсан тоогоор 50 байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 100200637010 тоот дансанд 2.294.649.535 төгрөгийг хөдөлмөр дэмжих санд төвлөрүүлсэн. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний 01 дүгээр тогтоолын хүрээнд Ажил олгогчдын чуулга уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 188 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, олон нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосон. | | | | | | |
| 178 | НЗДҮАХ-ийн 4.7.9 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 5.1.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, судалгаанд тулгуурлан дүүргийн залуучуудыг мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан ажиллана. | Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага төгссөн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | Хөтөлбөрт хамруулах залуучуудын тоо 50 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | - | НХХ ХөХҮХ | 100% | 100% |
| | | “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн зар мэдээллийг 20 хорооны мэдээллийн самбар, фэсбүүк хаяг, байгууллагын вэб сайтад байршуулж, 200 иргэнд мэдээлэл өгч ажиллалаа. Мэдээллийн дагуу 35 залууг хөтөлбөрийн сургалтад 2020 оны 06 дугаар сарын 12-14-ний өдрийн хооронд хамрууллаа.<br>Бизнес санааны сонгон шалгаруултад 10 баг оролцож, 5 баг шалгарч “Хурдасгуур хөтөлбөр”-т 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд хамрагдаж, дууссан. Хурдасгуур хөтөлбөрөөс эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийг 2 баг шалгарч тус бүр 10 сая төгрөгний санхүүжилт авч нийт 20 сая төгрөгний санхүүжилт олгоод байна.<br>-Дүүргийн барилгын чиглэлээр ажилладаг 31 залууг бүртгэлжүүлэн ажлын туршлагыг судлан үнэлэх Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, аргазүйн төвд холбон зуучилж ажиласан.<br>-Гэр бүлийн туршилтийн хөтөлбөрт хамрагддаг дүүргийн 18 дугаар хорооны иргэн 1 оюутанг нүүр будалтын студит туслах ажилтнаар ажилд оруулсан. | | | | | | |
| 179 | ДЗДҮАХ -ийн 5.1.3 Хороодод байрлах Е биржийн /Киоскмашин/ үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд ажлын байрны мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж ажиллана. | Хороодод байрлах Е биржийн хэвийн ажиллагааг ханган, иргэдэд ажлын байрны мэдээлэл, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, сургалтын талаарх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэнэ. | 20 хороо ХХҮХ -т байршилтай нийт 21 ширхэг Е бирж | Иргэд хороодоос ажлын байрны зар мэдээллийг шуурхай авч, Е биржийн хэвийн ажиллагаа, ажилласан цаг нэмэгдсэн байна. | - | НХХ ХөХҮХ | 100% | 100% |
| | | Дүүргийн 20 хороо, хэлтсийн байранд 1 нийт 21 Е бирж, хороо бүрт “Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн”, хэлтэст “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлал хариуцсан мэргэжилтэн-1” ажиллаж, иргэдэд ажлын байрны зар, мэдээллийг шуурхай хүргэж байна. ХХҮЕГ дээрх Е-биржийн нэгдсэн сервер хэвийн ажиллаж байгаа тул онлайн байгаа Е-биржийн ажлын байрны захиалага, мэдээ мэдээлэл шинэчлэгдэж байна. Тус киоск машин нь ашиглалтын хугацаа дууссан, техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахгүй болсон тул Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас е-биржийн тоног төхөөрөмжийг ашиглах хугацааг дуусгавар болгож байгаа. Иймд тухайн төхөөрөмжийн менежер програм хийгдээгүй учраас ажилсан цаг, хандалтын тоог гаргах боломжгүй болно.<br>Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд шинээр ажил хайгч 1255 иргэнийг бүртгэж, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинээр бий болсон 1500, ажил олгогчоос ирүүлсэн сул чөлөөтэй 803 ажлын байрыг бүртгэн 720 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж ажилласан. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах хүсэлтэй 1402 иргэнд тодорхойлолт гарган өгч, ажил, мэргэжлийн чиг баримжааны ганцаарчилсан зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээг 801 иргэнд үзүүллээ. | | | | | | |
| 180 | НЗДҮАХ-ийн 4.7.3 дахь заалт; | Зорилтот бүлгийн иргэдийг байнгын ажлын байранд авч | Байнгын ажлын байранд | Зорилтот бүлгийн иргэд байнгын | - | НХХ ХөХҮХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ-ийн 5.1.4 Ажил олоход хүндрэлтэй, зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлд бэлдэн, хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | ажиллуулсан ажил олгогчдод цалингийн дэмжлэг, урамшуулал олгох, дүүргийн хэмжээнд бий болсон шинэ ажлын байрыг бүртгэнэ. | зуучлагдсан иргэдийн тоо, шинэ ажлын байрны тоо, урамшуулал, цалингийн дэмжлэгийн хэмжээ | ажлын байртай болж, ажил олгогчид цалингийн дэмжлэг, урамшуулал олгосон байна. | | | | |
| | | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг 801 иргэнд ганцаарчилсан хэлбэрээр үзүүлсэн. Ажил олгогчийн урамшууллыг ажил идэвхтэй хайж байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулсан 4 иргэнийг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, материалыг хүлээн авлаа.<br>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинээр бий болсон байнгын болон түр ажлын байр 1500, сул чөлөөтэй 803 ажлын байрыг бүртгэн, 720 иргэнийг ажилд зуучилсан. Зорилтот бүлгийн иргэд байнгын ажлын байртай болж, 2 ажил олгогчид цалингийн дэмжлэг 11,300,000 төгрөг олгосон байна. | | | | | | |
| 181 | Архивын тухай хуулийн 6, 20,23,25 дугаар зүйл; ДЗДҮАХ 5.1.7 "Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ. | Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, бичиг хэрэг хариуцсан албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт, гарын авлага, аян зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Архив бичиг хэрэг хариуцсан албан хаагчдын мэдлэг чадвар дээшилж, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа сайжирсан байна. | 13,000.0 | ТЗУХ АТ | 100% | 100% |
| | | Сургалтын төлөвлөгөөний дагуу дүүргийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад цахимаар болон ажлын байранд заавар, зөвлөгөө өгөх, цахимаар сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт 165 албан хаагч хамрагдсан байна. Төрийн архивын цахим мэдээллийн нэгдсэн сангаас 11 лавлагаа үйлчилгээг олгосон байна.<br>Иргэд болон аж ахуй нэгжүүдэд 452 архивын лавлгаа, үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн байна. | | | | | | |
| 182 | | "Төрийн албан хаагчийн сургалт" хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Албан хаагчдын 80%-ийг хамруулсан байх | Албан хаагчдыг урт, дунд, богино хугацааны сургалтад хамруулсан байна. | 40,000.0 | ТЗУХ | 70% | 70% |
| | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 7 удаагийн сургалтад 61, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт” сэдэвт цахим сургалтад нийт 20 хороодын албан хаагч, хэсгийн ахлагч нарыг хамруулсан. Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 9 албан хаагчийг тус тус хамруулсан. Мэргэжил, боловсролоо дээшлүүлэхээр 3 албан хаагч магистр, 1 албан хаагч бакалаврын сургалтад суралцаж байна. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан Мэдээллийн цагаар сургалт зохион байгуулахыг зогсоосон. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 183 | | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хөтөлбөрт албан хаагчдыг хамруулах | Өнгөрсөн оноос буурууллахгүй ажилласан байна. | 400,000.0 | ТЗУХ | 100% | 100% |
| | | Засаг даргын Тамгын газрын 17 албан хаагчид орон сууцны нөхцөлөө сайжруулах, өөрийн орон сууцтай болох, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж 94,0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. | | | | | | |
| 184 | Батлан хамгаалах тухай хуулийн 3.1.6 дахь заалт ДЗДҮАХ-ийн 5.1.8 Дүүргийн иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэнэ. | Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 99 жилийн ойн баярын үйл ажиллагаа, генерал цолтонд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | Дүүргийн иргэд, генерал цолтнуудыг бүрэн хамруулах | Дүүргийн иргэдэд цэрэг эх оронч хүмүүжил олгох, Батлан хамгаалах салбарыг сурталчилсан байна. | 33,000.0 | ЦШ | 100% | 100% |
| | | Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 99, Чөлөөлөх дайны ялалтын 75, Цэргийн штабын 95 жилийн ойг угтан зохион байгуулж буй уралдаан нь Монгол хүн болж төрсөн бахархлыг тээгч байх үндэсний хөтөлбөрийн хүрээнд, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, өсвөр үеийнхэд уран сайхны боловсрол олгох, эх орны тухай дууг түгээн дэлгэрүүлэх, хүүхдийн авьяасыг нээх зорилгоор Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/16 дугаар захирамж, удирдамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд “Эх орноо магтан дуулъя” сэдэвт дууны уралдааныг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 2 дугаар сургуулийн урлагийн танхимд зохион байгууллаа.<br>“Эх орноо магтан дуулъя” уралдаанд дүүргийн ерөнхий боловсролын 19 сургуулийн сурагчид 30 гаруй уран бүтээлээр оролцлоо.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 99, Чөлөөлөх дайны ялалтын 75, Цэргийн штабын 95 жилийн ойг угтан зохион байгуулсан “Эх орноо магтан дуулъя” Уралдааны тэргүүн байранд 4 сургууль, дэд байранд Монгол Улсын Консерватор сургууль, гуравдугаар байранд 11 сургууль, тусгай байр буюу дөрөвдүгээр байранд Монгол Оросын хамтарсан сургуулийн хамтлаг шалгарч Засаг даргын нэрэмжит өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулав.<br>Дүүргийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/141 дүгээр захирамжийн дагуу Монгол Улсад генерал цол бий болсны 76 жилийн ойн өдрийг тохиолдуулан тус дүүрэгт оршин суудаг генералуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа.<br>Дүүргийн Засаг дарга Генералуудад Монгол Улсад генерал цол бий болсны 76 жилийн ойн өдрийн баярын мэндийг дэвшүүлж Генералуудад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг хүргүүллээ.<br>Уг арга хэмжээнд дүүрэг оршин суугаа 15 генерал цолтнуудыг дүүргийн Засаг даргын гарын бэлэг бэлэн мөнгийг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Ц.Бямбасүрэн гардуулан өгч баярын мэнд хүргэлээ зарим генералуудын дансанд мөнгийг шилжүүлж утсаар баярын мэндчилээ хүргэсэн. | | | | | | |
| 185 | | Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, аж | Дүүргийн иргэд,12 ААНБ | Батлан хамгаалах хууль тогтоомжийн | 21,000.0 | ЦШ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт явуулна. | | талаар мэдлэгтэй болсон байна. | | | | |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад аж ахуй нэгжийн батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд шалган туслах ажил зохион байгуулахаас өмнө дарга, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийж, шалгалтад хамрагдах байгууллагын хуваарийг танилцуулж, арга зүйн сургалтыг зохион байгуулж бэлтгэл ажлын хангах зөвлөгөө өгч ажилласан.<br>Бүтэн жилд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг дараах төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, Аж ахуйн нэгжүүдэд Батлан хамгаалах хууль тогтоомжийн хяналт шалгалтыг явууллаа. Үүнд: Нийслэл Өргөө амаржих газар, Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Ерөнхий боловсролын 45 дугаар сургууль, Ерөнхий боловсролын 58 дугаар сургууль, Моннис моторс ХХК, Грандхаан Айриш Паб ХХК, Таван богд ХХК, Туушин зочид буудал ХХК, Молор трейд ХХК, Блю скай эйжиа ХХК зэрэг нийт 10 байгууллага аж ахуй нэгжийн батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд шалган туслах ажил зохион байгуулахаас өмнө дарга, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтарсан арга зүйн сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 15-ний өдөр зохион байгуулсан. Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийж, байгууллагын ажилчин албан хаагчдад батлан хамгаалах хуулийг сурталчилан ажилласан.<br>2020 онд 10 байгууллагын 412 иргэнийг хяналт шалгалтад хамруулан цэргийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний журам зөрчсөн 25 иргэнийг сануулж, цэргийн үүрэгтний үнэмлэхгүй 14 иргэнд үнэмлэхийг шинээр олгон, цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 44 иргэнд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр болох 24,3 сая гаруй төгрөгийн төлбөрийн мэдэгдэх хуудас бичиж олгон барагдуулахад хяналт тавьж ажиллаж байна. | | | | | | |
| 186 | | Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн мэргэжил олгох болон Бэлтгэл офицерын мэргэжил олгох сургалт зохион байгуулна. | Цэргийн бэлтгэл сургалтад бүрэн хамруулах | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 2,000.0 | ЦШ | 100% | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2020 оны н/01 дүгээр захирамжийн дагуу цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах бэлтгэл ажлыг ханган Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн удирдлага, сувилахуйн албаны холбогдох албан тушаалтантай уулзаж сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулахад бэлэн болгосон. Цэргийн бэлтгэл албаны сургалтад хамрагдах хилийн болон дотоодын цэрэгт алба хаасан иргэдийн судалгааг гарган 55 иргэнийг мэдэгдэх хуудсаар дуудан уулзаж, 12 иргэнтэй сургалтад хамруулахаар гэрээ байгуулсан. /Сургалт 09 сард явагдана./<br>Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн н/01 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/22 дугаар тушаалын дагуу Баянзүрх, Сүхбаатар дүүргийн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд “Боолтын сувилагч” мэргэжил олгох цэргийн бэлтгэл албаны сургалтыг Зэвсэгт хүчний 027, 032 дугаар ангиудын материаллаг баазыг түшиглэн 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдийн цэргийн I зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд “Боолтын сувилагч” мэргэжил олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмчээр батлуулсан.<br>Цэргийн бэлтгэл албаны сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сувилахуйн албаны мэргэжилтнүүдтэй хичээлийн цаг, сэдвийг тохирч, хичээл заах багш нарын бэлтгэлийг хангасан.<br>“Боолтын сувилагч” мэргэжил олгох сургалтад шаардагдах сургалтын материал хэрэгслийн тооцоог гаргаж, сургалтын бэлтгэлийг хангасан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Цэргийн бэлтгэл албаны сургалтаар “Боолтын сувилагч” мэргэжил олгох сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр эхлүүлсэн.<br>Мэргэжил олгох сургалтад хамрагдаж байгаа цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд өглөө хичээл эхлэхээс өмнө хүн нэг бүрийн халууныг хэмжиж, /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар УОК-ийн зөвлөмжийг танилцуулж, мөн багаж хэрэгсэл дээр дадлага хийхдээ дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр танилцуулан гарын үсэг зуруулсан.<br>Цэргийн бэлтгэл албаны сургалтад нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдийн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүд хамрагдаж “Боолтын сувилагч” мэргэжил эзэмшсэн. | | | | | | |
| 187 | | Удирдах албан тушаалтнуудын цэргийн бэлтгэл сургалт зохион байгуулна. | Сургалтад бүрэн хамруулах | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 8,000.0 | ЦШ | 100% | 100% |
| | | Дайчилгааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх хэсэг, дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/339 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2020 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дүүргийн дайчилгаа удирдах бүлгийн гишүүдтэй “Албан тушаалтаны гүйцэтгэх үүрэг, ажиллагаа” сэдвээр сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгууллаа.<br>Дайчилгаа удирдах бүлгийн гишүүдийг дадлагын дохио өгч ажиллуулан сургалтыг эхлүүлсэн.<br>Тус сургалтаар 4 цагийн онолын хичээлийг төлөвлөн хичээлийн хөтөлбөрийг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан дараах хичээлүүдийг орсон.<br>Үүнд:<br>- Дайчилгаа удирдах бүлгийн гишүүдэд бэлтгэл хурандаа М.Батсуурь “Батлан хамгаалах тухай багц хууль болон дайчилгааны тухай хууль”, мөн “Дайчилгаа удирдах бүлгийн гишүүдийн үүрэг” сэдвээр,<br>- Дайчилгааны офицер дэд хурандаа Х.Бат-Амгалан “Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах” сэдвээр,<br>- “Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалт” сэдвээр,<br>- Нийслэлийн “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын дэд дарга Д.Амартүвшин “Зэвсэгт хүчний нэгтгэл ангийг техникээр нөхөн хангахад шилжүүлэх байрын үүрэг ажиллагаа” сэдвээр тус тус хичээл орсон.<br>2020 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 06.30 цагт Дүүргийн дайчилгаа удирдах бүлгийн гишүүдэд дадлагын зарлан мэдээлэх дохиог жижүүрт өгч дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон техник шилжүүлэх байрын бүрэлдэхүүнд дохиог үүрэн болон телефон утсаар өгч, дамжуулсан.<br>Хичээлийн төгсгөлд дайчилгаа удирдах бүлгийн гишүүд “Цугларах, Шилжүүлэх байр”-ын сургалтын үйл ажиллагаатай танилцсан. | | | | | | |
| 188 | | Цэргийн штабуудын офицер, ахлагч нарын 2020 оны даргын бэлтгэл сургалт зохион байгуулна. | Нийслэл дүүргүүдийн цэргийн штабын офицер, ахлагч нарын тоо | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 5,000.0 | ЦШ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Улсын хэмжээнд бэлэн байдалд шилжиж, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хийгдээгүй. | | | | | | |
| 189 | | "Оюутан цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулна. | Оюутнуудын тоо | Цэргийн хэргийн мэдлэгтэй болсон байна. | 2,500.0 | ЦШ | | Үнэлэх болом жгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны Журам батлах тухай 32 дугаар тогтоол /“Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журам/, Нийслэлийн Засаг даргын 2020 оны а/131, дүүргийн Засаг даргын 2020 оны А/64 дүгээр захирамжуудын дагуу бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Засгийн газрын 32 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасан болзол хангасан 22 их дээд сургуулиудад оюутныг оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутнуудын тоон даалгавар болон судалгааг ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн. /Улсын онцгой комиссийн шийдвэрээр арга хэмжээ цуцлагдсан/ | | | | | | |
| 190 | | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын анхан болон гүнзгийрүүлсэн шатны дадлага олгох сургалт зохион байгуулна. | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдыг сургалтад бүрэн хамруулах | Цэргийн хэргийн мэдлэгтэй болох, мэдлэг дээшлүүлсэн байна. | 6,000.0 | ЦШ | 100% | 100% |
| | | Монгол улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/572 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/170 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь 2020 онд 14 иргэнийг Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд элсүүлсэн.<br>Дүүргийн 20 хороонд албан бичиг цахимаар хүргүүлэн Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд алба хаах хүсэлтэй иргэдийг хорооны Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн дүйцүүлэх албанд элсүүлж, дүүргийн эрүүл мэндийн төвд 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдөр эмчийн үзлэгт хамруулсан.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб 2020 онд Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд элссэн 14 иргэнийг дүүргийн , таних нэр, дүрэмт хувцас, гутал зэргийг захиалан авч цэргийн дүйцүүлэх алба хаагчид хүлээлгэн өгсөн.<br>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, 2019 оны 336 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий сайдын 2020 оны 92 дугаар захирамж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 18 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1109 дүгээр захирамжийн дагуу Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн байрлалд “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл, тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтад хамрагдах 16 цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг 2020 оны 09 дүгээр сарын 18-24-ны өдрүүдэд хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх мэдлэг дадлага олгох сургалтыг нийслэл дүүргүүдийн цэргийн штабын төлөвлөлт, сургалтын офицер, ахлагч нар зохион байгуулж явууллаа.<br>Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн Улсын Онцгой комиссын зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахин Батлан хамгаалахын Сайдын баталсан цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл, тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтын хөтөлбөрийн дагуу дараах хичээлүүдийг төлөвлөж, зохион байгууллаа.Үүнд:<br>1.Орон нутгийн хамгаалалт-6 цаг<br>2.Батлан хамгаалах хууль тогтоомж, цэрэг эх оронч хүмүүжил-10 цаг<br>3.Цэргийн нийтлэг дүрмүүд-22 цаг<br>4.Зэвсэг техникийн бэлтгэл-6 цаг<br>5.ҮОХЗ-ээс хамгаалах, хүн эмнэлгийн бэлтгэл-6 цаг<br>6.Нийслэлийн бүтээн байгуулалтад оролцоход гүйцэтгэх үүрэг-6 цаг<br>7.Биеийн тамирын бэлтгэл-12 цаг<br>8.Хүмүүнлэгийн үйл ажиллагаа-4 цаг<br>9.Улсын болон орон нутгийн бүтээн байгуулалт -5 цаг нийт 77 цагийн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хичээл сургалтад цэргийн дүйцүүлэх алба хаагчид хамрагдсан. Улсын болон орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Налайх дүүргийн 2,8 дугаар хорооны орчны хог цэвэрлэх дүүргийн автобусны буудлуудыг тохижуулах зэрэг ажил хийж гүйцэтгэсэн. | | | | | | |
| 191 | | 2020 оны Цэргийн үүрэгтэн бэлтгэл офицеруудын бүртгэл, нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлага, халалтыг зохион байгуулна . | Цэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн насны залуучууд тоо | Цэргийн бүртгэл чанартай явагдаж, хяналтын тоог бүрэн биелүүлсэн байна. | 43,500.0 | ЦШ | 100% | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1248 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2019 оны 12 сарын 13-ний өдрийн А/471 дүгээр захирамжийн дагуу 2020 оны Цэргийн бүртгэл явуулах хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж Цэргийн штабын даргаар батлуулж, цэргийн бүртгэлийн талаар зохион байгуулах сургалтын бэлтгэл ажлыг хангасан.<br>Дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нь цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын бүртгэлийг зохион байгуулж явуулах ажлын төлөвлөгөө, хороодын цэргийн бүртгэлийн ажлын явцыг шалгах хуваарь гарган ажиллах бөгөөд шаардлагатай маягтуудыг хэвлүүлэн хороодод хүргүүлэн, цэргийн бүртгэлийн ажлыг хороонд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй сургалт–семинар 2020 оны 01 дүгээр сарын 17-нд зохион байгуулсан.<br>Цэргийн штабт ашиглагдаж байгаа мэдээллийн сангаас 20 хорооны цэргийн үүрэгтэн 18-50 насны эрчүүдийн мэдээллийн өгөгдөхүүнийг хорооны мэдээллийн санд суулган өгөхийн хамт дүүргийн статистикийн хэлтсийн 2019 оны хүн амын тоо болон хорооны хүн амын мэдээллийн сан /ХАМС/-гийн өгөгдөхүүнийг үндэслэн хороодын бүртгэвэл хорооны ХАМС программын мэдээлэлтэй тулгалт хийж, хаягандаа байдаггүй, шилжин явсан иргэдийг тодотгох ажлыг явуулж байна.<br>Цэргийн бүртгэлийн үед 2002 онд төрсөн залуучуудад цэргийн үүрэгтний үнэмлэх шинээр олгох, мөн цэргийн үүрэгтний үнэмлэх аваагүй иргэдийг үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулна. зохих цэргийн үүрэгтнүүдийн хяналтын тоог тогтоон өгөх, байнгын хяналт тавин ажиллах. Хороонд ашиглагдаж байгаа цэргийн бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээллийг<br>Цэргийн бүртгэлийг чанартай явуулах, цэргийн үүрэгтэн эрчүүдийг бүрэн хамруулахын тулд цэргийн бүртгэлийн талаар “Өдрийн сонин”, “Өнөөдөр сонин” телевиз, дүүргийн вэб сайтуудад мэдээ мэдээлэл нийтлүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>Цэргийн бүртгэлийг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагад хяналтын бүртгэлийг явуулахаар албан бичгийг хүргүүлнэ.<br>Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2020 оны тоо бүртгэлийг журмын дагуу зохион байгуулж, мэдээлэл, сурталчилгааны олон төрлийн хэлбэрийг ашиглан зохион байгуулсан нь бүртгэлийн чанарт сайнаар нөлөөлж, цэргийн тоо бүртгэлийн мэдээллийн сан, Хорооны хүн амын мэдээллийн сангийн зөрүү, иргэдийн хаягийн зөрчил зэрэг асуудлууд багасах боломжийг нэмэгдүүлсэн. Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2020 оны цэргийн тоо бүртгэл 96,2 хувьтай явагдсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1115, дүүргийн Засаг даргын А/325 дүгээр захирамжуудыг удирдлага болгон тус дүүргийн нутаг дэвсгэрт цэргийн жинхэнэ албаны 2020 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг 2020 оны 10 дугаар сарын 22-ний өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулан явууллаа.<br>Цэргийн албаны ээлжит татлага, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийн бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөөг боловсруулан дүүргийн Цэрэг татлагын товчооны даргаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаа. | | | | | | |

| | | |
|---|---|---|
| | | Энэ жилийн цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагаар цэргийн алба хаах насны нийт 4259 иргэдийн нэрийг жагсаалтаар нэгтгэн гаргаж, цэргийн жинхэнэ албанд зарлан дуудах хуудас бичиж тараасанаас 122 иргэн /шилжсэн, гэр бүлээрээ гадаадад амьдарч байгаа болон хаягандаа байхгүй зэрэг/-д бичигдсэн зарлан дуудах хуудас эзэндээ хүрэлгүй буцаагдсан. Нийт 4137 зарлан дуудах хуудас эзэндээ хүрч 94,8 хувьтай тараагдсан. Үүнээс 83 иргэн цэрэг татлагын байранд ямар нэгэн шалтгаангүйгээр ирээгүй байна.<br>Тус дүүргийн цэрэг татлагын байрны эрүүл мэндийн үзлэгээр 4054 нь биеэр орж асуудлаа шийдвэрлүүлсэн бөгөөд тэдний 355 нь буюу 8,7 хувь нь эрүүл мэндээр, 3469 нь буюу 85,5 хувь нь суралцахаар, 61 нь буюу 1,5 хувь нь ар гэрийн гачигдлаар, 1 иргэн хэргийн холбогдолтой гэсэн шалтгаанаар түр чөлөөлөгдөж, 168 иргэнийг цэргийн албанд тэнцүүлэн цэргийн жинхэнэ албанд татагдав.<br>Энэ ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндээр түр чөлөөлөгдсөн иргэдийн тоо өмнөх ээлжийн цэрэг татлагаар орж мөн шалтгаанаар түр чөлөөлөгдсөн иргэдээс 5.1 хувиар буурж 2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар орж эрүүл мэндээр чөлөөлөгдсөн 23 иргэн тэнцэж цэргийн албанд татагдсан<br>Цэрэг татлагын товчоо нь 18-25 насандаа цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол бүрдсэн 32 иргэн /1994 онд төрсөн/-ийг энэ оны 11 дүгээр сарын 10-ны дотор төлбөрийг барагдуулах, 3 иргэн /1994 онд төрсөн/-ий Цэргийн албаны тухай хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгахаас чөлөөлж, Засаг даргын захирамжаар баталгаажуулах шийдвэр гаргасан.<br>2020 оны хоёрдугаар ээлжээр гадаадад сурч амьдарч байгаа цэргийн насны залуучуудын 245 өргөдлийг 10 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд дүүргийн хүлээн авч шийдвэрлэсэн.<br>Дүүргийн боловсролын хэлтсийн харъяа насан туршийн боловсрол олгох “Гэгээрэл-Хөгжил” төвтэй хамтран цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгээр орж байгаа залуучуудын боловсролын судалгааг гаргуулж бага боловсролтой 5 иргэнийг суурь боловсролын мэдлэг олгох сургалтад хамруулахаар бүртгүүлсэн.<br>2019 оны хоёрдугаар ээлжээр цэргийн жинхэнэ алба хаах хугацаагаа дуусгаад халагдсан иргэдийг хүлээж авах өдөрлөгийг 10 дугаар сарын 16-18-ны өдөр 8 дугаар хорооны иргэний танхимд дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, дүүргийн цагдаагийн газар, нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, ажил олгогч байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.<br>Нийт халагдсан иргэдийн 102 иргэнийг, угтан авч байгаа ар гэрийнхэнтэй нь хамт ажлын байрны болон мэргэжил олгох сургалтын мэдээлэл сурталчилгаанд хамрууллаа.<br>Гадаад хэлний дамжаанд 6, их, дээд сургууль, коллежид үргэлжлүүлэн суралцах 12, барилгын туслах ажилтнаар 12, хамгаалалтын албанд 5, урьд эрхэлж байсан ажилдаа ажиллах 16 Зиргэн, дүүргийн цагдаагийн газарт 28, хувиараа хөдөлмөр эрхлэх 8 иргэнийг бүртгэн авсан бөгөөд, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн алба, албан бус боловсролын Гэгээрэл хөгжил төв, тогтмол харилцан ажиллагаатай ажилдаг М-Си-Эс Армор ХХК, Сүүн мандал ХХК, Хүчит зам ХХК зэрэг ажил олгогч томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудад байгаа 100 гаруй сургалт дамжаа, 250 орчим ажлын байрыг танилцуулан сурталчиллаа.<br>Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн Д.Тунгалаг ажлын хэсэгт ажиллаж ажлын байрны бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүд, мэргэжлийн сургалтад хамруулах, ажил мэргэжлийн чиг баримжаа зэргээр зөвлөгөө өгч дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй сул чөлөөтэй болон шинэ ажлын байрт бүртгэх ажлыг явуулсан.<br>Дүүргийн цагдаагийн 1,2 дугаар хэлтсээс цагдаагийн албанд ахлагчаар элсүүлэх санал тавь танилцуулга хийсэн “Эко констракшн, “Баян соёмбо”, “Буман хишигтэн цэрэг” хамгаалалтын алба, “Бишрэлт групп” ХХК, “Их үйлсийн эрэлд” ХХК, ХХК, Таван толгой ХХК, Орхон дээд сургууль, зэрэг байгууллагуудаас цэргээс халагдан ирсэн цэргийн бэлтгэл үүрэгтэнд ажлын байрны санал танилцуулж нийт 41 цэргийн үүрэгтэнг ажлын байраар зуучилж ажиллалаа. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Цэрэг хүлээн авах ажиллагаанд дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн дарга С.Сайнбаяр ажлын хэсэгт ажиллаж суурь боловсролын гэрчилгээгүй 1, бүрэн дунд боловсролын гэрчилгээгүй 2, бага боловсролтой-1 иргэнийг бүртгэлд хамруулан сургалтад хамруулж боловсрол олгохоор болсон.<br>2019 оны нэг, хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албан татагдаад халагдаж ирсэн дайчдыг дайчилгааны даалгавартай анги командуудад оногдуулан дансалсан. | | | | | | |
| 192 | | Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, цэргийн албаа хааж байгаа дайчдын санал сэтгэгдлийг сонсоно. | Цэргийн алба хааж байгаа дайчидын тоо | Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | 9,000.0 | ЦШ | 100% | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/228, 08 дугаар сарын 19-ний өдрийн А/276 дугаар захирамжуудын дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Н.Энхболдоор ахлуулсан бүрэлдэхүүн 2020 оны 08 сарын 20-25-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт байрлах Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 256 дугаар анги, Баянхонгор аймагт байрлах Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид нийслэлээс хугацаат цэргийн жинхэнэ албанд татагдан алба хааж буй цэргүүдийнхээ нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, санал сэтгэгдлийг сонслоо.<br>Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд, залууст эх оронч хүмүүжил олгох зорилгоор Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цэргийн штабаас жил бүр уламжлал болгон цэргүүдээ эргэдэг.<br>Тус ангид нийслэлийн Сүхбаатар дүүрэг болон бусад дүүргээс хугацаат цэргийн жинхэнэ албанд татагдсан залуус албаа нэр төртэй хааж байна.<br>Энэ үер тус ангийн ангийн удирдлагууд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ангийн түүхэн товчоо, хийж хэрэгжүүлж буй ажлаа танилцуулж, цэрэг эрс сурсан эрдмээ сонирхуулж, чин сэтгэлийн үгээ хуваалцлаа. Хугацаат цэргийн алба хаагчид эр зоригийн илэрхийлэл албаараа бахархаж сэтгэл дүүрэн байгаагаа илэрхийлж байлаа.<br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлээс татагдсан хугацаат цэргийн албан хаагчдадаа 1000ш амны хаалт, 500ш гар ариутгагч, дүүргийн Засаг даргын илгээлт болон ар гэрээс нь хүргүүлсэн захиа, эргэлтийг хүлээлгэн өглөө.<br>Мөн эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 256 дугаар, Баянхонгор аймагт байрлах Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч болон офицер, ахлагч, албан хаагчдад дүүргийн Засаг даргын “Талархал бичиг” болон дурсгалын зүйл гардууллаа. | | | | | | |
| 193 | | Дайчилгаатай команд штабын хээрийн сургууль зохион байгуулна . | Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн тоо | Бэлэн байдал дээшилсэн байна. | 10,000.0 | ЦШ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Улсын хэмжээнд хөл хорио тогтоосон тул хийгдээгүй. | | | | | | |
| 194 | | Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчлах, Дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулна. | Томилгоот бүрэлдэхүүн оролцох | Бэлэн байдал дээшилсэн байна. | 13,000.0 | ЦШ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **“Цугларах, техник шилжүүлэх байрууд”- ын томилгоот бүрэлдэхүүний сургалт**<br>Дайчилгааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэхь хэсэг, дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/339 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2020 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дүүргийн цугларах байрын томилгоот бүрэлдэхүүнтэй “Зэвсэгт хүчний анги, салбаруудыг бэлтгэл офицер, бэлтгэл үүрэгтнээр нөхөн хангахад цугларах байрын томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, ажиллагаа” сэдвээр сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нийслэлийн ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн байранд зохион байгууллаа.<br>Цугларах байрын томилгоот бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг дүүргийн ЗДТГ-ын даргаар батлуулж, сургалт явуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>Нийслэлийн ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн захирлын тушаалаар томилгоожсон цугларах байрын бүрэлдэхүүнийг тодотгож, сургалт, дадлагад шаардлагатай тасгуудад хөтлөгдөх баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулсан.<br>Цугларах байрыг бүрэн дэлгэн дайчилгаагаар ирсэн бэлтгэл офицер, бэлтгэл үүрэгтэнг хэрхэн яаж хүлээн авах, тасгуудаар яаж оруулах, анги командад хувиарлах талаар дадлага хийлгэсэн.<br>***Техник шилжүүлэх байрын томилгоот бие бүрэлдэхүүнтэй сургалт***<br>Дайчилгааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэхь хэсэг, дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/339 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2020 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дүүргийн техник шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүнтэй “Зэвсэгт хүчний анги, салбаруудыг авто техникээр нөхөн хангахад техник шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, ажиллагаа” сэдэвт сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдөр дүүргийн техник шилжүүлэх байр Нийслэлийн “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т зохион байгууллаа.<br>Техник шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг дүүргийн ЗДТГ-ын даргаар батлуулж, сургалт явуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>Нийслэлийн “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын даргын тушаалаар томилгоожсон шилжүүлэх байрын бүрэлдэхүүнийг тодотгож, сургалт, дадлагад шаардлагатай тасгуудад хөтлөгдөх баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулсан.<br>Техник шилжүүлэх байрыг бүрэн дэлгэн дайчилгаагаар ирэх техникийг хэрхэн яаж хүлээн авах, тасгуудаар яаж оруулах, үзлэг оношлогоогоор орох, анги командад хувиарлах талаар дадлага хийлгэсэн. | | | | | | |
| 195 | | Нийслэл, дүүргийн Засаг даргын нэрэмжит дүүргүүдийн Ерөнхий боловсролын сургуулийн дунд зохиогдох цэрэг спортын "Дөл" тоглолтыг зохион байгуулна. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид оролцох | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид эх оронч сэтгэлгээтэй болсон байна. | 6,000.0 | ЦШ | | Үнэлэх болом жгүй. |
| | | /Улсын онцгой комиссийн шийдвэрээр арга хэмжээ цуцлагдсан./ | | | | | | |
| 5.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 196 | Инновацийн тухай хуулийн 4 дүгээр зүйл; ДЗДҮАХ-ийн 5.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг | Хөгжлийн бэрхшээлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн өөрөө өөртөө ажлын байр бий болгох санал, | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрөө өөртөө ажлын | - | НХХ ХөХҮХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжих чиглэлээр батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, үүний дотор Старт ап бизнес компаниуд, инновацийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулна. | санаачлагыг дэмжих төсөл зарлан, шаардлагатай санхүүжилтийг зориулалтын дагуу олгоно. | | байр бий болгосон байна. | | | | |
| | | “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эх, хувиараа болон бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй, бичил бизнес, өрхийн үйлдвэрлэл, фермерийн аж ахуй эрхлэгчдэд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төслийг 2020 оны 03 дугаар сарын 04-нөөс 04 дүгээр сарын 01-нийг өдрийг дуустал хугацаанд зарлан, 30 иргэн төсөл ирүүлснээс Ажлын хэсэг үйл ажиллагаатай нь танилцаж, нээлттэй сонгон шалгаруулалт хийв. Үүнээс нийт 19 төслийг 80 сая төгрөгийн санхүүжилтээр дэмжиж, орлогыг нь нэмэгдүүлэн ажилласанаар 19 иргэн байнгын ажлын байртай боллоо.<br>“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг хөтөлбөр”-т хамрагдсан төслийн эргэн төлөлтөд хяналт тавин ажиллаж байна. | | | | | | |
| 197 | | Жижиг дунд үйлдвэрлэгчдийг урт хугацаатай, хүү багатай зээл, тусламж олон улсын төсөл хөтөлбөрт хамруулах замаар бүтээгдэхүүн болон ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 75 ажлын байрыг нэмэгдүүлэх | Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо нэмэгдэж өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн байна. | - | НХХ ХөХҮХ | 100% | 100% |
| | | -“Ажлыг байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй, бичил бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төслийг 2020 оны 03 дугаар сарын 04-нөөс 04 дүгээр сарын 01-нийг өдрийг дуустал хугацаанд хүлээн авсан. Нийт 54 төсөл ирүүлсэнээс Ажлын хэсэг үйл ажиллагаатай нь очиж танилцан, нээлттэй сонгон шалгаруулалт хийж, 28 төслийг 123 сая 500 мянган төгрөгийн санхүүжилтээр дэмжиж, орлогыг нь нэмэгдүүлэн ажилласанаар 35 иргэн байнгын ажлын байртай болж хэрэгжилт бүрэн хангагдсан.<br>“Ажлыг байрыг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 28 иргэнийг төсөлд хяналт тавьж, “Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST” хөтөлбөрт хамруулахаар ажиллаж, 6 иргэн хамрагдсан. Мөн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Хөгжлийн шийдэл” ТББ-тай 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг /USAID/ -ийн санхүүжилттэй хэрэгжих Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх хөтөлбөрийн /Best хөтөлбөр/ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, жижиг зээлд хамрагдсан, хамрагдах боломжтой бизнес эрхлэгч иргэдэд сургалт, уулзалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах дэмжин туслах, хөгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ. Сургалтыг “Хөгжлийн шийдэл” ТББ өөрсдийн санхүүжилтээр цогц сургалт зохион байгуулж, 51 иргэн чадавхжуулах сургалтад хамрагдсан. Эдгээр иргэдэд тус байгууллагаас үүргэвч, плаш, бизнесийн гарын авлагын ном, тэмдэглэлийн дэвтэр бүхий 1 иргэнд нийт 55.000 төгрөгний зүйл өгсөн. Хөгжлийн шийдвэл ТББ нь өөрсдийн төслийн санхүүжилтээс дээрх иргэдэд нийт 2.805.000 олгож ажилласан.<br>-Бичил зээлд хамруулах хүрээнд ХНХЯ-д банк сонгох сонгон шалгаруулалт явагдаж тус дүүргийн “ХААН БАНК”-ны 3 салбараар дамжуулан иргэдэд бичил зээл олгогдохоор болсон. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд жижиг зээл олгох зар мэдээллийг 5 эх сурвалжаар 189 иргэнд хүргэж, 25 иргэн бүртгэгдсэн.<br>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой зээлийн өмнөх сургалт түр хугацаагаар хойшлогдсон бөгөөд сургалтыг онлайн хэлбэрээр явуулахаар төлөвлөн ажиллаж байна. Тус зээл нь 5-10 сая төгрөгийн хооронд шаардлага | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангагдсан иргэдэд бичил зээл олгодоно. Дэлхийн банкнаас 740 сая төгрөгийн санхүүжилт банкинд орсон ба санхүүжилт олгох ажил ирэх жил мөн үргэлжлэн хийгдэнэ. | | | | | | |
| 198 | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн борлуулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор борлуулалтын нэг цэгийг нэмж байгуулна. | Бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, сурталчлах зорилгоор худалдааны 2 цэг ажиллуулж 20 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулах | Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн байна. | 20,000.0 | ХХҮХ ЖДҮДТ | 100% | 100% |
| | НЗДҮАХ-ийн 4.7.3 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 5.2.2 Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулах борлуулалтыг дэмжиж ажиллана. | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвд бойжиж буй үйлдвэрлэл эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэгчдийн борлуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах шинэ цэгийг дүүргийн 9 дүгээр хороо, 17/1 байрны 1 давхарт байрлах өрөөнд байгуулах, тухайн өрөөний тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулах дүүргийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А//187 дугаар захирамжийн хүрээнд үнэлгээний хороо байгуулагдан худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж шалгаруулалтанд оролцсон аж ахуйн нэгжүүдээс Бузт ХХК шалгарч, засвар, тохижилтын ажил хийгдэж дуусаад байна. | | | | | | |
| 199 | | Дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, дотоод гадаадын үзэсгэлэн, яармаг худалдаанд хамруулж, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлнэ. | 10 удаагийн дотоод гадаадын үзэсгэлэн худалдаанд 50 үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах | Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт, өрсөлдөх чадвар нэмэгдсэн байна. | 30,000.0 | ХХҮХ ЖДҮДТ | 100% | 100% |
| | | - Монголын уламжлалт сар шинийг угтаж үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулахаар бэлтгэл ажлыг хангаж захирамжийн төслийг боловсруулж, дүүргийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн байранд үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар төлөвлөсөн, мөн Мишээл экспо худалдааны төвд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаанд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулахад лангуу түрээслэхээр төлөвлөн албан бичгийг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 8/88 дугаар албан бичгээр Мишээл экспо ХХК-д явуулсан боловч шинэ коронавирусын халдвар гарсантай холбогдуулан үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаагүй.<br>- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр 27-ны өдрийн "Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/108 дугаар захирамж, 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 дугаар захирамжийн хүрээнд Нийтийг хамарсан үзэсгэлэн худалдаа, үйлчилгээний аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байх мэдээллийг дүүргийн хороодын Ажлын албанд 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 8/280 дугаар албан бичгээр хүргүүлэн хяналт тавин ажиллалаа. Мөн дүүргийн 3 дугаар хороо, Аса циркт зохион байгуулагдаж байсан цагаан сарын үзэсгэлэн худалдааг зохион байгуулагчдад тус захирамжийг хүргүүлж, үзэсгэлэн худалдааг зогсоосон<br>- Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Дүүргийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/88 дугаар захирамжаар эргүүлээр ажиллах ажилтан албан хаагчдад | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зориулсан 400ш ханцуйны таних тэмдгийг оёход шаардагдах 6,8 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, дүүргийн Жижиг, дунд үйлвэрлэлийг дэмжих төвийн үйлдвэрлэл эрхлэгчдээр гүйцэтгүүлж, дэмжин ажилласан.<br>- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн бойжигч Б.Хүрэлбаатар, /тавилга/, Х.Тулга /Монгол футболк/, н.Оюунсүрэн /үндэсний хувцас/ нар хамтран Дорноговь, Хөвсгөл, Дундговь аймгуудад өөрсдийн бараа бүтээгдэгхүүнээ сурталчлах, борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх зорилгоор дээрх аймгуудад явуулын худалдаа ажиллуулж, 8,275,000 төгрөгийн борлуулалттай ажилласан байна.<br>- Мишээл экспо олон улсын худалдааны төвийн үзэсгэлэнгийн танхимд 2020 оны 06 дугаар сарын 12-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатарт үйлдвэрлэв-2020” үзэсгэлэн худалдаанд дүүргийн 3, 7, 8, 14 дүгээр хорооны ноос ноолууран эдлэл, үндэсний хувцас, монгол футболк, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4 иргэн оролцож, 11,650,000 төгрөгийн борлуулалт хийж, өрхийн амжиргаагаа нэмэгдүүлсэн байна.<br>- Дүүргийн үндэсний хувцасны үйлдвэрлэл эрхлэгч Б.Оюунсүрэн, Монгол футболк үйлдвэрлэл эрхлэгч Х.Тулга нар хамтран Сүхбаатар, Баянхонгор, Өвөрхангай, Дорноговь, Хөвсгөл аймгуудад 2020 оны 07 дугаар сарын 05-25-ны өдрүүдэд үндэсний их баяр наадам угтсан явуулын худалдаа үйлчилгээг зохион байгуулж, 12,460,000 төгрөгийн борлуулалт хийж, өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна.<br>- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Улаанбаатар түншлэл-2020” Олон улсын үзэсгэлэн 2020 оны 09 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба дүүргийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/284 дүгээр захирамжаар шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн жижиг, дунд бизнес эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэгчид, гараааны бизнес эрхлэгчдийг дэмжин урамшуулах, тэдгээрийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, олон улсын стандартад нийцсэн импортын бараа бүтээгдэхүүнийг Монголын зах зээлд нэвтрүүлэх, зах зээлээ өргөжүүлэх, экспортыг дэмжих, шинэ зах зээлд гаргах, түншлэлийг бий болгох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцууллаа.<br>Үзэсгэлэн худалдааны 9м2 талбай бүхий 2 павилионд 50 гаруй нэр төрлийн 1200 гаруй бараа бүтээгдэхүүнийг сурталчлан, 5,270,000 мянган төгрөгийн борлуулалт хийж, өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна.<br>- 2020 оны 10 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "ITM-2020" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн мэдээллийг үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргэснээр футболканы үйлдвэрлэл эрхлэгч Х.Тулга оролцож, 1,680,000 төгрөгийн борлуулалт хийж оролцсон байна.<br>- Мишээл экспо олон улсын худалдааны төвийн үзэсгэлэнгийн танхимд 2020 оны 11 дүгээр сарын 05-08-ны хооронд зохион байгуулагдсан "Өвлийн гоёл 2020" үзэсгэлэн худалдаанд ЖДҮДТөвийн бойжигч ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч Ч.Бадамцэцэг, Монгол футболкын үйлдвэрлэл эрхлэгч Х.Тулга нар оролцож, нийт 4,900,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.<br>2020 онд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих 8 ажлыг зохион байгуулж, нийт 47,665,000 төгрөгийн борлуулалт хйиж, өрхйин орлогоо нэмэгдүүлсэн байна. | | | | | | |
| 200 | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн борлуулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор томоохон худалдааны төвүүдэд | Хамруулах иргэний тоо 5 | Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн байна. | - | НХХ ХөХҮХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | борлуулалтын цэг ажиллуулах арга хэмжээ зохион байгуулна. | | | | | | |
| | | Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх, сурталчлах зорилгоор дүүргийн 11 дүгээр хорооллын “Дөрвөн-Уул” захын худалдааны төвийн 1 давхарт 52м.кв худалдааны цэг ажиллуулж, 14 иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулж байна. Төсөл хөтөлбөрийн борлуулалтын дэмжлэгийн түрээсийн төлбөрт 8.400.000 төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэнд түрээсийн хөнгөлөлтөд 1.500.000 төгрөг олгож, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн. | | | | | | |
| 201 | НЗДҮАХ-ийн 4.7.5 дахь заалт;<br>ДЗДҮАХ-ийн 5.2.3 Зорилтот бүлгийн иргэн, нөхөрлөл, хоршоодыг бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулна. | Зорилтот бүлгийн иргэн, нөхөрлөл, хоршоодод бизнес инкубацын үйлчилгээ үзүүлж, ажлын байраар хангана. | Зорилтот бүлгийн 1 иргэнд бизнес инкубацын үйлчилгээ үзүүлэх | Зорилтот бүлгийн иргэний үйлдвэрлэлийн бүтээмж сайжирсан байна. | - | ХХҮХ<br>ЖДҮДТ | 70% | 70% |
| | | Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны Дамбадаржаа 52 гудамж 693г тоотод оршин суугч тавилгын чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгч А.Хүрэлбаатартай 2020 оны 09 дүгээр сарын 28 өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл 20/31 дугаартай ажлын байрны хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажилласан. | | | | | | |
| 202 | | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвөөс зохион байгуулж байгаа арга хэмжээнд зорилтот бүлгийн иргэдийг хамруулна. | Зорилтот бүлгийн 5 иргэнийг хамруулах | Зорилтот бүлгийн иргэд чадваржсан байна. | - | ХХҮХ<br>ЖДҮДТ | 100% | 100% |
| | | Итгэлийн оч гал дөл НҮТББ, “Сургалт, судалгааны оюуны тамир төв” ТББ-тэй хамтран 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр дүүргийн үйлдвэрлэл эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнд аж ахуй эрхлэх, татварын эрх зүйн сургалтыг зохион байгуулсан. | | | | | | |
| 203 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжил эзэмшүүлэх, нөхөрлөл, хоршоо байгуулан хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. | Хамруулах иргэний тоо -15 | ХБИ мэргэжилтэй, байнгын ажлын байртай болж, өрхийн орлого нэмэгдэн амьжиргааны түвшин дээшилсэн байна. | - | НХХ<br>ХөХҮХ | 100% | 100% |
| | | Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хуулийн 11.3 дахь заалт, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн А/85 тоот тушаалаар батлагдсан эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллагуудын жагсаалтын дагуу хүсэлтийг хүлээн авч, сонгон шалгаруулж, гэрээ хийн ажиллахаар бэлтгэл ажил хангагдсан.<br>“ЗА НЭГДЭЛ” ТББ-ын сургалтын төвөөр дамжуулан 28 иргэнийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулж, 840.000 төгрөгний санхүүжилтийг сургалтын байгууллагад олголоо. | | | | | | |
| 204 | ДЗДҮАХ-ийн 5.2.4 Дүүргийн жижиг, дунд | "Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл" дэд хөтөлбөрийн 3.2.3 | Үйлдвэрлэлийн чиглэл, хороо, | Үйлдвэрлэл эрхлэгчдийн | - | ХХҮХ<br>ЖДҮДТ | 90% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрийг дэмжих төвийг түшиглэн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, судалгаа, мэдээллийн төвийг байгуулна. | дахь заалтын хүрээнд Үйлдвэрлэгчдийн бүртгэлийг тогтмол хийж, төрөлжүүлэн бүртгэлийг сайжруулна. | үйлдвэрлэлийн төрлөөр нь бүртгэх | бүртгэл сайжирсан байна. | | | | |
| | | - Дүүргийн 20 хорооноос үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэлийг авч, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн мэдээллийн санд бүртгэлтэй үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэлтэй нэгтгэн, үйлдвэрлэл эрхлэгчдийг бүтээгдэхүүний чиглэл, төрлөөс нь хамааруулан бүртгэлжүүлж байна. Дүүргийн жижиг, дунд 300 үйлдвэрлэл эрхлэгчийн бүртгэл мэдээлэл бүрэн баталгаажсан.<br>- Сургалт, судалгаа мэдээллийн төвөөр дамжуулан дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үйлчилгээний тухай, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлтэй зээл болон арилжааны банкуудаас олгож буй бизнесийн зээл, бизнесийн зөвлөгөө, мэдээллийг 178 иргэнд хүргэн ажиллалаа.<br>- Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр өөрийн хөрөнгөөр барьсан ажлын байртай боловч зээлийн асуудалтай байгаа 9 үйлдвэрлэл эрхлэгчийн бүртгэл, судалгааг гаргаж, мэдээллийг хүргүүллээ. | | | | | | |
| 205 | | Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл дэд хөтөлбөрийн 3.2.5 дахь заалтын хүрээнд Иргэд олон нийтэд үндэсний үйлдвэрлэлийг сурталчлах контент үзэсгэлэн худалдаа, форумыг төрийн болон төрийн бус байгууллага, салбарын мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулна. | Үндэсний үйлдвэрлэлийг сурталчлах 1 удаагийн өдөрлөг зохион байгуулж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчилах | Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт нэмэгдсэн байна. | 4,000.0 | ХХҮХ | 100% | 100% |
| | | - Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамж, 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 дугаар захирамжийн хүрээнд Нийтийг хамарсан үзэсгэлэн худалдаа, үйлчилгээний аливаа арга хэмжээ зохион байгуулаагүй байна.<br>- Капитрон банкны Ажлын хэсэгтэй хамтран дүүргийн 5, 12, 19 дүгээр хороодод жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хатгамал, эсгий урлал, бэлэг дурсгал, гар урлалын чиглэлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6 иргэний ажлын байр, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнтэй 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр танилцсан. Капитрон банкны ажлын хэсгээс цаашид бүтээгдэхүүн үйлчилгээг нь сурталчлан, борлуулалтыг нь дэмжин ажиллах үйлдвэрлэл эрхлэгчийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах саналыг ирүүлэх юм.<br>- Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газартай хамтран “Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 07 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд дүүргийн 10 үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн бүтээгдэхүүний болон аж ахуй эрхлэх сургалтыг Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын байранд зохион байгуулан ажилласан. | | | | | | |
| 206 | НЗДҮАХ-ийн 1.2.3, 1.2.6 дахь заалт; | “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.4 | Өдөрлөг, сургалтад | Өдөрлөг, сургалтад хамрагдсан иргэд, | 5,000.0 | ХХҮХ МХХ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ-ийн 5.2.6. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажиллах, гадаад болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.<br>"Улаанбаатарт үйлдвэрлэв" дэд хөтөлбөрийн 2.2.3 Дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | дэх заалтын хүрээнд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн хүрээнд аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагатай хамтран нийтэд чиглэсэн үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж хэвшинэ. | хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо | аж ахуйн нэгжийн 50% нь сургалтаар олж авсан мэдлэг, мэдээллээ амьдрал дээр хэрэгжүүлсэн байна. | | | | |
| | | 1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Чиглэл өгөх тухай 1/221 дугаар албан бичигт “Хариуцлагатай-хэрэглэгч” сэдвийн хүрээнд цахим орчинд тэмдэглэх тухай чиглэл ирүүлсэн. Уг чиглэлийн дагуу тус дүүрэгт амьдарч буй иргэн, үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд зориулан “Хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгоцгооё”, “Хогоо ангилан ялгаж хэвшье” сэдэвт мэдээ, мэдээлэл агуулсан 2 төрлийн сурталчилгааны зурагт хуудсыг гаргаж, http://sbd.gov.mn/ цахим хуудас, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар дүүрэг, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, хороодын пейж хуудсуудаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.<br>2. Нийслэлийн Засаг даргын 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жил болгон зарласантай холбогдуулан хотын өнгө үзэмжийг сайжруулах, аж ахуйн нэгж байгууллагуудын гадаад болон дотоод орчны стандарт, норм дүрмийг хангуулах ажлын хүрээнд доорх ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд: Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/134 дүгээр тушаалын дагуу Худалдааны газрын үйлчилгээ MNS5021:1:2019, Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946:2019 стандартын шаардлагын хэрэгжилтийг хангуулах, орчны тохижилт, байгууллагын гадна хаягийн стандартыг хангуулан ажиллах чиглэлээр тус дүүрэгт худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.<br>Шалгалтанд хамрагдсан худалдааны 52, хоол үйлдвэрлэлийн 96, нийт 148 аж ахуйн нэгжид Монгол хэлний тухай хууль, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журмыг мөрдөж Монгол хэл дээр хаягжилтийг хийлгэсэн эсэхэд хяналт тавьж ажиллалаа.<br>Шалгалтанд хамрагдсан нийт худалдааны газруудын 64 хувь, хоол үйлдвэрлэлийн газруудын 71 хувь нь Монгол хаягтай байсан бөгөөд шалгалтын үр дүнд худалдааны 19, хоол үйлдвэрлэлийн 28, нийт 47 буюу 32 хувь нь гадна хаягийн байгууламжийг Монгол хэл дээр болгон шинэчилж, биелэлтийг хангуулан ажиллалаа.<br>3. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт “Монгол хэлний тухай хууль”-ийн хэрэгжилтийг 2020 оны 8/1239 дугаар албан бичгээр, “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг 2020 оны 06-р сарын 09-ний өдрийн 8/1307 дугаар албан бичгээр тус тус хүргүүллээ.<br>4. Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран “Молор трейд” ХХК-ийн “Их тамир” амралтын газрын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэнээс ирүүлсэн гомдлын хяналт шалгалт хийж хоол үйлдвэрлэл, үйлчилгээ шаардлага хангахгүй, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд нийслэлийн Захирагчийн ажлын албаны дарга, түр зөвлөлийн дарга Т.Гантөмөрийн баталсан “Худалдаа, үйлчилгээний газруудад коронавируст “Ковид-19” халдвараас сэргийлэх, халдварын эрсдлийг бууруулах, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний заавар”-ыг зөрчиж хүчин чадлыг бууруулаагүй хэт олон хүнийг нэг дор хүлээн авсан, халуун хэмжигч, гар ариутгагч хангалттай бус зэрэг зөрчил илэрснийг холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулахаар ажиллаж байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 5. Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран 8 дугаар хорооны оршин суугчийн гаргасан гомдлын дагуу тус хорооны 29 дүгээр байрны 1 давхарт үйл ажиллагаа эрхэлж буй 9 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд 14 хоног тутамдаа ариутгал халдваргүйтгэлийг хийлгэдэг, завсар зайгаа битүүлж засвар хийсэн, ил жоом харагдахгүй байсан тул тус байрыг хариуцсан “Б84” СӨХ болон тус хорооны Засаг даргад тус байранд хортон шавьж устгах арга хэмжээ авч ажиллах тухай 02.015/320 дугаар албан бичгийг 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан.<br>6. Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хэрэгжих хууль тогтоомж, дүрэм, журмыг бүрэн хэрэгжүүлэхтэй холбоотой бизнес эрхлэгчдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэргэжлийн туслалцаа үзүүлж, сургалт мэдээллээр хангах чиглэлээр МХХ нь Шангри-Ла Улаанбаатар хотел ХХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.<br>7. Нийслэлийн хэмжээнд зарласан “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд дүүрэг дэх МХХ-тэй хамтран “Мэргэжил, арга зүйн туслалцаа” сэдэвт үзүүлэх сургалтыг Алтан жолоо ХХК-ийн Улаанбаатар их дэлгүүрт байрлах “Сансар-40” супермаркетыг түшиглэн зохион байгууллаа. Сургалтаар аж ахуйн нэгж, иргэдэд хууль, тогтоомж сурталчлах, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, стандартыг мөрдүүлэх, үйлчилгээний соёл, орчин үеийн чиг, хандлага зэрэг агуулгын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ. Сургалтад оролцогчдод Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас эрхлэн гаргасан “Худалдааны стандарт” номыг гарын авлага болгон тараалаа. | | | | | | |
| 207 | | “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн 3.2.4 дэх заалтын хүрээнд Хүн амын дунд хоол тэжээлийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ. | 2 удаагийн сургалтаар 200 иргэн, аж ахуйн нэгж хамруулах | Иргэн, аж ахуйн нэгжийн сургалтад хамрагдсан байна. | 2,000.0 | ХХҮХ | 90% | 100% |
| 207 | | 1. Хоол үйлдвэрлэлийн газарт тавигдах стандартууд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан “Нэг хот- нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр сургалт зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан 120 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн ажилтнуудад Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019, Хоолны газрын нэр томъёо MNS 6777:2019 стандарт, “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт”-уудыг танилцуулан, мэдээлэл олгож, цаашид анхаарах зүйл, авч хэрэгжүүлж буй ажлуудын талаар санал солилцлоо.<br>Мөн шинээр батлагдах гэж буй “Хоолны газрын хүний нөөцөд тавигдах стандарт, шаардлага”, “Кейтринг үйлчилгээнд тавих стандарт, шаардлага” зэрэг стандартуудын төслийг танилцуулж, санал авлаа.<br>Шинэчлэгдсэн стандартуудыг Стандарт хэмжилзүйн газраас /БЗД, Жуковын автобусны буудлын замын хойно байрлах/ авч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг нийт аж ахуйн нэгжүүддээ анхааруулаа. Цаашид бүх аж ахуйн нэгжүүдэд стандартыг танилцуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн байсан ба шинэ коронавирусийн халдварын улмаас төлөвлөгдсөн сургалтууд зохион байгуулагдаагүй болно.<br>2. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/134 дүгээр тушаал, “Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдааны газруудыг аттестатчилах” удирдамжийн дагуу Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946:2019 | | | | | | |

| | | |
|---|---|---|
| | | стандартын шаардлагыг хангуулах, хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр Цагдаагийн хэлтэстэй хамтран 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хяналт шалгалт зохион байгууллаа.<br>Шалгалтын удирдамжинд заагдсаны дагуу хоол үйлдвэрлэлийн 96 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажилт, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангаж буй эсэх, түүхий эд, материал, хүнсний нэмэлтийн гарал үүсэл, баталгаажилт, хадгалалтын горимын мөрдөлт, шошгын стандарт, бэлэн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, худалдаалалтын нөхцөл, зохистой дадал, байгууллагын дотоод хяналтын журмын хэрэгжилтэнд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, ШУТИС-тай хамтран 2020 оны 05 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулсан “Хүүхдийн хоолны шим тэжээлийн найрлага, хоолны үнийн тооцоог хийж, үлгэрчилсэн цэс, зөвлөмжийг танилцуулах” сургалтанд хамрагдлаа.<br>4. Монгол Улсын Засгийн газраас Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Монгол улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалаар батлагдсан зааварчилгааны дагуу хүнсээр хангах мэргэжлийн ангиудаас болон худалдааны төв, сүлжээ дэлгүүр, хүнсний үйлдвэрүүд зэрэг нийт 42 үйлчилгээний байгууллагуудад хүнсний нөөцийн мэдээг хэрхэн гаргах, ирүүлэх талаар заавар зөвлөгөөг цахимаар өгч, мэдээллээр хангаж ажиллалаа. Дээрх аж ахуйн нэгжүүдээс Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн Яамнаас гаргасан маягтын дагуу 7 хоног тутамд хүнсний нөөцийн судалгааг авч нэгтгэн, УБЗАА-ны ХҮХҮХ-т хүргүүлэн ажиллаж байна.<br>5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, үйлчилгээний чанар стандарт, салбарын ажиллагсдын ур чадварыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, урьдчилан сэргийлэх, хоол үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, илчлэг тооцох аргачлал зэрэг шаардлагатай мэдээ, мэдээлэл олгох зорилгоор дүүргийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс хамтран 2020 оны 09 дүгээр сарын 23, 24, 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд нийт 3 удаагийн сургалт зохион байгууллаа. Сургалтанд төрийн болон төрийн бус өмчийн 28 сургуулийн эмч, тогооч, нярав зэрэг нийт 85 ажилтан, 34 цэцэрлэгийн эмч, нярав, тогооч зэрэг нийт 123 ажилтан, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн 64 төлөөлөл нийт 272 хүн хамрагдаж, сургуулиудад хийгдсэн хяналт шалгалтын дүн мэдээ, цаашид авах арга хэмжээ, “Хүүхдийн хоолны шим тэжээлийн найрлага, хоолны мөнгөний үнийн тооцооны үлгэрчилсэн зөвлөмж”, “Хоол үйлдвэрлэлийн аюулгүй байдал”, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшүүлэх тухай А/1067 дугаар захирамжийн дагуу хийгдэж буй “Хүнсний хаягдлаар компост бордоо хийх” төслийг танилцуулан хүнсний хогийг хэрхэн ангилан ялгах талаар мэдээлэл олголоо<br>6. Дүүргийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/389 дүгээр Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний тусламж үзүүлэх тухай захирамж, дүүргийн Онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний тусламж үзүүлэх тухай А/01 дүгээр тушаалын дагуу дүүргийн 5 хүнсний дэлгүүр, 1 хүнсний үйлдвэрээс гол нэрийн 5 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авч, тусламжийн багц болгон, Сүхбаатар дүүргийн лого бүхий уутанд савлаж, 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр өглөөний 08.00-16.00 цагийн хооронд зорилтот бүлгийн иргэдэд хүргэх ажлыг зохион байгууллаа.<br>Хүргэлтийн ажилд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хороодын ажлын алба, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Улаан загалмайн хороотой хамтран нийт 5 баг гарч, 1-20 дугаар хорооны 350 өрхөд хүргэхээс гэртээ байсан 334 өрхөд хүргэж, хаягандаа байгаагүй 16 иргэний тусламжийн хүнсийг хороодын Засаг дарга нарт нь хүлээлгэн өгсөн. |

<table>
<tr>
<td rowspan="2">208</td>
<td rowspan="2"></td>
<td>“Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн 4.1.6, “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020 дэд хөтөлбөр”-ийн 3.4.5 дахь заалтын хүрээнд Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад зохистой дадал нэвтрүүлж, аюулгүй хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.</td>
<td>500 иргэн, аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулах</td>
<td>Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 100 иргэн, аж ахуйн нэгж зохистой дадлыг үйлчилгээндээ нэвтрүүлсэн байна.</td>
<td>3,000.0</td>
<td>ХХҮХ</td>
<td>90%</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">1. Хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд салбарын хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг сурталчлан таниулах зорилгоор “Хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан гарын авлага”-ыг бэлтгэж, хэвлүүлэхээр ажиллаж байна.<br>2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгоцгооё”, “Хогоо ангилан ялгаж хэвшье” сэдэвт мэдээ, мэдээлэл олгох зурагт хуудсыг бэлтгэн http://sbd.gov.mn/ цахим хуудас, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар дүүрэг, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, хороодын пейж хуудсуудаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.<br>3. Кейтеринг үйлчилгээнд тавих шаардлага, Хоолны газрын хүний нөөцөд тавих шаардлага, Түгээлтын төв түүний үйлчилгээ ерөнхий шаардлага MNS:5021-2:19 стандарт, Жижиглэн худалааны зах түүний ерөнхий шаардалга 5021-3:19 стандартын төслүүдэд дүүргийн 1-20 дугаар нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 180 иргэн, аж ахуй нэгж байгууллагаас саналыг авч нэгтгэн 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр емайл хаягаар хүргүүлж, 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 8/376 дугаар албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтэст хүргүүлсэн.<br>4. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/134 дүгээр тушаал, “Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдааны газруудыг аттестатчилах” удирдамжийн дагуу Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946:2019 стандартын шаардлагыг хангуулах, хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр Цагдаагийн хэлтэстэй хамтран 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хяналт шалгалт зохион байгууллаа.<br>Шалгалтын удирдамжинд заагдсаны дагуу хоол үйлдвэрлэлийн 96 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дүрэмт хувцас өмсөөгүй 25, ажлын байранд бичиг баримтгүй 11, хоолны дээж авалт хангалтгүй 8, агуулахыг зориулалтын дагуу ашиглаагүй 5, нийт 49 зөрчилд 7-14 хоногийн хугацаатай үүрэг өгч, зөрчлийг арилгуулан ажиллалаа.<br>5. Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлт өгсөн хоол үйлдвэрлэлийн 29 аж ахуйн нэгжийн ажлын байрны үзлэг шалгалтыг 2020 оны 07 дугаар сарын 24, 08 дугаар сарын 06, 09 дүгээр сарын 10, 25, 10 дугаар сарын 8, 19, 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд тус тус зохион байгуулж, хяналт шалгалтын дүн мэдээ, танилцуулгыг бэлтгэн Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүллээ.<br>6. Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлт өгсөн худалдааны 18 аж ахуйн нэгж, байгууллага ажлын байрандаа стандарт, эрүүл ахуйн зохистой дадал, норм дүрмийг мөрдөж ажиллаж буй зэрэгт хяналт тавьж, ажлын дүн мэдээг нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүллээ.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 209 | | “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020 дэд хөтөлбөр”-ийн 3.3.1 дэх заалтын хүрээнд Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна. | 2-3 удаагийн сургалтаар 200 ажилчид хамруулах | Ажилчдын ур чадвар нэмэгдсэн байна. | 4,000.0 | ХХҮХ МХХ | 100% | 100% |
| | | Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 09 дүгээр сарын 28-30, 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бариста, бартендер, зөөгч, тогооч, удирдах ажилтан, угтагч, жолооч зэрэг 10 чиглэлийн мэргэжлийн гэрчилгээ олгох сургалтанд хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 40 гаруй байгууллагын 300 гаруй ажилтан, мэргэжил эзэмших хүсэлтэй 100 гаруй иргэн, нийт 400 гаруй иргэдийг хамруулсан.<br><br>Монгол улсын Ерөнхийлөгчийн 10 дугаар зарлиг, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 30, 62 дугаар тогтоол, Улс, Нийслэл, Дүүргийн онцгой комиссын хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын А/108, 166, 168, 223, 333, 752 дугаар захирамжийг үндэслэн томуу, томуу төст өвчлөл, тархалт болон коронавирусын халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор танхимын сургалт зохион байгуулах боломжгүй болсон тул дүүрэг МХХ-ээс төлөвлөгөөт шалгалтанд хамрагдсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 68, ЕБС-ын хоол үйлдвэрлэл, үйлчилгээ 17, худалдааны чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 58, нийт 143 аж ахуйн нэгжийн 165 удирдах албан тушаалтан, тогооч, эрүүл ахуйч нарт хоол үйлдвэрлэл үйчилгээний зохистой дадал, эрүүл ахуйн талаах сургалтыг байгууллага тус бүр дээр зохион байгуулж ажиллалаа. | | | | | | |
| 210 | | “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020 дэд хөтөлбөр”-ийн 3.4.3 дахь заалтын хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний хаяг, шошго, хоолны цэсэд шим тэжээлийн мэдээллийг тусгана. | 2 удаагийн сургалт, хяналт шалгалтыг зохион байгуулж, стандартыг хангуулах | 2 удаагийн сургалт зохион байгуулагдаж, хэрэгжилтийг хангуулсан байна. | - | ХХҮХ МХХ | 100% | 100% |
| | | Хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946:2019 стандартыг хангуулах ажлын хүрээнд хоолны цэсэнд шим тэжээлийн мэдээллийг тусгуулах ажлыг 2019 оноос эхлэн “Хоол үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэх нь”, “Хүнсний аюулгүй байдал”, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд дагаж мөрдөж буй эрх зүйн баримтууд”, “Шинэчлэгдсэн стандарт” зэрэг нийт 8 удаагийн сургалт, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарсан болон урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт хяналт шалгалтууд мөн Согтууруулалх ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг аттестатчилах хяналт шалгалт зэрэг нийт 6 төрлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, үүрэгжүүлэн, гүйцэтгэлийн биелэлтийг шалгахад аж ахуйн нэгжийн 50 орчим хувь нь хоолны цэсэнд шим тэжээлийн мэдээллийг тусгуулахаар бэлтгэж, хэвлэлтэнд өгч, 50 хувь нь хоолны цэсэндээ шим тэжээлийн мэдээллийг тусгасан байна.<br><br>Дүүрэг дэх МХХ-ийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад аж ахуй нэгж иргэдийн худалдан борлуулж буй хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгололтын байдалд тандалт судалгаа хийхэд Өгөөж ХХК, Талх чихэр ХХК, Мах Импекс ХХК, Хаан Хүнс ХХК зэрэг дотоодын томоохон үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго нь стандартын шаардлага хангасан, тухайлбал хүнсийг зөв хэрэглэхийг нийтэд сурталчлах зорилгоор шошго дээр зааврыг | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | товч тодорхой бичсэн, шаардлагатай мэдээллийг агуулсан, саван дээрхи шошгыг боодлынх нь гадна уншиж болохуйц , боодол нь уншихад саад болохооргүй байна. Хяналт шалгалтын явцад кремтэй бүтээгдэхүүн, хэрчсэн гурил, хагас боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгоны стандарт зөрчигдсөн, он сар хадгалах хугацаа бичигдээгүй, он сар нь арилсан, бүтээгдэхүүний сав баглаа боодол гэмтсэн байна. Зөрчилтэй байсан Нутгийн хишиг, Түсэгийн тээг ХХК-ний дэлгүүрт хадгалалтын хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй  Данист бэйкери ХХК- ий Горзоок нэрийн наполеон торт нийт 29 ш тортыг газар дээр нь устгаж, бусад компанийн хаяг шошготой хайрцаг ашиглан өөрийн үйлдвэрийн пирогийг худалдан борлуулж байсан Дэвжих Жавхлант ХХК-д зөрчлийн хэрэг нээн ажиллалаа.<br>Савласан хүнсний бүтээгдэхүүнд  хүнсний бүтээгдэхүүний шимт бодисын мэдээлэл бичигдээгүй байна. Үри шигдан ХХК-ий ресторан нь өөрийн хоолонд агуулагдах шимт бодисын хэмжээг тодорхойлон, хоолны  цэсэнд тухай хоолонд агуулагдах шимт бодисын хэмжээг бичиж,  хоолонд агуулагдах давсны хэмжээг давс тодорхойлох багажаар үзэн тэмдэглэл хөтлөж хэвшсэн байна.<br>Хяналт шалгалтаар хоолны шим тэжээл, ккал-ыг тооцоогүй, цэсэнд дурьдаагүй зөрчил бүхий 5 аж ахуйн нэгжид 3000.0 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч бүрэн барагдуулан эрх бүхий албан тушаалтаны албан даалгавар хүргүүлж биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна. Шалгалтанд хамрагдсан худалдаа үйлчилгээний 61 аж ахуйн нэгжийн 70 ажилтан, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 49 аж ахуйн нэгж, байгууллагын 93 дотоод хяналтын ажилтан болон ерөнхий менежерийг хамруулж хүнсний бүтээгдэхүүний хаяг, шошго, хоолны цэсэд шим тэжээлийн талаар байгууллагын сургалтыг зохион байгуулан, хоол үйлдвэрлэлийн технологийн картад нэмэлт өөрчлөлт оруулан батлуулж хоолны цэсэнд шим тэжээл, ккал-ын мэдээллийг тусгуулан хэвлүүлж хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа. | | | | | | |
| 211 | | “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020 дэд хөтөлбөр”-ийн 3.4.4 дэх заалтын хүрээнд Худалдаа, үйлчилгээний байгууллагуудад хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг нэвтрүүлнэ. | 200 аж ахуйн нэгжийн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэхэд хяналт тавих | Хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг 50 аж ахуйн нэгжид нэвтрүүлсэн байна. | - | ХХҮХ МХХ | 100% | 100% |
| | | Хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946:2019 стандартыг хангуулах ажлын хүрээнд хоолны цэсэнд шим тэжээлийн мэдээллийг тусгуулах ажлыг 2019 оноос эхлэн “Хоол үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэх нь”, “Хүнсний аюулгүй байдал”, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд дагаж мөрдөж буй эрх зүйн баримтууд”, “Шинэчлэгдсэн стандарт” зэрэг нийт 8 удаагийн сургалт, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарсан болон урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт хяналт шалгалтууд мөн Согтууруулалх ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг аттестатчилах хяналт шалгалт зэрэг нийт 6 төрлийн хяналт шалгалтаар үүрэгжүүлж, гүйцэтгэлийн биелэлтийг шалгах ажлыг зохион байгуулсан. Шалгалтанд хамрагдсан нийт 89 аж ахуйн нэгжийн 85 хувь нь хүүхдийн ширээ, сандал байрлуулж, 60 хувь нь хүүхдийн хоолны цэсийг гаргаж, хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг нэвтрүүлсэн байна.<br><br>НМХГ-ын дэд даргын баталсан 02-02/12 дугаар удирдамжийн хүрээнд МУБИС-ын харъяа Ерөнхий боловсролын сургууль, Биеийн тамир спортын дунд сургууль, 131, 71, 58, 31, 35 дугаар  дунд  сургуулийн ойролцоо үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ,  нийт 41 аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар бүтээгдэхүүний хэрэглэж дуусах хугацаа  хэтэрсэн 12 нэр төрлийн 25 ширхэг 65.0 мянган төгрөгийн хүнсний | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтээгдэхүүнийг устгалд оруулж, шинжилгээ сорилтын бичиг баримтгүй, шошгын зөрчилтэй “Даниста бэйкери” ХХК-ийн Горзок нэрийн 56 ширхэг, “Гайхамшигт 4 улирал” ХХК-ийн 17 ширхэг наполеон торт, “Русская зима” ХХК-ний 10 ширхэг печень, 27 ширхэг медовик нэрийн тортыг татан авалт хийлгүүллээ. Хяналт шалгалтын явцад 81 зөрчил илрүүлж, 68 зөрчил буюу 84 хувийг арилгуулж, илэрсэн зөрчилд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 2 аж ахуйн нэгж, 7 иргэнд нийт 2200.0 мянган төгрөгний шийтгэл ногдуулж, бүрэн барагдуулан ажиллалаа.<br>Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хуулиудын холбогдох заалтын хэрэгжилт 66%-тай, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажилт нийт бүтээгдэхүүний 30%-д нь лабораторийн сорилын дүнтэй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн байдалд хяналт тавьдаггүй 100%, хадгалалтын горимд температурын хяналтыг хийж, дотоод хяналтыг хэрэгжүүлж, бүртгэл хөтлөлт хийдэг 10 буюу 22%-д хэрэгжиж байна. Ажлын байрны цэвэрлэгээ хангалтгүй хийж байгаа 35 буюу 77 хувь, 41 /ТҮЦ/ буюу 91.1 хувь нь гар угаах нөхцөлөөр хангагдаагүй байна.<br>Монгол улсын Ерөнхийлөгчийн 10 дугаар зарлиг, Улс, Нийслэл, Дүүргийн онцгой комиссын хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын А/108, 166, 168, 223, 333, 752 дугаар захирамжийг үндэслэн томуу, томуу төст өвчлөл, тархалт болон коронавирусын халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор хоол үйлдвэрлэлийн 3, худалдааны 4 газарт хүүхдэд зориулсан гар ариутгах, угаах хэсэгийг шинээр байгуулан ажиллах талаар үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажилаллаа. | | | | | | |
| 212 | | “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.6.1 дэх заалтын хүрээнд Дотоодын аялал жуулчлалын байгууллагуудын үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2 удаагийн шалгалт, 38 аж ахуйн нэгж хамруулах | 50% нь стандарт шаардлага хангасан байна. | 1,500.0 | ХХҮХ МХХ | 100% | 100% |
| | | 1. Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газраас 2020 оны 01 дүгээр 13-ны өдөр зохион байгуулагдсан НЗД-ын 2019 оны А/995 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Төвлөрсөн болон бие даасан ариутгах системд холбогдох боломжгүй газар MNS5924:2015 стандартын хэрэгжилтийг үнэлэх судалгаа”-ны асуумжийн дагуу дүүргийн 9-20 дугаар хорооны нутаг дэвгэрт худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн ариун цэврийн байгууламжийн үнэлгээг хийж, тайлан мэдээг Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газарт хүргүүллээ.<br>2. Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран тусгай зөвшөөрөл сунгах болон шинээр авахаар хүсэлт гаргасан 4 зочид буудал, 8 дэн буудалд хяналт шалгалтыг 2020 оны 01 дүгээр сарын 03, 07, 28-ны өдөр, 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд нийт 4 удаа зохион байгууллаа. Хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс стандартын шаардлага хангасан 3 зочид буудал, 4 дэн буудлын тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг НАЖГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэлээ. Мөн стандартын шаардлага хангаагүй орчинд үйл ажиллагааг явуулж байсан 1 зочид буудал, 4 дэн буудлын үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар анхааруулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.<br>3. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн баталсан “Амралтын газар, жуулчны бааз, зочид буудлуудад шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж”-ийг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 85 амралтын газар, зочид буудал, дэн буудлуудад хүргүүлж, 2020 оны 04 дүгээр сарын | | | | | | |

<table>
<tr>
<td></td>
<td rowspan="3"></td>
<td colspan="7">30, 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд Нийслэлийн аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтний хамт нийт 8 амралтын газар, 5 дэн буудалд түүвэрлэн гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд үйлчлүүлэгч болон ажилчдын гар ариутгах болон халуун үзэх нөхцлөөр хангагдсан, сэрэмжлүүлэг, сурталчилгааны материалыг байрлуулсан, 14 хоног тутамдаа ариутгалыг хийлгэсэн байсан.<br>4. Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн баталсан “Дэн буудал” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газрын Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсийн холбогдох улсын байцаагчид хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дэн буудлуудад “Дэн буудлын үйлчилгээний ерөнхий шаардлага” MNS5738:2007 стандарт”-ын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй нийт 35 дэн буудал хамрагдсан.<br>Шалгалтаар зөрчил илэрсэн 5 дэн буудалд кохих хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллалаа.<br>5. МХХ-ээс дүүргийн Прокурорын газрын дарга, хэлтсийн даргын хамтран баталсан удирдамжийн дагуу дүүргийн 19, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 5 амралтын газарт хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчлийг үндэслэн Намдумандал ХХК, Молор трейд ХХК-нд ЗТХ-ийн 6.15 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.2 дахь заалтын дагуу тус бүр 3000.0 төгрөг нийт 6000.0 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч хялбаршуулсан журмаар шийдвэрлэн барагдуулан, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтаны албан даалгавар өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Ковид-19 халдвараас сэргийлэх мэдэгдлийг хүргүүлж ажиллалаа.<br>Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчилтэй байсан 2 аж ахуйн нэгжийн зөрчил арилгалтын түвшин 87 хувьтай байлаа.</td>
</tr>
<tr>
<td rowspan="2">213</td>
<td>“Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.4.2 дахь заалтын хүрээнд Хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулна.</td>
<td>2 удаагийн сургалт, 80 аж ахуйн нэгж хамруулах</td>
<td>Ажилчдын ур чадвар нэмэгдсэн байна.</td>
<td>3,000.0</td>
<td>ХХҮХ МХХ</td>
<td>70%</td>
<td>70%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">Шинэ коронавирусийн халдвартай холбоотойгоор гарсан Нийслэлийн Засаг даргын А/166, А/168 дугаар захирамжуудыг зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйлчилгээ эрхлэгчдэд зориулан гаргасан мэдэгдэл, зөвлөмж, зааврын хамт хороодын Ажлын албаар дамжуулан 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 8/213, 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 8/1167 дугаар албан бичгүүдээр аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж мэдээ, мэдээллээр хангасан.<br>Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай А/223 захирамжаар аялал жуулчлалын чиглэлээр үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон байдалд байнгын хяналт тавьж ажилласан.<br>Нийслэлийн Засаг даргын А/521 дүгээр захирамж гарсантай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 8 амралтын газар, 35 дэн буудлын үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаагаа нээн ажиллуулж байгаатай холбогдуулан аж ахуйн нэгжүүд ариутгал халдваргүйтгэл хийж, мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж буй эсэхэд 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэл байнгын хяналт тавин ажиллалаа.<br>Шинэ коронавирусын цар тахалтай холбоотойгоор Нийслэлийн Засаг даргын А/1242, А/1248 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн гаргасан зааварчилгааны хэрэгжилтийг хангуулах үүднээс хороодын Ажлын албаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Монгол улсын Ерөнхийлөгчийн 10 дугаар зарлиг, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 30, 62 дугаар тогтоол, Улс, Нийслэл, Дүүргийн онцгой комиссын хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын А/108, 166, 168, 223, 333, 752 дугаар захирамжийг үндэслэн томуу, томуу төст өвчлөл, тархалт болон коронавирусын халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор сургалт зохион байгуулах ажил хийгдээгүй болно. | | | | | | |
| 214 | | Үйлдвэрлэл эрхлэгчдийн туршлага солилцох уулзалт, аялалыг зохион байгуулна. | Үйлдвэр эрхлэгч 20 иргэнийг 3 үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлуулах | Үйлдвэрлэгчдийн хамтран ажиллах нөхцөл бүрдэж өрсөлдөх чадвар нэмэгдсэн байна. | 3,000.0 | ХХҮХ ЖДҮДТ | 100% | 100% |
| | | - Үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийг дэмжих, томоохон үйлдвэрүүдийн үйлдвэрлэл, маркетингтай танилцуулах, харилцан туршлага солилцох бизнес аялалыг дүүргийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр 17-ны өдрийн А/314 дүгээр захимжаар 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулан ажиллалаа.<br>Аяллын хүрээнд Улаанбаатар хивс ХК, ГБД Трейдинг ХХК-ний “Газар шим” хүнсний үйлдвэртэй 45 үйлдвэрлэл эрхлэгчийг танилцуулсан бөгөөд Улаанбаатар хивс ХК-ны менежер Б.Отгонтуул нь үйлдвэрийнхээ талаар танилцуулж, 40-50 жилийн хугацаанд зах зээлийн шуурганд тэсэж, одоог хүртэл үйлдвэрлэлээ амжилттай явуулж байгаа олон олон туршлагаасаа хуваалцаж, нэрийн дэлгүүрээ сонирхуулсан. ГБД Трейдинг ХХК-ны маркетингийн менежер А.Жамбалдорж нь “Газар шим” хүнсний үйлдвэрийн түүх, амжилтыг дэлгэцээр танилцуулж, шилэн хоргоор үйлдвэрийнхээ процессыг үзүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдэд тус бүрт гарын бэлэг гардуулж, халуун дотно хүлээн авч аялуулсан. | | | | | | |
| 215 | | Үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах борлуулалтыг нь дэмжих зорилгоор "Сүхбаатар дүүрэгт үйлдвэрлэв" сэтгүүл гаргана. | Дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдээс 25 ААН, иргэнийг болон төвийн танилцуулга, бусад мэдээллийг 30 хуудсанд багтаан 300 ширхгийг хэвлүүлэн тараах | Үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн зах зээлд танигдаж, борлуулалт нэмэгдсэн байна. | 2,500.0 | ХХҮХ ЖДҮДТ | 100% | 100% |
| | | - Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 5 иргэний үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний зураг, хаяг, утасны дугаар бүхий танилцуулга мэдээллийг Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн фэйсбүүк хуудас болон цахим орчин, мэдээллийн самбарт байршуулан, нийтэд сурталчилж байна.<br>- Үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг төрлөөс нь хамааруулан цуврал хэлбэрээр, цахимаар сурталчлан ажиллаж байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 216 | | Тогтвортой үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, салбарын тэргүүний ААНБ, иргэдийг тодруулж урамшуулна. | 4 ААН, иргэнг шагнаж урамшуулах | ААНБ-уудын үйл ажиллагаа идэвхижсэн байна. | 2,000.0 | ХХҮХ ЖДҮДТ | 100% | 100% |
| | | - Ковид-19 цар тахлын үед түүхий эдийн олцод муу байгааг харгалзан дүүргийн оёдлын үйлдвэрлэл эрхлэгчдэдээ зориулж, BSM Япон, Монгол трейдинг ХХК-ийн Жиро салонтай хамтран Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын 19 тоотод 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр "Хамтран ажиллах бизнес өдөрлөг зохион байгуулж, 5 үйлдвэрлэл эрхлэгч зээлээр түүхий эд худалдан авах гэрээ байгуулан хамтран ажиллахаар болсон.<br>- Оёдлын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 17 дугаар хорооны иргэн Л.Доламжавыг ахуйн үйлчилгээний салбарт тасралтгүй 35 жил амжилттай хөдөлмөрлөж, хойч үедээ мэдлэг чадвараа өвлүүлж буйг үнэлэн Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнаууллахад дэмжиж ажилласан. | | | | | | |
| 217 | | Үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн чадавхжуулах болон бизнесийн төрөл бүрийн сургалт уулзалтыг зохион байгуулна. | 8 удаагийн сургалтыг 200 бизнес эрхлэгчийг хамруулах | Үйлдвэрлэгчид чадваржсан байна. | 10,000.0 | ХХҮХ ЖДҮДТ | 100% | 100% |
| | | - Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн фэйсбүүкээр "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний тухай хууль"-ийн талаарх мэдээллийг бэлтгэн хэвлүүлж 66 иргэнд мэдээллийг хүргэсэн. Мөн дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид зориулсан шалгуур үзүүлэлтийн талаарх мэдээллийг бэлтгэн 33 иргэнд тараасан.<br>- Мөн нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр 27-ны өдрийн "Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/108 дугаар захирамжийн 1.3 дугаар заалтад олон нийтийг хамарсан сургалт зохион байгуулаагүй байна.<br>- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн "Жижиг, дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх" БЭСТ хөтөлбөрийн хүрээнд "Хөгжлийн шийдэл" ТББ –тэй хамтран 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээл авах хүсэлтэй байгаа дүүргийн 10 үйлдвэрлэл эрхлэгчдэд төсөл бичих танхимын сургалтыг зохион байгуулсан.<br>- ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам", аж ахуй нэгж хэрхэн болох тухай, зээлийн журамтай холбоотой цахим сургалтыг 4 удаа хийж, 221 иргэнд хүргэсэн.<br>- Салбарын хууль эрх зүйн мэдээллийг иргэдэд хурдан шуурхай хүргэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хууль эрх зүйн гарын авлага 160ш, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас шинээр батлагдсан зээлийн журам, төслийг цахимаар бүртгүүлэх заавар, Зээлийн батлан даалтын сангийн эрхлэх үйл ажиллагаа, төсөл хэрхэн бичих зэрэг агуулга бүхий гарын авлага 100ш-ийг хүлээн авч Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвөөр үйлчлүүлэгсэд болон үйлдвэрлэл эрхлэгчдэд тараан, мэдээллээр ханган ажилласан.<br>- Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газраас 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан төсөл боловсруулах арга зүй, хөнгөлөлттэй бизнесийн зээл, тусламж, дэмжлэг хэрхэн олж авах, бизнесээ хэрхэн удирдан зохион байгуулах чадвар эзэмшүүлэх сургалтад дүүргийн 10 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - Баянхошуу Бизнес Инкубатор төвд Нийслэлийн Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл, Инновацын газар, GIZ ЭТИС хөтөлбөр, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл, Азийн сан, Хөгжлийн шийдэл ТББ-ын BEST хөтөлбөр хамтран 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр "Бизнесийг хөгжүүлэх санхүүжилтийн боломж" нээлттэй өдөрлөг зохион байгуулсан ба тус өдөрлөгт төвийн 5 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулав.<br>- Дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Худалдаа хөгжлийн банк, дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр дүүргийн 9 давхрын хурлын зааланд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн талаар мэдээлэл олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар Худалдаа хөгжлийн банкнаас үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан өөрсдийн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулсан бөгөөд үйлдвэрлэл эрхлэгчид зээл, тусламжид хамрагдахад тулгамдаж буй асуудлын талаар харилцан санал солилцож, сургалтанд оролцогсдыг зээлийн бүтээгдэхүүний талаарх гарын авлагаар хангалаа.<br>- Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвөөс 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан "Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах нь" сургалтад төвийн 2 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулсан.<br><br>2020 онд танхимын 6 удаагийн сургалтаар 71 иргэнд, цахимын 4 удаагийн сургалтаар 221 иргэнд, нийт 10 удаагийн сургалтаар 291 үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдээлэл хүргэж ажилласан. | | | | | | |
| 218 | | “Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" дэд хөтөлбөрийн 3.3.12. дахь заалтын дагуу Нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчлах, хэрэглүүлэх аяны хүрээнд үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулна. | 2 удаагийн сургалтад 100 , үзүүлэх сургалтад 40-50 бизнес эрхлэгчийг хамруулах | Ажиллагсдын ур чадвар сайжирч, үйлчилгээний чанар дээшилсэн байна. | 4,000.0 | ХХҮХ | 100% | 100% |
| | | Томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт болон шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комисс болон нийслэл, дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэл, тогтоосон хэм хэмжээний хүрээнд олноор бөөгнөрөх сургалт, үзүүлэх сургалтын арга хэмжээ зохион байгуулагдаагүй.<br>Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ахуйн үйлчилгээний 400 гаруй газруудад Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс ирүүлсэн худалдаа, үйлчилгээний байгууллагуудад өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийг хэрхэн хийх, халдваргүйтгэлийн бодисыг хэрхэн найруулж хэрэглэх талаарх зөвлөмжийг хэвлүүлэн тарааж, 14 хоног тутамд ариутгал халдваргүйтгэл хийлгүүлэн, үйлчилгээний цагийн хязгаар тогтоосон 10 бассейн, 17 сауны үйл ажиллагааг түр зогсоож, дүүргийн Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хороодын ажлын албатай хамтран гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.<br>Эмбасси резидэнс ХХК, Би Би Девеломент Хотел ХХК-ийн Новотел зочид буудлын саун, бассейн, фитнес, гоо сайхны үйлчилгээний ариун цэвэр, эрүүл ахуй, стандартын шаардлагын биелэлт, үйл ажиллагаатай танилцаж, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, нийслэлийн Засаг даргын Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг | | | | | | |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td colspan="7">эрчимжүүлэх тухай захирамжуудыг танилцуулж, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар баталсан “Үйлчилгээний зарим байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтын түр журам”-ыг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байх зөвлөмж өгсөн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 418 дугаар тогтоолоор батлагдсан “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд “Салбарын үйлчилгээнд зэрэглэл тогтоох журам боловсруулж, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг тогтоож, мөрдүүлэх, ахуйн үйлчилгээний салбарыг ОУ-ын түвшинд алдаршуулсан баг тамирчдыг дэмжих тусгайлсан журам боловсруулан батлуулах. /Санхүүгийн дэмжлэг, татварын хөнгөлөлт, төрийн шагнал гэх мэт нарийвчлан тусгах/ зэрэг саналуудыг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанд 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 8/224 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>Дүүргийн 6 дугаар хорооны иргэн Н.Энхбаярын хувцас засварын үйл ажиллагаа эрхэлдэг Ч.Лхамын болон 12 дугаар хорооны Бүрд худалдааны төвд үсчний үйл ажиллагаа эрхэлдэг иргэн Б.Мөнхзаяагийн үйлчилгээний талаар ШӨХТГ-т гаргасан иргэдийн гомдлыг Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Чанарын шаардлага хангаагүй ажил, үйлчилгээ гүйцэтгэсний улмаас хэрэглэгчид учирсан хохирлын хэмжээгээр гэрээний үнийг багасган төлөх” гэсэн заалтыг үндэслэн үйлчлүүлэгч Б.Эрдэнэд үйлчилгээний хөлсний зөрүү болох 40 хувийг буцаан олгуулж, үйлчилгээний үнэ тарифыг ил тод нээлттэй тавиулж, иргэдийн гомдлыг тус тус шийдвэрлэсэн.<br>Дүүргийн 10 дугаар хороо, Их тойруугийн 30 дугаар байранд гоо сайхны үйлчилгээ эрхлэхээр хүсэлт ирүүлсэн Уран ямба ХХК-ийн хүсэлтийн дагуу ХХҮХ-ийн дарга Г.Амгалантай хамт газар дээр нь очин үйлчилгээний байртай танилцаж, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага. MNS 5567:2006 стандартын шаардлага ханган ажиллах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Орон сууцны тухай хуулийн 17.1.7 дахь “Саун, нийтийн халуун усны болон угаалгын газар, нийтийн бие засах газар, зориулалтын бус байранд нийтийн хоолны газар ажиллуулах, 40 дБА-аас их хэмжээний дуу чимээ гаргах” заалтыг зөрчиж байсан тул уг байрны 04 тоотод спа, сауны үйлчилгээ явуулахыг хориглож, үйлчилгээний газрын эзэн А.Даваасүрэнд анхааруулсан.</td>
</tr>
<tr>
<td rowspan="2">219</td>
<td rowspan="2"></td>
<td>“Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" дэд хөтөлбөрийн 3.3.15. дахь заалтын хүрээнд Дэлхийн ур чадварын тэмцээнд нийслэлээс салбарын залуу мэргэжилтнүүдийг оролцуулж, дэлхийн түвшинд салбарын ажиллах хүчний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.</td>
<td>2-3 хүнийг дэмжих</td>
<td>Салбарын ажиллагсдын мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.</td>
<td>12,000.0</td>
<td>ХХҮХ</td>
<td>100%</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="7">Дэлхий нийтэд шинэ төрлийн коронавирусийн халдвар тархсантай холбогдуулан дэлхийн үсчин гоо сайханчдын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Дэлхийн аварга шалгаруулах уралдаан тэмцээнийг 2020 оны 11 дүгээр сард Франц улсад онлайн хэлбэрээр зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан Монголын Мэргэжлийн Үсчин, гоо засалчдын холбооноос Монгол улсаас оролцох мэргэжлийн багийг бэлтгэж байна. Уг багийн бүрэлдэхүүнд дүүргийн үсчин гоо сайхны Хосшагай салон, Грийс салон, Every good зэрэг салоны 10 гаруй Монгол улсын мастер үсчин, гоо засалчид үс засалт, хумс засал, нүүр будалтын 4 төрөлд амжилттай оролцсон.<br>Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/174 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/120 дугаар захирамжаар батлагдсан Ахуйн үйлчилгээний цэгийн 20... оны хагас, бүтэн жилийн</td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | захиргааны мэдээллийн /3-АҮЦМ/ маягт, нөхөх зааврын дагуу хороодын Ажлын албатай хамтран ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд судалгаа хийж, дүүргийн ахуйн үйлчилгээний салбарын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 25 төрлийн үйлчилгээний 135 ААН, 300 иргэний мэдээллийг оруулсан.<br>Санхүүгийн зохицуулах хороо болон нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нэгдсэн мэдээллийн сан бий болгохтой холбогдуулан нутаг дэвсгэрийн хэмжээнд үнэт металл, үнэт чулуу эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхэлж буй 16 аж ахуйн нэгж, иргэдийн дэлгэрэнгүй судалгааг 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 8/1086 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | | | | | | |
| 5.3 Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ. | | | | | | | | |
| 220 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйл; ДЗДҮАХ 5.3.1 Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс орны хот, дүүргүүдтэй хамтран ажиллах, хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтооно. | Уламжлалт харилцаат хот, дүүргүүдтэй байгуулсан Санамж бичигт тусгагдсан заалтыг салбар бүрт эрчимжүүлнэ. | Хамтын ажиллагааны дагуу байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах салбарыг нэмэгдүүлэх | Боловсрол, Эдийн засаг, нийгмийн салбаруудын үйл ажиллагаа эрчимжсэн байна. | 110,000.0 | ТЗУХ | | Үнэлэх болом жгүй. |
| | | Дэлхий нийтэд тархаад буй КОВИД-19 тахлын улмаас гадаад айлчлал болон зочид төлөөлөгчдийг хүлээн авах ажиллагаа мөн сурагч солилцоонууд цуцлагдсан. Энэхүү цар тахалтай холбоотойгоор нийт ах, дүүсийн хамтын ажиллагаат хот дүүргүүд рүү Үндэсний баярууд болон Иргэдийн баярт зориулан видео мэндчилгээ илгээсэн.<br>Үүнд:<br>1. БНХАУ-н Дунчөн дүүрэг Хятадын “Үндэсний баяр’’<br>2. А/ БНСУ-н Сөүл хотын Жунгру дүүрэг Солонгосын “Ургацын баяр”<br>Б/ Инчеон хотын Жүн дүүрэг “29 дэх удаагийн Иргэдийн баяр”<br>3. Япон Улсын Нагано мужийн Сакү хот “Ахмадын баяр” | | | | | | |
| 221 | ДЗДҮАХ 5.3.2 Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг албан айлчлал сургалт, семинар, үзэсгэлэн, туршлага аялалд хамруулж мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлнэ. | Дээд шатны байгууллагаас ирсэн шийдвэрийн дагуу болон дүүрэгтэй хамтын ажиллагаатай хот, дүүргүүд рүү албан хаагчдыг сургалт, семинарт хамруулна. | Албан хаагчдын ур чадвар, мэдлэгийг харилцаат хот, дүүргийн туршлагаас суралцуулах | Мэдлэг, ур чадвар дээшилж, хариуцсан ажилд ахиц дэвшил гарсан байна. | 111,000.0 | ТЗУХ | 100% | 100% |
| | | БНСУ-н Сөүл хотын Жунгру дүүргийн дэмжлэгтэйгээр Солонгос улсын Засгийн газрын тэтгэлэгт ЛОГОДИ /Орон нутгийн удирдлагын хөгжлийн хөтөлбөр/ сургалт онлайн хэлбэрээр 09 дүгээр сарын 02-08-ны өдрийг хүртэл явагдаж дууссан. Тус сургалтад 6 улсаас нийт 13 төлөөлөгч оролцсон. Энэхүү сургалтад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга В.Гомбодорж хамрагдаж сургалтыг амжилттай дуусгасан. | | | | | | |
| 222 | БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 | Эх орны голомт, Их хотын хоймор Сүхбаатар дүүргийн | Ойн баярыг зохион байгуулах төлөвлөгөө | Төлөвлөгөө хэрэгжсэн байна. | 400,000.0 | ТЗУХ | 40% | 40% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оны 04-р сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар Сүхбаатарын район нэртэйгээр байгуулагдсанаас хойш эдүгээ 55 жилийн ой 2020 онд тохиож байна. | түүхт 55 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулна. | боловсруулж, хэрэгжүүлэх | | | | | |
| | | Тус дүүрэг үүсгэн байгуулагдсаны 55 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан дүүргийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад чиглэсэн “Иргэнд ээлтэй дүүрэг” аяныг зохион байгуулах тухай саналыг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлж, ДИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 09 дүгээр сарын 26 дугаар “Иргэнд ээлтэй бүтээлч дүүрэг” аян зохион байгуулах тухай тогтоол батлуулсан. Тогтоолын дагуу энэ оныг дуусталх хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагад чиглэсэн 22 төрлийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | | | | | |

ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА Х.БОЛОРМАА

ХЯНАСАН: ТГХШХ-ийн ДАРГА М.БЯМБАСҮРЭН

НЭГТГЭСЭН:ТГХШХ-ийн МЭРГЭЖИЛТЭН Б.БАТЦЭЦЭГ